



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-30</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>31-147</i>
<hr/>	
<i>1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 02 дугаар дүгнэлт</i>	<i>32-44</i>
<i>2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлт</i>	<i>44-58</i>
<i>3. Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр /2022-2023 оны зээлийн төлөвлөгөө/-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	<i>58-70</i>
<i>4. “Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	<i>70-72</i>
<i>5. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны өдөр, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нараас 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>72-132</i>
<i>6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	<i>132-138</i>
<i>7. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>138-147</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 50,7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 08 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Батжаргал, Б.Баттөмөр, Б.Бейсен, Г.Ганболд, Ц.Даваасүрэн, Х.Нямбаатар;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Сэргэлэн, Б.Чойжилсүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг, Ц.Цэрэнпунцаг;

Тасалсан: Ш.Адьяаа, Ц.Анандбазар, Х.Ганхуяг;

Хоцорсон: Э.Бат-Амгалан-3 цаг 17 минут, Б.Баярсайхан-16 минут, С.Батболд-1 цаг 44 минут, Д.Ганбат-44 минут, С.Одонтуяа-1 цаг 06 минут, М.Оюунчимэг-12 минут, Д.Өнөрболор-07 минут, Д.Сарангэрэл 1 цаг 29 минут, Б.Саранчимэг-1 цаг 00 минут, Н.Учрал-3 цаг 04 минут, Д.Цогтбаатар-47 минут, Ж.Чинбүрэн-47 минут, Ж.Эрдэнэбат-42 минут.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 02 дугаар дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ц.Нанзаддорж оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ц.Нанзаддорж, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нар тус тус танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Б.Пүрэвдорж, Ц.Мөнх-Оргил нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр хариулж тайлбар хийв.

Байнгын хорооноос гаргасан санал тус бүрээр санал хураалт явуулав.

Г.Занданшатар: Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а дэд заалтад “анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд

нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 19
Бүгд: 44
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.6 дэд заалтад “хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 16
Бүгд: 45
64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 16
Бүгд: 45
64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19
Бүгд: 45
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...”

гэж заасанд нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 20
Бүгд: 46
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 22
Бүгд: 46
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... зөрүүтэй хэрэглэсэн эсэх, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...”

гэж заасанд нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19
Бүгд: 45
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Г.Занданшатар: “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 21
Бүгд: 45
53.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /11:05/

Уг асуудлыг 11 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Эрдэнэбулган оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Эрдэнэбулган, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ц.Мөнх-Оргил, Ж.Сүхбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр нар хариулж тайлбар хийв.

Байнгын хороодоос гаргасан санал тус бүрээр санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт ““Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэж заасны “... илрүүлэх ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. ... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 24
Бүгд: 45
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулууны “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулууны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19
Бүгд: 45
55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 17
Бүгд: 45
62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт ““Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэж заасны “... илрүүлэх ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 20

Бүгд: 45
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Г.Занданшатар: “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 20
Бүгд: 45
55.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн найруулгыг танилцуулав.

Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /11:58/

Уг асуудлыг 11 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр /2022-2023 оны зээлийн төлөвлөгөө/-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерөн-Өлзий, Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Гантулга, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ажлын албаны дарга Т.Төрболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 12 цаг 31 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, С.Ганбаатар, Ц.Сандаг-Очир, Ц.Мөнх-Оргил, Б.Энхбаяр, Б.Баярсайхан нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д заасны дагуу Баасан гарагийн 10.00 цагт эцэслэн батлах санал хураалтыг явуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 20230.05.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д заасны дагуу Баасан гарагийн 10.00 цагт эцэслэн батлах санал хураалтыг явуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Тав. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн

2023.04.05-ны өдөр, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нараас 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, мөн газрын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Наранцэцэг, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Б.Болд, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга А.Энхмаа, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Энхбат, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, Тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Судлаач, доктор Э.Гэрэлт-Од нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Улсын Их Хурлын даргын зөвлөх О.Номинчимэг нар байлцав.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 55 минут үргэлжилж, 13 цаг 03 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 10 минутад эхлэв.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Н.Наранбаатар, С.Ганбаатар, Б.Жаргалмаа, Д.Өнөрболор, Ц.Сандаг-Очир, Д.Ганбат, О.Цогтгэрэл, Ч.Хүрэлбаатар, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 14 цаг 33 минутаас хуралдааныг даргалав.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Э.Бат-Амгалан, Б.Баттөмөр, Н.Ганибал, Т.Доржханд, Ц.Мөнхцэцэг, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж, Д.Сарангэрэл, Ц.Туваан, Б.Энх-Амгалан, Б.Энхбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хасах:

“1/4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг:

4.3.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 126 гишүүнийг дараах байдлаар сонгоно:

4.3.1.Улсын Их Хурлын 78 гишүүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос олныг төлөөлөх /мажоритар/ аргаар;

Тайлбар: “олныг төлөөлөх /мажоритар/ арга” гэж тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү бөгөөд хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцохыг ойлгоно.

4.3.2.Улсын Их Хурлын 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорционал/ аргаар.”

Тайлбар: “хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорционал/ арга” гэж сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн авсан саналынх нь тоо, хувьд үндэслэн энэ хуульд заасны дагуу суудал хуваарилж, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцохыг ойлгоно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 9

Бүгд: 48

81.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ж.Сүхбаатар нар үг хэлэв.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт, мөн зүйлийн 16 дахь заалтыг нэгтгэн 1 дүгээр зүйлийн 19 дэх заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2 дугаар зүйлийн 5 дахь заалтыг хасах:

“19/20 дугаар зүйлийн 20.22 дахь хэсэг:

20.22.Гадаад улсад байгаа иргэн гадаадад санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө сонгуульд оролцохоо мэдэгдэж, бүртгүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 9

Бүгд: 48

81.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.4.4 дэх заалт, 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.6-7.10 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 8

Бүгд: 48

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалтыг хасах:

“7/9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг:

9.3.Гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдөр /цаашид “гадаадад санал авах өдөр” гэх/-ийг сонгуулийн төв байгууллага /цаашид “Сонгуулийн ерөнхий хороо” гэх/-ын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтоох бөгөөд гадаадад санал авах өдөр нь дөрөв хүртэл өдөр байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 12

Бүгд: 48

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу 11.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 8

Бүгд: 48

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10, 11 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10/11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг:

11.4.Улсын Их Хурлын гишүүнийг энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар сонгох сонгуульд Монгол Улсын нутаг дэвсгэр сонгуулийн нэг тойрог байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 9

Бүгд: 48

81.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 12, 13 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12/12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг:

12.2.Энэ хуулийн 4.6-д заасны дагуу ээлжит бус сонгууль явуулах тохиолдолд Улсын Их Хурал ээлжит бус сонгуулийн санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө энэ хуульд нийцүүлэн сонгуулийн тойргийг байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 11
Бүгд: 48
77.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд үг хэлэв.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 19¹ дүгээр зүйлийн 19^{1.3} дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19^{1.3}.Төв комиссын дарга дотоод ажлын асуудлаар захирамж гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 9
Бүгд: 48
81.2 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалтын 19¹ дүгээр зүйлийн гарчгийн “бүрэн эрх,” гэснийг хасаж, 19^{1.7} дахь хэсгийн “эрхийг” гэснийг “чиг үүргийг” гэж, 19^{1.7.10} дахь заалтын “эрх” гэснийг “чиг үүрэг” гэж, 19^{1.7.2} дахь заалтын “сахин биелүүлэх явдлыг хангах” гэснийг “хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 8
Бүгд: 48
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 20.16 дахь хэсгийн “танилцах” гэсний дараа “, ашиглах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 8
Бүгд: 48
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 19 дэх заалт буюу 20 дугаар зүйлийн 20.18 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 2 дугаар зүйлийн 6 дахь заалтыг хасах:

“19/20 дугаар зүйлийн 20.21 дэх хэсэг:

20.21.Энэ хуульд заасан журмын дагуу Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигч, төрийн бус байгууллагын төлөөлөл сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаатай танилцаж нягтлах эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 11
Бүгд: 49
77.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан тайлбар хийв.

Хуралдаан даргалагчаас найруулгыг анхаарах чиглэл өгөв.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 20 дахь заалт буюу 23.8 дахь хэсгийн “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас” гэснийг “холбогдох байгууллагаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 14
Бүгд: 49
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дэх заалт буюу 29 дүгээр зүйлийн 29.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

24/29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэг:

“29.10.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ ардчилсан ёс, шударга ёсны зарчмыг баримталж, нийгмийн бүлгийн төлөөлөл, оролцоог хангана.”

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Ч.Хүрэлбаатар, С.Чинзориг, Д.Тогтохсүрэн, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 27 дахь заалт буюу 33.1.10 дахь заалтын “дэвшигчийг” гэсний дараа “, 29.7-д заасныг зөрчсөн бол тухайн нэр дэвшигчийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 12
Бүгд: 47
74.5 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 28 дахь заалт буюу 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсгийн “хэмжээнээс” гэснийг “хэмжээний 50 хувиас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 12

Бүгд: 47
74.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 29 дэх заалтын 38.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.13.Төрийн аудитын дээд байгууллага нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн энэ хуулийн 38.5-д заасан мөрийн хөтөлбөр, 38.7-д заасан хандивын тайланд тус бүр нэг дүгнэлт гаргана. Хандивын тайлан нь ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааг, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацааг хамаарна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 11
Бүгд: 47
76.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 31 дэх заалтын 41.16, 41.17 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41.16.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нь тухайн нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааг эрхлэн явуулна.

41.17.Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нэгдсэн хэвлэмэл материал нь гурван хэвлэлийн хуудаснаас хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Ч.Хүрэлбаатар, С.Бямбацогт, Д.Тогтохсүрэн нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 33 дахь заалт буюу 47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32/47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсэг:

47.12.Жагсаалтаар нэр дэвшигчийн цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааг нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага энэ хуульд заасны дагуу бүртгүүлсэн цахим хуудсаар эрхлэн явуулна. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахад энэ хуулийн 50.1-д заасны дагуу тогтоосон зардлын дээд хэмжээний 15 хувиас хэтрэхгүй байна.”

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 34 дэх заалт буюу 48 дугаар зүйлийн 48.1.8-48.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34/48 дугаар зүйлийн 48.1.8 дахь заалт:

48.1.8.тухайн жилийн төсөвт тусгаагүй нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх, амлалт өгөх, зарлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 10
Бүгд: 43
76.7 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 35 дахь заалт буюу 48 дугаар зүйлийн 48.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34/48 дугаар зүйлийн 48.10 дахь хэсэг:

48.10.Радио, телевиз нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 10
Бүгд: 45
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 37 дахь заалт буюу 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37/53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсэг:

53.4.Энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшигч нь нам, эвслийн сонгуулийн сурталчилгаанд зориулан хандив өгч болох бөгөөд нэг нэр дэвшигчийн өгсөн хандивын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон нэр дэвшигчээс тойрогт зарцуулах зардлын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 11
Бүгд: 44
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 38, 39 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37/59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг:

59.4.Саналын хуудас нь дараах хэсэгтэй байна:

59.4.1.энэ хуулийн 4.3.1-т заасан сонгуулийн тойрогт нэр дэвшигчид өгсөн саналыг тэмдэглэх;

59.4.2.энэ хуулийн 4.3.2-т заасан нам, эвсэлд өгсөн саналыг тэмдэглэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 14
Бүгд: 45
68.9 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 41 дэх заалт буюу 63¹ дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 11
Бүгд: 46
76.1 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 42 дахь заалт буюу 64¹ дүгээр зүйлийн 64^{1.1} дэх хэсгийн “Сонгуулийн ерөнхий хорооноос” гэснийг “энэ хуульд заасны дагуу” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 12
Бүгд: 46
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 43 дахь заалт буюу 65 дугаар зүйлийн 65.16, 65.17 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43/65 дугаар зүйлийн 65.16, 65.17 дахь хэсэг:

65.16.Бүртгэлийн хуудас авсан сонгогчийг сонгогчийн нэрийн жагсаалтын нэгдсэн санд бүртгэгдсэн тухай тэмдэглэгээ хийнэ.

65.17.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 65.6-д заасан сонгогчийн гарын хурууны хээгээр сонгогчдын нэрийн жагсаалтын нэгдсэн сантай тулган таниулах ажлыг хариуцна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 12
Бүгд: 46
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан үг хэлэв.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 44 дэх заалтын 67¹ дугаар зүйлийн 67¹.4, 67¹.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“67¹.4.Энэ зүйлд өөрөөр заагаагүй бол гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажиллагаанд энэ хуулийн 65, 66 дугаар зүйлд заасан журмыг баримтална.”

“67¹.6.Гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн энэ хуулийн 59.4.2-т заасан хэсэгт саналаа өгнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 9
Бүгд: 46
80.4 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 45 дахь заалт буюу 67 дугаар зүйлийн 67.17 дахь хэсгийн “төв комисст” гэсний дараа “гадаадад санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 9
Бүгд: 46
80.4 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Төслийн 1 дүгээр зүйлийн 48 дахь заалт буюу 71 дүгээр зүйлийн 71.11 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 8
Бүгд: 46
82.6 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Төслийн 1 дүгээр зүйлийн 49 дэх заалт буюу 72¹ дугаар зүйлийн 72¹.4 дэх хэсгийн “дипломат төлөөлөгчийн газарт” гэснийг “салбар комисст” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 9
Бүгд: 46
80.4 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 50 дахь заалтын 74.1 дэх хэсэг, 74.1.3, 74.1.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 8
Бүгд: 46
82.6 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 51 дэх заалт буюу 74 дүгээр зүйлийн 74.2.2 дахь заалтын “3” гэснийг “4” гэж өөрчилж, төслийн 1 дүгээр зүйлийн 52 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 9
Бүгд: 46
80.4 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 53 дахь заалт буюу 74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсгийн 74.3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“74.3.2.Энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвслийн авсан саналын хувь болон нийт нам, эвсэлд өгсөн хүчинтэй саналын хувь хоорондын зөрүүг энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвсэлд тэнцүү хэмжээгээр хуваан нам, эвсэл тус бүрийн авсан саналын хувь дээр нэмж тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 10
Бүгд: 46
78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 53 дахь заалт буюу 74 дүгээр зүйлийн 74.3.3 дахь заалтын “38-д” гэснийг “48-д” гэж, 74.3.4 дэх заалтын “38-д” гэснийг “48-д” гэж тус тус өөрчилж, төслийн 1 дүгээр зүйлийн 54 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 13
Бүгд: 46
71.7 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 53 дахь заалт буюу 74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 74.3.5 дахь заалт нэмж, 74.3.4 дэх заалтын тайлбарыг хасах.

“74.3.5.энэ хуулийн 74 дүгээр зүйлийн 74.3.4-т заасны дагуу нэг суудалд ногдох саналын хувьд хуваахдаа бутархай нарийвчлалтай гаргаж, эхний ээлжид бүхэл хэсэгт нь тэнцэх суудлыг хуваарилах, хэрэв хуваарилагдаагүй суудал үлдвэл хамгийн их үлдэгдэлтэйгээс нь эхлэн нэг нэгээр суудлыг нам, эвсэлд нэмж хуваарилах зарчмаар бүх суудлыг хуваарилж дуусгана.

Тайлбар: “хуваарилагдаагүй суудал” гэж энэ хуулийн 74.3.4-т заасны дагуу нам, эвслийн авсан саналын бүхэл хэсэгт нь ногдох суудал хуваарилахад суудал хуваарилагдаагүй үлдсэн, мөн нам, эвслийн авсан саналд ногдох суудлын тоо нь тухайн нам, эвслийн жагсаалтаар нэр дэвшигчийн тооноос их тооцогдсоны улмаас суудал хуваарилагдаагүй үлдэхийг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 10
Бүгд: 47
78.7 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1/4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг:

4.2.Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 18
Бүгд: 47
61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 11
Бүгд: 46
76.1 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 14 дүгээр зүйлийн 14.12 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 8
Бүгд: 46
82.6 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 8, 9 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8/30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг:

“30.1.Нам, эвсэл нь 78 хүртэл хүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойрогт, 48 хүртэл хүнийг нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаар тус тус нэр дэвшүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 12
Бүгд: 46
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1 дүгээр зүйлд нэмэх:

“30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг:

30.3.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 14
Бүгд: 41
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Д.Ганбат, Б.Энхбаяр нар үг хэлэв.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг:

42.1.Тойрог тус бүрд нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбартай байна. Сум, дүүргийн Засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос батлагдсан журмын дагуу нэгдсэн самбарыг бэлтгэж, байршуулах ажлыг зохион байгуулна. Нэгдсэн самбар дараах шаардлагыг хангасан байна:

42.1.1.энэ хуулийн 60 дугаар зүйлд заасныг үндэслэн зурагт хуудсыг байрлуулах дарааллыг тогтооно.

42.1.2.сонгуулийн сурталчилгааны нэгдсэн самбарыг үнэ төлбөргүй ашиглуулна.

42.1.3.нэгдсэн самбарт байрлуулах нэр дэвшигчийн зурагт хуудас нь нэг хэвлэлийн хуудасны дөрөвний нэг хэмжээтэй байна.

42.1.4.сонгогчийн тоонд үндэслэн суманд хоёр хүртэл, хороонд гурав хүртэл нэгдсэн самбар байрлуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 11
Бүгд: 41
73.2 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу 48.9 дэх хэсгийн “орохыг” гэснийг “орох, нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигч ухуулах байр ажиллуулахыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 12
Бүгд: 41
70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“50.2.Сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох аргачлал нь сонгуулийн зардлыг бууруулахад чиглэх бөгөөд сонгуулийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, өрхийн болон сонгогчийн тоо, энэ хуульд заасан бусад шаардлагад үндэслэнэ. Аргачлалыг төрийн аудитын дээд байгууллагын саналаар Сонгуулийн ерөнхий хороо батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 14
Бүгд: 41
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 13
Бүгд: 41
68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 14 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14/65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг:

65.6.Санал авах байранд ажиллаж байгаа итгэмжлэгдсэн ажилтан сонгогчийн гарын хурууны хээг сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбартай тулгаж, энэ хуулийн 66.5-д заасан бэхэн тэмдэглэгээ хийгдсэн эсэхийг нягтлан, зөрчилгүй бол сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 12
Бүгд: 41
70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 15 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“66.2.Сонгогч энэ хуулийн 59.4.2-т заасан хэсэгт нэг нам, эвсэлд саналаа өгнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 8

Бүгд: 41
80.5 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“66.5. Сонгогч саналаа тэмдэглэсэн саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийсний дараа тухайн сонгогч саналаа өгснийг илэрхийлэх бэхэн тэмдэглэгээг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу хийнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Төслийн 3 дугаар зүйлийн “5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “иргэн” гэсний дараа “гадаад улсад суугаа Монгол Улсын иргэн” гэж,” гэснийг, “20.1 дэх хэсгийн “шийдвэрлэх ажлыг” гэсний дараа “Сонгуулийн ерөнхий хорооны хяналт дор” гэж, “зохион байгуулж,” гэсний дараа “энэ хуульд заасан журмын хүрээнд” гэж, 20.5 дахь хэсгийн “холбогдох мэдээлэлтэй” гэсний дараа “болон байнга оршин суугаа хаягт бүртгэлтэй бусад сонгогчдын мэдээлэлтэй” гэж, 20.13 дахь хэсгийн “цахим хэлбэрээр” гэсний өмнө “санал авах өдрөөс 5 хоногийн өмнө 2 удаа” гэж,” гэснийг, “20.15 дахь хэсгийн “жагсаалтыг” гэсний дараа “хуульд зааснаас бусад тохиолдолд” гэж,” гэснийг, ““жагсаалт дахь” гэсний дараа “энэ хуулийн 20.5 дахь хэсэгт заасан” гэж, “буруу бүртгэгдсэн,” гэсний дараа “байнга оршин суугаа газрын хаягт нь бүртгэлгүй сонгогч нэмэгдсэн зэрэг асуудлаар” гэж,” гэснийг, “, мөн хэсгийн “нэвтрүүлнэ.” гэсний дараа “Сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний хуваарь, цагийг тэнцүү хэмжээнд тогтооно.” гэж,” гэснийг, “67 дугаар зүйлийн 67.14 дэх хэсэгт “67.13” гэсний өмнө “67.1” гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 8
Бүгд: 39
79.5 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “харилцах” гэсний өмнө “хороотой” гэж, “46 дугаар зүйлийн” гэсний өмнө “40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “Нэр дэвшигч нь” гэсний өмнө “Сонгуулийн тойрогт” гэж, “54 дүгээр зүйлийн” гэсний өмнө “51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийн “эвсэл болон” гэсний дараа “сонгуулийн тойрогт” гэж, ” гэж, “54 дүгээр зүйлийн 54.2 дахь” гэсний дараа “хэсгийн “эсхүл” гэсний дараа “сонгуулийн тойрогт” гэж,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 9
Бүгд: 39
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Төслийн 3 дугаар зүйлийн “14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “хороо” гэсний дараа” гэснийг “мөн зүйлийн 10.4 дэх хэсгийн “захиргааны байгууллага” гэсний дараа “, сум, дүүрэг” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “болон хэсгийн хороо” гэсний дараа” гэж, “50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсгийн” гэснийг “50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсгийн” гэж, “тойрогт болон жагсаалтаар” гэснийг “тойрогт” гэж, “тоо нь саналаа өгсөн нийт сонгогчийн” гэснийг “тоо нь тухайн хэсгийн хорооны хүлээн авсан саналын хуудасны” гэж, “, нам, эвсэл тэдгээрээс жагсаалтаар нэр дэвшигчийн санал тэмдэглэх хэсэгт нэгээс илүү нам, эвсэл болон жагсаалтаар нэр дэвшигчид нэгээс илүү санал тэмдэглэсэн” гэснийг “, нам, эвслийн санал тэмдэглэх хэсэгт нэгээс илүү нам, эвсэлд санал тэмдэглэсэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32

Татгалзсан: 7

Бүгд: 39

82.1 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “11 дүгээр зүйлийн” гэсний өмнө “10.1.14 дэх заалтын “46, 47, 48.9-д” гэснийг “46, 47 дугаар зүйл, 48.9, 48.10-д” гэж,” гэж, “13 дугаар зүйлийн” гэсний дараа “13.1 дэх хэсгийн “нутаг дэвсгэр, төвийг” гэснийг “нутаг дэвсгэрийг” гэж, мөн зүйлийн” гэж, “21 дүгээр зүйлийн” гэсний өмнө “20.15 дахь хэсгийн “хувилж олшруулах,” гэснийг “энэ хуульд зааснаас бусад тохиолдолд хэвлэж” гэж,” гэж, “21.1 дэх хэсгийн” гэсний дараа ““нутаг дэвсгэр, төвийг” гэснийг “нутаг дэвсгэрийг” гэж,” гэж, “39 дүгээр зүйлийн” гэсний өмнө “38 дугаар зүйлийн 38.7, 38.8, 38.12 дахь хэсгийн “26.3.6, 26.4.6” гэснийг “38.13” гэж,” гэж, “46.4 дэх хэсгийн” гэсний өмнө “зүйлийн 46.2 дахь хэсгийн “тогтоосон” гэснийг “баталсан” гэж,” “Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран” гэсний өмнө “журмыг” гэж, “Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн” гэсний өмнө “, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмыг” гэж, “60 дугаар зүйлийн” гэсний өмнө “58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсгийн “26.3.6, 26.4.6, 38.5” гэснийг “38.5, 38.13” гэж,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32

Татгалзсан: 7

Бүгд: 39

82.1 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө” гэснийг “цахим хэлбэрээр нэг удаа” гэж, “нам, эвсэл бүртгүүлснээс хойш ажлын 3 хоногт” гэснийг “болон санал авах өдрөөс 3 хоногийн өмнө тус тус цахим хэлбэрээр” гэж, “32.11 дэх хэсгийн “тав” гэснийг “долоо”” гэснийг “32.11 дэх хэсгийн “хүлээн авснаас хойш тав” гэснийг “хүлээн авах хугацаа дууссанаас хойш долоо”” гэж, “хугацаа” гэснийг “хуваарь, цагийг” гэж, “тэдгээрээс тойрогт болон жагсаалтаар нэр дэвшигч, бие даан” гэснийг “тэдгээрээс тойрогт нэр дэвшигч, бие даан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 9

Бүгд: 39

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “20 дугаар зүйлийн 20.11, 23.1, 24.1, 24.2, 24.3 дахь хэсгийн “14-өөс” гэснийг “16-аас” гэж, 20 дугаар зүйлийн 20.11 дэх хэсгийн “14-өөс доошгүй” гэснийг “5-аас доошгүй” гэж,” гэснийг, “42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн “аймгийн төв болон дүүргийн нэг хэсэгт 5, бусад хэсэгт 3-аас” гэж,” гэснийг, “50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсгийн “харгалзан Сонгуулийн ерөнхий хороо болон Монгол Улсын Ерөнхий аудитор хамтран батална.” гэснийг “үндэслэл болгоно.” гэж,” гэснийг, 5 дугаар зүйлийн “13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “, төвийг” гэснийг,” гэснийг, “29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгийн “ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд” гэснийг,” гэснийг, “54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “нам, эвсэлд, эсхүл нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш” гэснийг,” гэснийг, 6 дугаар зүйлийн “4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2, 12 дугаар зүйлийн 12.4, 14.12 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.15 дахь хэсэг” гэснийг, “50 дугаар зүйл, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг,” гэснийг, “, 65 дугаар зүйлийн 65.6 дахь заалтыг” гэснийг, “26.3.5,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

53.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “13 дугаар зүйлийн” гэсний өмнө “10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “улсын төсвөөс санхүүжих” гэснийг,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

54.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 11

Бүгд: 39

71.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 43 дахь заалт буюу 67¹ дугаар зүйлийн дугаарыг 66¹ болгож, 3 дугаар зүйлийн “10.4 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “, улсын хил хамгаалах байгууллага, батлан хамгаалах байгууллага, архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж,” гэснийг “10.4 дэх хэсгийн “дээд байгууллага” гэсний дараа “, батлан хамгаалах болон архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын хил хамгаалах” гэж,” гэж, “дагалдах хэрэглэл” гэснийг “дагалдах хэрэгсэл,” гэж, 5 дугаар зүйлийн “, 20.6.8” гэснийг “, 20.6.7, 20.6.8” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн “холбоотой өөрчлөлтийн” гэсний дараа “талаар” гэж, 7 дугаар зүйлийн “48 дугаар зүйлийн” гэсний өмнө “29 дүгээр зүйлийн 29.7, 29.8 дахь хэсгийн дугаарыг “29.8, 29.9” гэж,” гэж, мөн зүйлийн “48 дугаар зүйлийн” гэсний өмнө “30 дугаар зүйлийн 30.3, 30.4 дэх хэсгийн дугаарыг “30.4, 30.5” гэж,” гэж нэмж, 7 дугаар зүйлийн “12 дугаар

зүйлийн 12.5 дахь хэсгийн дугаарыг 12.4 гэж” гэснийг, “71 дүгээр зүйлийн “71.11, 71.12, 71.13, 71.14, 71.15, 71.16, 71.17, 71.18” дахь хэсгийн дугаарыг ““71.12, 71.13, 71.14, 71.15, 71.16, 71.17, 71.18, 71.19” гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 8
Бүгд: 40
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэн, Т.Доржханд, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Ж.Сүхбаатар нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн” гэсний дараах ““20-оос” гэснийг “30-аас” гэж” гэснийг ““20-оос” гэснийг “40-өөс” гэж” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, С.Одонтуяа, Х.Булгантуяа, Д.Сарангэрэл нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 21
Бүгд: 42
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “32.12 дахь хэсгийн “22” гэснийг “18” гэж,” гэснийг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 25
Бүгд: 42
40.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 14
Бүгд: 42
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг:

“60.1.Саналын хуудаст нам, эвслийн нэрийг Улсын Их Хурлын өмнөх сонгуульд авсан суудал, саналын тооны ихээс бага руу жагсааж, дарааллын дагуу бичнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 12
Бүгд: 40
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсгийн “хяналтын дэд хорооны” гэсний дараа “, Сонгогчдын нэрийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 5
Бүгд: 40
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 9
Бүгд: 40
77.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 7
Бүгд: 40
82.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “чиглэлээр” гэсний дараа “Сонгуулийн автоматжуулсан системийн тухай” гэж нэмж, мөн заалтын “12 дугаар сарын 31-ний” гэснийг “10 дугаар сарын 01-ний” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 3
Бүгд: 40
92.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, мөн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дотоодын зөвлөх Д.Номингэрэл, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх

Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, С.Ганбаатар, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.1.2.хүн амын эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах бол;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 16

Бүгд: 38

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 36.4 дэх хэсэг нэмэх:

“36.4.Энэ хуулийн 36.1.2-т заасны дагуу худалдан авах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 16

Бүгд: 38

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсгийн “, хөндлөнгийн” гэснийг хасаж, мөн зүйлийн 50.5, 50.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, үүнтэй уялдуулан 50.7, 50.8 дахь хэсгийг хасах:

“50.5.Үнэлгээний хорооны хараат бус гишүүнээр иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг сонгоно.

50.6. Үнэлгээний хороонд тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн хүнийг томилон ажиллуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Д.Эрдэнэбат, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, мөн газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны Хяналт зохицуулалтын албаны дарга П.Ганболд, Иргэний нисэхийн Үндэсний төвийн дарга Н.Батсайхан, мөн төвийн Захиргаа, хүний нөөцийн газрын менежер З.Туяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 18 цаг 43 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Д.Эрдэнэбат нар хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 18
Бүгд: 37
51.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Н.Ганибал нарын урилгаар Сүхбаатар аймгийн Наран сумын ерөнхий боловсролын сургуулийн 17 дахь төгсөлтийн төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбатын урилгаар Санхүү, Эдийн засгийн техникумын 1988 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Г.Тэмүүлэн нарын урилгаар Архангай аймгийн Хайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 1983 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Д.Өнөрболор, Ж.Эрдэнэбат нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ахмадын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар нарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн урилгаар Баянзүрх дүүргийн 22 дугаар хорооны ахмадууд, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын урилгаар “Ханжин транс” ХХК-ийн ажилчид, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын урилгаар Ховд аймгийн сумдын багийн Засаг дарга болон Тамгын газрын дарга нар, Нийслэлийн ерөнхий боловсролын “Монгени”, “Гэрэлт ирээдүй” сургуулийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 06 дугаар сарын 07-ны өдөр төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, мэндчилгээ дэвшүүлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 59 минут үргэлжилж, 73 гишүүнээс 57 гишүүн хүрэлцэн ирж, 78.1 хувийн ирцтэйгээр 19 цаг 14 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 08 минут

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирц бүрдсэн байна. Ингээд Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 14 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 2 дугаар дүгнэлт

2 дугаарт Монгол Улсын Цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлт

3 дугаарт Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр зээлийн төлөвлөгөөг соёрхон батлах тухай хуулийн төсөл. Засгийн газраас өргөн мэдүүлсэн.

4 дүгээрт Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл соёрхон батална. Соёрхон батлах тухай учраас нийт гишүүдийн олонхоор батална гэдгийг бас сануулаад хэлчихье.

5 дугаарт Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэгдсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын

тогтоолын төслүүд анхны хэлэлцүүлгийг явуулна. 62 саналтай.

6 дугаарт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

7 дугаарт Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

8 дугаарт өнөөдөр Сонгуулийн хуулийг хэлэлцээд л таарна л даа. Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна.

9 дүгээрт. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд хэлэлцэх эсэх асуудлыг 9 дүгээрт хэлэлцэнэ.

10 дугаарт Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд

11 Хүний эмийн чанар хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл нийлүүлэлтийн асуудлаар Монгол Улсын эмийн хяналт шалгалтыг сайжруулах эсхүл хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй байлгах талаарх саналыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Хяналт шалгалтын түр хорооны явцын тайлан.

12 Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

13 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

14 Гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ ээ.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орно.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ. Ажлын хэсгийг оруулъя. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Цагааны Нанзаддорж танилцуулна.

Ц.Нанзаддорж: Монгол Улсын Их Хурлын дарга Эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 5 сарын 3-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг уншиж сонсгоё.

Монгол Улсын шүүхийн тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.Туулхүү, Ц.Нанзаддорж, Г.Баясгалан, Д.Гангабаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн

Ариунболд, П.Ундрах-Эрдэнэ болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нар оролцов.

Уг хуралдаанаар Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а, 25.7.5.б дэх дэд заалт, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1, 123.2.3 дахь заалт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.3 дахь заалт, мөн хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1, 172.2.2, 172.2.3 дахь заалт, 173 дугаар зүйлийн 173.4 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 14 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 1, 48 дугаар зүйлийн 1, 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 50 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, мөн зүйлийн 2, 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Үндэслэл.

1.Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 1 сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэгт Улсын дээд шүүх давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл журмын дагуу хянан үзэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангана гэж заасан бөгөөд мөн зүйлийн 25.7.5 дахь заалтад Улсын Дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах тохиолдолд хяналтын журмаар хянан хэлэлцэж шийдвэрлэх гээд 25.7.5.а дэд заалтад анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, 25.7.5.б дэд заалтад хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн, 25.7.5.в дэд

заалтад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэж хуульчлан хяналтын шатны шүүхийн чиг үүргийн зорилтыг тодорхойлж, хяналтын журмаар хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тохиолдол гэж заажээ.

Улмаар дээрх хуульд нийцүүлэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан нь хууль тогтоогчийн бүрэн эрхэд хамаарч байна.

2.Улсын Дээд шүүхээс доод шатны шүүхийн шийдвэрийг анхан болон давж заалдах шатын шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн тохиолдолд хянан шийдвэрлэхээр хуульчилсан нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгыг бүрэн хангаагүй, хэргийн оролцогчдын хяналтын шатны шүүхэд хандах боломжийг хязгаарласан байна.

Тодруулбал, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг алдагдуулсан бусад тохиолдлуудыг Улсын Дээд шүүх хянах боломжгүй болгон явцууруулж хуульчилсан нь Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийг хөндсөн байна. И

Иймд Монгол Улсын Шүүхийн тухай хууль болон Эрүү, Иргэн, Захиргааны процессын хууль хоорондын уялдааг хангах хүрээнд шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хязгаарласан эрх зүйн хийдлийг арилгах шаардлагатай байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн

31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

1.Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а дэд заалтад анхан болон давж заалдах шатын шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, 25.7.5.б заалтад хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр хэлж тайлбарлаж хэрэглэсэн, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1 дэх заалтад Анхан болон давж заалдах шатын шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, 123.2.3 дахь заалтад шүүх хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад Анхан болон давж заалдах шатын шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, 1.3 дахь заалтад шүүх хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн, Мөн хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зөрүүтэй хэрэглэсэн эсэх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1 дэх заалтад Анхан болон Давж заалдах шатын шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, 172.2.3 дахь заалтад шүүх хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх заалтад Монгол Улсын иргэн шударга шүүхээр шүүлгэх эрхтэй гэж заасанд нийцээгүй байна.

2.Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а, 25.7.5.б дэд заалт, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1, 123.2.3 дахь заалт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр заалтын 1 дэх хэсгийн 1.1, 1.3 дахь заалт, мөн хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай

хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1, 172.2.2, 172.2.3 дахь заалт, Мөн хуулийн 173 дугаар зүйлийн 173.4 дэх хэсэг нь иргэдийн мэдээлэлд дурдсан Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

3.Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а дэд заалтад Анхан шат болон давж заалдах шатын шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, 25.7.5.б дэд заалтад хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1 дэх заалтад Анхан болон давж заалдах шатын шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, 123.2.3 дахь заалт, Шүүх хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад Анхан болон давж заалдах шатын шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, 1.3 дахь заалтад шүүх хуулийг Улсын Дээд Шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн, Мөн хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг зөрүүтэй хэрэглэсэн эсэх, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1 заалтад Анхан болон давж заалдах шатын шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, 172.2.3 дахь заалтад Шүүх хуулийг Улсын Дээд Шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн гэж тус тус заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч Одбаяр, гишүүд Туулхүү, Нанзаддорж, Баясгалан, Гангабаатар гэжээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хороон дарга Баттөмөрийн Энхбаяр танилцуулна аа. Индэрт урьж байна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ, Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг 2023 оны 5 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан журмын дагуу 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийн агуулгыг танилцуулсан болно.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа Үндсэн хуульд заасны дагуу хүн бүр өөрийн эрх нь зөрчигдсөн гэж үзвэл уг эрхээ сэргээлгэхээр анхан, давж заалдах, хяналтын шатын шүүхэд ханддаг байх нь зүй ёсны асуудал бөгөөд гомдол гаргасан хүн шүүхийн шийдвэр хэрхэн

гарахаас үл хамааран шүүхийн бүх шатад хандаж асуудлаа шударгаар эцэслэн шийдвэрлүүлсэн гэсэн итгэл үнэмшилтэй үлдэх нь чухлыг онцлоод, хүний эрхийн асуудал дээр онцгой мэдрэмжтэй хандах ёстой талаар, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар хяналтын шатын шүүх хяналтын журмаар гомдлын дагуу хэргийг хянан хэлэлцээд давж заалдах шатын шүүхийн шийдвэрийн хэдэн хувийг өөрчилж шийдвэрлэсэн статистик судалгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбат нэг асуудлаар шат шатны шүүхээс өөр шийдвэр гаргадаг талаар, Улсын Их Хурлын гишүүн Дэлгэрсайхан Хяналтын шатны шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэх үндэслэл шалгуурын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн авах нь зүйтэй талаар дурдаад, хуулийн байгууллага мөрдөж байгаа хэргийн талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж байгаа нь шүүхэд хөндлөнгөөс нөлөөлж байгаа хэрэг мөн эсэх, ингэснээр хэлмэгдүүлэх нөхцөл бүрдэж болзошгүй учир хүний эрхтэй холбоотой асуудал дээр мэдрэмжтэй хандах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд шат шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах шаардлага үүсэж байгаа тул холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбат шат шатны шүүхүүд хуулийн нэгдмэл хэрэглээнд алдаа гаргаж байж болзошгүй талаар тус тус үг хэлсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а дэд заалтад Анхан болон давж заалдах шатын шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, 25.7.5.б дэд заалтад хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж

хэрэглэсэн, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1 дэх заалтад Анхан болон давж заалдах шатын шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, 123.2.3 дахь заалтад шүүх хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад Анхан болон давж заалдах шатын шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн. Мөн хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зөрүүтэй хэрэглэсэн эсэх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1.1 дэх заалтад Анхан болон давж заалдах шатын шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, 172.2.3 дахь заалтад Шүүх хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн шударга шүүхээр шүүлгэх эрхтэй гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 2 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Раднаасэд, Бөхчулууны Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Цэндийн Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа. Өөр алга. Шатарбалын Раднаасэд гишүүн асуулт асууна.

Ш.Раднаасэд: Энэ шүүхийн хууль харахад энгийн хүмүүст бол нэг их юу биш байх ач холбогдолтой биш байх. Одоо ингээд Цэцээс шийдвэр гараад

энийг хүлээж авахаар хяналтын горь журмаар шүүхэд хандаад мөрдөж байгаа. Хуулийн дагуу хэлэлцэгдээгүй орхигдсон хүмүүсийн асуудал яах вэ нэг шударга шүүхээр шүүлгэх эрх чинь зөрчигдчихөөд байна шүү дээ. Анх энэ хууль явж байх үед бас хэлж байсан. Анх төсөл явж байх үед ажлын хэсэг дээр ч санал хэлсэн, Байнгын хороон дээр ч хэлж байсан. Энэ том хийдлээс болоод нэлээдгүй хүн эд хөрөнгө, амь нас, бусад олон зүйлээрээ шүүхээр шүүлгэх боломжгүй байж хохирч байгаа ийм юм үүсэж байгаа. Энийг хүлээж аваад нэмэлт, өөрчлөлт хийлээ гэхэд тэр хуулийг яах вэ энэ хугацаанд байсан тэр хүмүүсийн асуудал буцаан хэрэглэх үү, үгүй юу гэж.

2 дугаарт би энэ цэцээс асуулт асууж болохгүй байна. Хуулиар нэг зүйлийг ерөөсөө ойлгохгүй байгаа. Өчигдөр Байнгын хороо дээр бас хэлсэн. Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэсэн мөртөө ийм ийм хуулийн энэ заалтуудыг түдгэлзүүлсүгэй гээд ингээд зогсоогоод хаячихсан. Энэ өмнө нь ийм жишиг би ер нь ерөөсөө огт харж байгаагүй байхгүй юу. Үндсэн хууль зөрчөөгүй. Гэхдээ энэ заалтыг түдгэлзүүл. Энэ хэнд таалагдах гэж ийм заалт бичиж ийм шийдвэр гаргав гэдэг. Нийцсэн, нийцээгүй, зөрчсөн, зөрчөөгүй гэдэг л 2 төрлийн юм гарах ёстой. Тэгээд энэ түдгэлзүүлчихээр чинь зөрчсөн ч юм шиг. Тэгээд энэ дээд талыг нь харахаар 2 дугаар хэсгийг нь харахаар зөрчөөгүй ч юм шиг. Өөрөөр биччихсэн байгаа байхгүй юу. Энэ хожмын өдөр энэ Үндсэн хууль зөрчсөн эсэх албан тушаалтнуудын асуудал дээр ч гарч ирнэ шүү. Яг ийм жишигээрээ бол.

Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч Үндсэн хууль зөрчөөгүй байна. Гэхдээ энэ огцуулах асуудлыг хэлэлцэх нь зүйтэй ч гэдэг юм уу нэг ийм юм Ерөнхий сайд, Их Хурлын дарга, Их Хурлын гишүүд Үндсэн хууль зөрчөөгүй байна гэсэн нэг ийм сонин жишиг л үлдээчих шиг болох юм. Энэ бичмэл байдлаас нь харахад. Энэ

чинь хүчээр хууль тогтоох эрх мэдэл рүү халдаж байгаа байхгүй юу Цэц бол. Зөрчөөгүй байна, гэхдээ энийг түдгэлзүүлсэн. Түдгэлзүүлснийг хүлээж авсан бол Их Хурал заавал засах ёстой. Энэ чинь чиглүүлэгч болчхоод байна шүү дээ. Энэ цэцийн шийдвэр чинь. Хүссэн, хүсээгүй энэ 3 хууль дээр өөрчлөлт хийхээс өөр аргагүй байдалд авааччихаж байгаа байхгүй юу. Тэгээд энэ байдлаар яваад байх уу. Энэ бас сонин. Энэ цэцийнхнээс би юм асуух хуулийн заалтгүй учраас хэцүү болчхоод байна л даа. Энэ ийм асуулт ч биш юм даа. Нэг иймэрхүү санал л байна даа.

Түрүүний тэр юуг мэдээж төлөөлөгчөөр явсан Энхбаяр гишүүн хариулах байлгүй.

Г.Занданиатар: Байнгын хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Хууль бол буцаж үйлчлэхгүй 1 дүгээр асуудал.

2 дахь асуудал бол Үндсэн хуулийн цэцэд энэ Шүүхийн хуулийн буюу Улсын дээд шүүхийн хэрэг хяналтын журмаар хянан шийдвэрлэх 3 үндэслэлийн 3 дахь үндэслэл бол Үндсэн хууль зөрчөөгүй байна гэдэг дүгнэлт гарч байгаа юм. Эхний 2 нь болохоор Үндсэн хууль зөрчсөн байна гэдэг дүгнэлт гаргаагүй. Сая Раднаасэд гишүүн хэлж байна. Уг нь бол манай Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулийн цэц бол хууль тогтоомж Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргадаг ийм байгууллага байгаад байгаа юм. Энэ дүгнэлт болохоор зөрчсөн гэдэг дүгнэлт гараагүй шууд. Энэ нь болохоор үндэслэл хэсэг дээрээ бас харагдаж байгаа. Үндэслэл хэсгийн 2-т хууль хэрэглээний нэгдмэл байдлыг алдагдуулсан бусад тохиолдлуудыг Улсын дээд шүүх хянах боломжгүй болгон явцууруулж хуульчилсан гэдэг ийм үндэслэл биччихсэн байгаа юм. Өөрөөр хэлбэл энийгээ нэг жсоохон өргөтгөөч ээ

гэсэн санаа. Тэрнээс биш энэ хязгаарлаж байгаа нь бол Үндсэн хууль зөрчсөн гэж бол хэлээгүй байгаад байгаа байхгүй юу. Яг энэ үндэслэлийнхээ агуулгаар би бол энэ нийцээгүй байна гэдэг томъёолол Цэц хэрэглэсэн юм байна гэж ойлгож байгаа юм. Үндсэн хуулийн цэц дээр Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож мэтгэлцээний шатад оролцчих явцад Цэцэд өргөдөл гаргасан иргэнээс, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч миний биеэс, мөн Үндсэн хуулийн цэцийн гишүүдээс мэтгэлцээний шатад Дээд шүүх ямар үндэслэлээр энэ бусад боломжуудыг өргөтгөх боломжтой вэ гэдэг асуудлаар ямар нэгэн мэтгэлцээн өрнөөгүй. Энэ дээр цэц дээр ямар нэгэн мэтгэлцээн яригдаагүй. Гомдол гаргаж байгаа иргэн тухайлбал өшөө нэмээд ийм үндэслэлийг бичээч гэдэг асуудал ерөөсөө тавиагүй. Их хурал ч тавиагүй, Цэц өөрөө тавиагүй. Тэгсэн мөртөө ер нь нэг арай өргөтгөчхөөч ээ гэж байгаа байхгүй юу. Санаа нь. Цэцийн шийдвэр нь. Тийм учраас ч Үндсэн хуулийн институцийн хувьд Цэц ч тэр, Улсын Их Хурал ч тэр харилцан бие биедээ бас хүндэтгэлтэй хандах энэ зарчмыг баримтлах агуулгаар өчигдөр манай Хууль зүйн байнгын хороо ярилцаад энэ цэцийн дүгнэлтийг бол хүлээж авъя. Хүлээж аваад хэдийгээр Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт яг ийм ийм байдлаар өргөтгөөч гэж хэлж өгөөгүй ч гэсэн Улсын Дээд шүүхээс бид бас санал авсан байгаа. Тодорхой үндэслэл бас нэмж, өргөтгөх боломж бол бас байгаа юм байна гэж үзээд Улсын Дээд шүүхээс саналыг нь авчихсан байгаа. Тэгээд хүлээж аваад Дээд шүүхийн саналын дагуу ярилцаж байгаад бас хууль тогтоомжоо боловсронгуй болгочихъё гэдэг ийм байр суурь дээр Хууль зүйн байнгын хороо хүлээж авах шийдвэрийг гаргасан байгаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь, Наянтайн Ганибал нарын урилгаар Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын

сургуулийн 1993 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Раднаасэд гишүүн ээ, Баттөмөрийн Энхбаяр дарга аа, та хэд энэ Үндсэн хуулийн цэцийн тогтоол батлагдсан тохиолдолд өнөөдөр ч юм уу яаралтай хуралдаад энэ асуудлаа бас ажлын хэсэг байгуулж энийг нэг хянан тохиолдуулах нь зүйтэй, хэлэлцэх нь зүйтэй. Цайны цагаар 13 цагаас өнөөдөр Хууль зүйн байнгын хороо хуралдаарай. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байгаа. Би хоёрхон жишээ дээр та бүхэнд бас нэг мэдээлэл өгье гэж бодож байна. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар банкны зээлээс 1 хувийн шимтгэл авч байгааг иргэний хэргийн анхан шатын шүүхэд гомдол гаргасан. Түүнийг нь иргэний хэргийн давж заалдах шатын шүүх хэвээр шийдвэрлэсэн. Тийм учраас Дээд шүүхийн Иргэний танхим хууль хэрэглээний асуудал байхгүй байна гээд энийг танхим хүлээж аваагүй. Үүнийх нь дагуу Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрынхан акт тавиад, торгуулийн акт тавьсан боловч тэрийг нь банкнууд эсэргүүцэж Захиргааны хэргийн анхан шатын шүүхэд өгсөн. Захиргааны хэргийн анхан шатын шүүх энэ торгуулийн акт бол үндэслэлгүй байна гэж шийдвэр гаргасан байгаа юм. Тэрийг нь давж заалдах шатын шүүх нь бас хэвээр баталсан. Тийм учраас Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим энэ гомдлыг хүлээж аваагүй. Хууль хэрэглээний хувьд асуудал байхгүй байна гээд. Тэгэхээр 1 нь болохоор зээл дээр шимтгэл тавьж байгаа болохгүй байна гэдэг, нөгөөдөх нь тэрний дагуу тогтоол тавихаар бас болохгүй байна гээд, торгууль тавихаар болохгүй байна гэгчхээ байгаа юм. Тэгэхээр ийм асуудал дээр түүнийг

тодорхой хэмжээгээр шийдэх зайлиггүй шаардлага, өөрөөр хэлбэл тэр аль нэгэн талд нь шийдвэрлэх тэр зүйлийг Дээд шүүх зайлиггүй шийдвэрлэх ёстой байхгүй юу даа. 2 дахь жишээ Баянгол дүүргийн шүүх барилгын метр квадратыг тооцохдоо барилгын дотроор нь хэмжинэ гээд гаргачихлаа. Тэгээд түүнийг нь давж заалдах шатын шүүх нь хэвээр нь баталчихлаа. Тэгэнгүүт хууль хэрэглээний асуудал байхгүй учраас Дээд шүүхийн Иргэний танхим энэ асуудлаар хүлээж авахгүй болчихож байгаа юм. Гэтэл Хан-Уул дүүргийн шүүх барилгыг ойсоор нь хэмжиж квадрат метрийг нь тогтооно гээд шийдвэр гаргангуут тэрийг нь Хан-Уул дүүргийн давж заалдах шатны шүүх нь бас хэвээр нь үлдээгээд, тэр нь Дээд шүүх дээрээ хүлээж авахгүйгээр болчихож байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 2 өөр шийдвэр 2 өөр шүүх дээр гараад ингээд явсан энэ асуудлыг зайлиггүй Дээд шүүх 1 талд нь шийдвэрлэж өгөх шаардлага гараад байгаа байхгүй юу даа. Тэгэхээр олон олон жишээнүүд байгаа. Тийм учраас энэ иргэдийн шүүхээр шийдүүлэх тэр эрхийг энэ хууль хэрэглээний асуудал байхгүй байна гэдгээр Дээд шүүх хүлээж авахгүй байх нь бол тэр иргэдийн эрхэд халдаж байгаа ноцтой үйлдэл мөн байна гэж үзэж байгаа. Тийм учраас энэ Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй гэж Их Хурлын гишүүддээ зөвлөмөөр байна. Тэгээд хэрвээ энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй гэж Их Хурлын гишүүддээ зөвлөмөөр байна. Тэгээд хэрвээ энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах юм бол яг энэ асуудлаар бас тодорхой хуулийн заалтыг өөрчлөх зайлиггүй шаардлага гарна. Энэ ажлын хэсэгт би орж ажилламаар байна гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр дарга хариулъя.

Б.Энхбаяр: Шүүхийн шинэчлэлийг яг 2 жил 5 сарын өмнө Шүүхийн хууль батлагдаж байсан. Энэ шинэчлэл дээр

бол парламент дахь бүх улс төрийн намууд санал нэгтэйгээр энэ зарчим дээр нэгдэж, энэ шинэчлэлийг хийж байсан. Энэ шинэчлэлийн гол амин сүнсний 1 нь Монгол Улсын Дээд шүүх бүх хэрэг маргааныг хяналтын журмаар шийдвэрлэдгийг хязгаарласан энэ зохицуулалт байсан. Энэ үед бол судалгаа хийж, парламентын судалгааны хүрээлэн бас нэлээн олон судалгааны хүрээлэн хийж Дэлхийн бусад улс орнуудын Дээд шүүхүүд ингэж манайх шиг бүх хэргээ хянадаг юм уу, үгүй юм уу гэдэг дээр судалгаа хийж үзэхэд манайх шиг ийм бүх хэргээ хянадаг Дээд шүүхтэй улс байгаагүй. Дээд шүүх бүх хэрэг маргааныг хянан шийдвэрлээд ердийн байдлаар ингээд хянаад байхаар юу болоод байсан гэхээр ерөөсөө шүүх гэдэг энэ дээд шүүх эцсийг нь хүртэл нь энд очиж байж л шийдвэрээ гаргуулдаг. Анхан шатын шүүхийн шийдвэрийг ерөөсөө шүүхийн шийдвэр гэж үздэггүй, шүүх гэж тоодоггүй ийм байдалтай болчихсон. Шүүхийн зардал ихэсдэг, цаг хугацаа явдаг. Монгол банкнаас Улсын Их Хуралд танилцуулсан Мөнгөний бодлогын талаарх баримт бичигт зааснаар эдийн засгийн өсөлт, банкны хүү өндөр байгаагаас шалтгаалж байгаа 1 хүчин зүйл бол энэ шүүхээр хэрэг маргаан удаан шийдвэрлэхтэй холбоотой байна гэж үзэж байсан. Бизнесийн дундаж маргаан шүүхээр 4 жил явж байна. Шүүхийн шийдвэр нь гараад хохирлоо барагдуулах дээр мөн удаан хугацаа зарцуулж байна. Ингээд 4-6 жилийн хугацаанд хөрөнгөө барьцаалж зээл авсан маргаан, иргэд хоорондын маргаан явдаг ийм удаан процессстой улсад хөрөнгө оруулалт оруулах, нөгөө зээлийн хүү бага байх, эрсдэл бага байх гэсэн ийм бусад хүчин зүйлүүд нөлөөлж байгаа тухай яригдсан. Бусад улс орны шүүхүүд дээр бас нэг яригдсан асуудал бол шүүхийн бие даасан хараат бус байдал гэдэг бол шүүх шүүхээсээ өөрөө шүүгч шүүгчээсээ хараат бус байх тухай ойлголтыг бас багтааж ойлгоод байдаг. Бүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар Улсын дээд шүүх нь доод шатны

шүүхүүдээ удирддаг, чиглүүлдэг, нөлөөлдөг ийм нөлөөллийн хэрэгсэл болж хувирсан байна гэдэг дүгнэлт гарсан. Хэрэв энэ хүссэн байдлаар нь шийдэхгүй бол чиний шийдвэрийг чинь Дээд шүүх дээр би өөрөө татаж авчирч хянаж байгаад өөрчилчихнө гэдэг байдлаар дарга шүүхийн тогтолцоо манай улсад бүрдэхэд нөлөөлсөн байна гэж үзсэн.

Тийм ч учраас энэ шүүхийн дотоод дахь хараат бус байдлыг арилгах, бусад улс оронд байдаг шүүх хэрэглээний нэгдмэл байдлыг шүүх систем дотор хангах, эрх зүйг хөгжүүлэх онолын болон бусад чиг үүргээ Улсын Дээд шүүх хэрэгжүүлдэг байх ёстой гэдэг агуулгаар энэ өөрчлөлт хийгдсэн. Энэ бол зөв, зүйтэй өөрчлөлт болсон гэдгийг Улсын Дээд шүүх, Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн дүгнэлтдээ мөн өөрсдөө албан ёсоор нотолсон байдаг. Өөрөөр хэлбэл энэ шинэчлэл бол зөв, зүйтэй шинэчлэл мөн гэдгийг Улсын Дээд шүүх ч нотолж байгаа. Өчигдөр Байнгын хорооны хурал дээр мөн нотолсон. Нийт шүүгчдийнхээ хурал дээр. Тийм учраас энийг бол боловсронгуй болгоод, хүлээж аваад, жоохон өргөтгөөд ингээд явъя гэдэг ийм Дээд шүүхийн зарчмын байр суурьтай.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуулт асууна.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа 2 асуулт ч гэх юм уу даа. Асуудал байна. Энэ байна шүү дээ их ноцтой юм болоод байгаа юм биш үү гишүүд ээ. Энэ энэ дээр жоохон анхааралтай, тал талаасаа харж ярилцахгүй бол Үндсэн хууль зөрчөөгүй байна гэж хэлчхээд, зөрчөөгүй заалтыг түдгэлзүүлчхээж байна шүү дээ. Тэгээд түдгэлзүүлснийг нь Энхбаяр гишүүн ээ, бид нар хүлээн зөвшөөрчих юм бол таны саяын яриад байгаа юм чинь яг эсрэгээрээ болчих байхгүй юу. Хяналтын шатны шүүхээр бүх асуудал орж байх ёстой юм байна. Бүх маргаан хяналтын шатаар шийдвэрлэгдэж байх ёстой юм байна. Тэгж байж Үндсэн хуульд заасан

шударга шүүхээр шүүлгэнэ гэдэг эрх хэрэгжих юм байна гэдэг цаад далд утгатай санааг чинь наад цэцийн дүгнэлт чинь гаргачхаад байна шүү дээ. Тэгэхээр наадах чинь бол бид нарын шүүхийн хуулийг боловсруулж хийсэн таны яриад, бид нарын дэмжээд, Дээд шүүхтэйгээ хэрэгжүүлээд явж байгаа энэ түүхийн реформын үндсэн гол санааг чинь аажим аажмаар устгах гэж байна. Байхгүй болгох гэж байна.

Нэгэнт Үндсэн хуультай зөрчөөгүй ч гэсэн түдгэлзүүлчихсэн энийгээ зас гэж хэлж л байгаа бол наадах чинь Үндсэн хууль зөрчиж байна л гэж хэлж байгаатай бүр ямар ч ялгаа байхгүй. 1 дүгээрт Энхбаяр гишүүн ээ. Тэгээд бид нар юу гэдэг юм Дээд шүүхтэй яриад ганц нэг засвар хийчихлээ гэхэд наадах чинь дахиад асуудал орж ирээд дахиад Үндсэн хууль зөрчсөн гэдэг заалтаараа л яваад өгнө өө 1 дүгээрт.

2 дугаарт энэ байна шүү дээ Үндсэн хуулийн 64.1 дээр цэц яг юу хийх ёстой вэ гэдэг чинь аягүй тодорхой заачихсан байгаа шүү дээ. Үндсэн хууль зөрчсөн эсэхийг л тогтоох ёстой байхгүй юу. Зөрчсөн гэдэг үг л энд дүгнэлтэд орох ёстой. Тэрнээс биш нийцсэн, нийцээгүй гэдэг чинь нийцэх, зөрчих 2 чинь зарчмын ялгаатай 2 заалт биз дээ. Зарчмын ялгаатай. Зөрчинө гэдэг чинь бол бүр ингээд 100 хувь үзэл санааных нь эсрэг явчихсан юм. Нийцээгүй гэдэг чинь үзэл санаатай нийцэж байна, заалттай нийцэж байна. Тэгэхдээ үзэл санаатай нийцээгүй байна ч гэдэг юм уу арай өөр хэлбэрээр яриад байна шүү дээ. Тийм ээ. Тэгээд нийцээгүй гэж хэлчхээд тэгсэн мөртөө зөрчөөгүй, тэгсэн мөртөө түдгэлзүүл гэдэг чинь ямар эрх зүйн үр дагавар гарах вэ та бодоод үз дээ. Тэгэхээр Цэц ингээж хуулийн хийдлийг шалгадаг энэ хууль хийдэлтэй байна. Энэ хууль хоорондоо нийцээгүй байна. Энийг янзал, зас гэдэг нэг байгууллагын хуулийн хэлтэс шиг ажиллах, Улсын Их Хурлын хууль тогтоох эрхэд халдах энэ эрх хаанаас олоод авчхав. Энийгээ нэгмөсөн

цэгцэлж авах ёстой юм биш үү. Би бол энэ их л эргэлзээтэй дүгнэлт гарсан байна. Манай Хууль зүйн байнгын хорооны дүгнэлт ч гэсэн эргэлзээтэй байна. Энийг хүлээж авах. Яг юу бодож Цэц энэ дүгнэлт гаргачхав аа. Зөрчөөгүй гэж хэлсэн мөртөө нийцээгүй гэж хэлээд, тэгсэн мөртөө зөрчөөгүй юмыг түдгэлзүүлчхэж байгаа ямар хууль баримтлаад Цэц чинь хуулиа баримталж л явах ёстой шүү дээ. Шүүхийн л байгууллага юм чинь. Энэ дээр уг нь Цэцээс л тодруулга авмаар байгаа байхгүй юу. Цэц шийдвэр гаргачхаад байхад гаргасан хүнээс нь бид нар тайлбар авахгүй, гаргаагүй хүнээс тайлбар аваад суугаад байдаг ийм утгагүй зохицуулалттай болчихоод байгаа байхгүй юу Их Хурлын дарга аа.

Дээр нь тэр Пүрэвдорж гишүүний яриад байгаа саяын 2 жишээ бол энэ чинь яг л бид нар хуульд биччихсэн байгаа шүү дээ. Анхан болон давж заалдах шатын шүүхийн хууль хэрэглээний зөрөөг арилгах гэдэг чинь яг л тэр асуудал орчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр заавал анхан, давж заалдах 2 нь 2 өөр гаргаж байж хэрэглээний зөрүү арилгах тухай асуудал биш шүү дээ.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуултад хариулна. Хууль зүйн байнгын хорооны дарга.

Б.Энхбаяр: Би бол яг Мөнх-Оргил гишүүнтэй бүр дотор нь орчихсон юм шиг адилхан бодолтой байгаа юм. Яг адилхан үзэл бодолтой. Яг ийм олон асуултуудтай бас байгаад байгаа юм.

1 дүгээрт Цэцэд Мөнх-Оргил гишүүн маань Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн ажлын хэсгийг бас ахалж байгаа. Энэ цэцийн процессыг их боловсронгуй болгох шаардлагыг улам нотолж байгаа юм. Жишээлбэл энэ дүгнэлт. Нөгөө талаар ер нь цэцийн гишүүнд тавигдах энэ жоохон академик жоохон чиглэлийн хүмүүс,

академик гэдэг нь би жоохон хууль зүйн өндөр мэргэшлийг яриад байгаа юм тавьдаг байхгүй бол ер нь жоохон ном уншдаггүй, хар практикаар явчихсан хүмүүсийг Цэцэд хэт олон оруулаад байвал цэцийн шийдвэрүүд яг энэ өнөөдрийнх ишг ингэж гарна. Яагаад гэхээр ийм том зарчмын асуудал дээр гарч байгаа Цэцийн шийдвэрийн үндэслэл хэсэг нь ердөө ийм тал хуудас юм байгаа юм. Ерөөсөө ийм үндэслэл хэсэг шүү дээ. Яагаад гэдэг Мөнх-Оргил гишүүний энэ асуугаад байгаа асуултыг бид үндэслэл хэсгээс л уншина. Шийдвэрийнх нь. Энэ үндэслэл хэсэг нь болохоор ердөө ийм тал юм байгаа байхгүй юу. Яг яагаад, ямар учраас, яагаад гэдэг асуултуудаа бичсэн эсэх нь. Тэр нь болохоор юу байна вэ гэхээр яг Мөнх-Оргил гишүүний асуугаад байгаа ингэж байгаа байхгүй юу.

Шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хязгаарласан эрх зүйн хийдлийг арилгах шаардлагатай байна гэж. Тэгээд яг юуг нь яаж арилга гээд байгаа юм. Ямар болчихсон учраас нийцээгүй гээд байгаа юм гээд, юуг нь яаж боловсронгуй болго гээд байгаа юм. Судалгаа байхгүй, онол байхгүй, тайлбар байхгүй. Тэгэхээр яг Мөнх-Оргил гишүүнтэй адилхан би бол ингээд тааж бас уншаад байгаа байхгүй юу. Энэ ингэж л бодсон юм байх даа л гэж байгаа болохоос биш яг ингэж бодсон учраас гэдэг тэр юм нь энэ Цэцийн шийдвэрт байхгүй байгаад байгаа юм.

Тийм учраас жишээлбэл энэ Цэцийн шийдвэр бол үндэслэл хэсэг нь бол нэг иймэрхүү байхад, бидний дараагийн хэлэлцэх гэж байгаа 03 тоот шийдвэрийн үндэслэл хэсэг 3 хуудас юм байгаа байхгүй юу. 7 үндэслэл бичээд 3 хуудас үндэслэл хэсэг биччихсэн. Тэрийг уншихаар бол Цэц ингэж бодож үндэслэлээ тодорхойлж, шийдвэрээ гаргасан юм байна гэдгийг уншихаар ойлгоод байгаа юм. Энийг уншихаар ойлгохгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ нь өөрөө бас нөгөө тухайн асуудлыг оруулж байгаа байдаг юм уу,

гаргаж байгаа байдаг юм уу энэ Цэцийн гишүүдийн өөрсдийнх нь би бол академик, шинжлэх ухаанч байдалтай нь холбогдож байна гэж шуудхан хэлэхэд дүгнээд байгаа юм. Мөнх-Оргил гишүүнтэй бол би нөгөө сая хэлээд байна шүү дээ. Зөрчсөн гэж хэлээгүй мөртөө хуулиа боловсронгуй болго гэж хэлээд түдгэлзүүлж байгаа юм. Түдгэлзүүлэхдээ болохоор 2023 оны 12 сарын 15-ны өдрөөс гэж байгаа юм. Ирээдүй цаг дээр тавьж түдгэлзүүлж байгаа. Энэ бол сүүлийн 30 жилийн хугацаан дахь Үндсэн хуулийн цэцийн ирээдүй цаг дээр тавьж хууль түдгэлзүүлж байгаа 2 дахь шийдвэр юм байна лээ. 2 дахь. Мөн ийм урт хугацааны бас боломж олгож гаргаж байгаа анхны шийдвэр юм байна лээ Цэцийн хувьд.

Тэрнээс биш Цэцийн шийдвэр бол гаргасан өдрөөсөө түдгэлздэг байхгүй юу уг нь бол гэх мэт ийм нь юансуудыг цаашдаа энэ Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль дээр боловсронгуй болгох шаардлага байгаад байгаа юм байна лээ.

Г.Занданшатар: Цэндийн Мөнх-Оргил гишүүн тодруулъя.

Ц.Мөнх-Оргил: Аливаа хуулийн заалт Үндсэн хууль зөрчсөн байвал шууд л түдгэлзэх ёстой шүү дээ. Шууд. Тэрнээс биш зөрчөөгүй байна гэж хэлчхээд ирээдүйд түдгэлзүүлчихнэ гэдэг чинь бид нарт даалгавар өгөөд байна шүү дээ. Тийм биз дээ. Тэгэхээр бид нар чинь Цэцээс даалгавар авах ёсгүй шүү дээ. Бид нар чинь сонгогчидтой, ард түмний төлөөлөл. Бид нар ард түмнээ төлөөлж энд хууль тогтоох ёстой болохоос биш Цэцийн даалгавраар хууль тогтоодог байгууллага биш шүү дээ. Үнэхээр хууль зөрччихсөн байвал шууд түдгэлзүүлнэ. Хууль зөрчөөгүй бол тэрийг Цэц түдгэлзүүлэх эрхгүй. Ирээдүйд ч байна уу, хойчид ч байна уу, урд ч байна уу, одоо ч байна уу. Маши ойлгомжтой байгаа байхгүй юу. Энэ чинь хаа нэгэн газраа хэдүүлээ шугам татаж Цэцийн

хийх ажил, Их хурлын хийх ажил гэж ялгаж салгаж өгөхгүй бол энэ чинь бүрэн холилдоод явлаа шүү дээ.

Дээр нь энэ Раднаасэд гишүүний асуултад та түрүүн их маш тодорхой товчхон хариулчихлаа. Хууль буцаж үйлчлэхгүй гэж. Бас тийм биш байх шүү шүү. Энэ үнэхээр.../минут дуусав/

Г.Занданшатар: Санал хураалт явуулъя гишүүд ээ. Чуулганы танхимд цуглаарай. Мөнх-Оргил гишүүн агуулгын хувьд өөрөө үзэл бодлоо илэрхийлж байгаа боловч хэлэлцэж байгаа яг дэгийн процессын талаар бол Улсын Их Хурлын дарга аа гэх шаардлагагүй ээ.

Та нарын бат гэсэн хуулиар л дэгийн дагуу хэлэлцэж байна. Харин одоогоос бараг 5 сарын өмнө Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийг боловсруулах ажлын хэсгийг танаар ахлуулж байгуулсан. Хуулиа өргөн барьж энэ цэцийн асуудлаа шийдвэрлэх асуудалд Цэцийн маргаан хянан шийдвэрлэх процесс энэ тэрийг нарийвчлах, дагалдуулаад Улсын Их Хурлаар энийг хэлэлцэх асуудлынхаа дэг энэ тэрийг ер нь тэр хуулиараа зохицуулах тийм чиглэл өгсөн шүү дээ. Үг байхгүй. Цогтгэрэл гишүүн асуулт асууя гэсэн юм. Тэгэхдээ өөрөө асуухаа больчихсон юм шиг байна. Тэгээд санал хураалт явуулъя. Тэгвэл гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. 9 санал хураалт байгаа. Эрүү, Иргэн, Захиргааны шүүхтэй холбоотой 3, 3-аар ингээд 9 асуудал. Тэгээд Шүүхийн тухай хуулийн үндсэндээ 9 асуудлаар дүгнэлт гарчихсан учраас 9 дүгнэлт тус бүрээр нь санал хураалт явуулна. Санал хураалтад бэлтгэе.

Энэ хооронд зочид танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын “Монгени” цогцолбор сургуулийн 116 ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын

үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт сурагчид та бүхэндээ сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

9 санал хураалт явуулна.

1 дүгээр санал хураалт. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а дэд заалтад “анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт явуулах уу. Санал хураалт явуулъя. Санал хураалт цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн 25 гишүүн дэмжиж 56,8 хувийн саналаар Байнгын хорооны саналыг дэмжлээ. Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзлээ.

2.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.б дэд заалтад “хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;” гэж заасан нь Монгол Улсын үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1 дэх дэд заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;” гэж заасан нь Монгол Улсын үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14 дэх заалтад

Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 64,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж, хэрэглэсэн.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 57,8 хувийн саналаар санал нэмэгдэл ер нь нийцээгүй гэдэг чинь тэгээд л зөрчсөн л гэсэн дүгнэлт шүү дээ. 66.4 Тэгж байдаг байх аа. Үндсэн хуульд.

5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатын шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 56,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасан нь нийцээгүй

байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 52,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "... зөрүүтэй хэрэглэсэн эсэх, ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн "... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ..." гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 58,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1 дэх заалтад "анхан болон давж заалдах шатын шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн "... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ..." гэж заасанд нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Тогтоолын төсөл нь аваад ир. 58,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.3 дахь заалтад Шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэлэлцсэн гэж заасан нь Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн шударга шүүхээр шүүлгэх эрхтэй гэж заасанд нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 63 гишүүний саналаар санал дэмжигдлээ.

9. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар

зүйлийн 172.2.1 дэх заалтад "анхан болон давж заалдах шатын шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн "... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ..." гэж заасанд нийцээгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 55,6 хувийн саналаар санал хурааж байгаа юм байна лээ. Байнгын хорооны саналаар санал хурааж дууслаа. Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 2 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг ... тэгээд яагаад болчихсон гээд байгаа юм бэ.

1 заалтыг ахиад нэмж хураах нь.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.3 дахь заалтад "шүүх хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн "... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ..." гэж заасанд нийцээгүй нэгдсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт явъя. 57,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Байнгын хорооны саналаар санал хурааж дууслаа.

Яах вэ энэ санал хураалтын дундуур Үндсэн хуулийн энэ 66.1 2-ыг харахад 66.2.1, 2-т нийцээгүй гэсэн үгнүүд байна л даа. Зөрчсөн гэсэн үг ч байгаа юм. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн 16.14-д нийцээгүй гээд үндсэндээ зөрчсөн л гэсэн дүгнэлт гарсан л гэж ойлгогдохоор л юм байна л даа. Энэ тогтоолын төслөө баталчхаад Хууль зүйн байнгын хороог хуралдуулах асуудлыг шийдье.

Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя

гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Тогтоолыг баталъя. 53,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ тогтоолыг хэвлэж тараасан байгаа. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Энэ яах вэ хүлээн зөвшөөрч байгаа учраас үндэслэх хэсгээ бол тодорхой бичээгүй юм байна. Ер нь бол үндэслэх хэсгээ их тодорхой бичиж баймаар юм байна лээ шүү дээ. Хууль зүйн байнгын хороо дээр дараа нь энэ цэц дээр ахиж маргаан үүсгээд. Дараагийн асуудалд орно.

11.06 цагт

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 3 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Жуужаагийн Эрдэнэбулган танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Эрдэнэбулган: Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийг уншиж сонсгоё.

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Солонго, Г.Туулхүү, Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гомдол гаргагч иргэн Л.Галбаатар болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан нар оролцов.

Уг хуралдаанаар Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан хангамжийг хэлнэ гэж заасны “илрүүлэх” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална. 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасныг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Үндэслэл.

Нэг.Монгол Улсын Их хурал гүйцэтгэх ажлын тухай хуулийг 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдөр баталж, тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ гэж тодорхойлсон нэмэлтийг 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар оруулжээ.

Улмаар гүйцэтгэх ажлын тусгай техникийг хуулиар эрх олгогдоогүй этгээд олж авсан, ашигласан, борлуулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн

хуулийн 21.1.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт нэмэлт оруулан хуульчилсан байна

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад Монгол Улсын иргэн халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшигөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж зааж хүний хувийн халдашгүй чөлөөтэй байх эрхийг үндсэн эрх хэмээн баталгаажуулсан байна.

Уг заалт нь халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөвхөн хуульд заасан үндэс журмаар хязгаарлах төдийгүй дур мэдэн халдахыг хориглосон зохицуулалт юм. Ийнхүү дур мэдэн гэж заасан нь хуулиас гадуур хүний эрхийг хязгаарлахыг хориглосноос гадна хэт ерөнхий, өргөн хүрээнд 2 дугаар хоёрдмол утгаар тайлбарлаж болохуйц хэм хэмжээг тогтоохыг хориглосон агуулгыг илэрхийлнэ. Энэ нь эрх бүхий төрийн байгууллага албан тушаалтан ийм хуулийг дур зоргоор тайлбарлан хэрэгжүүлж, хүний эрх эрх чөлөөг зөрчих эрсдэлтэй байдагтай холбоотой юм. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасан.

Гурав.Хууль тогтоогч хүний хувийн халдашгүй чөлөөтэй байх эрхийг хязгаарлах үндэслэл журмыг тодорхойлохдоо тухайн хуулийг хэрэгжүүлэх байгууллага, иргэдэд хоёрдмол утгагүй, тодорхой ойлгогдохоор томъёолох, иргэд уг хуулийг зөрчсөнөөс үүсэх үр дагавар, хүлээх хариуцлагын талаар урьдчилан таамаглах, мэдэх боломжтой байхаар

хуульчлах үүрэгтэй. Ингэснээр хууль хэрэгжүүлэгч байгууллага болон шүүх хуулийг нэг утгаар хэрэглэх эрх, эрх чөлөө нь тухайн хууль тогтоомжоор хязгаарлагдаж буй иргэн зан үйлээ хуульд нийцүүлэх, эрх зүйн үр дагаврыг урьдчилан харж таамаглах нөхцөл бүрдэнэ. Энэ нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан хуулийн зохицуулалтын нөхцөл, зорилго, хүрээг зохицуулж буй харилцааны онцлогт нийцүүлэн тодорхой ойлгомжтой томъёолон хуульчлах буюу хууль зүйн тодорхой байдлыг хангах зарчимтай холбоотой юм.

Дөрөв.Мэдээлэл гаргагч иргэд болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч түүнчлэн Тагнуулын ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газраас гаргуулж авсан тайлбар баримтаас үзэхэд тус маргаан бүхий зохицуулалтын агуулгыг харилцан ялгаатай байдлаар ойлгож тайлбарлаж байгаа нь харагдаж байна. Мөн шинжээчийн дүгнэлтэд Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг хүн уншаад өөрийн зан үйлээ зохицуулах боломжгүй байна. Өөрөөр хэлбэл хүн ямар техник хэрэгслийг хэрэглэсэн тохиолдолд Тагнуулын ерөнхий газраас тухайн техник хэрэгслийг хураан авах эсвэл авахгүй байхыг урьдчилан тооцох боломжгүй байна гэжээ.

Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэх ойлголтод хамаарах илрүүлэгдэх төхөөрөмж гэдэгт нууц камер илрүүлэгч, гар утасны программ, цахим халдлагаас сэргийлэхээр бүтээгдсэн компьютерын программ хангамж зэрэг хамаарах эсэх нь тодорхойгүй буюу иргэн өөрийн хувийн мэдээллийг хамгаалах зорилгоор ямар тоног төхөөрөмж программ хангамжийг ашиглах боломжтой эсэх нь ойлгомжгүй байна.

Дээрхээс үзвэл Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн маргаан бүхий зохицуулалт нь хууль, тогтоомж тодорхой байх Монгол

Улсын Үндсэн хуулийн шаардлагад нийцэхгүй байх ба иргэд хууль, тогтоомж зөрчсөнөөс үүдэх эрүүгийн хариуцлагын талаар урьдчилан таамаглах, зан үйлийн хуульд нийцүүлэн өөрчлөх боломжийг хязгаарлаж, хувь хүн өөрийн нууцаа хамгаалах, халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Тав. Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэхийг тогтооход хэрэглэдэг түгээмэл шалгуур нь тэнцвэрийн зарчим юм. Энэ зарчмын хүрээнд төрийн хууль ёсны зорилгод нийцүүлэн иргэний эрх, эрх чөлөөг хуулиар хязгаарлах боломжтой. Холбогдох зохицуулалтыг Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлтээр оруулахдаа хууль тогтоогч уг заалтын зорилгын талаар тухайлан хэлэлцээгүй байна. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчөөс ирүүлсэн тайлбарт иргэний хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх мөн хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа, эрүүгийн хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр нууц ажиллагаа хийх зэрэг ажилд саад учруулахаас сэргийлж буй бодлогын хүрээнд уг хуулийн заалтыг баталсан талаар тэмдэглэжээ.

Зургаа. Эрүүгийн хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр нууц ажиллагаа хийх зэрэг ажилд саад учруулахаас сэргийлэх хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалтад тусгасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх Засгийн газрын бүрэн эрхэд хамаарах төрийн хууль ёсны зорилго мөн байна.

Харин энэ зорилгын хүрээнд хүн нь хувь хүний нууц болон мэдээллийг цуглуулах, дамжуулах, нууцаар олж

авахад чиглэсэн хөндлөнгийн халдлагаас хамгаалах иргэний эрхийг хуулиар хязгаарласан нь хувийн халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн байх үндэстэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад заасан халдашгүй чөлөөтэй байх эрхийн хамгаалалтад иргэн өөрийн гэр бүл, захидал, харилцаа, орон байрны халдашгүй байдлаа хууль бус халдлагаас хамгаалах болон хуулиар хамгаалуулах эрхтэй. Энэ нь хувь хүн бусад этгээдээс гадна төрийн байгууллага, албан тушаалтны халдлагаас сэргийлэхтэй холбоотой зохицуулалт юм. Иргэний хувийн халдашгүй чөлөөтэй байх эрхийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан нь хүний эрхэм чанарыг дээдлэхтэй холбоотой бөгөөд иргэн бусдын хууль бус халдлагаас ангид байдлаар бие даан орших өөрийн мөн чанар, үзэл бодол, итгэл үнэмшил, мэдрэмжээ илэрхийлэх хувийн орон зайг нь хамгаалахад чиглэгдэнэ.

Долоо. Эрүүгийн хэргийг илрүүлэх болон нийтийн ашиг сонирхолд аюул учруулахуйц тохиолдолд энэхүү эрхийг хуулиар хязгаарлах боломжтой боловч хувь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн хязгаарлалт нь тэнцвэрийн зарчимд нийцсэн байх шаардлагатай. Уг маргааны хувьд иргэн өөрийн хувийн амьдрал мэдээллийн нууцыг өөрөө хамгаалах, хөндлөнгийн халдлагаас сэргийлэх боломжийг хориглох замаар эрүүгийн хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох нь хуулийн холбогдох зохицуулалтын зорилго гэж үзэхээр байна. Хүний хувийн халдашгүй чөлөөтэй байх эрхийг ийнхүү хязгаарлахгүйгээр уг хуулийн зорилгод хүрэх боломжтой байна. Тухайлбал, илрүүлэх тоног төхөөрөмжийг ашиглах зорилгоос нь хамааран хэрэгцээнд нь хуулийн хязгаарлалт тогтоож болно. Үүнээс үзэхэд хуулийн зохицуулалтын зорилго болон тухайн зорилгод хүрэхэд чиглэсэн арга хэмжээ нь зохист

нийцэлгүй байна. Гэмт этгээдийг олж тогтоох, гүйцэтгэх ажиллагаанд саад тотгор учруулахгүйгээр өөрийн хувийн мэдээлэл, орон байр, захидал харилцааны халдашигүй байдлыг хамгаалах зорилгоор илрүүлэх төхөөрөмжийг ашиглахыг иргэн зөвшөөрөх замаар дээр дурдсан хуулийн зорилгод хүрэх боломжтой байна.

Ийнхүү иргэний өөрийн болон гэр бүлийн халдашигүй байдал хувийн нууцаа хамгаалах эрхийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлсэн нь уг хуулийн зохицуулалтын зорилго биелснээр олж болох давуу талтай харьцуулахад илүү эрсдэл бүхий үр дагавартай байна.

Иймд гүйцэтгэх ажлын тухай хуулийн маргаан бүхий зохицуулалт нь хууль зүйн тодорхой байдлын зарчим болон тэнцвэрийн зарчмын дагуу тавигдах шалгуурт нийцээгүй улмаар иргэний халдашигүй чөлөөтэй байх эрхэд дур мэдэн халдах, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүрэг зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон тогтоох нь.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь.

1. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ гэж заасны “илрүүлэх” гэсэн нь Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь

заалтад халдашигүй чөлөөтэй байх эрхтэй иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашигүй байдлыг хуулиар хамгаална. 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт илрүүлэх гэж заасныг Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч Д.Одбаяр, гишүүд С.Солонго, Г.Туулхүү, Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Бямбасүрэнгийн Энх-Амгалан танилцуулна.

Б.Энх-Амгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийг 2023 оны

5 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан журмын дагуу 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийн агуулгыг танилцуулсан болно.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар, Б.Энх-Амгалан, Б.Энхбаяр нар асуулт асууж, үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлаас 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдөр баталсан Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ гэж заасны “илрүүлэх” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална. 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн төрөөс хүний эрх эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасныг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болноб

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Цэцийн дүгнэлтийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 3 дугаар дүгнэлтийг 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан журмын дагуу 2023 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийн агуулгыг танилцуулсан болно.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар, Ганбат, Бат-Эрдэнэ, Энхболд нар асуулт асууж, үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлаас 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдөр баталсан Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ гэж заасны “илрүүлэх” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх хэрэгтэй иргэний, хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэжээр хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу.

Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна. Амартүвшин гишүүнээр тасаллаа.

Д.Ганбат: Та бүхнийхээ амар амгаланг айлтгая.

Ингээд Байнгын хорооны дүгнэлт 1 талдаа хүлээж авахгүй гээд, Үндсэн

хуулийн цэц нь болохоор шийдвэр нь болохоор тэр үг үсгийг хасна гэсэн ийм дүгнэлт гаргажээ. Энэ юуг илэрхийлээд байна вэ гэхээр ерөөсөө л нөгөө хууль хяналтын байгууллагууд, манай Үндсэн хуулийн цэц бид бүгд ерөөсөө яг л нөгөө иргэддээ тэр халдашгүй байдал, хувийн эрх чөлөө, хувийн орон зайд нь халдахгүй байх энэ бүх баталгааг нь гаргаж өгч чадахгүй байгаа юм. Тэрний л 1 илрэл. Тэгээд л иргэд аргагүйн эрхэнд л өөрсдөө ийм байдалд шилжиж байгаа байхгүй юу.

Нөгөө талаар манай бас энэ тусгай байгууллагууд бол энэнээс илүү тоног төхөөрөмж, программ хангамж, өөрийн тийм ур чадвартай байх ёстой л доо. Энэ гар утас чинь бол бас энэ юуны бас хэрэгсэл гэж үзэх үү. Аягүй л бол цаашаа явж явж байгаад. Энэ юмыг нь болиулчихна. Дараа нь ахиад техник технологи бол өдөр болгон л хөгжиж байна шүү дээ. Зарим гар утасны хүчин чадал бол тэр ашиглаж чаддаг, ашиглаж байгаа юмандаа ямар л бол ямар байдлаар ашиглаж болж байна. Тухайлбал би Сүхбаатарын талбай дээр гэх үү, Чингисийн талбай дээр гэх үү. Энэ дээр манай иргэд үг хэлж, үзэл бодлоо илэрхийлж байх ёстой шүү дээ. Гэтэл тэр хүмүүсийг байнга шахна, дарамтална, үгийг нь нийлүүлэхгүй, үзэл бодлыг нь илэрхийлэхгүй, чөлөөтэй өөрийнхөө Үндсэн хуульд заасан эрхээ эдэлж байхад тэрийг нь байнга л энэ хууль хяналтын байгууллагынхан энэ бүхнийг ашиглаад л энэ Засгийн газар байнга амыг нь барьж байгаа шүү дээ. Ийм л байгаа.

Тэгээд энэ дээр бол энэ хуульд хяналт тавьдаг Улсын Их Хурал бол юу ч дуугардаггүй. Энэ бүх байдлаас ийм байдалд орж байна. Тэгээд нөгөө хүмүүс нь бүр арга ядаад Элчин сайдын яамдын гадна очиж байна шүү дээ. Энэ мэтчилний үйл явдал ингээд өрнөж байна аа. Үүний 1 илэрхийлэл нь юм. Тэгээд хар. 7, 8 настай хүүхдийг хүчиндээд л тэр орон шоронгоос гарсан нөхөр бол тэгээд л жорлон руу аваачаад л шидчихэж

байна шүү дээ. Амь насыг нь хохироогоод. Тэгэхэд тэрийг хамгаалдаг, тэрийг сэргийлдэг энэ бүх юм чинь хаана байна. Бүр амь насанд нь хүртэл ингээж хүрч байна шүү дээ. Энд л иргэд бухимдаад байгаа юм л даа.

Тэгээд аргагүйн эрхэнд л өөрсдийгөө хамгаалахын тулд л янз бүрийн байдлаар л тэр орон зайгаа өөрсдөө хамгаалж эхэлж байна гэж ойлгож байна. Тэрийг нь энэ хууль хяналтын байгууллага, Засгийн газар хуулийн дагуу баталгаатай хангаж чадахгүйгээс болж байна. Тэгээд Үндсэн хуулийн цэц нь эцсээ тултал энэ байр суурин дээр байж чадах уу. Байх юм уу, яах юм бол. Эсвэл өөрчлөөд явах юм уу. Дандаа л дохио зангаагаар хөдөлж байдаг л хүмүүс д дээ. Өмнө нь тийм л байсан. Одоо ямар байх юм байгаа юм. Цаашидаа бага ч гэсэн энийгээ алдаагаа засаасай.

Манай Байнгын хороо ингээд шийдчихээр энийг нь аваад Улсын Их Хурал эцсээ тултал энэ байр сууриндаа байх уу. Эсвэл ямар нэгэн байдлаар хуулийг жоохон өөрчилж бариад 1 тэгсэн ингэсэн болгоод л өнгөрөөх үү. Энийг бас үндсээр нь ингээж шийдээж баймаар байгаа юм аа. Ер нь болохгүй бол энэ төр засаг хамгаалж чадахгүй бол тэр Үндсэн хуульд заасан тэр хэмжээг нь эдлүүлж чадахгүй бол эрүүл саруул иргэддээ тэр зэвсгийг нь өгөх хэрэгтэй шүү дээ. Буу эзэмшихийг нь. Тэр Америкийн Нэгдсэн Улс энэ тэр байдаг шиг эндээ ч тулж болно шүү дээ бид нар. Америкийн Нэгдсэн Улсад тийм юм байдаггүй юм аа. Иргэн өөрөө өөрийгөө хамгаалдаг юм. Хэрэв төр засаг нь хамгаалж чадахгүй л бол иргэд тийм эрхтэй байдаг юм.

Г.Занданшатар: Тэр бол Америкийн том проблем байх аа. Бид нарт өөрийн проблем хангалттай. Баттөмөрийн Энхбаяр дарга хариулах уу. Аюулгүй байдал, гадаад бодлогын

байнгын хорооны дарга хариулъя. Бямбасүрэнгийн Энх-Амгалан.

Б.Энх-Амгалан: Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувиар хариулъя. Ганбат гишүүний асуултад хариулъя. Гар утасны программ хангамж бол энэ гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн программ хангамжийн иж бүрдэл биш. 1 дэх нь. Энэ бол өөр ойлголт. Энэ нээлттэй, ил, олон нийтийн худалдаагаар заагддаг арилжааны шинжтэй ийм программ хангамж. Энэ дээр энэ хуулийн зохицуулалт байхгүй.

Жагсах нэгдэх эрхийн асуудал өөр хуулиар зохицуулагдана. Жагсаал цуглааны тухай хуулиар зохицуулагдана. Энд энэ гүйцэтгэх ажлын тухай хууль буюу ялангуяа Үндсэн хуулийн цэцийн энэ гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэдэг энэ зохицуулалт тэр жагсаал цуглааны хүмүүсийн амыг үдээд, баривчлаад, бариад байгаа ийм асуудал энд бол хамаарахгүй ээ.

7, 8 настай хүүхэд хүчиндсэн тэрийг иргэдээ хамгаалахгүй байна гэдэг асуудал бол Эрүүгийн хуулийн зохицуулалтын асуудал. Эрүүгийн хуулийн тусгай ангиар зохицуулагддаг асуудал. Тэр иргэддээ буу өгье гэж уриалдаг чинь Их Хурлын гишүүний хэлэх үг мөн ч юм уу, биш ч юм уу би мэдэхгүй байна. Ингээж арай болохгүй байх аа.

Энэ Их Хурлын хариуцлагатай индэр дээрээс бид нар яг хуулийн зохицуулалттай, хуулийн заалттай зүйлүүдийг л ярих юм. Нэг асуудлыг л хэлье. Үндсэн хуулийн 16 дугаар зүйл бол халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан эрхээ хамгаалуулах эрхтэй. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална. Үүнийгээ төр хамгаална гэж байгаа шүү дээ. Төр иргэнийхээ өмнө гүйцэтгэнэ гэж байгаа юм. Тийм учраас төрийн үндсэн үүрэг бол иргэнээ хамгаалах үүрэгтэй, иргэнийхээ эрх, эрх чөлөө, хүний эрх, эрх

чөлөөг хангахуйц тийм хууль эрх зүйн орчныг бүрдүүлж хамгаалах ёстой юм. Тийм учраас энэ Үндсэн хуулийн энэ зохицуулалтыг Монгол Улсын төр өөрөө гүйцэтгэх ёстой юм. Гүйцэтгэх ажлын тухай хууль бол тусгай техник хэрэгслийн асуудал ярьж байгаа болохоос биш, хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа тухай асуудал байхгүй юм. Яагаад тэр байхгүй юм гэхээр Гүйцэтгэх ажлын тухай хуулиараа энэ эрх олгогдоогүй байгууллага, албан тушаалтан, иргэн, гүйцэтгэх ажлын техник, тусгай хэрэгслийг ашиглахыг л хориглож байгаа юм. Мөн гүйцэтгэх ажилд ажиглах хориглох зүйлийг Гүйцэтгэх ажлын тухай хуулиараа гүйцэтгэх ажлын явцад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах тухай асуудлын 7 дугаар зүйлээрээ гүйцэтгэх ажлын явц явуулах үндэслэл хамрах хүрээг нь 9, 11, 12 дугаар зүйлээр гүйцэтгэх ажлын хяналтыг яаж тавих вэ гэдгийг 22 дугаар зүйлээр маш тодорхой зохицуулчихсан юм. Тийм учраас энэ гүйцэтгэх ажлыг хууль хяналтын хяналтгүй явуулдаг ийм зүйл байхгүй ээ гэдгийг бас танд хэлье ээ.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя. 1 минут.

Д.Ганбат: Яах вэ хууль, эрх зүйн орчин бол ийм байна. Иргэдээ бол хамгаалах ёстой юм байна. Төр нь гэтэл яг амьдрал дээр хамгаалж чадаж байна уу, үгүй юу л гэдгийг чинь асуугаад байна л даа. Хамгаалж байгаа нь хаана байгаа юм бэ. Нөгөө талаар энэ би тусгай байгууллагуудынхаа энэ тоног төхөөрөмж, боловсон хүчнээ сайжруул гэж хэлэх гээд байгаа юм. Энэ чинь тийм л дохио өгсөн зүйл юм биш үү. Тэр чинь ур чадвар энэ юмнууд хэнд ч мэдэгдэхээргүй л байх ёстой шүү дээ. Тэгээд захын хувь хүний орон зай, тухайлбал миний орон зайд халдаж байгаа ийм юмыг шалгуулахад ямар ч харцу авахгүй шүү дээ. Усанд хаясан чулуу шиг. Энэ чинь хэнд үйлчлээд байдаг юм бэ. Яг Монгол Улсын аюулгүй

байдлын төлөө үйлчилдэг юм уу, хэдэн эрх барьж байгаа нөхдийн гарт байдаг юм уу. Ийм юмнаас чинь болоод л ийм шийдвэрүүд алдаатай зөрөөтэй гараад байна шүү дээ. Энэ дээрээ л та нарыг би дүгнэлт хий гэж хэлээд байна.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр дарга хариулъя. Хууль зүйн байнгын хорооны дарга хариулъя.

Б.Энхбаяр: Ганбат гишүүний хөндөж байгаа гүйцэтгэх ажилд тавих хяналтыг сайжруулахтай санал нэг байгаа. Энэ хүрээнд Улсын Их Хурлаас Хөгжлийн банкиг шалгах түр хорооны санал, дүгнэлтийг хэлэлцээд 2023 оны 4 сарын 21-ний өдрийн 26 тоот тогтоол гаргасан.

Уг тогтоолын 2 дахь заалтад гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналттай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хууль тогтоомжийн төслийг боловсруулж 2023 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Хууль зүйн байнгын хороонд даалгасан байгаа. Энэ тогтоолоор өгсөн үүргийн дагуу ирэх 7 хоногийн 2 дахь өдрийн Хууль зүйн байнгын хороогоор гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч бие даасан хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулах гэж байгаа юм. Улмаар намрын чуулганаар энэтэй холбоотой хуулийн төслийг өргөн барина гэдгийг бас Ганбат гишүүнд хэлье ээ.

Г.Занданшатар: Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуулт асууна.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлтийг харин бол дэмжчихмээр юм санагдаад байх юм. Би бол хувьдаа дэмжье гэж бодож байна. Яагаад гэвэл энэ 5, 6 хуудас дүгнэлт дээрээ, үндэслэл дээрээ маш тодорхой хэлчхээд байна шүү дээ. Маш тодорхой хэлчхээд байна. Өөрөөр хэлбэл явсаар байгаад асуудал юунд тулчхаад байна вэ

гэхлээр энэ Үндсэн хуульд баталгаажуулаад өгчихсөн иргэний халдашгүй, чөлөөтэй байх эрх, иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэдэг нь энийг зөвхөн төр хамгаалаад байх юм уу, манай Тагнуулын ерөнхий газар, прокурорын байгууллагуудын дүгнэлт бол тийм байна шүү дээ. Энийг төр хамгаална. Энэ хувь хүнд ерөөсөө хамаагүй асуудал. Тэгэхээр зөрччихсөн байна гэж үзэх юм бол төрд хандаарай бид нар очоод тэрийг чинь шалгаад, хамгаалаад өгье гэсэн нэг санаа хэлээд. Энэ гомдол гаргасан, мэдээлэл гаргасан иргэн Ундрах-Эрдэнэ, Галбаатар 2 болохлоороо үгүй ээ, энэ бол ерөөсөө төрд хамаагүй, хувь хүн өөрөө хамгаалах ёстой гэж энэ 2 асуудал 2 талдаа яригдаад байна шүү дээ. Энийг Цэцийн дүгнэлт үндэслэх хэсэг, шинжээчийн дүгнэлтийн 6 хуудсан дээрээ маш тодорхой миний бодлоор бол тэнцвэрийг нь зөв олоод гаргачихсан байна.

Төр ч хамгаална, иргэн ч өөрийгөө хамгаалах эрхтэй байх ёстой. Тодорхой хэмжээнд. Энийгээ энэ дүгнэлтдээ юу гээд хэлчихсэн байна вэ гэхээр 1 дүгээрт хамгийн гол нь хууль дээдлэх зарчим. Хууль дээдлэх зарчмын 1 гол суурь нь бол хууль тодорхой байх ёстой. Энэ чинь тодорхойгүй байна. Илрүүлнэ гэдэг яг юуг хэлээд байгаа юм бэ. Ямар зорилготой, ямар юмыг хэлээд байгаа юм бэ. Ингээд ерөнхий хэд хаячихлаар чинь иргэн хүн гэрт нь тагнах, чагнах юм байна уу, үгүй юу гээд өөрийнхөө хамгаалах гээд явж байгаа юмыг ч гэсэн хязгаарлачхаад байна шүү дээ. Гар утсан дээрээ тавьчихсан апп-ыг ч гэсэн энд оруулчих бололцоотой болчихоод байна шүү дээ. Тийм учраас хэтэрхий өргөн байна.

Хууль тодорхой байх, хууль дээдлэх зарчмын 1 том чухал юу гэдэг юм зарчим бол эрхийг, хүний эрхийг хязгаарлаж байгаа тэр хязгаарлалтууд нь маш тодорхой хязгаарлагдмал байх ёстой,

зорилттой байх ёстой гээд байгаа юм. Тэгэхээр энэ хууль дээдлэх зарчимд нийцэхгүй байна гээд.

2 дахь энэ дүгнэлтэд хэлээд байгаа юм чинь тэнцвэрийн зарчим алдагдчихаад байна. Өөрөөр хэлбэл хууль хяналтын байгууллагууд гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд энэ гүйцэтгэх ажил явуулдаг тоног төхөөрөмжийг хувь хүний гарт өгүүлэхгүй байх тэр гарцаагүй нийтийн эрх ашиг тэнд байна. Нөгөө талаас хувь хүн бусдын эрх ашигт халдахгүйгээр зөвхөн өөрийнхөө халдашгүй байдал, өөрийнхөө нууцыг хадгалах гэр орны аюулгүй байдлыг хамгаалах зориулалтаар өөрийгөө хамгаалах бас эрх ашиг байна. Энэ 2-ыг тэнцүүлэх ёстой шүү дээ. Энэ хэтэрхий тэнцвэрийг нь алдагдуулсан байна шүү дээ. Яагаад хуулиа тодорхой болгоод ийм ийм тоног төхөөрөмжийг хувь хүн ашиглаж болно. Өөрөөр хэлбэл энэ дүгнэлт дээр хэлээд байна шүү дээ. Гэрт нь тагнах, чагнах аппарат тавьж уу. Нууц камер тавьж уу, үгүй юу гэдгийг би шалгачихъя. Өөрөөр бол шалгадаг энэ тоног төхөөрөмжөө ашиглаад бусдыг чагнадаг байх юм бол энэ бол хориотой гэдэг юмаа л заагаад өгчих гэж хэлээд байгаа юм биш үү. Тэгэхээр энийг нь хүлээж аваад, харин тэр илрүүлэх гэдэг тоног төхөөрөмж дотор яг юуг хэлээд байгаа юм бэ гэдгийг нь залруулаад өгчих юм биш үү.

Тэгээд эцэст нь хэлэхэд уг нь Цэцийн дүгнэлтүүд ингээд үндэслэл нь 5, 6 хуудас дээр гараад, шинжээчийн дүгнэлттэй, холбогдох байгууллагуудын дүгнэлттэй, тэгээд энэ Үндсэн хуулийнхаа суурь үзэл баримтлалтай нийцүүлээд, зарчмуудаа тайлбарлаад явчихсан гаргалгаатай байх юм бол Улсын Их Хуралд асуудлаа шийдэхэд амар байгаа байхгүй юу. Ийм л дүгнэлтүүд бол бид нар гаргаж баймаар байгаа юм. Тэрнээс биш өмнөх дүгнэлт ишг ерөөсөө тал хуудсан дээр үндэслэл гэж хэлээд тэндээ ямар ч үндэслэл байхгүй зөрчсөн байна гэж хэлээд, яг

зөрчсөн байна гэдэг үндэслэлээ дахиад дүгнэлт дээрээ тусгачихлаар чинь Улсын И Хурал шийдвэр гаргахад хүндрэлтэй болчихоод байгаа юм л даа.

Г.Занданишатар: Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. Үндсэн хуулийн 16 дугаар зүйл халдашгүй чөлөөтэй байх ёстой. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаалах ёстой. Төрөөс иргэний эрх, эрх чөлөөг хангахуйц тийм хуулийн зохицуулалтыг хийж иргэнийхээ өмнө иргэнээ хамгаалах үүргийг төр хүлээх ёстой гэдэг ийм Үндсэн хуулийн заалттай. Энийг л хангаж өгөөч гэж л иргэд хүсэж байгаа юм. Энэ бол юу юм бэ гэхээр гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл. Энэ гар утасны программ биш, энэ бол харуул хамгаалалтын камер биш, энэ бол гэрт тавьдаг дохиолол биш. Энэ хүүхдийнхээ цүнхэнд зүүдэг Жи Пи Эс бол биш. Энэ бол дэлхийн практикт байдаг тусгай албадын ашигладаг ийм тусгай зориулалтын өндөр өртөгтэй техник хэрэгсэл. Энэ техник хэрэгслийн жагсаалтыг өнөөдөр гаргаад хуульчилж болохгүй. Яагаад гэвэл техник хэрэгсэл жил болгон шинэчлэгдэж байгаа. Жил болгон шинэчлэгдэж байгаа. Тийм учраас энэ техник хэрэгслийг ийм ийм юм гэж жагсаачхаад өгдөг, нөгөө жагсаалтад ороогүй техник хэрэгслийг ашиглаж болно гэх юм бол тэр сөрөг тагнуул болоод тагнуулын үйл ажиллагаа явуулдаг тусгай гүйцэтгэх ажиллагаа явуулдаг энэ техник хэрэгслийг иргэнд очих эрх нь нээгдчих гээд байгаа юм. Нэг чухал зүйл нь иргэн өөрийнхөө орон байрны аюулгүй байдлыг хамгаалах үүрэгтэй. Болно. Гэхдээ энд манайх тагнах, чагнах хэрэгсэл тусгай алба тавьсан байж магадгүй гэж үзэх юм бол тэрийгээ Тагнуулын ерөнхий газарт өргөдлөө гаргаад шалгуулчих ийм бас боломж бололцоотой. Эрх зүйн

үндэслэлтэй. Мөн гүйцэтгэх үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудад хориглох зүйлийг маш тодорхой заагаад өгчихсөн байгаа юм.

Тийм учраас энэ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид мөн энэ Тагнуулын байгууллагын тухай хууль энэ тэрд ерөөсөө үйл ажиллагаа явуулахдаа хүний эрх, эрх чөлөөг дээдлэх нь үндсэн зарчим мөн гээд оруулчихсан байгаа юм. Үүнээс илүүгээр тэрийг ингэж тухайн хүнийг шантаачлах ч юм уу тухайн хүний хувийн орон зайд халдах ч юм уу яг Үндэсний аюулгүй байдалтай холбоотой болоод терроризм, экстремизм, хүн худалдаалах, хар тамхи гээд энэ нууц далд аргаар үйлдэгддэг гэмт хэргийг илрүүлэхэд шаардлагатай нууц, далд аргаар илрүүлдэг техник тоног төхөөрөмжийг хэлж байгаа болохоос биш иргэний хувийн орон зай гэр бүл орноо хамгаалах асуудлыг энд бол заагаагүй юм. Энд хэрвээ ингэх юм бол яг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт дээр нэг айхтар юм байж байгаа юм л даа. Хүлээгээд авчих юм Үндсэн хуулийн 13 дугаар зүйлд заасны хувь хүн бусад этгээдээс гадна төрийн байгууллага албан тушаалтны халдлагаас сэргийлэх зохицуулалт юм байна. Ийм учраас иргэний хувийн халдашгүй чөлөөтэй байх эрхийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан учраас тухайн хүн хууль бус халдлагаас ангид байхаас бие даан орших үүднээс энийг бас зохицуулж болох юм гэхээр зэрэг энэ техник тоног төхөөрөмжийг ашиглах эрхийг иргэдэд буюу нэг ёсондоо хуулиар олгогдоогүй байгууллага, албан тушаалтанд нээх болчих гээд байгаа юм. Энэ бол өөрөө Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд асар их хор хохиролтой учраас энийг бол тийм зохицуулалтаар хийж болдоггүй ээ гэдгийг л энд тайлбарлаад байгаа юм.

Г.Занданишатар: Эхлээд зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбатын урилгаар Санхүү эдийн засгийн техникумын 1988 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл

ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сайн сайхныг хүсэн ерөөе.

Цэндийн Мөнх-Оргил гишүүн тодруулж асууя. 1 минут.

Ц.Мөнх-Оргил: Энх-Амгалан гишүүн ээ, төр хамгаална. Төр хариуцна гэдэг чинь зөвхөн төр хариуцна гэсэн үг биш шүү дээ. Иргэн өөрөө өөрийгөө хамгаалах, өөрийнхөө нууцаа хамгаалах, гэр орныхоо аюулгүй байдлыг хамгаалах эрх нь тэнд байгаа байхгүй юу. Үүрэг ч байна, эрх нь ч байна. Тэгэхээр энийг л үгүйсгэж болохгүй шүү л гэж цэцийн дүгнэлт чинь 1 дүгээрт хэлээд байна шүү дээ.

2 дугаарт энэ гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэдэг томьёолол чинь хэтэрхий өргөн ойлгомжгүй байна л гэж хэлээд байгаа байхгүй юу. Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах гэдэг чинь хориотой хэвээрээ л байгаа. Тэрийг хувь хүнд өгөхгүй. Тэр хувь хүнд очихгүй. Ганцхан илрүүлэх гэдэг чинь илүү хүний өөрийгөө хамгаалах эрхийг хязгаарлачхаад байна гэж Цэц хэлээд байгаа байхгүй юу. Тэрнээс биш бүх тусгай ажил, нууц ажиллагааны гүйцэтгэх ажлын тоног төхөөрөмжийг иргэдэд өгөөд бай гэсэн дүгнэлт бол биш шүү дээ.

Г.Занданшатар: Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Гүйцэтгэх ажлын тухай хуулийг сайжруулах ёстой юу гэвэл сайжруулах ёстой. Энийг дахиж шинээр оруулж ирэх асуудлыг намрын чуулганаар хийнэ гэж сая Хууль зүй байнгын хорооны дарга хэлж байна. Тэр дээрээ зарим нэгэн зүйлийг нь тодорхой болгох ёстой юм. Энэ 6.3 гэдэг заалт бол Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэдэг нь өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олгох, цуглуулах,

дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник тоног төхөөрөмж, түүний иж бүрдэл хэсэг программ хангамжийг хэлж байгаа юм гэж байгаа юм. Нэг цогц л юм хэлээд байгаа юм. Энэ заалт зогсох юм бол энэ тэр чигтээ зогсох байхгүй юу. Үүний чинь “илрүүлэх” гэдгийг нь салгаад авчихдаг. Техник гэдгийг нь салгаад авчихдаг. Төхөөрөмж гэдгийг нь салгаад авчихдаг эсвэл иж бүрдэл гэдгийг нь саргал асаагаад авчихдаг, программ хангамж гэдгийг нь салгаж авдаг юм биш. Энэ бол тэр мэдээ мэдээллийг олж авдаг техникийг иж бүрдлээр нь хэлээд байгаа юм шүү гэж байгаа болохоос биш, илрүүлдэг тоног төхөөрөмж гэж тусдаа юм ярьж байгаа юм ерөөсөө биш юм. Тэгэхээр энэ гүйцэтгэх ажлын энэ чинь 1 заалт байхгүй юу.

Г.Занданшатар: Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн асуулт асууя.

Ж.Сүхбаатар: Нөгөө үг хэлэх боломжгүй учраас би чинь асуулт асуух гээгүй л дээ. Энэ дэг дээр ер нь энэ цэцийн асууж болдоггүй энэ дэгийн чинь юм бол ерөөсөө болохгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр асуултын цаг дээр үг л хэлэхээс.

Яах вэ энэ дээр би саналаа нөгөө хүлээн зөвшөөрөх боломжгүйгээр өгчихсөн юм. Тэрийгээ л би тайлбарлах гэж байгаа юм. 2 талтай юм байж байгаа. Нэг талаас бол түрүүн Мөнх-Оргил гишүүний хэлдэг иргэний өөрийгөө хамгаалах тийм боломж эрхийн асуудлуудыг нь программ хангамжийн тоног төхөөрөмж дээр ямар байх вэ гэдэг нэг асуудал байгаа.

Нөгөө талаас нь манай гүйцэтгэх ажил явуулдаг ялангуяа Тагнуулын байгууллагын үйл ажиллагаа, гаднын тагнуул, тагнан турших үйл ажиллагааны эсрэг бас Үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийх гэж байгаа ажил 2-ын хоорондын огтлолцол

тодорхой хэмжээний зөрчилдөөн энэ дээр үүсээд байгаа юм. Үүсээд байгаа юм. Би бол ямар байдлаар саналаа яагаад өгч байна вэ гэхээр өчигдөр процессын талаасаа бид бол хаалттай хуралдаан хийсэн. Холбогдох аюулгүйн чиглэлийн хүмүүсийн яриаг сонссон. Энэ заалтыг яг ингээд зөрчсөнөөр нь явчих юм бол бидэндээ Үндэсний аюулгүй байдлын чадамж сулрах, үйл ажиллагаа явуулахад хүндрэл учрах магадлалтай байна гэдгээ тайлбарлаад байгаа юм. Энийг нь бол илүү онцолж үзсэн. Мэдээж миний хувьд ч гэсэн байр суурь бол хүний эрх хамгаалах талаасаа бол зохицуулалтууд шаардлагатай гэж үзэж байгаа.

Ялангуяа манай гүйцэтгэх ажилтнуудад тавьж байгаа хяналт шалгалт нь тэр дотоод хяналт шалгалт нь тагнуул, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр, цагдаа гээд энд бол хангалтгүй байгаа санагддаг. Тухайлах юм бол хуульч хүний хувьд харахад. Хэвлэл мэдээллийн байгууллагууд дээр гүйцэтгэх ажилтнуудтай холбоо тогтоосон байж болзошгүй байдлын мэдээллүүд сүүлийн үед их гарч байгаа нь нууц биш шүү дээ. Сэтгүүлчидтэй хамтран ажиллаж байна. Мэдээллээ зарж байна. Шантаачилж байна. Эрэмшиж байна. Энэ чинь цаашидаа гүйцэтгэх ажил хяналтаас гарч байгаа нь бол бид илэрхий хараад байгаа. Энэ хэдий хүртэл үргэлжлэх юм бэ гэдэг асуудал бол ер нь бол яригдаж байгаа, харагдаж байгаа. Зүгээр энэ дотор зарим нэг иргэд маань өндөр үнэтэй ийм том тусгай хэрэгслүүдийг авч, өөрсдийгөө хамгаалах нэрийдлээр авч ашиглах байдлаар сонгууль ойртож байгаа байдаг юм уу, сонгуулийн үеэр ч гэдэг юм уу, бусад үед ч гэсэн бусдыг тагнан чагнах ийм ажиллагаануудыг бол бас явуулаад байна гэдэг асуудал бол байгаад байгаа юм.

Тэгэхээр ингээд манай парламентыг чинь янз бүрээр, элдвээр хэлсээр байгаад парламентын хяналт шалгалтыг үгүйсгэх оролдлогуудыг

сүүлийн үед бас эрчимтэй хийж байгаа юм. Ард түмнийг бол энэ Их Хурлын гишүүн төлөөлөхгүй, би төлөөлж байгаа юм. Ард түмний өмнөөс бид хяналт тавина гэдэг ийм ойлголт руу бас яваад байгаа юм. Үгүй л дээ. Хууль ёсоор ард түмний төлөөлөгчид гэвэл хэчнээн муу сайн хэлсэн сонгуулиар гарч ирсэн Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний төлөө төлөөлдөг, дуугардаг эрхтэй. Тэр хэмжээгээрээ, тэр мандатаараа бусдад хяналт тавих эрхээ шилжүүлж болохгүй. Тэгэхээр бид бол энийг хүлээж авсан ч гэсэн түрүүний Энх-Амгалан даргын хэлээд байгаа тэр гүйцэтгэх ажлын хуулийг шинэчлэх шаардлагатай.

2 дугаарт миний хувьд энийг цаашиа ямар байдлаар явах, ямар ч байсан манай Үндэсний аюулгүй байдлын байгууллагынхаа ажлыг сулруулахгүйгээр энийгээ явъя. Гэхдээ гүйцэтгэх ажилд тавих хяналт гэж ерөөсөө байхгүй болчихоод байгаа шүү. Парламентын хяналт. Дэлхийн улс орнууд бол парламентын тусгай хяналтыг хүчтэй хийдэг бол байдаг. Энэ чинь эргээд тэр гүйцэтгэх ажилтнууд чинь даргыгаа ч тэр Засгийн газрыг ч тэр, Их Хурлыг ч тэр шантаачлах байдал гаргуулахгүй байх гол баталгаа нь хаана байдаг юм гэхээр парламентын хяналт дээр байдаг байхгүй юу. Одоо чинь тийм юм байхгүй болчихоод байна шүү дээ. Ард түмнийг төлөөлж хамгийн дээд хяналт тавих ард түмний тэр хяналт тавих эрхтэй бүрэн хууль ёсны байгууллага нь парламент байхад, парламентыг үгүйсгэх замаар нэг хэсэг иргэд, нэг хэсэг нөхөд, бүлэглэлүүд энэ хяналтаас мултарчхаж байгаа юм.

Магадгүй энэ манай үндэсний аюулгүй байдлыг хамгаалах байгууллагууд ч гэсэн өнөөдөр хяналтад байна уу гэж хэн ч баталгаа өгч чадахгүй байгаа. Тэгэхээр энийг тэгэхдээ бид бас орхиж болохгүй. Би энийг шийдэх ёстой манай парламент. Гэхдээ аюулгүй байдлын байгууллагуудынхаа энэ удаагийн саналыг хүлээж авч байгаа. Гэхдээ цаана нь бас асуудлууд байгаа

шүү гэдэг энэ тодотголтойгоор энэ саналаа өгсөн учир нь ийм байгаа юм.

Г.Занданишатар: Үг хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хороодын саналаар санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая. Санал хураалтад бэлтгэе. 2 санал хураалт. Байнгын хороодын саналыг дэмжиж санал хураалт явуулна. Та битгий будилуулаад бай. Ер нь энэ Үндсэн хуулийн цэцийн тогтоолыг, Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй тогтоол гарахдаа өмнө 2, 3 кэйс дээр дандаа тэр үндэслэл хэсгийг тодорхой дурдаж байсан шүү дээ. Тэгэхээр Хууль зүйн байнгын хороо энэ редакцын засвар дээрээ ч гэсэн энэ 3 заалтыг эшилж авмаар байна.

1 дүгээрт Үндсэн хуулийн 18.5-д Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлалт тогтоож болно. 19.1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна. Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэсэн энэ заалтуудын үндсэн дээр. Ер нь манайх техник технологийн түвшин ямар билээ. Энэ заалт дэмжигдэх юм бол Монгол Улс Үндэсний аюулгүй байдлаа хамгаалах боломжгүй болно гэсэн дүгнэлт гаргасан байгаа шүү дээ. Ийм заалт яагаад ингэж хэрэгжиж байгаа юм. Ер нь бол хүний эрхийг хамгаалахдаа дүй процесс буюу эрх зүйн зайлишгүй процессын хэм хэмжээний үнэд нь л зохицуулалт хийнэ үү гэхээс биш, яг шууд гүйцэтгэх ажлын тухай хуулийн

тэр процесст нь тэр парламентын хяналт байх. Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүний яриад байгаа тэр хяналт тэнцлийг хангах замаар л хангана уу гэхээс биш шууд Үндэсний аюулгүй байдлын чадамжийг алдагдуулах, чадавхыг алдагдуулах ч зарчмаар ингэж хүний эрх, эрх чөлөөг хамгаална гэсэн ойлголт байхгүй. Ерөөсөө энэ дандаа зайлишгүй процесс дунд нь л хяналт тэмцлүүдийг бүх шатад Үндсэн хуулиас авхуулаад бүх эрх мэдлийн хооронд хяналт тэмцлээр л хангана уу гэхээс биш. Тэгэхээр энэ үндэслэлүүдийг тодорхой дурдаж тогтоох хэсэгт бол зааж байх хэрэгтэй. Тэгэхгүй бол энэ чинь хүний эрхийн чинь хамгийн гол үндэс нь Үндэсний аюулгүй байдалтай холбогддог юм шүү дээ. Гэмт хэрэгтэй ч тэмцэх чадамжгүй болно шүү дээ. Террорист бүлэг жишээлбэл илрүүлдэг тоног төхөөрөмжтэй байх юм бол бүх хяналт тавих боломжоо алдагдана шүү дээ.

Ер нь хүний эрхийн асуудал бол эрх зүйн зайлишгүй бус аргаар халдахыг л хориглож байгаа. Эрх зүйн зайлишгүй процессын бус аргаар алдаж болохгүй.

2 Байнгын хороо 100, 100 хувийн саналаар. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Байнгын хороодын саналаар санал хураалт явуулна.

1.Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэж заасны “... илрүүлэх ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. ... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн

зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Тусгай хяналтын дэд хорооны дарга орж ирж байна. Тэгээд санал хураалт явуулна. Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Болорчулуун гишүүн, Дамдинням гишүүн, Анужин гишүүн, Пүрэв-Очирын Анужин гишүүн горимын санал.

П.Анужин: Би санал хураалтаас хоцорчихлоо. Уучлаарай. Саяын санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү гэсэн саналыг гаргаж байна. Уучлаарай.

Г.Занданишатар: Болорчулуун сайд горимын санал хэлнэ. Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Төхөөрөмж ажилласангүй ээ, дахин санал хураалт явуулж өгнө үү.

Г.Занданишатар: Хаянгаагийн Болорчулуун гишүүн санал хураалтыг хүчингүйд тооцох горимын санал гаргасан байна. Хаянгаагийн Болорчулуун гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Туваан гишүүн бас горимын санал гаргалаа. Ингээд энэ горимын саналаар санал хураалт явуулъя. Энэ миний тоног төхөөрөмж бас ажиллахгүй болчихлоо. 57,8 хувийн саналаар санал хураалт дэмжигдэж, өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулъя. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд суудалдаа сууя. 1 цаг 54 минут 48 секунд хоцорлоо. Санал хураалт. Санал хураалт саналаа өгцгөөе. 62,2 хувийн саналаар Байнгын хороодын санал дэмжигдлээ.

2.Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах,

дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэж заасны “... илрүүлэх ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хороодын саналаар санал хурааж дууслаа.

“Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолыг хэвлэж тараасан байгаа. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Саяын Байнгын хороодын саналыг дэмжсэн. Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны саналыг дэмжсэн оролцож байгаа. Тэгэхдээ тогтоол дээрээ тэр сая хэд хэдэн гишүүд ярилаа шүү дээ. Бид нар энэ Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага байгааг дурдах нь зүйтэй юу гэж санал оруулж байна. Энэ бол оруулчхаж болох болов уу гэж бодох юм. Дахиж найруулж байгаад. Тэгээд эцсийн найруулгыг сонсоод. Энэ дээр ер нь сая 2, 3 гишүүн хэлсэн. Үнэхээр Их Хурлын зүгээс, парламентын зүгээс энэ гүйцэтгэх ажилд тавих хяналтыг илүү боловсронгуй болгох ийм шаардлага байгаа юм. Би бас Хууль зүйн байнгын хороотой ярьж байсан. Энхбаяр даргад хэлж байсан. Олон улсын парламентын

холбооноос гарсан яг энэ чиглэлээр парламентууд ямар үүрэг гүйцэтгэх ёстой, ямар эрхтэй, үүрэгтэй байх юм гэдгийг нэлээн заачихсан бүр бүх парламентуудад хандсан зөвлөмж байдаг. Тэрний дагуу бас Байнгын хорооноос энийгээ орчуулаад, бэлдээд санаа оноо тусгахаар ярьж байгаа юм байна лээ. Үүнийг энэ хуулийг хэлэлцсэнтэй хамтатгаад ер нь тусгайлан тогтоол гардаг юм уу, эс үгүй бол одоо гарч байгаа тогтоол дээрээ нэмээд гаргахивал тэр ажил нь зүгээр нэг яриа биш, албажсан болоод, үүрэгдсэн болоод явчих ийм суурь тавьчихна гэж бодоод байгаа. Энэ дээр Энхбаяр дарга бид 2-ын санал бол нийлж байгаа. Тэгэхээр үүнийгээ оруулж байгаад тэгээд бушуухан шиг хийж аваад, Халдашигүй байдлын дэд хороо энэ тэртэйгээ хамтраад юмнуудаа хийж байх зүйтэй. Тэр саналыг оруулчихвал яасан юм бэ гэж би найруулгын юм дээр санал болгож байна.

Г.Занданишатар: Нямаагийн Энхболд гишүүний санал 1 дүгээрт энэ найруулгатай холбоотой санал биш. Зарчмын зөрүүтэй санал байна.

2 дугаарт энэ талаар тогтоол өмнө нь батлагдсан Хууль зүйн байнгын хороо дээр яг ийм агуулгатай тогтоол, харин тогтоолоо хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулах асуудал байгаа. Түрүүн Энхбаяр гишүүн хэлэлцүүлэг дээр Нямаагийн Энхболд дарга аа, дурдсан. Тийм тогтоол батлагдаад гарчихсан юм байна лээ. Тэгэхдээ энэ дүгнэлтдээ энэ эцсийн найруулга дээр шууд орох бололцоогүй. Харин эцсийн найруулгын саналыг Улсын Их Хурлын Тамгын газар хянан хэлэлцэхдээ тогтоох хэсэгт Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар болон Байнгын хороодын хурлаар хэлэлцсэн үндэслэлүүдийг тодорхой тусгаж зааж өгье. Ингээж нөгөө тогтоох хэсгээ тодруул гэсэн ийм саналууд гарсныг эцсийн найруулгаар авъя. Ингээд эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

11.59 цаг.

Дараагийн асуудалд орно. Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ ээ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан: Эрхэм Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын гишүүд ээ,

Та бүхний өдрийн амар амгаланг айлтгая аа. Монгол Улсын хамгийн том түнш байгууллагын нэг болох Азийн хөгжлийн банктай ирэх жилүүдэд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор тус банкнаас Монгол Улсад хуваарилж болох 655 сая ам.долларын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг хийлээ. Энэхүү санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн төслийг Улсын Их Хурлын Төсөв, Эдийн засаг болон Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороодод танилцуулж, хөтөлбөрт гарын үсэг зурах эрх олгох Ерөнхий сайдын захирамжийн төслийг зөвшилцөн дэмжсэнээр 2 талаас гарын үсэг зурсан болно.

Азийн хөгжлийн банктай байгуулах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр нь олон улсын гэрээ бөгөөд Улсын Их Хурлаар зайлиггүй соёрхон батлах шаардлагатай тул ийнхүү хуулийн төслийг боловсруулж оруулж ирж байна.

Тус хөтөлбөрийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулснаар хөтөлбөрийн эх үүсвэрийг заавал авч ашиглах үүрэг хүлээхгүй бөгөөд энэ нь зээлийн гэрээ биш харин хөтөлбөрийг Улсын Их Хурлаар соёрхон баталсан тохиолдолд Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг зээлийн гэрээ хэлэлцээрийг байгуулж ажиллах цаашидаа боломж үүснэ.

Хөтөлбөрт гарын үсэг зурснаас хойших хугацаанд дараах төсөл хөтөлбөрийн зээлүүдийн яриа хэлэлцээг Азийн хөгжлийн банкттай цаашид эхлүүлэн бэлтгэл ажлыг хангаж болох юм. Үүнд, Төсвийн дэмжлэгийн хэлбэрээр гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 200 орчим сая ам.доллар, шинэ сэргэлтийн бодлого болон алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 400 орчим сая ам.доллар, Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн 2 дугаар үе шат эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанарыг сайжруулах төсөл. Ингээд санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг соёрхон баталж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: *Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар танилцуулна. Цогтбаатар гишүүнийг индэрт урьж байна.*

Д.Цогтбаатар: *Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,*

Улсын Их Хуралд Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр, 2022 оноос 2023 оны зээлийн төлөвлөгөөг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл

арга хэмжээнд туссан 7 төрлийн ажилд өөрчлөлт орсон эсэх, авч байгаа зээлийг ач холбогдлоор нь эрэмбэлэх эсэх, төсөв санхүү, эдийн засгийг бэхжүүлэх, төсвийн зээлийн хөтөлбөр, татварын удирдлагын нэгдсэн системийг шинэчлэх банкны салбарт бодлогын шинэчлэл хийх зэрэг ажлууд тусад нь хэр үр ашигтай оновчтой болох талаар, Таван толгойн цахилгаан станц барих стратегийн томоохон орд болох Асгат, Хармагтайд хөрөнгө оруулалт хийгдэх эсэх, Эдийн засгийн өсөлтийг дэмждэг салбарууд бизнес эрхлэгчид хөдөө аж ахуй, аялал жуулчлалаас гадна Монгол брэндээ дэмжих, шинэчлэх ухаан, инновацын салбарыг дэмжсэн хөрөнгө оруулалт хийх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Баделхаан Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хийгдэх хилийн боомтыг тохижуулах, зам харилцааг сайжруулах зэрэг ажлуудыг дэмжиж байгаагаа илэрхийлээд Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн төслийг соёрхон батлах тухай асуудлыг Улсын Их Хуралд хэзээ өргөн барих талаар, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар уг төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд Азийн хөгжлийн банкнаас авсан өмнөх зээлийн төслийн тодорхой багцад эсвэл бүхэлд нь үр ашгийн тооцоо судалгаа хийсэн эсэх, төсөл хэрэгжсэнээр татварын орлого, ажлын байр хэдээр нэмэгдсэн, Сүхбаатар дүүрэгт Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр баригдаж байгаа дэд станц дэд бүтэц баригдах ажил ямар шалтгаанаас зогссон, дэд бүтцийг айл өрхтэй холбоход тодорхой бодлогоор дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн боломж байгаа эсэх, зээлийн санхүүжилтээр хийгдсэн ажлууд үр өгөөжгүй болох эрсдэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан бүс нутгийн авто замыг хөгжүүлэх засвар арчлалын 3 үе шаттай төслийн хүрээнд хийгдэх үндсэн ажил болох гүүрнүүдийн их засвар, шинэчлэлийн ажлын хүрээнд Завхан,

Говь-Алтай хооронд тавих Бүрэнгийн гүүрний асуудал төсөлд туссан эсэх, Говь-Алтай Улиастай чиглэлийн авто зам аль талаасаа эхлэн тавигдах талаар, Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт туссан орон нутгийн чанартай нь нутгийн зам төслийн хүрээнд Говь-Алтай аймгийн төвтэй Дарви, Шарга, Дэлгэр, Баян-Уул, Хөх морьт зэрэг 5 сумыг холбох ажлын Дэлгэр сумын 8км, Шарга сумын 17км, Баян-Уул сумын 20км замыг төв замтай холбох ажил орсон эсэх, боомтын сэргэлтийн хүрээнд Бургастайн боомтын асуудал хэзээ орох талаар ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Дэлгэрсайхан зээлийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих иргэдээ ажилтай орлоготой болгох, иргэддээ хүү багатай зээлийг хүртээмжтэй олгох асуудлыг Сангийн яам онцгой анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр зээлийн хугацаа нөхцөлийг дэмжиж байгаа бөгөөд төслийн задаргааг эргэж харах, зээлийн эдийн засгийн үр ашигтай оновчтой зарцуулах төслийн нэгжүүдийн зардлыг бууруулахад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар Ирэх оны төсөвт Өмнөговь аймгийн Даланзадгадаас Гурвантэс хүртэлх 320км замын 80км замын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр барихаар үлдсэн замыг нь орон нутгийн төсвөөс барих ажлыг тусгах, Улаанбаатар-Шивээ хүрэн, Гашиун сухайт-Шивээ хүрэн боомтыг авто замаар холбох боломж бүрдэх тул энэ асуудлыг анхаарч судлах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар Сүхбаатар дүүргийн 13, 14 дүгээр хороонд 1,3км суваг бүхий инженерийн байгууламж баригдсан боловч төсөв байхгүйн улмаас 90 метр газарт сувгийн ажил зогссон тул шаардлагатай төсвийг шийдвэрлэх асуудлыг ойрын хугацаанд анхаарч шийдвэрлэх талаар тус тус үг хэлсэн болно.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж 80 хувийн саналаар соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр 2022-2023 оны зээлийн төлөвлөгөөг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданиатар: Зочид танилцуулъя Улсын Их Хурлын гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилэг, Ганзоригийн Тэмүүлэн нарын урилгаар Архангай аймгийн Хайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 1983 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд эргэн дурсахуйн шинэ уулзалтад нь их амжилтыг хүсэн ерөөгөөд хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт, Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Байгалмаагийн Одонтуяа, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Батмөнхийн Ерөн-Өлзий, Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага

зохицуулалтын газрын дарга Бандийн Гантулга, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ажлын албаны дарга Түмэндэмбэрэлийн Төрболд.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Сарангэрэл гишүүн. Даваажанцаны Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Азийн хөгжлийн банкны шугамаар хэрэгжиж байгаа төслүүд, авч байгаа хөнгөлөлттэй зээлүүд Монголын нийгэм, эдийн засагт болон тулгамдаж байгаа салбаруудад бол бас нэлээн тийм шийдэл болдог, үр дүнтэй хэрэгждэг ийм ажил байдаг гэж ойлгодог. Тухайлбал би жишээ авах гэж байгаа нь ковидын үед Азийн хөгжлийн банкны шугамаар 34,4 сая доллар, Дэлхийн банкны шугамаар 26,9 сая долларын эрүүл мэндийн салбарт тоног төхөөрөмж авах, болзошгүй эрсдэлээс хамгаалах, бэлэн байх ийм зорилгоор бол зээлийн гэрээг соёрхон баталж Улсын Их Хурлаар оруулж байсан.

Олон улсын зээл хөтөлбөрийг бол Сангийн яам хариуцдаг учраас тухайн үеийн Сангийн сайд Хүрэлбаатар энэ асуудлыг бас оруулж хэлэлцүүлсэн. Харамсалтай нь бол биднийг Засгийн газарт ажиллаж байхад, тэр дундаа намайг Эрүүл мэндийн сайдаар ажиллаж байхад хүн амын дунд корона вирусийн халдвар гараагүй. Гэхдээ ямар ч байсан хэрвээ эрсдэл гарах юм бол бэлтгэл хангуулах үүднээс Сангийн яам ялангуяа Хүрэлбаатар сайд манлайлан ажиллаж саяын миний хэлсэн тоо бүхий энэ төслийг батлуулсан юм байгаа юм. Тэгээд энэ мөнгийг бол Засгийн газар идэж уугаад, үр дүнгүй зарсан ийм асуудал яригддаг. Намайг Эрүүл мэндийн сайдаар ажиллаж байхад хүн амын дунд корона вирусийн халдвар гараагүй учраас бид бол саяын гэрээний мөнгийг бол 1 долларыг нь ч зарцуулаагүй. Дараагийн

ажил авсан Мөнхсайхан болон Энхболд сайд нар энэ Азийн хөгжлийн банкны шугамаар 34,4 сая доллар, Дэлхийн банкны шугамаар 26,9 сая сая долларыг зарцуулсан. Өнөөдөр энэ зарцуулалт ямар байгаа вэ. Би шууд асуухад тухайлбал Азийн хөгжлийн банкны шугамаар Улсын Их Хурлаар Сангийн сайд оруулаад батлуулсан 34,4 сая доллар Эрүүл мэндийн салбарт хэрхэн яаж үр дүнгээ өгсөн бэ. Энэ олон нийтийн шүүмжлээд байгаа шиг үр дүнгүй хэн нэгэн хүний карманд орчихсон авлига, хээл хахууль болчихсон ийм зүйл байгаа юу. Сангийн яам энэ Азийн хөгжлийн банкны шугамаар хийгдсэн энэ төсөл дээр хяналт шалгалт, дүгнэлт хийсэн үү. Өнөөдөр хэдэн эрүүл мэндийн байгууллага энэ 34,4 сая долларын үр дүнд эм тарианы нөөц болон тоног төхөөрөмжөө сайжруулж чадсан бэ. Би энэ асуултад хариулт аваад дараа нь тодруулна.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. 81.

Б.Ганзориг: Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Сарангэрэл гишүүний асуусан Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 5 яаралтай үеийн тусламжийн нэмэлт санхүүжилт төслийн хүрээнд нийтдээ бид нар одоогоор 27,4 сая ам.долларыг авч ашиглаад байна. Энэ 27,4 сая ам.долларын хүрээнд нэлээн хэд хэдэн ажлууд хийгдсэн. Би жишээлээд томоохон ажлуудаас нь та бүхэнд дурдъя. 7 аймгийн төвлөрсөн ариутгалын тасагт 91 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлэх, мөн хэт авианы багаж авах, түүнчлэн халдварын эрсдэлтэй үйлчлүүлэгчдийг оношлох, эмчлэх ангиографикийн системийг авах, мөн халдварын эрсдэлтэй үйлчлүүлэгчийг оношлох, эмчлэх 191 ширхэг тоног төхөөрөмжийг авах гэх мэтчилэн энэ төслийн хүрээнд Азийн хөгжлийн

банктайгаа тохирсон бүх санхүүжилтүүдийг яг хууль журмын дагуу авч ашигласан. Эдгээр авсан тоног төхөөрөмж маань өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Засгийн газар ковидын эсрэг авсан арга хэмжээг бол дэмжиж ажиллаж үр дүнгээ өгсөн байгаа. Баярлалаа.

Г.Занданишатар: Даваажанцаны Сарангэрэл гишүүн тодруулж асууя. 1 минут.

Д.Сарангэрэл: Ажлууд номын дагуу бүгд хийгдсэн юм байна. Нийгмийн зүгээс бол хийгдээгүй, ковидын үеэр олон улсын зээл төсөл хөтөлбөрийг бол идэж уусан гээд 2 жилийн турш ийм бухимдал явж байхад энэ сайхан бэлэн хариултаа Сангийн яам ялангуяа өөрөө ажил хариуцаж байсан хүн өгч байхгүй яасан юм. Нийгмийн бухимдал та нарт хамаагүй байдаг юм уу. Ерөөсөө энэ талын мэдээллийг би анх удаа сонсож байна шүү дээ. Одоо яг хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор 650 сая доллар буюу 2,2 их наяд гаруй төгрөг гэдэг бол их хэмжээний мөнгө. Бид нар бас зээлийнхээ асуудал дээр болгоомжтой хандаж байх ёстой гэдгийг олон нийтэд ч хэлж байгаа. Улсын Их Хуралд ч гэсэн бас ийм байр суурьтай гишүүд байдаг. Сая бол энэ төслийн танилцуулгыг харж байхад зам харгуйд нэлээн хэсэг нь явах юм байна. Энэ манай улсын зээлийн дарамтад хэрхэн нөлөөлөхөөр байгаа вэ. Энэ ийм зайлиггүй шаардлагатай зээл үү. Энэ тулгамдсан асуудал мөн үү. Энэ рүү чиглэсэн зээл заавал өнөөдөр авах шаардлага.../минут дуусав/

Г.Занданишатар: Сангийн сайд Болдын Жавхлан хариулна.

Б.Жавхлан: Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Энэ яг тухайлан төслийн гэрээг баталж байгаа асуудал биш ерөнхий хөтөлбөр юм байгаа юм. Дунд хугацааны өөрөөр хэлбэл ингээд Их Хурлаар батлагдаад тэрнээс цааш ер нь

2-3 жилийн хугацаанд бэлтгэл ажил нь хангагдаад, үүгээр ямар төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлж гэрээ авч болох вэ гэдгийг Азийн хөгжлийн банктай судлаад эргээд Их Хурлаар орж ирэх юм байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ удаа яригдаж байгаа 655 сая ам.доллар нь тус банкнаас Монгол Улсад авна шүү гэж энэ хэмжээний эх үүсвэрийг тусгайлан хадгалуулж байгаа гэсэн үг. Одоогоор бол ерөнхий байдлаар буюу саяын таны хэлсэн ер нь дэд бүтцийн чиглэлийн ийм төслүүд байдаг санхүүжүүлэх нь зүйтэй юм гэсэн 2 талын эхний хэлэлцээр явж байгаа. Энэ төслүүд нь бол дандаа Улсын Их Хурлаар батлагдсан шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд.../минут дуусав/

Г.Занданишатар: Сарангэрэл гишүүн нэг минут.

Д.Сарангэрэл: Мэдээж хэрэг Жавхлан сайд тооцоо судалгаатай хамгийн хэрэгтэй газраа бол авахаар төлөвлөж байгаа гэдгийг би ойлгож байна. Өнөөдрийн зүгээр хамгийн тулгамдаж байгаа асуудал хөдөө орон нутгийн зам харгуйгаас илүүтэй Улаанбаатар хотын түгжрэлийн асуудал бол өнөөдөр Монголын нийгэм, эдийн засгийн тэр дундаа нийслэлчүүдийн амьдралд хамгийн тулгамдсан асуудал болж байгаа. Та нар маань мэдэж байгаа. Түгжрэлийн үед машины хурд 8км цагийн хурдтай л түрүүн хэлсэн хэдэн цаг ч билээ өдөрт энэ түгжрэлд цагаа зарцуулж байгаа гээд маш олон ийм дүгнэлтүүд хийчихсэн юм байна лээ. Энэ тулгамдаж байгаа асуудлаар нь эрэмбэлэх юм бол түгжрэлдээ энэ зээлээсээ тодорхой хэмжээг нь мэдээж түлхүү хэмжээг нь зарцуулах ийм хэрвээ төсөл төлөвлөгөө юм бол тэгж төлөвлөж болох уу сайд аа.

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд хариулна.

Б.Жавхлан: Тийм. Тэгэхээр энэ яах вэ ерөнхий хөтөлбөр учраас таны ярьж

байгаа асуудлыг цааш нь үргэлжлүүлж дотор нь задалж орж ярьж бол болно. Одоогоор нийслэлдээ яг энэ ерөнхий хөтөлбөрийн хүрээнд бол яригдаагүй байгаа. Гэхдээ Засгийн газраас нийслэл Улаанбаатар хотдоо дамжуулан зээлдүүлж байгаа маш олон төслүүд байгаа. Маш олон төслүүд байгаа. Ер нь дүн нь бараг 600-с ч илүү хэмжээний ийм төсөл хөтөлбөрүүд явж байгаа, хэрэгжиж байгаа ч байгаа, одоо яригдаж байгаа төслүүд ч ер нь байгаа. Тэгээд энэ рүү оруулж болно, болно.

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Бэлгийн морины шүдийг үздэггүй ээ гээд нэг үг бий. Энэ морины шүдийг ч бүр “А”, “Б”-гүй тоолох ёстой юм байгаа юм л даа. Яагаад гэвэл энэ бэлэг биш. Энэ бол зээл, өр. Ардын хувьсгал анх гарахад бол өрийн дансны бичгийг шатаах л гэдэг ганцхан үгээр гарсан юм байгаа юм шүү дээ. Монгол орон мөнгө хүүлэлтийн аймшигтай дөнгөнд орсноо мэдээд л тэр үед ч яах вэ шатаачихдаг байж. Одоо бол тэгээд боомилуулна даа. 34 тэрбум долларын өртэй байна гэдэг бол том өр. Тэгэхээр энэ бэлгийн морины шүд гэж яриад байгаа энэ зээлийг бол сайн хянах ёстой. Ямар ч хяналтгүй, ямар ч засаг захиргаагүй явж ирсэн. Би өнөөдрийн нөхцөлийг ярьсангүй. Ер нь энэ дээр нэг эргэж харах цаг болсон. Тэгэхээр гол энэ зээл чинь хэдэн дарга нар, сайд нарт зориулсан зээл биш ээ. Бизнес эрхлэгч нар, ард түмэнд тэр дэд бүтэц байна уу. Тодорхой тэр олон асуудлуудыг шийдэх гэж. Дэлхийн банк, Валютын сан, Азийн сангийн олон бичиг баримт дээр бидний зээл тусламжийг энэ мэдээж тусламж биш зээлээд тухайн орны ард иргэд болон төрийн бус байгууллагууд болон мэргэжлийн холбоонууд нь хяналт тавих ёстой шүү гэдэг бичиг баримт дээр байнга тусдаг. Тэр ямар шатдаа явж байгаа вэ. Зүгээр нэг дарга нарын хүрээнд хөөрхий тэр дээгүүрээ л идчихдэг юм гэнэ лээ гэдэг шиг алга

болчихгүй байх баталгаа нь хэр байгаа вэ. Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, ерөнхий юм ярьж байна. Харсан чинь харин ерөнхий л юм байна. Хугацаа, хэрэгжих газар, тэгээд төслийн өртөг тэгээд л боллоо. Хүрэх үр дүн гээд заримд нь байна, заримд нь алга. Тэгэхээр энэ нарийвчилсан зүйлийг ямар шугамаар яаж ярих вэ. Яг тэр бизнес эрхлэгчид болон ард иргэдэд би Орхон аймгийнхаа бизнес эрхлэгчид, ард иргэдэд энэ төслийг яаж дэлгэрэнгүй танилцуулж, яаж энд оролцох вэ, яаж энд бизнесменүүд хамрагдах вэ гэдэг тал дээр яаж оролцох вэ. Би тэрийг өөрийнхөө пэйжээр дамжуулах хэрэгтэй байгаа. Би хаанаас яаж материалуудаа дэлгэрэнгүй авах вэ. Хоёрдугаар асуулт.

Гуравдугаар асуулт. Энэ асуудал Аюулгүй байдлын байнгын хороогоор орох нь зөв. Ер нь бол улс орон улс орныг эзэлье гэвэл ер нь цэрэг дайн танк оруулахаа больчихсон. Өртүүлээд л, зээл өгөөд л тэгээд л унагаадаг болсон цаг үед Аюулгүй байдлын байнгын хороогоор орох нь зөв. Гэхдээ мэргэжлийн Төсвийн байнгын хороо энэ дээр хаана явна вэ. Төсвийн байнгын хороогоор байр суурь нь хаана байгаа вэ. Үүний үр дүн. Хэрэгжээд энийг зүгээр дарга нарын идэж уугаад алга болгосон байна гэдэг юм уу. Эсвэл үнэхээр бодитой дэд бүтцэд оруулсан байна гэхэд үр дүнг нь Төсвийн байнгын хороо хянана гэж би ойлгож байна. Хариуцна гэж бодож байна. Тэгэхээр Төсвийн байнгын хороогоор эрх мэдлийг нь нэмэгдүүлэх тал дээр та нарт ямар нэгэн санаа оноо байгаа юу. Миний асуулт их тодорхой байна. Эцэст нь хэлэхэд ер нь бол энэ төсөв одоо та нар нарийвчилж харах юм бол хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл 2 дугаар үе шат 55 сая доллар. Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг төсвийн дэмжлэгийн төсөл 100 сая доллар. Уур амьсгал. Яг үүгээр дагнаж байгаа хүмүүс, мэргэжлийн холбоонуудтай нь яаж харилцаж байгаа вэ гэдгийг л тодруулж асуугаад байгаа шүү. Сэргээгдэх эрчим

хүчийг хөгжүүлэх төсөл. Эрдэнэбүрэн, Мянгад цахилгаан дамжуулах шугам, Алтай сум, Завханы Улиастай хучилттай замаар холбогдох гээд. Энэ эцсийн эцэст бидний хүүхдүүд, хойч үе төлнө шүү дээ. Дараа нь төлнө. Энэ төсвөөс ч илүү ноцтой, анхаарал татахуйц зүйлүүд байгаа. Энэ дээр гишүүдийн оролцоог хангах, Төсвийн байнгын хороогоор хэлэлцэх, эрэмбэлэх энэ санал санаачилгыг би гаргаж байна. Энэ талаар ер нь ганцхан энэ хэд биш. Ер нь энэ олон улсын төсөл, хөтөлбөр зээл.../минут дуусав/

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундрам, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ахмадын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт ахмадууд та бүхэнд эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Асуултад Сангийн сайд Болдын Жавхлан хариулна.

Б.Жавхлан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Хэрэгжилтийн баталгаа байна уу гэж асууж байна. Ганбаатар гишүүн ээ, ингэдэг болсон шүү. Бид өнгөрсөн жилийн 5 сард дараагийн 3 жилийнхээ гадаад өрийн стратегийг Их Хурлаар батлуулж авдаг. Өөрөөр хэлбэл энэ хүрээнд л ажиллана шүү. Та нар эндээс ийм зориулалтаар зээл аваад ингэж ашиглаарай, таазаа ингэж бариарай, хязгаараа ингэж бариарай гээд Улсын Их Хурлаас Засгийн газар гэрийн даалгавраа авчихдаг. Яг тэр хүрээндээ явж байгаа гэж ойлгоорой. Мөн гаднаас хэрвээ бид нар зээл авахаар бол одоо байгаа арилжааны өндөр хүүтэй, богино хугацаатай ийм зээл ахиж хэзээ ч авахгүй. Авсан тохиолдолд зөвхөн дахин санхүүжилтийн зорилгоор л ашиглана. Харин ялангуяа эдийн засгаа дэмжих, төлбөрийн тэнцлээ дэмжих,

бизнесийн орчныг сайжруулах, шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хийгдэх ёстой 90 гаруй төслийг Улсын Их Хурлаар батлуулж авсан байгаа. Зөвхөн энэ төслүүдийг л санхүүжүүлэхэд бүтээн байгуулалт хийхэд ашиглана шүү гэдгийг Их Хурлаас бидэнд даалгавар өгсөн. Энэ хүрээндээ л бид ажиллаж байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл Их Хурлын чиглэл дор ажиллаж байна гэсэн үг. Эн зориулалтууд нь.

Төсвийн байнгын хороогоор оролгүй яах вэ Ганбаатар гишүүн ээ, та Төсвийн байнгын хорооны гишүүн. 2022 оны 6 сард жилийн өмнө орсон. Та суусан байна. Та дэмжиж кноп дарсан байна. Танд баярлалаа. Тэгээд тэрнээс хойш энэ ингээд судлагдаад одоо хөтөлбөр ерөнхий байдлаар л ингээд батлагдана. Одоо ингээд соёрхон батлагдсанаас хойш яг таны ярьж байгаа тэр түвшинд хэрэгжүүлэгч төсвийн ерөнхийлөн захирагч сайд бүр, яам бүр дээр энэ төсөл бүр дээр ТЭЗҮ дараагийн тооцооллууд нарийн хийгдээд явах юм байгаа юм. Тэгээд яг Их Хурлаар дахиад оруулж ирж батлуулна. Тэр үед та яг төслүүд дээр ингэж ингэж хэрэгжих нь байна. Хувийн хэвшил нь ингэж ингэж хэрэгтэй зүйлүүд болох нь байна гээд тойрог, бусад иргэд дээр ийм мэдээллүүдийг өгөх боломжтой болно гэж хэлье ээ.

Энэ дээр та хараарай. Ингээд дандаа хилийн үр бүтээмж энэ боомтын сэргэлтийн хүрээнд бүс нутгийн авто зам гээд энэ хөдөөгийн хөгжил, Эрдэнэбүрэн, Мянгад, Улиастайн эрчим хүчний цахилгаан дамжуулах агаарын сүлжээ гээд энэ эрчим хүчний сэргэлтийн бодлогын хүрээнд, хүнсний аюулгүй байдал, эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанарыг сайжруулах төслийн үргэлжлэл гээд дандаа яг Их Хурлаар батлагдсан ийм жагсаалтын төслүүд байгаа гэдгийг дахин тодруулж хэлье. Баярлалаа.

Г.Занданишатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууна.

С.Ганбаатар: Тийм ээ ер нь бол Сангийн яамнаас биднийг бас сайн материалаар хангаж энэ дээр ажиллаж байгаа. Зүгээр ерөнхий нийтдээ бид энэ 30 жилийн хугацаанд өр зээл бодлого ямар шатдаа явав гэдгийг нарийвчилж эргээж харах цаг болсон гэсэн утгаар би хэллээ. Зээл авна гэдэг бол тийм буруу зүйл биш. Би ерөөсөө эсэргүүцээгүй. Зээлийн хэрэгжилт үр дүн хамгийн чухал. Энэ дээр тухайн тэр зээл хэрэгжээд үр дүнг нь хүртэх ёстой тэр ард иргэд байна уу, төрийн бус байгууллагууд байна уу, тухайн орон нутаг байна уу, тухайн мэргэжлийн тэр салбаруудынх нь оролцоог хангах нь бидэнд бүүр маш чухал байна гэсэн санааг би бас хэлсэн. Энийгээ бас би протоколд тэмдэглүүлээд дараагийн Төсвийн байнгын хороогоор ярихад энийг бас ажил хэрэг болгож санал санаачилгаа гаргахыгаа бас тэмдэглүүлье. Асуулт алга аа.

Г.Занданишатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Энэ чинь нөгөө намрын чуулганы төгсгөл дээр орж ирж байсан зээлийн гэрээний хэлэлцээр байх шив дээ. 650 сая доллар. Тэгээд нэгд Төсвийн байнгын хороогоор орж ирэхгүй юм. Дандаа төсөв мөнгө цаана нь явж байгаа. Гэтэл Төсвийн байнгын хорооны гишүүд нь ямар ч мэдээлэл байхгүй. Цаашидаа энэ ер нь төсөв санхүүтэй холбоотой асуудлаа энэ Төсвийн байнгын хороогоороо хэлэлцүүлдэг байгаач ээ. Яах гэж Төсвийн байнгын хороо байдаг юм. Нэгд энийг хэлье. Энийг асууя.

2-т Төсвийн байнгын хорооны гишүүний хувьд бол ер нь Засгийн газраас орж ирж байгаа энэ аливаа зээл, өр зээлийг бол хувь гишүүнийхээ хувьд бол дэмжихгүй. Манайх чинь улсаараа 33 тэрбум долларын өртэй болчихсон. Засгийн газрынх нь өр нь 8 тэрбум болчихсон. Тэгээд л өр зээлээсээ салъя.

Өр зээлээ бууруулъя л гээд л яваад байгаа шүү дээ. Гэтэл тэгээд л араас нь ахиад л зээл аваад л ийм ч сайхан нөхцөлтэй, ийм ч бага хүүтэй зээл гээд л ингээд л аваад л байх юм. Тэгээд зээл аваад хөгждөг болсон бол өмнөх энэ олон зээлийн чинь үр өгөөж, үр дүн нь хаана байна. Эргээд үр ашгаа өгсөн ийм төсөл хөтөлбөрүүд гээд хэлчих юм хаа байна. Үнэхээр харамсалтай байгаа шүү дээ. Энэ Азийн хөгжлийн банкнаас ер нь өнгөрсөн хугацаанд хэчнээн хэмжээний зээл авсан юм. Үүний үр дүнг ер нь хэлэлцсэн тайлан баланс хэлэлцсэн юм байна уу. Тэгээд л араас нь өмнөх зээлийн үр ашгийг хэлэлцээгүй байж байж л дараагийн зээлээ залгуулаад л авах юм ярих юм. Тэгээд ингээд харахаар зарим нэг энэ 7 төрлийн төсөл хөтөлбөрийн чинь зарим нь болохоор тодорхой ажил хийхээр ингээд ороод ирчихсэн. Зарим нь болохоор үндсэндээ ерөнхий ингээд ажлууд Хөдөө аж ахуй, Уур амьсгалын ингээд. Энэ 7 яамны сайд л хуваагаад авчаж байгаа юм байна шүү дээ. Энэ зээлийг чинь. Хөдөө аж ахуйн сайд, Зам тээврийн сайд, Байгаль орчны сайд, Боловсролын сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Тэгээд ингээд л зээлээ нэмээд явах юм уу?

Тэгээд Төсвийн байнгын хорооны гишүүд нь хамгийн гол нь ямар ч ойлголт мэдээлэл байхгүй. Төсвийн байнгын хороон дээр энэ асуудлаа ярьдаггүй. Тэгээд үүний эргэн төлөлт үр дүн нь юу байгаа юм. Аваад ямар эдийн засгийн, энэ эрх барьж байгаа намын мөрийн хөтөлбөр ингээж хэрэгжинэ гэсэн юм байгаа юм уу. Энэ амлалтууд ингээж хэрэгжинэ гэж байгаа юм байгаа юм уу. Үнэхээр аминд тулчихсан ажил байгаа учраас энэ ийм шийдвэр гарна, үр дүн гарна гэсэн юм байгаа юм уу. Тэгээд ийм гоё ганган зээлүүдээ хэзээ болих юм бэ. Хувь гишүүнийхээ хувьд бол би бол дэмжихгүй байр суурьтай байна. Баярлалаа.

Б.Жавхлан: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Бид 3, 3 жилээр

гадаад өрнийхөө стратегийг батлуулж явдаг. Их Хурлаар. Тэгэх бүрдээ гадаад зээлийн байдал, эрсдэл, ашиглалтын тайлан, дараагийн 3 жил ямар зээлүүдийг авч юунд зориулах вэ гэдгийгээ Улсын Их Хурлаар батлуулаад явдаг байгаа. Тэр үед бүх тайлангаа хэлэлцээд ингээд цаашаагаа зөвшөөрөл аваад явдаг гэсэн үг. Энэ дагуу бид нар яг жилийн өмнө дараагийн 3 жилийнхээ ерөнхий төлөвлөгөөгөө батлуулаад, стратегиа батлуулаад ингээд явж байгаа шүү. Тэр үед нэг бүрчлэн маш дэлгэрэнгүй ярьсан байгаа. Азийн хөгжлийн банктэй бид 33 дахь жилдээ ажиллаж байна. Манай хамгийн том зээлдүүлэгч. Ийм олон талт хөгжлийн институт байгаа. Одоогоор 2,3 нийтдээ зээлийн ашиглалт нь бол 2,3 тэрбум долларын 101 төсөл арга хэмжээг бид хэрэгжүүлсэн байдаг юм. Одоо яригдаж байгаа энэ 650 сая доллар нь бол би түрүүн хэд хэд хэллээ. Улсын Их Хурлаар батлагдсан шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хийгдэх ер нь голцуу дэд бүтцийн ийм төслүүд байгаа. 650 сая долларын яг тулсан энэ дэд бүтцийн томоохон ажлуудыг бид нар төсвөөрөө яагаад ч хийж чадахгүй. Бид нар 2,2 их наяд төгрөгийн ийм санхүүжилтийг бид нар гаргаж чадахгүй. Тийм учраас ийм бага хүүтэй, нэн хөнгөлөлттэй урт хугацааны зээлээр энийг санхүүжүүлээд явах нь эдийн засагт үр өгөөжтэй юм гэдгээр бид ингээд ажиллаж байгаа гэдгийг ойлгоорой. Төсвийн байнгын хороогоор орох уу, хаагуур орох вэ гэдгийг бид үзэмжээрээ шийднэ гэж юу байх вэ. Энэ дэгийн тухай хуулиараа гадаад өр зээлийн асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Улсын Их Хуралд орж ирж танилцуулдаг. Замд нь Төсвийн байнгын хороогоор танилцуулдаг. Төсвийн байнгын хороогоор жилийн өмнө танилцуулсан. 2022 оны 6 сарын 28-ны өдөр танилцуулж Төсвийн байнгын хорооноос дэмжигдээд ингээд шат дараатай явж байгаа асуудал байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуулт асууна.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Хуулийн төслийг дэмжиж байгаа. Нэг товчхон асуулт байна. Энэ 2022-2023 оны ерөнхий хөтөлбөр гээд байх юм. Тэгээд энэ чинь хугацаа нь оройтчихож байгаа юм биш үү Жавхлан сайд аа. Энийг 2021 оны сүүлээр л баталж байх ёстой байсан юм биш үү. Ямар нэгэн шалтгаан байна уу. Одоо энэ 2023 оны дундуур батлахлаар чинь энэ хэрэгжилтэд нь яаж нөлөөлдөг юм бэ.

Л.Мөнхбаатар: Сангийн сайд Болдын Жавхлан асуултад хариулъя.

Б.Жавхлан: Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. Энэ цаг хугацааны хувьд яг таарч байгаа юм. Одоо ингээд эндээс соёрхон батлуулаад Азийн хөгжлийн банкны захирлуудын зөвлөлийн хурлаар оруулж эцэслэн тэндээ мөн батлагдана. Ингээд яг ногоон гэрэл асаад төслүүд дээрээ яамнуудаараа хэлэлцэгдээд ойрын 2-3 жилийн хугацаанд хэрэгжиж эхлэх ийм төслүүд дээр л бид ажиллах юм байгаа юм. Тэгээд цаг хугацааны хувьд бид нар ямар ч байсан энэ хавартаа бид соёрхон батлуулаад явуулчихвал амжихаар байгаа.

Л.Мөнхбаатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуултаа асууя.

Б.Энхбаяр: Азийн хөгжлийн банктэй санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн 650 сая доллароос 10 сая доллар нь бол сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах гэсэн чиглэлд зарцуулах юм байна. 10 сая доллар нь болохоор Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол, Сүхбаатар дүүргүүдийн болон Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төвд гэсэн ийм 5 байршилд сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд гэж байгаа байхгүй юу. Тэгээд 10 сая доллар гэдэг чинь 35 тэрбум төгрөг. Одоо чинь 640 хүүхдийн 1 сургууль чинь

10, 11 тэрбум төгрөгийн өртөгтэй болчихоод байгаа шүү дээ. Тэгэхээр энэ 640 хүүхдийн үндсэндээ 3 сургууль бол барих мөнгө байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ тэгээд ихэнх нь бол зам юу л юм байна л даа. Дэд бүтцийн чиглэлийнх юм байна. Энэ сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг дээшлүүлэх энэ төсөвт өртгийг нь нэмэгдүүлж болохгүй юу. Энэ бол саяын хэлсэн 5 байршилд 10 сая доллар гэвэл энэ жишээлбэл манай Баянзүрх дүүрэгт бол 1 сургууль ч барих мөнгө хүрэхгүй юм шиг мөнгө л харагдаад байна л даа. Тэгтэл 2024 онд жишээлбэл миний бие Сангийн яам болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамд өөрийн 22 дугаар тойргийн газар нь чөлөөлөгдчихсөн, дэд бүтцийн хувьд асуудалгүй гэсэн 7 байршилд 4 сургууль, 3 цэцэрлэг барих шинээр барих хөрөнгө оруулалтын санал хүргүүлсэн байгаа юм. Энэний төсөвт өртөг нь 92 тэрбум төгрөг болж байсан. Зөвхөн миний сонгогдсон тойрог дээр л гэхэд. Манай тойргийн тухайд бол улсын хэмжээний 1 хүүхдэд ноогдох сургууль, цэцэрлэгийн хүртээмжийн байдлаар бол улсын хэмжээнд хамгийн сүүл мушгиж байгаа. Энийг бол Энх-Амгалан сайд бол маш сайн мэдэж байгаа. Ийм газар байгаа. Огт сургууль, цэцэрлэггүй 2 хороо байгаа. 10 мянган хүнтэй шүү дээ. 10 мянган хүнд сургууль, цэцэрлэг байхгүй ийм бүүр 2 хороо байгаа. Тэгэхээр энэ асуудлыг энэ чинь төсөвт өртгийг нь нэмээд яг ийм нэн тулгамдчихсан байгаа газартаа нэмэх ийм боломж байна уу гэсэн эхний асуулт байгаа.

2 дахь асуулт нь бас яг энэтэй холбоотой одоо 4 жил болж байна даа. Баянзүрх дүүргийн Дүнжингаравын цааши 3км-т 1300 хүүхдийн сургууль, цэцэрлэгийн цогцолбор энэ онд ашиглалтад орох учиртай. Тэгэхээр манай сонгогчид бас асуугаад байгаа. Энэ хэзээ ашиглалтад яг орох вэ. Яг энэ жилдээ яг ашиглалтад орно биз дээ гэдэг зүйлийг би бол Боловсролын сайдаас асууж байгаа юм.

2 дугаарт нь энд 25, 26 дугаар хорооны хүүхдүүдийг 3км таслалтай байгаа учраас бас нэгдсэн журмаар автобус явуулахгүй бол энэ цаашаа түгжрэл үүсэх гээд байгаа юм. Бас хувийн тээврийн хэрэгслээрээ цаашаа хүүхдээ зөөх юм бол түгжрэл үүсэх гээд байгаа юм. Угаасаа түгжрэлтэй байгаа, Улаанбаатарын хамгийн түгжрэлтэй байгаа хороо шүү дээ энэ чинь. Тэгэхээр энэ дээр бас ямар зүйлийг бодож байна вэ гэсэн ийм асуулт байна.

Л.Мөнхбаатар: Энхбаяр гишүүний асуултад хэн хариулах вэ. Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Азийн хөгжлийн банкны нэмэлт санхүүжилтээр яах вэ манай салбарт шийдэж байгаа нь 10 сая долларын л санхүүжилт байгаа юм л даа. Тэгээд энэ дээр яах вэ, гол бид нарын ач холбогдол өгч байгаа гол зүйл бол ерөнхийдөө 3 ээлжид орчих гээд байгаа эрсдэлтэй 17 сургууль нийслэлийн хэмжээнд байгаад байгаа юм. Тэгэхээр өнгөрсөн жил бид нар Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газар нэлээн хүч чармайлт тавьсны хүрээнд бид нар цэцэрлэгийн хүртээмжийг шийдэж чадсан. Энэ маш том дэвшил болсон. Тэрэнтэй адилхнаар энэ жилийн 9 сарын 1-ээс өмнө бид нарын хийхээр зорьж байгаа гол ажил бол ер нь энэ 3 ээлжийн сургуулиуд дээрээ бид нар тодорхой бодлогын арга хэмжээ авмаар юм байна 1 дүгээрт.

2 дугаарт бол 1 ангид энэ 50, 60-уулаа сууж байгаа энэ асуудал дээр бас тодорхой бодлогын шийдлүүд хийх ёстой юм байна гэж. Тэгэхээр цаашидаа ерөөсөө 1 ангид 45 хүүхдээс дээшээ хүүхэд сургахгүй байх энэ боломжуудыг л бид нар хангаж өгөх ёстой юм байна гэж байгаа юм.

Мэдээж урт хугацаанд энэ бол том сургуулиуд барьж байж л шийдэгдэнэ. Урт хугацаанд. Гэхдээ сургууль барьтал бүгд хүүхдүүдийг 1 ангидаа 50, 60-аар нь

суулгаад бид нар хараад суугаад байж байна. Тэгээд хот, хөдөөгийн боловсролын чанарын ялгаа, хотын төвийн сургууль, хотын захын сургуулийн чанарын ялгаа арилгах гэж байна гэж ингэж нүд хуурч бид нар сууж болохгүй л дээ. Тийм учраас энэ намрын барих гэж байгаа гол зорилго бол энэ 3 ээлжид одоо орчихсон байгаа, орох гэж байгаа энэ эрсдэлтэй сургуулиуд дээр энэ өргөтгөлийн барилгуудыг зарим сургуулиуд дээр давхар нэмэх ийм шийдлүүдийг гаргаж ирээд л Азийн хөгжлийн банканд танилцуулаад ингээд энэ дэмжигдээд л ингээд л явж байгаа ийм байгаа.

Энхбаяр гишүүний хувьд яг энэ Азийн хөгжлийн банкны юугаар хийгдэж байгаа Баянзүрх дүүргийн 24 дүгээр хорооны 1 шинэ цэцэрлэг, Баянзүрх дүүрэг дээр одоо энэ чинь бараг үндсэндээ Баянзүрх дээр гэхэд 3 цэцэрлэг шинээр баригдах ийм төлөвлөлтүүд, өргөтгөлүүд хийх энэ асуудлууд энэ төслийнхөө хүрээнд ингээд явагдаж байгаа. Таны хөндөж тавьсан тэр сургууль бол хариуцлагатайгаар хэлье. Энэ намар гэхэд ямар ч байсан энэ хичээлийн жилийн 10 сарын 1 гэхэд ашиглалтад ороод хүүхдүүдээ авах ийм боломжоор л бид нар хангаж ажиллаж гэж байгаа. Энэ дээр нөгөө мордохын хазгай гэдэг шиг бас их олон тийм бодлогын алдаанууд гарсан. Нийслэлийн хооронд, яамдын хооронд, гүйцэтгэгчдийн хооронд. Тэгээд дулааны эх үүсвэрүүдийг хаанаас яаж шийдэх вэ тэгээд хувийн нөгөө компаниудын газар дээр энэ дулааныхаа шугамыг татах, татахгүй тухай асуудал гээд ингээд маргаан явж явж байгаад л тэгээд 1 эцсийн шийдэл гаргаад энэ намар гэхэд энэ сургууль ашиглалтад орно л гэдгийг танд хариуцлагатайгаар хэлье.

Л.Мөнхбаатар: Балжиннямын Баярсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Баярсайхан: Энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Тэгээд хэд хэдэн асуулт байна.

1 дүгээр асуулт Азийн хөгжлийн банкны 4 дэх үе шатад ямар ямар ажлууд орохоор тусгагдсан бэ гэдэг дээр тодорхой яг ямар салбарт энэ зээл зориулагдах юм бэ гэдэг асуулт байна.

2 дугаар асуулт бол энэ Азийн хөгжлийн банктэй хийсэн гэрээний дагуу Говь-Алтай, Завхан аймгийг холбох 198км авто замын ажил байгаа. Энэ ажил яг энэ зээлийн хүрээнд хэзээ хийгдэж дуусах вэ. Бүрэн. Энэ онд эхэлнэ гэж байгаа. Яг хэдэн километр барих юм бэ. Энэ ажлыг бол орон нутгийн чанартай хөгжлийн ажил ярьж байна гэж бас шүүмжлээд байх шиг байсан. Зарим аймгууд бүх сумаа нийслэлтэй холбож байхад Завхан аймгийн хувьд бол урд байгаа хөрш аймагтайгаа авто замаар холбогдох гэж байгаа л ийм л бүтээн байгуулалтын ажил байгаа. Энэ ажлыг асууж байна.

3 дугаарт энэ Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн 2 дугаар үе шат хэрэгжих юм байна. Энэ дотор агро бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд зээл олгох, хөдөө аж ахуй, газар тариалангийн бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгжид техник, технологийн дэвшилийг нэвтрүүлэх, хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулалтын хүчин чадал үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гэсэн зорилтууд туссан байна. Энэ алслагдсан аймгуудад яаж хэрэгжих юм бэ. Өнөөдөр хүнсний аюулгүй байдлын хангамж гээд л олон олон зорилтууд яваад байгаа боловч яг үнэндээ энэ алслагдсан аймгуудад энэ зээл тусламж, энэ төслийн үр дүн бас төдийлөн сайн хүрэхгүй байгаад байна. Одоо хөдөө орон нутагт хамгийн их бухимдуулж байгаа зүйл энэ Дарханы арьс ширний нэхий боловсруулах үйлдвэр хугацаандаа ашиглалтад орохгүй байна. Хэзээ орох вэ гэдэг асуудал байгаа. Үнэхээр энэ үйлдвэр удааширч байгаа юм бол орон нутагт бага оврын ийм арьс шир боловсруулах үйлдвэр энэ төслийн хүрээнд баригдах боломжтой юу гэсэн ийм асуулт байна.

Мөн энэ Улиастай дэд станцыг барих ажил энэ төслийн хүрээнд тавигдсан байгаа. Тэгэхээр энэ ажил бас ямар хэмжээнд хэзээ хийгдэх юм бэ гэсэн эдгээр асуултуудад эхлээд хариулт авъя. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг хариулах уу. Ажлын хэсэг өмнөх дугаараа өргөөд 83 дугаар микрофон өгье. Албан тушаал, нэрээ хэлээд асуултад хариулаарай.

Б.Одонтуяа: Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр одоогийн өргөн барьсан байгаа санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд Ховд, Увс, Говь-Алтай, Завхан аймгуудын төвийг холбох 163,3км авто зам, мөн 198км авто замуудыг барих 150 сая долларын төсөвт өртөгтэй бүс нутгийн автозамыг хөгжүүлэх төслийн 3 дугаар үе шатны санхүүжилт батлагдана гэж ойлгож болно. Мөн түүнчлэн аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр гээд Азийн хөгжлийн банктай бид нар бас тусдаа санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг өргөн барихаар бэлтгэл ажлаа хангасан байгаа. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд бол цаашидаа бид нар алслагдсан аймаг болон нийт улсын хэмжээнд 52 байришлд 17 аймгийн 35 сум аймгуудын төвийг оруулсан 52 сумд жижиг дундын бизнесийн зээл болон дэд бүтцийн ажлуудыг хийх хөрөнгө оруулалтын хөтөлбөр удахгүй бас чуулганаар хэлэлцүүлэхээр төлөвлөж ажиллаж байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу. Нэмээд хариулчихъя. 83 дугаар микрофон өгье. Гүйцээгээд хариулчих.

Б.Одонтуяа: Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх 4 дүгээр үе шатын хүрээнд Арц суурь, Шивээ хүрэн өнгийн авто замыг холбох төслийн саналыг Азийн хөгжлийн банкны эхний ээлжид

хэлэлцээд явж байгаа. Азийн хөгжлийн банкны зүгээс техник тусалцааны хүрээнд бэлтгэл ажлыг хангах, зураг төсөл болон ТЭЗҮ хийх ажлуудыг эхлээд хийж байж дараа нь төслийг хэрэгжүүлэх саналаа баталгаажуулдаг байгаа.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулъя Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Тэгээд одоо хэлэлцэж байгаа асуудал 655 сая долларын зээлийн хэлэлцээр хэлэлцэж байгаа. Үүнээс 150 сая доллароор нь баруун бүсийн баруун аймгуудын хооронд холбох хатуу хучилттай замын төсөл. Нийтдээ биш. Манай гишүүд жоохон буруу ойлголттой байх шиг байна. 1 дүгээрт нь хэлье.

2 дугаарт нь эхний ээлжид 3 дугаар үе шатанд бол Улаангом Ховдыг холбох юм. Энэ бол Орос, Монгол, Хятад 3 улсыг холбосон баруун бүсийн коридор болох эдийн засгийн хувьд ач холбогдолтой гэж байгаа учраас 1 дүгээр ээлжид тавигдсан юм байна лээ. Мөн үүнтэй зэрэгцээд Говь-Алтай аймгийн төв, Завхан аймгийн төв Улиастай хотыг холбох ажлууд хийгдэнэ. Энд бол санхүүжилтээс тодорхой хэсэг нь зарцуулагдана. Үлдсэн ажлуудыг 4 дүгээр шатаас санхүүжүүлнэ. Өөрөөр хэлэх юм бол энэ удаагийн 650 сая долларын 150 сая нь замд зарцуулагдана 150 саяас зарцуулах хөрөнгөөс Завхан аймаг Говь-Алтай аймгийг холбох 2 аймгийг холбох зам санхүүжилтийн эх үүсвэр хүрэлцэхгүй байгаа. Тийм болохоор 4 дүгээр ээлжийн эхний ээлжид нэгэнт эхэлсэн ажлаа дуусгах энэ бас төсвийн хуулийн зарчмын дагуу бид нар Завхан аймаг Говь-Алтай аймгийг эхний ээлжид бас холбох ажлыг эхний санхүүжилтийг нь шийдэхийг эхний ээлжид зарчим болгож ажиллана.

Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд 1 ч шинэ хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил байхгүй байгаа.

Тэгээд энэ хүрээндээ бас зарим аймгуудын төвийг Нутгийн зам хөтөлбөрийг хэрэгжүүлэх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, зарим аймгуудын сумдыг холбох ажлуудад хөрөнгө санхүүжилт дутагдалтай байгаа. Үнэн. Үүнийг 2024 онд бас тодорхой хэмжээгээр санхүүжүүлж хэрэгжүүлбэ гэдэг саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд бид нар бас тавьж байгаа. Эдийн засаг, хөгжлийн яам энэ 2024 онд төлөвлөгөө батлагдсан. Энэ төлөвлөгөө дээр бол зарим аймгуудын зарим сумдыг бас хатуу хучилттай замаар холбох тодорхой төслүүд хэрэгжинэ. Энэ Азийн хөгжлийн банкны энэ санхүүжилтийн хүрээнд үндсэндээ зам дагуух юу гэдэг юм 2 аймгийг холбох, зам дагах ойролцоох сумдыг бас холбох хатуу хучилттай замаар холбох ажлыг бас хийж хэрэгжүүлэхээр төсвийн хэмнэгдсэн хөрөнгөөс шийдэгдээд явдаг ийм зарчим байдаг. Үүний дагуу бас өмнө нь ч шийдээд явж байгаа жишиг байгаа. Үүнтэй адилхан цаашидаа бас Завхан, Говь-Алтай аймаг болон Ховд, Увс аймгийг холбох энэ зам дагуух сумдыг бас хатуу хучилттай замаар холбох санхүүжилтийнх нь эх үүсвэр хэмнэгдсэн тохиолдолд ингээд холбох ийм бодлогыг бас баримталж ажиллана гэдгийг бас танд хэлье ээ.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу. Балжиннямын Баярсайхан гишүүн тодруулж асууя.

Б.Баярсайхан: Баярлалаа. Тэгвэл энэ төслийн хүрээнд ямар ч байсан 198км авто замын тал нь энэ жил эхлээд явах юм байна гэж ойлголоо. Тэгээд Завхан аймаг энэ жил 100 жилийн ойтой байгаа. Завхан аймгаас эхлээд ингээд 100-аад километр зам бол энэ ондоо тавигдах юм байна гэж ойлголоо. Ер нь бол хотын төвлөрлийг сааруулъя, хотод цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг бий болгож энэ түгжрэлийг сааруулъя гэвэл бид нар хөдөөгөө л хөгжүүлэх шаардлагатай байгаа. Тэгэхээр хөдөө яг

хөдөөгийн иргэдийн амьдрах тэр суурь нөхцөл болсон энэ зам, дэд бүтэц, сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг бид нар дэмжсэнээрээ л өнөөдөр хотдоо бид нар төвлөрлийг сааруулна хөдөөдөө хүмүүсээ аз жаргалтай амьдруулна. Тийм учраас энэ төслийн хүрээнд бас хөдөөг сэргээх энэ ажлаа үр дүнтэй бас хийнэ гэж итгэж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа.

Ингээд хуулийн төслийн эцэслэн батлах санал хураалтыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д заасны дагуу маргааш өглөө Баасан гаргийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар явуулна.

12.47 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. Таныг индэрт урьж байна. Ажлын хэсгийг бас оруулаарай.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дэд дарга Эрхэм гишүүд ээ,

Монгол Улс, Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцод 1989 онд нэгдэн орж, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 162 дахь гишүүн болсноор тус байгууллагын бодлого, стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, гэрээ конвенцод нэгдэх, аюулгүй ажиллагааны аудит, хамтын ажиллагааны төсөл хөтөлбөр, сургалтад хамрагдах, хурал чуулганд оролцох зэргээр олон улсын иргэний

нисэхийн үйл хэрэгт оролцоод ирсэн билээ.

Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай 1963 оны Токиогийн конвенцид манай улс 1990 онд нэгдэн орсон. Агаарын хөлөг түүний дотор байгаа хүмүүс, өмч хөрөнгө, хөлгийн бүхээг дэх хэвийн журам дэглэмд аюул учруулж болзошгүй агаарын хөлгийн бүхээг дэх хяналтгүй зан төлөвийн ноцтой байдал давтамж нэмэгдэж буйтай холбогдуулан түүнийг хязгаарлах хэвийн журам дэглэмийг сэргээн тогтооход харилцан туслалцаа үзүүлэх, олон улсын хэм хэмжээг бэхжүүлэх зорилгоор Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 2014 оны Нисэхийн аюулгүй байдлын дипломат Бага хурлаас дээрх конвенцын нэмэлт протоколыг баталсан байна.

Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протоколоор агаарын хөлгийн бүхээг дэх гэмт хэргийн харьяаллыг илүү өргөжүүлсэн бөгөөд хэв журам зөрчсөн гэм хорыг арилгахтай холбоотой нөхөн төлбөрийн зохицуулалтыг нэмж тусгажээ. Энэхүү протокол нь 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 36 улс гарын үсэг зурж, 17 улс хоёрхон баталж, 26 улс нэгдэн орж, 2 улс хүлээн зөвшөөрчээ.

Агаарын тээврийг либералчилж, нислэгийн тоо, чиглэлийг эрчимтэй нэмэгдүүлж байгаа энэ үед манай улс нь иргэний нисэхийн аюулгүй байдлын стандарт түвшнийг олон улсын шинэчлэн сайжруулсаар байгаа стандарт шаардлагад нийцүүлэх, агаарын хөлгийн бүхээгт үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээ авах, хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг зайлшгүй сайжруулах шаардлага үүсээд байна.

Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон баталснаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардахгүй бөгөөд шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.

Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Бямбацогт сайдад баярлалаа. Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна. Наранбаатар гишүүнийг индэрт урьж байна.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дэд дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Уг хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, уг хэлээгүй бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, тус конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Агаарын бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, уг хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Наранбаатар гишүүнд баярлалаа. Чуулганы хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Зам тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга Сүхээгийн Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Чимэддоржийн Мөнхтуяа, Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын албаны дарга Пүрэвжавын Ганболд нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд байна уу. Нэрээ өгье. Алга байна.

Байнгын хорооны саналаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д заасны дагуу маргааш буюу Баасан гаргийн 10 цагт санал хураалтыг явуулъя.

12.53 цаг.

Дараагийнхаа асуудалд орёе.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Д.Тогтохсүрэн: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 4 гишүүн 2023 оны 4 сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл Д.Ганбат нараас 2023 оны 4 сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд ишлжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 79 дүгээр захирамжаар дээрх хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэнгээр ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, Б.Баттөмөр, Н.Ганибал, Т.Доржханд, Ц.Мөнхцэцэг, С.Одонтуяа, Д.Сарангэрэл, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Б.Энх-

Амгалан, Б.Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Гадаад харилцааны яам, Үндэсний аудитын газар, Сонгуулийн ерөнхий хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороо болон судлаачдын төлөөллийг оролцуулан байгуулж ажиллууллаа.

Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн хуулийн төслүүдийг хэлэлцэхдээ Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 4 гишүүний Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд суурилуулан нэгтгэн хэлэлцэх горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын D-Parliament.mn цахим системээр дамжуулан олон нийтээс тухайн төсөлтэй холбогдуулан санал авахад нэр бүхий иргэдээс 56 санал ирүүлснийг ажлын хэсэгт танилцуулсан болно.

Тус Байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд

нийцүүлэн Улсын Их Хурлын 126 гишүүний 78 гишүүнийг сонгуулийн тойргоос олныг төлөөлөх мажоритар хаалт дотор аргаар, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх буюу пропорциональ аргаар сонгох, гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдрийг Улсын Их Хурал тогтоох бөгөөд 4 хүртэл өдөр байх, гадаадад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий төв болон салбар комиссын чиг үүрэг, сонгогч тухайн тойргийн мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчид болон нам, эвсэлд санал өгөх тухай, Төрийн аудитын байгууллага нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр болон хандивын талаар дүгнэлт гаргах, сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоохтой холбогдох асуудлын талаар, сонгуулийн зардлыг бууруулах зорилгоор тойрог тус бүрд нь нэр дэвшигчийн зурагт хуудасны байршуулсан нэгдсэн самбартай байх зохицуулалтыг тусгах, нам нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчдээсээ мөнгөн болон мөнгөн бус хандив, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглох, Ардчилсан ёс, шударга ёсны зарчмыг баримтлах, нийгмийн төлөөлөл оролцоог хангах, жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааг нам эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага эрхлэн явуулах, сонгогчдын нэрийн жагсаалтад давхардал байгаа эсэхийг нягтлан шалгах зорилгоор сонгуульд оролцож байгаа нам, эвсэлд сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим хэлбэрээр 2 удаа өгөх, нам, эвсэлд суудал хуваарилахдаа намын тухайд нам эвсэлд өгсөн нийт саналын 3 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх шаардлагыг 4 ба түүнээс дээш болгон өөрчлөх, тухайн тойрогт санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн саналыг тойрогт нэр дэвшигчдээс хэн нь ч аваагүй, эсхүл тухайн тойргийн мандатын тоонд хүрээгүй бол үлдсэн мандатад дахин санал хураалт явуулахтай холбогдох зохицуулалтуудыг хасах, нам, эвслийн авсан саналд ноогдох суудлын тоо нь тухайн нам, эвслийн

жагсаалтаар нэр дэвшигчийн тооноос илүүд тооцогдсоны улмаас хуваарилагдаагүй үлдсэн суудлыг хуваарилагдаагүй суудалд тооцох зэрэг нэгтгэсэн нийт 55, хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбоотой 4, нийт 59 зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэл, Адъяасүрэн, Оюунчимэг, Одонтуяа, Сүхбаатар, Доржханд нар нам эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 40-өөс доошгүй хувь аль 1 хүйсийнх байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа нэр дэвшигчийн үнэмлэхийг санал авах өдрөөс 22 хоногийн өмнө олгодог зохицуулалтыг хэвээр үлдээх, Улсын Их Хурлын гишүүд Доржханд саналын хуудаст нам эвслийн нэрийг Улсын Их Хурлын өмнөх сонгуульд авсан суудал саналын тооны ихээс бага руу жагсааж дарааллын дагуу бичих талаар тус тус санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Хэлэлцүүлгийн үед Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэл, Оюунчимэг, Батсуурь, Сүхбаатар, Туваан нар хуулийн нэгтгэсэн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно. Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэгтгэсэн төслийн талаар санал хурааж дэмжигдсэн зарим зарчмын зөрүүтэй саналын томъёолол Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зохицуулалттай зөрчилтэй эсэх, хэрхэн нийцүүлэх, түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбоотойгоор нэгтгэсэн төслийг дагаж мөрдөх хугацааг нийцүүлэх талаар эрх зүйн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргуулах санал гаргасныг Байнгын

хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тогтохсүрэн даргад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Сонгуулийн ерөнхий хорооны дарга Пүрэвийн Дэлгэрнаран, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга Дугардоржийн Баяндүүрэн, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Дагвадоржийн Дэлгэрсайхан, Гадаад харилцааны яамны Консулын газрын дарга Бат-Очирын Болд, Цахим хөгжил харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Лхагвасүрэнгийн Энхбат. Энхбат дарга ирсэн байна. Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга Алтайн Лувсан-Очир, Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Доржсүрэнгийн

Бат-Эрдэнэ, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Алинагийн Энхмаа, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Няндагийн Наранцэцэг. Наранцэцэг дарга ирсэн байгаа юм байна. Судлаач, доктор Эрдэнэбилигийн Гэрэлт-Од нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их хурлын гишүүд байна уу. Нийтдээ 62 санал хураалт явагдана. Санал хураалтын үед бас асуух боломжтой байгаа. Ганбаатар гишүүнээр тасаллаа. Нэрсийг нь нэмье. Жаргалмаа гишүүн байна. Өнөрболор гишүүн байна. Сандаг-Очир гишүүн байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн. Өөр хэн байна. Ганбат гишүүнийг нэмлээ. Ганбат гишүүнээр тасаллаа. Болсон уу. Ганбат гишүүнийг нэмээрэй. Ингээд Ганбат гишүүнээр тасаллаа.

Тогтохсүрэн дарга аа, юу яах юм уу хэлэлцүүлгээ явуулах уу. 13 цаг болсон байна. Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдааныг завсарлууллаа. 14 цагаас чуулганы нэгдсэн хуралдаан эхэлнэ.

ЗАВСАРЛАГА.

Л.Мөнхбаатар: *Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан нээгдсэнийг мэдэгдье ээ.*

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: *Бид нар саяхан Үндсэн хуульд өөрчлөлт оруулсан. Өөрчлөлт оруулах гол шалтгаан нь улс орны ирэх жилүүдийн урт хугацааны хөгжлийн бодлогоо зөв тодорхойлох, төсвийг үр дүнтэй байлгах, Монгол хүнээ бодох, ингээд алсыг харсан том өөрчлөлт хийж байгаа гээд ард түмнээрээ хэлэлцүүлээд ингээд өөрчлөлт*

хийсэн. Тэгээд Үндсэн хуулийн өөрчлөлт амьдрал дээр яг бодитоор нөгөө хэлж, ярьж байсан шигээ улс төрийн намууд хэрэгжих үү, яах вэ. Гүйцэтгэл, үр дүн нь үнэхээр гарах уу гэдэгт гол суурь нь болж өгөх хууль бол Сонгуулийн тухай хууль. Тэгэхээр Сонгуулийн тухай хуульд ингээд нэмэлт, өөрчлөлт оруулж байна. Бид нар 1 зүйл дээр их онцгой анхаарах хэрэгтэй байна л даа. Яг сонгуулийн хууль дээр жишээлбэл нөгөө холимог тогтолцоо гээд орж ирж байгаа. Жагсаалтын ард нам дугуйлах уу, хүн дугуйлах уу. Хүн бол энэ дээр ард түмэн хэн байгаа юм гэдгийг яаж мэдэх вэ гээд, жагсаалт хаалттай гэдэг нэр энд жишээлбэл зарим нэг нэр томьёолол хүртэл явж байна. Тэгэхээр би яг ажлын хэсгээс 48 гэдэг 78/48 гэж байгаа. Тэгэхээр 48 нь намын жагсаалт орохдоо намын нэр бичнэ, харин тэр нь намын нэрийн ард хэн гэж хүн байх яах вэ, Оюунчимэг байна уу, хэн байна, Энхболд гэж хүн байна уу гээд тэрийг ард иргэд яаж мэдэх вэ. Өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хороо дээр ярьж байгаагаар бол эхлээд нөгөө олон нийтийн сүлжээ ер нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр намын нэрийн жагсаалтад багтаж байгаа хүмүүсийг нэгтгээд 1 сурталчилгаа явуулж олон нийтэд ийм хүн бас намын нэрийн жагсаалтад орж байгаа гэдэг танилцуулга явна гээд тэгж байна лээ л дээ. Гэхдээ энд яг ард түмнийг төлөөлөх үүрэг хариуцлагаа ухамсарладаг, дараа нь хариуцлага тооцсон ч байж чаддаг тийм төлөөллийг л иргэд хүсэж байна шүү дээ. Яагаад гэвэл Монгол парламент гэдэг бол ард түмний төлөөллийн байгууллага. Тиймээс парламентыг чадавхтай болгох, илүү үнэ цэнтэй, чанартай байлгах асуудал нь Үндсэн хуулийн өөрчлөлтийн гол цөм байсан. Энийг хэрэгжих, эсэх нь Сонгуулийн хуулийг бид яаж зөв батлахаас бас шалтгаална. Тэгэхээр энэ жагсаалттай холбоотой бас тодорхой мэдээлэл авъя гэж бодож байна.

2 дахь зүйл нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр одоо бас ингэж байна л даа.

Одоогийн үйлчилж байгаа Сонгуулийн тухай хуулийн 39.2 дээр 8 төрлөөр сонгуулийн сурталчилгааг явуулна гэж байгаа. Өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хороо дээр харж байхад радио телевиз юм уу жишээ нь олон нийтийн сүлжээ гэдэг дээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээр бол тодорхой байгаа юм. Радио телевизээрээ ч юм уу ийм цагт ингэж явуулна гээд. Харин энэ дээр жишээ нь хэвлэмэл хуудас гэхээр сонин дээр яаж явах юм. Эсвэл энэ дээр байгаа юу, байхгүй юу. Энэ 8 хэлбэр яг 8-уулаа орж ирж байгаа юу. Одоо үйлчилж байгаа Сонгуулийн хууль дээр байгаа 39.2-т байгаа 8 хэлбэр нь яг энэ сонгуулийн хуулийн өөрчлөлт дээр тэр чигээрээ үлдэж байгаа юу, эсвэл энд өөрчлөлт орж байгаа юу. Тэгэхгүй бол байдлыг харахад бас ингээд хоёрдмол утгатай. Жишээлбэл тухайн нэр дэвшигч юм уу олон нийтийн сүлжээгээр сурталчилгаа явуулж болох ч юм шиг, болохгүй ч юм шиг ийм хоёрдмол утгатай зүйлүүд байгаад байгаа юм. Тэгэхээр энэ нь яаж өөрчлөгдөж байгаа вэ гэдэг дээр нэг тодорхой мэдээлэл авъя. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдэг дээр олон нийтийн сүлжээ гэдгийг чинь яаж ойлгох вэ гээд энэ дээр 1 дүгээрт бас тодорхой мэдээллүүд нь өөрөө чухал байна.

Нөгөө талаасаа энд намууд анх орж ирэхдээ жишээ нь Засгийн газрын төсөл дээр жендерийн баланс барих квотыг 50/50 гэсэн, Ардчилсан намын өргөн барьсан дээр 60/40 гэсэн. Одоо болохоор 70/30 болоод явж байна л даа. Тэгэхээр бас улс төрийн намууд анх оруулж ирсэн зүйл дээрээ хариуцлагатай байр суурин дээрээ бас чанга хатуу зогсох бол чухал байгаа. Жендерийн асуудал бол эрэгтэй, эмэгтэй хүний тухай биш, харин улс орны хөгжлийн асуудал. Жендерийн баланс алдагдсанаас болоод манай улсын Монгол хүний хөгжил, Монгол хүний амьдралын чанар, агаар, хөрсний бохирдол, эрүүл мэнд, боловсрол гээд энэ салбарууд яаж орхигдож өнөөдөр ямар түвшинд

байгааг бид нар бүгдээрээ харж байгаа. Энэ нь өөрөө шийдвэр гаргах түвшинд жендерийн баланс алдагдсан гол шалтгааны 1 байсан гэдэгтэй бол хэн ч маргахгүй байх. Тэгэхээр энэ асуудлуудыг бас ирэх жилүүдэд засъя гэдгээр ингэж орж ирж байсан. Гэхдээ энэ дээр жишээлбэл ямархуу байр суурь бариад ингэж явж байгаа вэ гээд.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Тогтохсүрэн дарга хариулъя.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Тэр нийгмийн сүлжээ, цахим сурталчилгаа эд нартай холбоотой юман дээр манай ажлын дэд хэсгээс хариулт өгчих байх. Оюунчимэг гишүүний тэр жагсаалтаар нэр дэвшигч нартай холбоотой асуудал бид Үндсэн хуулийн өөрчлөлтийг сая баталсан. 48 гишүүнийг пропорциональ тогтолцоогоор сонгоно гээд оруулчихсан.

Мэдээж гишүүдийн зүгээс тавьж байгаа 1 асуудал бол 1 дүгээрт нэр дэвшигчид тавих шаардлагыг өндөрсгөх шаардлагатай байна. Жагсаалтын ард янз бүрийн муу нэртэй хүн нуугдах вий гэдэг ийм болгоомжлол бол их байгаа юм. Тийм учраас энэ дээр 2 чиглэлийн арга хэмжээ авах ёстой гэж бодож байгаа юм. Оюунчимэг гишүүн ээ, 1 дүгээрт нь бол энэ Сонгуулийн хуульд бид нар 2 заалт оруулж өгсөн. 1 дэх нь бол энэ нийгмийн бүлгийн төлөөллийг хангах, цаашидаа тэги зарчмыг хангах, ардчилал, шударга ёсны зарчмыг хангах чиглэлд нь анхаарах шаардлагатай байна гэдэг энэ чиглэлээр нэг заалт оруулж өгсөн.

2 дахь нь улс төрийн намуудын жагсаалт дээр янз бүрийн нөгөө дэнчин, барьцаа, мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр юм шаарддаг эдгээрийг бүгдийг нь хориглож өгсөн байгаа.

2 дахь нь энэ Сонгуулийн хуулийн дараа Улс төрийн намын хууль орж ирэх юм. Тэгэхээр улс төрийн намын хууль

дээр нэр дэвшигч нарт тавих шаардлагыг нь нарийн болгох, нэр дэвшигчдийг тодруулах, сонгох, шалгаруулах зүйлийг хуулиар илүү тодорхой болгож өгье гэж үзэж байгаа. Ингэж байж энэ өөрөө нөгөө Үндсэн хуульд тусгагдсан энэ шаардлага хангагдана гэж ингэж үзэж байгаа юм.

Сурталчилгааны хэлбэр 8 бол огт өөрчлөгдөөгүй. Хэвээрээ. Энэ хөндөгдөж орж ирээгүй. Хөндөгдөж орж ирээгүй учраас ажлын хэсэг дээр яригдаагүй. 50/50 гэж огт өргөн баригдаагүй. Пропорциональ тогтолцоо, мажоритар тогтолцоо 50/50 гэж өргөн баригдсан. Нямаагийн Энхболд нарын гишүүдийн өргөн барьсан хууль нэг хүйсийг 30-аас доошгүй гэдэг л хууль өргөн барьсан. Тэрийг бид нар ажлын хэсэг ярилцаад хэвээр нь өнөөдөр оруулж ирж байгаа. Түүнээс биш орж ирснийг доошлуулж, бууруулж байгаа асуудал огт байхгүй.

Л.Мөнхбаатар: 87 дугаар микрофоныг өгье. Ажлын хэсэг хариулъя. Албан тушаал, нэрээ хэлээд асуултад хариулаарай.

А.Лувсан-Очир: Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга Лувсан-Очир. Сонгуулийн сурталчилгаа цахим орчинд явуулахтай холбоотой зохицуулалт 47 дугаар зүйл дээр байгаа. Сонгуулийн сурталчилгаа цахим орчинд 3 цахим хуудсаар явуулна. 1 дүгээрт бол нэр дэвшигч болон нам, эвслийн өөрийнх нь цахим хуудсаар бол сонгуулийн сурталчилгаа явуулахаар байгаа.

2-т нь олон нийтийн цахим хуудсан дахь өөрийнхөө цахим хуудсаар сонгуулийн сурталчилгаа явуулна.

3-д нь бол бусад хэлбэрийн цахим хуудас гэж байгаа. Эдгээр цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш 3 хоногийн дотор Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх ийм хуулийн зохицуулалттай байгаа.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүн тодруулж асуух юм уу. Тодруулъя.

М.Оюунчимэг: Яагаад заавал 70/30 гэдэг хувилбар байх ёстой юм бэ гэдэг дээрээ бас яг тодорхой тайлбар өгөхийг би бол хүсэж байна л даа. Яагаад гэвэл чадвартай нь тэгээд л дэвшээд л олон түмэндээ хүлээн зөвшөөрөгдөөд ажлаа хийгээд шударга явах ёстой. Тэгэхээр энэ дээр хариулт нь бүдэгхэн байна.

2 дахь нь энэ сонгуулийн хуулийн хамгийн гол өөрчлөх болсон шалтгаан нь сонгууль бол мөнгөний сонгууль болоод байна. Тэгээд сонгуулийн зардал дэндүү өндөр байна. Тиймээс сонгуулийн хууль хэлэлцэх үед зардлыг 42-50 хувиар бууруулж ингэж тооцно гэсэн. Тэгээд гол зардал нь сурталчилгаа, ухуулга хуудас гээд ингээд янз бүрийн юмаар ордог. Тэгэхээр яг одоо орж ирж байгаа Сонгуулийн хуулийн төсөлтэй танилцахад сонгуулийн үеийн тэр зардал яг 40-50 хувиар буурч байгаа зүйл нь яг хаанаа байгаа вэ. Мөнгөний сонгуулиас бүгд татгалзъя. Харин энийг бол уралдааны яг ард түмний үйл ажиллагаа, улс орны хөгжил гэсэн иргэдийнхээ төлөө оюун ухаан яг юмаа уралдуулж тэрнийхээ шийдвэрийг нь гаргадаг үр дүн гүйцэтгэлтэй улс орны хөгжил гэсэн ийм.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн дарга хариулъя.

Д.Тогтохсүрэн: Одоогийн мөрдөж байгаа хууль дээр нэг хүйсийн доод хэмжээ 20 хувь байгаа. Хууль санаачлагчид 30 хувь болгож 10 хувиар нэмэгдүүлж орж ирсэн. Тэгээд энэ 30 хувиар нь л явж байгаа асуудал. Түүнээс биш бууруулж байгаа юм байхгүй. Харин өсгөснийг нь хэвээр нь баталгаажуулаад явж байгаа зүйл ээ. Зардал бууруулах дээр бол хууль санаачлагч зардал бууруулах чиглэлээр тодорхой хэд хэдэн чухал юмнууд оруулж ирсэн. Сурталчилгааны материалуудыг багасгасан. Самбарын хэмжээг

багасгасан. Ухуулагчдын тоог бууруулсан гээд. Тэгээд нийт дүнгээр нь бол 40 гаруй хувиар сонгуулийн сурталчилгаа буурах юм байна гэж тооцсон байна лээ. Харин бид нар ажлын хэсэг дээр ярилцаад 2 чиглэлийн арга хэмжээг авсан.

1 дүгээрт нь бас хамгийн их мөнгө зардаг юм бол зурагт самбарууд байна гэж үзсэн. Тийм учраас тойрогт нэр дэвшиж байгаа нэр.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчихъя. Тогтохсүрэн даргын микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Тийм учраас тойрогт нэр дэвшиж байгаа нэр дэвшигч нар нэгдсэн 1 самбартай байя. Жишээлбэл сумд 1 л самбар байна. Тэр самбар дээр 10 байна уу, 20 байна уу 30 хүн нэр дэвшсэн бол тэр дээр зургаа оруулъя гэдэг байдлаар тооцож энд оруулж ирсэн байгаа. Тэгээд зургийн хэмжээ, зурагт самбарын хэмжээ, тэгээд ямар дарааллаар явах вэ гээд нарийн юмнуудыг нь бол хуулийн төсөлд заримыг нь тусгаж оруулж ирсэн байж байгаа. Ингэснээрээ бол зардал нэлээн буурна гэж ингэж үзэж байгаа юм.

2 дахь нь нөгөө ухуулагчийн урамшууллын асуудлыг 2 дахин бууруулсан. Хууль санаачлагчийн оруулж ирснээс 2 дахин бууруулсан байгаа. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй гэдгийг сая бид нар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас хэтрэхгүй байна гэж бууруулж өгсөн байгаа. Тэгээд хамгийн их зардал гардаг нь юм бол ухуулагчийн зардал байгаа. Тийм учраас ухуулагчийн зардал, зурагт самбарын зардал 2-ыг бууруулсан. Тийм учраас зардал тодорхой хэмжээгээр буурна гэж ингэж үзэж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах юм уу. Ажлын хэсэг нэмж хариулъя. 85 дугаар микрофон.

Д.Бат-Эрдэнэ: Оюунчимэг гишүүний асуултад нэмж хариулъя аа. Сонгуулийн зардлыг бууруулах чиглэлээр хэд хэдэн зохицуулалтууд орсон. Үүний нэг нь бол сонгуулийн сурталчилгааны арга хэлбэрүүд 8 арга хэлбэрүүдийн тоо хэмжээгээр 1 дүгээрт 50 хувь бууруулж байгаа. Энэ нь бол өөрөө 1 дүгээрт буурах үндэслэл болно. 2 дугаарт түрүүн Тогтохсүрэн дарга хэлсэн. Зурагт самбарыг бид нар тэр Япон, Солонгосын жишигээр нэгдсэн самбартай байх зохицуулалтыг тусгаж оруулж ирсэн байж байгаа. 3 дугаарт нь Үндэсний аудитын газар бол энэ тоо хэмжээнд үндэслээд зардлын дээд хэмжээ гэж тогтооно. Гэхдээ зардлыг бууруулах бодлого баримтална гэдэг зарчмын зохицуулалтыг нь тусгаж өгсөн учраас үүнээс дахин бас давхар бууруулах ийм боломж нь бас бүрдэж байгаа. 2 шатлалтайгаар буурах боломж нь бүрдэж байгаа гэж ойлгож болно. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Бат-Эрдэнэ дарга хариулсан уу. Нэр, албан тушаалаа хэлж байгаарай. Яагаад гэвэл протоколд үлддэг. Хэн хэний асуултад хэн хэрхэн хариулсан нь протоколд үлддэг. Ийм дэгтэй шүү гэдгийг бас сануулж хэлье. Дараагийн гишүүн асуултаа асууя. Нанзадын Наранбаатар гишүүн асуултаа асууя.

Н.Наранбаатар: Сонгуулийн хууль маань Үндсэн хуулийн өөрчлөлтийг дагаж нэмэлт, өөрчлөлт орж ирж байна. Гишүүд тойрогтоо ажиллаж Үндсэн хуулийн өөрчлөлтийн талаар танилцуулга хийж, санал сонсож явсан. Тэгэхэд бол манай тойрог дээр бас тодорхой саналуудыг бас хэлж байсан. 1 дүгээрт бол холимог тогтолцоо буюу жагсаалт орж ирснээрээ жагсаалтын ард муу нэртэй улс төрч орж ирэх ийм магадлал үүснэ гэдгээс ер нь бүгд болгоомжилж үг хэлсэн хүн болгон л энийг ярьж байна лээ. Тэгээд ийм хүмүүс орж ирэхгүй байх баталгаа нь юу юм бэ. Яаж юугаар зохицуулах юм бэ. Намууд

өөрөө мэднэ гэхээрээ зэрэг л бас ялгаа байхгүй. Хуучин 2012 онд явсан шигээ ингээд эрх мэдэл, албан тушаал, хөрөнгө чинээтэй хүмүүс нь орчихдог байдлыг яаж хязгаарлах юм бэ. Малчдын төлөөлөл эмэгтэйчүүд, залуучууд, эмч, багш гээд нийгмийн бүлэг секторын төлөөллийг оруулж ирэх механизм нь юу юм бэ гэдгийг их асууж байсан. Энэ дээр бас нэг хариулт авчихъя.

2-т нь ярьж байгаа зүйл бол зардал сонгуулийн зардал хэт өндөр байна. Мөнгөтэй, төгрөгтэй хөрөнгө чинээтэй улсууд нь ялалт байгуулах сонгогдох ийм боломж бол өнөөгийн хуулиар байгаа. Үүнийг яаж хязгаарлах юм. Ялангуяа нэг хүнээс гаргаж байгаа зардлын хэмжээ мөн ухуулга сурталчилгаандаа гаргаж байгаа зардал, ухуулагч нарын тоо дээр анхаарахгүй бол хөдөө орон нутагт бол энэтэй холбоотой улс төржилт маш их явж байгаа. Нэг гэрийн 2 хүртэл 2 өөр намын ухуулагч болоод ингээд сум, багт улс төржилт маш их явагддаг учраас энийг хязгаарлах тал дээр ямар заалтууд орж ирж байгаа юм бэ. Одоо шинжлэх ухаан технологи, цахим хөгжчихсөн үед ер нь тийм олон самбар, зурагт хуудас, олон ухуулагч байхын хэрэг байна уу, үгүй юу. Тойрогт нэр дэвшиж байгаа хүмүүсээ бол тэртээ тэргүй орон нутгийнхан мэдэж, таньдаг учраас таниулах гээд л их хэмжээний зардал гаргаад байх шаардлага байна уу, үгүй юү гэдэг ийм зүйлийг бас ярьж байгаа. Энэ дээр яаж хязгаарлаж өгч байгаа вэ гэдгийг асууя.

3-д нь бол 78 болж 2 тойрог нэмэгдэж байгаа. Манай сонгогчдын хувьд бас газар нутгийн хэмжээгээ харгалзаж үзээч. Хамгийн том газар нутагтай аймаг төлөөлөл бас тэр чинээгээрээ бас бусдаасаа харьцангуй илүү байх ёстой. Хүн амын тоо харьцуулсан ч гэсэн Өмнөговь аймгийн хувьд 75 мянган хүнтэй, дээр нь нэмээд 21 аймаг 9 дүүргийн хүмүүс очоод 100 гаруй мянган хүн ингээд байнгын бус ажиллаж, амьдарч байгаа. Хилийн 2

боомт гээд ингээд зайлиггүй мандатын тоог нэмэх ийм шаардлагатай. Эдийн засгийн цар хүрээ, газар нутаг, хүн амаараа нэлээд томоохон тойрог болж байгаа учраас энэ дээр ямар өөрчлөлт орох вэ гэдэг зүйлийг бас асууж байсан. Тийм учраас эдгээр дээр тодорхой хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн дарга хариулъя.

Д.Тогтохсүрэн: Жагсаалтаар нэр дэвшигчийн тухайд бол сурталчилгаа хийхээр зааж өгсөн байгаа. Тэгэхдээ сурталчилгааг зөвхөн намын эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагаас хийнэ. Өөрөө бол хийхгүй. 3 хүртэл хэвлэлийн хуудсаар сурталчилгааны материал гаргахаар байгаа. Тэгэхээр тухайн нам манайх ийм 48 хүний нэр дэвшүүлж байгаа. Манай хүмүүс ийм нэр цэвэр хүмүүс. Улсын бодлогыг ингээж авч явах чадвартай баг бүрэлдэхүүн байгаа гэдгээ танилцуулж, түүгээрээ намынхаа саналыг авах юм.

2 дахь нь нийгмийн бүлгийн төлөөллийн тухайд бид ярилцаж байгаад 29.10 дээр 1 заалт болгож оруулж ирсэн. Нийгмийн бүлгийн төлөөллийн оролцоо, төлөөлөл оролцоог хангана гэдэг нэг ийм өгүүлбэр оруулж ирсэн. Тэгээд түрүүн би хэлсэн энэ хуулийн дараа гарах Улс төрийн намын тухай хууль гарах юм. Улс төрийн намын тухай хууль дээр нэр дэвшигчид тавих шаардлагыг нам дээрээ илүү тодорхой болгож зааж өгөхгүй бол болохгүй байгаа юм. Ер нь маш олон гишүүд ард иргэдийн зүгээс хамгийн их болгоомжилж байгаа асуудал бол энэ байгаа юм. Жагсаалтын нэр дэвшигч бий болгочихдог. Баахан мөнгөтэй, төгрөгтэй янз бүрийн хүмүүс орж ирээд нөгөө сайхан цэвэр болгоно гэсэн төр маань болохгүй байх вий гэдэг ийм болгоомжлол их байгаа юм. Тэгэхээр энийг юугаар зохицуулах вэ гэхээр Улс төрийн намын хуулиар нь зохицуулах юм.

Тийм учраас энэ хуулийн дараа Улс төрийн намын хууль бас орж ирнэ. Улс төрийн намын хуулиар тэр нэр дэвшигчид тавих шаардлага, нэр дэвшигчдээ тодруулах, шалгаруулах, дэвшүүлэх процессуудыг нэлээн нарийн зааж өгөх шаардлага байгаа юм. Нийгмийн төлөөллийн тухайд би хэлчихлээ.

Зардлын тухайд бол түрүүн бас хэлсэн. Хууль санаачлагч бол нийт сонгуулийн зардал бол 40 гаруй хувиар буурах боломжтой гэж оруулж ирсэн. Энэ дээр нь бид ярилцаж байгаад хамгийн их зардал гардаг ухуулагчийн зардал байгаа. Тэрийг бууруулж байгаа. Самбарын зардал байгаа. Зурагт самбарын зардал их өндөр зардал гардаг энийг үндсэндээ байхгүй болчхож байгаа байхгүй юу. Тойрог байгуулах, мандат хуваарилахтай холбоотой асуудал одоо мөрдөж байгаа Сонгуулийн хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу сонгуулийн жилийн 2 сарын 1-ний өмнө Улсын Их Хурал шийдвэрлэхээр байгаа. Тийм учраас 1 дүгээр сарын сүүлээр Улсын Их Хурлын энийг шийднэ. Шийдэхдээ 4 зарчим бий. Аймаг, дүүргийн аймаг, дүүргээр байгуулагдана, аймаг, дүүргийн хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, засаг захиргааны нэгжийн байдал, байршил зэргийн харгалзан тогтооно гэсэн ийм зарчимтай. Үүний дагуу Сонгуулийн ерөнхий хороо санал бэлтгээд, энэ хууль гарсны дараа санал бэлтгээд 1 сард Улсын Их Хурлаар оруулж ирж, хэлэлцүүлж шийдвэрлүүлэх ийм хуультай байгаа.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулъя. Төрийн байгуулалтын байнгын хороны дарга Энхболд нэмж хариулъя. Энхболд даргын микрофоныг өгнө үү.

Н.Энхболд: Сонгуулийг мөнгөнөөс ангид байлгах зардал, хэмжээ элдэв юмыг бууруулахтай холбоотой бас нэг заалт орж байгаа. 30.30 дээр байгаа Наранбаатар гишүүн ээ. Өнөөдөр санал хураана хэдүүлээ. Нам, эвсэл нэр

дэвшүүлэхдээ тойрогт ч тэр, жагсаалтад ч тэр намын гишүүн дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглоно гээд зориуд заасан байгаа. Тэгэхээр энэ бол өөрөө нөгөө мөнгөний сонгууль явуулахаас яг намууд үүнийхээ дагуу хуульд заасны дагуу ил тод шилэн маягаар хөрөнгө мөнгөө босгох, тайлагнах ажлаа хийчихвэл энэ өөрөө хамгийн том хамгаалалтын нэг болно гэж үзэж хуулийн шинэчлэлд оруулж байгаа.

Л.Мөнхбаатар: Нанзадын Наранбаатар гишүүн тодруулж асууя. Нэг минут.

Н.Наранбаатар: Баярлалаа. Бас нэг хүлээлт гэх юм уу, асуулт байгаа нь бол орон нутгийн сонгууль яаж явах юм. Ер нь бодлого нь ямар байх юм. Ийм зарчмаар холимог тогтолцоогоор явах юм уу. Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Хурлын сонгууль гэдэг зүйлийг их сонирхож байгаа байх. Энэ дээр бас нэг тодорхой хариулт өгөөч ээ.

Л.Мөнхбаатар: Нямаагийн Энхболд дарга хариулъя. Орон нутгийн сонгууль яг энэ зарчмаар мөн адил явах уу л гэж асуугаад байх шиг байна. Энэ дээр нь бас тодорхой хариулт өгчихье.

Н.Энхболд: Орон нутгийн сонгууль тусдаа явдгаараа явна. Одоогийн байдлаар хамтарч явуулах тухай ямар ч асуудал яриа юм гараагүй байгаа. Тусдаа явуулна гэж ойлгож байгаа. Сая яваад иргэдтэй уулзахад бас хамгийн их сонирхож ялангуяа орон нутагт хамгийн их сонирхож байсан асуулт нь энэ байсан. Ингээж асуухдаа иргэд ямар саналыг дэвшүүлж байсан бэ гэхээр ер нь орон нутагт ийм холимог тогтолцоо зохихгүй юм байна лээ. Ёстой нөгөө түрүүчийн 2012 оны сонгуулиар чинь тойрогтоо явчхаад уначхаад, жагсаалтаар орчихсон тэр нь өөрөө маш их асуудал дагуулж байсан ийм зүйлүүд гарсан. Орон нутгийнх нь хувьд

шүү дээ. Тэгээд надад Байнгын хороо дээр албан ёсоор яриагүй. Тэгэхдээ гишүүдийн дийлэнхийн иргэдийн санал байдлыг сонссон. Байр сууриа илэрхийлж байгаа байдлыг харахад орон нутгийн сонгууль бол холимог тогтолцоог оруулахгүйгээр явах нь зүйтэй гэсэн ийм байр суурь давамгайлж байгаа харагдана лээ. Тэгэхдээ энэ хуулийг бид нар.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тусдаа хуулиар зарцуулагдах учраас тухайн үед нь ярья гэсэн агуулгатай хариулт өгч байна. Дараагийн гишүүн асуултаа асууя. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууя.

С.Ганбаатар: Сонгуулийн хууль дээр би 2 саналын тухай асуух гэж байна.

1 дүгээрт эрэгтэй байна уу, эмэгтэй байна уу аль нэг хүйсийг нь 40 хувь байлгана гэдгийг би дэмжиж байгаа. Эмэгтэйчүүдийн парламентад орж ирэх үүд хаалгыг, боломжийг бид нээх асуудал бол энэ Сонгуулийн хуулийн маш чухал асуудал шүү. Зарим нь бол эмэгтэйчүүдэд таалагдах гэж ярьж байна эд нар гэж ийм их Монгол ухар мөчид юм ярих дуртай л даа. Би ч юу ярьдгийг нь мэддэг болчихсон эрх баригчид социал демократ үзэлтэй та нар. Социал демократ намын гол төлөөлөгч Германы Фридрих Эберт анх энэ саналыг Германы парламентын сонгуулийн хуульд оруулж байсан. Миний улс төрийн нүдийг анх нээсэн хүн бол Анка Мартинэ гэж. 17 жил Бундестагт суусан хүн байдаг. Бурхан болчихсон. Тэр хүнээс би асууж байлаа. Үгүй, та яагаад ингээд энэ улс төрд ийм идэвхтэй байж чадав гэсэн би Эбертийн буянаар би ингэж суусан гэж. Тэгээд Эберт гэдэг хүн яасан юм бэ гэсэн эмэгтэйчүүдэд маш давуу эрхээр сонгуульд ялах тийм боломжийг хуульд оруулж өгсөн юм. Үгүй ээ, энэ чинь тэгш байдал гэж байдаг шүү дээ. Яагаад ийм хэт давуу байдлыг олгож байгаа юм бэ гэсэн. Эрчүүд мянга мянган жил

эмэгтэйчүүдийн эрхийг зөрчсөн юм. Бид нэг ийм хэмжээний комбинсац хийх хэмжээнд юм гэж надад ярьж байсан. Тэгээд би санаагаа илэрхийлэх үүднээсээ энэ жишээг ярилаа шүү. Тэгэхлээр 1 дүгээрт 40 хувь гэдэг дээр би дэмжиж байгаа. Энэ хасагдаж орж ирэх магадлал өндөртэй. Манай эрчүүд бие биедээ хайртай учраас 30 жил бид эрчүүд доминант хийсэн улс төрөөр явлаа. Эмэгтэй хүнд тал засах гэж байгаадаа биш. Эмэгтэйчүүдийн зовлон зүдгүүр бэрхшээл энэ чуулганд шийдвэрт оролцоосой гэж би хүсэж байгаа. Нөгөө Арабын эдийн засгийг шүүмжилж байсан нэг эдийн засагч хэлсэн шүү дээ. Араб эмэгтэйчүүдийнхээ оролцоог шийдвэртээ оруулдаггүй учраас 1 далавчтай шувуу шиг гэдэг шиг өнөөдөр энийг 40 хувийг оруулна. Хэрвээ 30 бол та нар ямар үндэслэл шалтгаан байгаа вэ. Ажлын хэсгээс асууж байна. Ямар үндэслэлээр 40-ийг миалж байгаа вэ. Миалахгүй бол сайн байна.

2 дугаар асуулт. Аваргууд бие биедээ нэг аманд нь хаяж өгдөг хүүхдүүд шиг. Тэгээд тохироод л эмэгтэйчүүдийгээ бие биедээ нэг аманд нь хаяж өгдөг энэ тэнэг байдлыг монголчууд бид уншдаг аа. Яг тэр сөөлжөөд тэр 40 байна уу, 50 хувь байна уу яг Германы тэр эрдэмтэн надад бас тэгж ярьж байсан. Тэр 5, 6 эрчүүд хоорондоо алалцаад дээрээ гарчихсан байхад тэр доороос эмэгтэй хүнийг авчирч 3-д нь тавьдаг юм гэж нэг ярьж байсан. Тэгэхлээр тэр листдээ ядаж сөөлжлөх тэр боломж хасагдаагүй биз дээ. Хасах гэж байгаа бол ямар үндэслэл байгаа вэ. Энэ хуулийг би дөнгөж сая хэдхэн минутын өмнө, хэдхэн цагийн өмнө авлаа шүү. Миний асуултад хариулах байх. Тэгээд эрчүүдийгээ би муу хэлсэнгүй ээ. Маш олон давуу талтай. Фантазтай, мөрөөдөлтгий, зоригтой, давуу талууд бий. Эмэгтэй хүмүүст прагматик, тэсвэртэй, хатуужилтай олон давуу талууд байгаа. Энэ бүхэн шийдвэрт хамтдаа оролцоосой гэдэг утгаараа би саяын санааг гаргаж ярьж

байгаа юм аа. Ингээд төлөөллийн ардчилалтай Монгол орон үнэнээсээ төлөөлөлтэй байх ийм боломжийг энэ хуульд оруулсан байх. Саяын 2 миний санал хасагдахгүй байна гэж би итгэж байна. Хасах гэж байгаа бол ямар үндэслэл байгаа вэ. Хуулийн үндэслэлийг нь надад хэлж өгөөрэй.

Г.Занданишатар: Ажлын хэсэг. Тогтохсүрэн дарга.

Д.Тогтохсүрэн: Одоо мөрдөж байгаа Сонгуулийн хуулиар 20 хувь байга. 20 хувь. Үндсэндээ 15 нэг хүйсийн төлөөлөл хамгийн бага нь нэр дэвшиж байгаа. 20 хувь одоогийн байгаа хуулиар. 2 хууль санаачлагч нэг нь 30 хувь, нэг нь 40 хувь гэж оруулж ирсэн. Энхболд нарын гишүүд 30 хувь гэж оруулж ирсэн. Өнөөдөр бол Монгол улсын хэмжээнд эдийн засаг, улс төр, нөхцөл байдлаа харгалзаж үзээд эмэгтэйчүүдийн би эмэгтэйчүүдийн гээд хэлчихье. Нэг нь тэгж ярьсан учраас. Эмэгтэйчүүдийн квотын асуудал бол зөвхөн юу гэдэг юм. 2 том намд зориулсан ийм зүйл биш. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 36 намд тэгш боломж олгох ёстой. Тийм учраас 30 хувь гэдэг бол 38 эмэгтэй нэр дэвших боломж гарч байгаа юм. Би хэлж байгаа юм. Өмнө нь 15 эмэгтэй нэр дэвших боломж байсан бол одоо доод тал нь 38 эмэгтэй дээд тал нь 126 эмэгтэй нэр дэвших боломж олгож байгаа юм.

2 дахь юм бол манай нам Социал демократ намын хувьд эмэгтэйчүүдийн парламентад орж ирэх боломжийг нээж, нэрсийн жагсаалтаар нэр дэвшигчдийг 1, 1 гэдэг хэлбэрээр жагсаалтад бичнэ гэж ийм хуулийн төслийг оруулж ирсэн. Энэ бол нөгөө таны түрүүний хэлдэг эмэгтэйчүүдэд асар том боломж олгож байгаа юм. Өнөөдөр шуудхан хэлэхэд 24 эмэгтэй шууд парламентын гишүүн болно. Доод тал нь. Энэ явж байгаа тохиолдолд 24 эмэгтэй шууд орж ирж байгаа юм. Жишээ авахад юу гэдэг юм Монгол

Ардын нам листнээс 16 суудал авах байвал 8 эмэгтэй, 8 эрэгтэй л орж ирнэ. Ардчилсан ман 14 суудал авбал 7, 7 л орж ирнэ. Хүн нам 10-ыг авах юм бол 5, 5 л орж ирэх байхгүй юу. Ингээд өөрөө шууд автоматаар 20-24 эмэгтэй ороод ирчхэж байгаа юм. Тэгээд энэ бол асар том боломж байхгүй юу. Асар том дэвшил. Магадгүй таны хэлж байгаа энэ бол асар том дэвшил байхгүй юу. Ийм өндөр дэвшилтэй байгаа үед 30 хувь хангалттай байгаа юм. 40 хувь болохоор 53 эмэгтэй нэр дэвших болж байгаа юм. 29 эмэгтэй нь тойрогт явах болж байгаа юм. 29 эмэгтэй. Энэ бүх байдлуудыг ингээд хараад байхаар өнөөдрийн нөхцөлд бол Монголд 30 хувь байхад бол бололцооны юм гэж бодож байгаа юм. Дэлхий нийтийн дундаж 40 орчим хувьтай байгаа юм. Нэр дэвшилт нь. Парламент дотроо бол 26 хувьтай байгаа юм. Тийм учраас бид нар нэг хоцрогдоод л нэг хүйсийг давамгайлаад байгаа юм бол харьцангуй нэлээн сайжирч байгаа гэж ингэж бодож байгаа юм аа.

Г.Занданишатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулна.

С.Ганбаатар: Би Фредрих Эбертийн сангийн Оюунгэрэл эгчтэй их ойрхон ажиллаж байсан. Олон жил ажилласан. Тэгээд яг итгэл үнэмшил, өөрийнхөө ойлгож сурч мэдсэн зүйлээ л та нартай хуваалцаж байгаа шүү. Тэгэхлээр ямар ч байсан тэр сөөжлөх гэдэг тэр зүйл бол орж байгаа юм байна. Маш том давуу тал өгч байна. Монголын нийгэмд сайн нөлөө үзүүлнэ гэж бодож байна. Судлаачид ярьдаг шүү дээ. Парламентад байгаа эмэгтэйчүүдийнх нь хэдэн хувь байгаа вэ гэдгээр тухайн парламентын авлигын индекс тодорхойлогддог гэсэн нэг яриа байдаг. Би эрэгтэй хүнийг доош нь хийсэнгүй. Зүгээр бид хамтдаа байх ёстой гэсэн санааг л би хэлж байгаа юм. Тэгэхлээр сөөжлөх бол орж байгаа юм байна. Би ойлголоо. 40 хувь дээр би дахиж ажлын хэсэгтэй ярилцаж, тэр 30, 40 гэдэг дээр

ярилцана. Дахиж асууна. Хамгийн гол нь гишүүд ээ, яг хэлж байгаа, ярьж байгаатай.../минут дуусав/

Г.Занданишатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Юуны өмнө Ганбаатар гишүүндээ баярлалаа. Бас жендерийн асуудлыг бас хөндөж дэмжиж үг хэлж байгаад. Өчигдөр бас Байнгын хорооны хуралдааныг харсан. Байнгын хорооны хуралдаан дээр аль нэг хүйсийн квотыг 40 хувиар тогтоох асуудал яригдаж байх тэр цаг мөчид бас Сүхбаатар гишүүн, Занданишатар дарга маань бас квотыг дэмжиж, бас үг хэлж, саналаа өгч байгаад бас талархлаа илэрхийлье. Энэ бол зөвхөн Жаргалмаагийн байр суурь биш. Монгол Улсад улс эх орноо гэсэн, улс орныхоо ирээдүйг гэсэн, үр хүүхдүүдийнхээ ирээдүйг гэсэн, улсынхаа хөгжлийн төлөө сэтгэл зүрх нь цохилж байдаг эмэгтэй хүн бүрийн бас үг байх гэж би төлөөлж хэлэхийг хүсэж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол Эмэгтэйчүүдийн холбоо болон Жендерийн үндэсний хороо, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр өнөөдөр бас сошиал орчин төдийгүй хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж байгаа бүхий л эмэгтэйчүүдийн төлөөлөл маань улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэх энэ санал дээр бас санал нэгтэй байгаа гэдгийг та бүхэн бас анзаарч харж байгаа байх гэж бодож байна.

Яг Ганбаатар гишүүний саяын хэлсэнчлэн хэлж байгаа үг шигээ энэ парламентад суугаа эрчүүд маань бас хүйсийн асуудал дээр, жендерийн асуудал дээр аль хүйсийн 40 хувийн квоттой байх гэсэн энэ асуудал дээр бас өөрсдийнхөө саналыг хэлж, хамгаалж чадна байх гэдэгт би итгэлтэй байна. Би сэтгүүлч байхдаа улс төрчдөөс юу гэж асуудаг байсан бэ гэвэл яагаад заавал жендер гэхээр эмэгтэйчүүд гэж хараад байгаа юм бэ гэдэг зүйлийг маш ихээр асуудаг байсан. Тэгвэл эрчүүд 40 хувь гээд шууд

зоочхож болдоггүй юм уу гэж. Улс төрчид маань асууж байна л даа. Эмэгтэйчүүдэд улс төр дэх оролцоо хүний нөөц байна уу гэж. Монгол Улсын нийт хүн амын 51-ээс дээш хувь нь эмэгтэйчүүд гэж тооцож байгаа. Өнөөдөр орон нутагт болоод төрийн байгууллагуудад эмэгтэйчүүдийн эзлэх хувиа та бүхэн харж байгаа байх гэж бодож байна. Магадгүй парламентад эрчүүд нь олон боловч яг гүйцэтгэх засаглал дээрээ, гүйцэтгэх орон нутагтаа хэн ажил хийж байгаа вэ гэвэл эмэгтэйчүүд хийж байгаа. Парламентад суусан эмэгтэйчүүд юу хийж байна вэ гэдэг олон шүүмжлэл бидэнд байдаг. Гэхдээ эмэгтэйчүүд байгаагүй бол өнөөдөр нийгмийн асуудлыг сургууль, цэцэрлэгийн хүртээмжийн асуудлыг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг, магадгүй чанартай насжилтын асуудлыг өнөөдөр энэ парламент ярих байсан уу, үгүй юу. Ярих байсан байх. Гэхдээ Тоогий дарга аа, хэчнээн хувь нь өнөөдөр эмэгтэйчүүд түлхүү ярьж байгаа вэ гэдгийг та бүхэн бас анзаарч хараасай.

Сошиалд маш ихээр хөтлөгддөг. Үнэн. Гэхдээ өнөөдөр сошиал орчинд улс орны хөгжлийн асуудлыг, нийгмийн асуудлыг хэн ярьж байна. Магадгүй парламентад сууж байгаа эмэгтэйчүүд эдийн засаг мэддэггүй, төмөр зам мэддэггүй, далайн тээвэр мэддэггүй гэж ойлгож магадгүй. Гэхдээ судлах чадвар өнөөдөр эмэгтэйчүүдэд байдаг. Өнөөдөр аль ч намын гэсэн харьяалалгүйгээр эмэгтэйчүүд маань нэгдэн улс төр дэх эмэгтэйчүүдийнхээ оролцоог нэмүүлэхийн тулд ярьж байгаа. Өнөөдөр Жаргалмаа дараагийн парламентад нэр дэвших гээд байгаадаа биш. Улс орныхоо хөгжлийн төлөө эмэгтэйчүүд тэгш эрхтэйгээр парламентад суух ёстой гэдэг байр сууриасаа хандаж байгаа. Парламент 76 суудалтай байсан тэр цаг мөчид бид нар 20 хувь, 30 хувийн квот ярьдаг байсан. Үнэхээр бид нар 2005 оноос хойш парламентын аль нэг хүйсийн харьцаагаа 20 хувиар тооцож байсан бол

одоо бид нар нэмэх зайлиггүй шаардлага байгаа гэж ярьж байгаа. Энэ тал дээр ер нь ямар байр суурьтай байгаа вэ. Өчигдөр Байнгын хорооны санал бас нэгхэн гишүүний саналаар унасан учраас би энийг дахин дахин тодотгож асууж байгаа юм.

Нөгөөтээгүүр нэр дэвшигчдийг бид нар сая Үндсэн хуулийнхаа шинэчлэлийг олон нийтэд танилцуулахдаа олон салбарын төлөөллийг оруулахын тулд бид нар пропорциональ тогтолцоог сонгож, холимог тогтолцоогоор сонгуулийг явуулна гэдэг үүднээсээ парламентыг бүрдүүлнэ гэдэг үүднээсээ олон нийтэд танилцуулж явсан. Жагсаалтад хэн нэр дэвших вэ. Жагссан нэр дэвшигчдийн нэр нээлттэй байх уу, үгүй юу. Эргээд энд нөгөөдөх л малчин, тариачин, багш, эмч хэн байдаг юм тийм ээ, багш нарын төлөө л орж ирэх үү, үгүй юу. Энийг нээлттэйгээр тавих уу. Эргээд хувь тооцохоор мандатынхаа авсан саналын тоогоор хувиа тооцож жагсаалтаа таслах уу, үгүй юу гэдэг дээр бас тайлбар авъя.../минут дуусах/

Г.Занданшатар: Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн дарга.

Д.Тогтохсүрэн: Нэр дэвшигчдийн жендерийн асуудал дээр би түрүүн Ганбаатар гишүүний болон Оюунчимэг гишүүний асуултад хариулт өгсөн. Тийм учраас бол нэмэлт хариулт байхгүй гэж бодож байна.

Нэр дэвшигчдийн хувьд бол нээлттэй байгаа. Тэр жагсаалтаар нэр дэвшигчдийг сурталчлах, тэр байтугай хэвлэл материал гаргах, нийтийн сүлжээгээр, цахим сүлжээгээр сурталчлах эд нар гээд бүгдийг нь тавьж өгсөн байгаа. Тийм учраас сурталчилж байж тэгээд түүгээрээ дамжуулж нам саналаа авах ийм бололцоо, боломжийг бүрдүүлж байгаа.

Нэр дэвшигчдийн тэр бүлгийн төлөөлөл их чухал байгаа. Тэрийг бол 100 хувь ойлгож байгаа. Тийм учраас энэ

хуулийн төслийн 29.10 дээр нийгмийн бүлгийн төлөөллийг хангана гэсэн ийм шаардлага орж ирсэн байгаа. Намуудад нэр дэвшүүлэхдээ тавигдах шаардлага дээр. Түрүүн би бас хэлсэн. Дахиад хэлье. Энэ хуулийн дараа Улс төрийн намын хууль гарна. Улс төрийн намын хууль дээр энэ нэр дэвшигчийг сонгон шалгаруулах процессыг ил тод нээлттэй болгох, боломжуудыг аль болохоор олгох чиглэлээр, тэгээд намуудын хариуцлагыг сайжруулах чиглэлээр хуулийн төслүүдэд тодорхой зүйл туссан байгаа. Тэрийг харин Улс төрийн намын хуульд нэлээд дэлгэрүүлж өгөх шаардлага байна гэж ингэж үзэж байгаа юм.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалмаа: Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль орж ирэхтэй зэрэгцээд сонгуулийн сурталчилгааг ямар хэмжээнд явуулах вэ, ямар хэлбэрээр явуулах вэ гэдэг олон асуудал бас яригдаж байгаа. Зүгээр энэ дээр нэг зүйлийг бас тодруулж асуумаар байна. Өөрөөр хэлэх юм бол радио, телевиз, сонин, зурагт хуудсаар бид нар сурталчилгаагаа хийхээс гадна ер нь сошиал орчинд маш ихээр идэвхийлэн ажиллаж эхэлдэг байгаа. Тэгэхээр энэ ер нь сошиал орчин дахь сурталчилгааны асуудлыг хэрхэн яаж зохицуулах вэ. Эргээд аюулгүй байдал гэдэг юм уу, нөгөө троллууд гэдэг юм уу нэр хаяггүй, эзэнгүй байгаа хаягуудын талаар ямар нэгэн хязгаарлалт хийх тийм боломж байгаа юм болов уу. Энэ дээр ямар нэгэн заалт байгаа юу гэдэг дээр тодруулга авъя.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд ажлын хэсгийн гишүүн. Лувсан-Очир Харилцаа холбооны зохицуулах хорооны.

Н.Энхболд: Яг сошиал орчноор хийх сурталчилгаатай холбоотой нэг үндсэн заалт байгаа. Тэр нь нийт сурталчилгааныхаа зардлынхаа 15 хувиас хэтрэхгүй хэмжээний зардлыг сошиал

орчныг зарцуулна гэсэн. Ямар хэлбэрээр хэдэн хаягаар хийж болох тухай Лувсан-Очир дарга түрүүн танилцуулсан байгаа. Түрүүн бас Тогтохсүрэн дарга асуултад хариулахдаа хэлсэн. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж ирсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан 8 төрлөөр сурталчилгаанууд явах хэвээрээ байгаа. Харин тэр сурталчилгаанд ямар сурталчилгааг, ямар хэмжээгээр явуулах вэ гэдэг зохицуулалтуудыг нь багасгаж тусгасан. Жишээ нь самбар, хэвлэлийн хуудасны тоо гэх мэтчилэн. Яг социал сурталчилгаагаар хувь хүний өөрийнхөө хаягаар явуулж байгаа юмнуудыг хориглоно, хаана гэхээр тэр .../минут дуусав/

Г.Занданишатар: 87. Лувсан-Очир.

А.Лувсан-Очир: Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга Лувсан-Очир. Сонгуулийн сурталчилгааг цахим хэлбэрээр явуулахдаа нэр дэвшигч болон нам эвсэл бол тус бүр нэг цахим хуудсыг, мөн цахим орчин дахь олон нийтийн сүлжээний бас нэг цахим хуудсыг бусад цахим хуудас буюу мэдээ мэдээллийн цахим хуудсыг бол ашиглахаар байгаа. Нам, эвсэл, нэр дэвшигчийн цахим хуудас болон бусад мэдээ мэдээллийн буюу бусад цахим хуудас дээр сонгуулийн сурталчилгаатай холбоотойгоор ямар сурталчилгааны мэдээ, мэдээлэл нийтлэгдсэн, тэр ямар нэгэн сэтгэгдэлгүйгээр нийтлэгдэх ийм зохицуулалт бол хэвээр үйлчилж байгаа. Сонгуулийн сурталчилгааг цахим орчинд явуулахтай холбоотой харилцааг эрх бүхий байгууллагуудын санаачилсан журмыг Сонгуулийн ерөнхий хороо баталж, түүний хэрэгжилтэд нэр бүхий байгууллагууд бол хяналт тавьж технологийн арга хэмжээ авч ажиллахаар хуулийн 47.9 дээр бол зохицуулалт хийгдсэн байдаг.

Г.Занданишатар: Зочид танилцуулъя. Ерөнхий боловсролын “Гэрэлт ирээдүй” сургуулийн 11 дүгээр

ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Тэгээд гэрэлт ирээдүй болсон эрхэм хүндэт сурагчдаа сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Сурах чиглэлийг эрхэм болговол хандах зүг чинь өөрөө тогтоно гэдэг үгийг санаж байгаарай.

Асуулт хариултын цаг үргэлжилж байна. Ингээд Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууна.

Д.Өнөрболор: Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе. Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийн ардчилалтай Монгол орон байх энэ санал дээр үнэхээр дэмжлэг үзүүлсэн Сүхбаатар гишүүн болон Занданишатар дарга нарт бас 50 гаруй хүн амын төлөөллийг илэрхийлж байгаа эмэгтэйчүүдийн нэрийн өмнөөс бас талархал илэрхийлье гэж бас хүсэж байна.

Тэгээд би бусад эрэгтэй гишүүдийг ч гэсэн бас энэ саналыг бол манай энэ материал нэлээн оройтож орж ирлээ. Нэгтгэсэн төсөл дээр Төрийн байгуулалтын байнгын хороны нэгтгэсэн төслийн 56 дээр байж байгаа. Энэ хуулийн төсөлтэй холбоотой дэмжээгүй саналыг та нар дэмжихгүй байхыг гишүүдээс бас уриалж байна. Нэн ялангуяа эрэгтэй гишүүддээ энэ саналыг босгож өгөөч ээ. Тэгш эрхийн ийм мэдрэмжтэй хандахыг та бүгдээс бас уриалж байгаагаа энэ даширамд бас хэлье гэж бодож байна. Ер нь өнөөдөр нам эвслээс нэр дэвшигчдийн 20 хувь нь хуулиараа аль нэг хүйсийнх байна гэж заасан байдаг юм байна лээ. Сая Тогтохсүрэн дарга бас тайлбарлаад л байна. Тэгээд яг хөрсөн дээрээ эмэгтэйчүүд нь 20 хувь, эрэгтэйчүүд нь 80 хувь. Ер нь эрчүүдэд ашигтай ээлтэй ийм улс төр болж өнөөг хүртэл энэ түүхэнд бол ингээд явж ирсэн юм байна лээ. Тэгээд эргээд ингээд харахад өнгөрсөн он жилүүдэд бол эрчүүд давамгайлсан ийм төр засаг байсан юм

байна лээ. Тэгэхлээр 30 жилийн тогтолцооны гажуудал, шударга бус байдал, тэгш бус байдал, эдийн засгийн боломжуудыг орхигдуулсан энэ байдал дээрээ бас бид нар дүгнэлт хийх ийм цаг ирсэн гэж бодож байна. Тийм учраас та бүгддээ бас тэгш эрхийн мэдрэмжтэй нэн ялангуяа эмэгтэйчүүдийг эрх ямба гэдэг талаас нь харалгүйгээр энэ бол өнөөдрийн завхрал, энэ болгон эмэгтэйчүүд олноор улс төрд байсан бол ингэтлээ газар авч хямралд оруулах нөхцөл байдал үүсэх байсан уу гэдэг талаас нь бас анхаарч үзээсэй гэж бодож байна.

Нөгөөтээгүүр сая Тогтохсүрэн дарга Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга ер нь дараа нь орж ирнэ л гээд байх юм. Энэ ер нь яг хэзээ орж ирэх вэ. Би бол бодохдоо Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тэгээд Улс төрийн намын тухай шинэчилсэн найруулга, Сонгуулийн хууль энэ 3 угаасаа багцаараа явж байж ач холбогдлын хувьд ч гэсэн улс төрийн суурь шинэчлэлийн чанартай болно. Дээрээс нь улс орны цаашдын хөгжилд дэвшил гарна. Энэ гурав гурвуулаа явж байж ач холбогдлоо үзүүлнэ гэж харж байгаа. Гэтэл ингээд 2 хууль нь ороод ирчихсэн, нөгөөдөх нь хэзээ өргөн баригдсан, хэлэлцэгдэх эсэх асуудал нь одоохондоо ингээд товгүй, тодорхойгүй байгаа тохиолдолд энийг үгүй, яагаад тэгж байна гэхлээр Тогтохсүрэн дарга аа, ер нь байна шүү дээ. Бид нар бас нэг зүйлийг ингээд аягүй сайн ойлгох ёстой байгаа юм. Сонгуулийн тухай хууль орж ирж байгаа байдал яг энэ төслөөр нь байна шүү дээ. Сонгуулийн зохион байгуулалттай холбоотой төрийн байгууллагуудын чиг үүргийг зохион байгуулах түвшинд л гол агуулга нь орж ирж байгаа байхгүй юу даа. Гэтэл нөгөө тэгш бус байдал, нөгөө баян ядуугийн ялгаа, авлига, хээл хахууль, нөгөө мөнгөнөөс хамааралтай сонгууль энэ байдал чинь өнөөдөр засагдахгүйгээр ийм хууль орж ирж байна шүү дээ. Тэгээд энэ дээр бид нар анхааралтай хандмаар

байна. Хариуцлагатай баймаар байна. Ер нь манай орны улс төрийн тогтолцооны суурь нь бол улс төрийн намууд учраас улс төрийн намуудын хариуцлагатай, ил тод, нээлттэй, дотоод ардчилалтай байх талын алхмуудыг өнөөдөр яг.../минут дуусав/

Г.Занданшатар: Дуламдоржийн Тогтохсүрэн ажлын хэсгийн ахлагч, Монгол Ардын намын бүлгийн дарга асуултад хариулна.

Д.Тогтохсүрэн: Тэгэхээр Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Сонгуулийн хууль бол сонгууль зохион байгуулах журам байхгүй юу. Үндсэн хуульд ч гэсэн тэгээд заачихсан байгаа Өнөрболор гишүүн ээ. Сонгуулийн хууль бол сонгууль зохион байгуулах журам. Сонгуулийг хэрхэн яаж зохион байгуулах вэ, иргэд, улс төрийн намд ямар боломж олгох вэ, тэгш өрсөлдөх боломжийг яаж олгох вэ энийг л зохицуулсан хууль. 1 дүгээрт нь Сонгуулийн хууль бол. Ер нь эрчүүдээс болоод өнөөдөр Монголын нийгэм ийм болчихсон гэж арай хэлж болохгүй л дээ. Бүх юмыг муу эрчүүд рүү чихэж. Ийм үг ярьдаг. Их Хурлын индрээс ийм юм ярьдгаа манай гишүүд жаахан болимоор байгаа юм. Мэдээж хувь хүнтэй холбоотой асуудал байгаа. Яагаад өнөөдөр жендерийн асуудлыг ингэж ярьж байна вэ гэхээр энэ хувь хүнээс л шалтгаалж байгаа шүү дээ. Эцсийн эцэст. Надаас өнөөдөр сэтгүүлч асууж байна лээ. Үгүй ээ, яагаад квот тавиад байгаа юм. Ард түмний сонголт өөр өөрөө шийднэ шүү дээ. Яагаад та нар зарим нэг хэсэг хүмүүсийг 1, 1 гээд сөөлжүүлж оруулж ирэх гээд байгаа юм гээд зарим хүн бүр аягүй дургүйцэж байгаа. Дургүйцэж байгаа энийг. Тэгэхээр энэ бол зүгээр л хувь хүнээс шалтгаалж байгаа асуудал байхгүй юу. Шуудхан хэлэхэд бол. Тэгээд л нэг эрчүүдээс шалтгаалаад л Монголын нийгэм өнөөдөр ийм болчихсон юм шиг нэг ийм юм ярьдгаа болих хэрэгтэй гэж би шууд хэлэх гэж байгаа юм.

2 дахь юм бол Улс төрийн намын хууль одоо Их Хуралд хэлэлцэгдэж байгаа. Энэ 3 хууль хамт яваа. Эхлээд сонгуулийн хууль өргөн баригдсан. Дараа нь Улс төрийн намын хууль өргөн баригдсан хэлэлцэгдчихсэн. Үндсэн хууль батлагдчихсан. Улс төрийн намын хууль батлагдаж байна. 7 сарын 7-оос өмнө Улс төрийн намын хуулийг гаргана гэж байгаа. Энэ 3 хамт явна. Улс төрийн намыг хариуцлагажуулах, сахилгажуулах, улс төрийн намыг илүү ил тод, нээлттэй болгоход чиглэгдсэн ийм хууль байгаа. Энэ хуулийг бол маш хурдан гаргах ёстой гэдэгтэй бол санал нэг байгаа. Тийм учраас ажлын хэсэг гараад ажиллаж байгаа энэ дээр.

Тэр жендертэй холбоотой асуудлаар бол түрүүн би хэлчихсэн дээ. Тэгээд ер нь би зүгээр энэ даирамд хэлэхэд манай эмэгтэй гишүүд тэгээд л нэг сошиалаар баахан юм явуулаад л, санал өгсөн гишүүдийн эрхэнд халдаад л, тэгээд л нэг хэсгийгээ магтаад л нэг ийм юм явуулдаг би боль гэж хэлэх гэж байгаа юм. Улсын Их Хурлын гишүүн ард түмнээс авсан мандатын хувьд өөрөө саналаа өгөх л эрхтэй. Тэрнийхээ дагуу саналаа өгөөд л явъя. Тэгээд л янз бүрийн сурталчилгаа хийгээд л ингэж тэгдгээ болих хэрэгтэй гэж би зориуд хэлмээр байгаа юм. Тэгээд сошиалаар тэр ард түмэнд хэрэгтэй юмыг нь ярих хэрэгтэй шүү дээ. Тэгэхгүй тэгээд л нэг л жендер ярьсан хэдэн хүн байх юм.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүн Нямаагийн Энхболд.

Н.Энхболд: Ийм байна. Сая Өнөрболор гишүүнээс хэлсэнтэй санал нэг байна. Энэ 3 хууль багцаараа явж байж л бид нарын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн үр дүн харагдана. Тэгэхээр 1 хуулиараа бүх зүйлээ зохицуулах гэж оролдох нь бас хэр зэрэг зөв юм бол доо 1 дүгээрт.

2 дугаарт. Сонгуулийн хуулиар бид нар 20 байсныг нь 30 болгоод ороод ирж

байгаа. Энийг бол бас дэвшил гэж үзэж байгаа. Олон намуудын зөвлөгөөнүүд болсон. 2, 3 удаа. Намууд бол том жижиг гэлгүй янз бүрийн л байр суурьтай байна лээ. Янз бүрийн, ерөөсөө жендерийн тухай асуудал хэрэггүй. Бид өөр өөрсдийнхөө хэмжээнд сайн хүмүүсээ дэвшүүлэх боломжууд байгаа шүү дээ гэж хэлж байгаа ийм зүйлүүд ч бас тэр хэлэлцүүлгүүдийн явцад ажиглагдаж байсан. Тэгэхээр би ингэж бодож байгаа. Одоо жишээ нь намын хууль гарна шүү дээ. Намын тухай хууль Өнөрөө гишүүн ээ. Намын тухай хууль яагаад их чухал вэ гэхээр 1 дүгээрт намууд өөрсдөө бас бодлогоо тодорхой хэмжээнд явуулах орон зайг үлдээх ёстой юм байгаа юм. Маш их том хариуцлага Үндсэн хуулийн өөрчлөлтөөр намуудад ирж байгаа. Энэ хариуцлагаа биелүүлэхийн тулд тэдэнд бас тодорхой хэмжээний эрх байх ёстой. Өөрийнх нь гэж. Тухайлбал жишээ нь боловсон хүчнийхээ нөөц, боломж бодлогодоо нийцсэн бүрэлдэхүүн дэвшүүлэх энэ зүйлүүд дээр нь бас тодорхой хэмжээгээр намуудад ажиллах эрхээ хэрэгжүүлэх ийм орон зай бас тодорхой хэмжээгээр хэрэгтэй. Энийг нь бид нар, намын хуулиуд, намынхаа хуулиудаар зохицуулах ёстой. Одоо ингээд түрүүн Тогтохсүрэн дарга хэллээ. Ерөнхийлөгч өргөн мэдүүлчихсэн. Намын тухай хуулийг бид нар хэлэлцээд эхэлчихсэн. Ажлын хэсгээ томилогдчихсон байж байгаа. Ажлын хэсгээр манай Ц.Мөнхцэцэг гишүүн ажиллаж байгаа. Энэ намын хуулиуд дотор Үндсэн хуулиар тэр намуудад хүлээлгэсэн үүрэг хариуцлагыг нь нийтлэг үүрэг хариуцлагуудыг нь тодорхой тусгаж өгөхийн хэрэгцээгээр бас улс төрийн намууд чинь угаасаа өөрсдийнхөө үзэл бодол дээр нэгдсэн тодорхой хүмүүсийн нэгдэл байдаг учраас тэр сайн дурын үндсэн дээр нэгдсэн улс төрийн олон нийтийн байгууллагуудад бас нэг үйл ажиллагаагаа бололцоондоо тааруулж явуулах орон зайг үлдээх нь бас зохистой юм болов уу л гэж бодож хуулиудаараа тэнцүү аль аль талдаа боломж олгосон,

Сонгуулийн хуулиараа квотыг нь нэмчихсэн. Тэгээд тэрнээс дээш нэмэх бололцоотой намууд нь нэмээд явна. Дотроо түрүүн миний хэлсэн нөөц, боломж элдэв юмаа харж байгаад хэдэн хувиа дэвшүүлэхээ нам нь шийдээд явж байх ийм боломжийг нь бас байлгах нь зүйтэй болов уу гэдэг агуулгаар л жишээ нь бидний нөхөд.../минут дуусав/

Г.Занданишатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Би 29.10-ын нийгмийн бүлгийн төлөөлөл оролцоог хангана гэдгийг нийгмийн бүлэг гэдгээ юу гэж ойлгож байгаа юм бэ. Одоо байгаа 76 дотор чинь бас нийгмийн бүлгийн төлөөллүүд байгаа байх л гэж бодож байна. Багш, эмч нарын гээд. Одоо бусад төлөөллүүд чинь малчдын, газар тариалан эрхлэгчдийн гэдэг юм уу, одонтой ээжүүдийн төлөөлөл бид нар оролцоно, оролцуулах ёстой гээд ингээд байвал яах вэ. Жолооч нар бид нарын төлөөлөл байх ёстой гээд ингээд байвал яах вэ. Энийг юу гэж ойлгож байгаа юм. Нийгмийн бүлгийн төлөөллийг бүгдийг нь оролцуулна гэвэл энэ чинь 126 ч багадаа байлгүй дээ. Энэ дээрээ та бүхэн юу гэж ойлгож оруулж ирж байгаа юм бэ гэдгийг нэгд асууя.

2-т шигтгэсэн хувилбарын 74.3.2 дээр шаардлага хангаагүй нам эвслийн авсан нийт саналын хувийг шаардлага хангасан нам эвсэлд тэнцүү хэмжээгээр хувааж өгнө гэж. Яагаад тэр намыг сонгоогүй өөр намд өгсөн саналыг нь таны өгсөн санал танай нам шаардлага хангаагүй ээ. Тэр 5 хувийн, 7 хувийн босгыг даваагүй учраас шаардлага хангасан өөр таны санал өгөөгүй өөр намд чинь саналыг чинь хуваарилж өгч байна гэдэг нь хэр зохимжтой юм бэ. Хүний өгсөн саналыг өгөөгүй намд нь хуваарилах гэж байна шүү дээ. Энэ хэр зохимжтой заалт вэ гэдгийг нэг тодруулж өгөөч.

66.2 дээр нам, эвсэл, тэдгээрээс жагсаалтаар нэр дэвшигчийн саналыг тэмдэглэх хэсэгт 1 нам, эвсэлд эсхүл жагсаалтаар нэр дэвшигчээс нэг нэр дэвшигчид саналаа өгнө. 48 жагсаалтын нэр дэвших саналын хуудас нь саналын хуудсыг 2 хуудсанд багтаагаад 48, 3 хуудсанд багтаагаад 48 хүний нэр саналын хуудас байя гэж бодъё. 10 нам нэр дэвшүүлээ гэхэд үндсэндээ бараг 30, 40 хуудас болох нь. Тэгээд зөвхөн намыг нь дугуйлаад тэгээд тэр намын нэр дэвшсэн 48 дотроос ахиад нэг хүнийг дугуйлж болох юм байна тийм үү. Энүүгээр орж ирснээр бол. Тэр 48 дотроос 1-ийг. Тэгээд энэ 48 чинь бол 48-уулаа намыг төлөөлж жагсаалтаар нэр дэвшиж байгаа хүн байхгүй юу. Нэр дэвшигч нар. Гэтэл яагаад заавал нэгийг нь дугуйлах ёстой гэж. 48 хүртэл дугуйлж болох ёстой юм биш үү. 66.2 шүү дээ би шигтгэсэн хувилбарын 66.2-ыг та нарын оруулж ирсэн санал дээр ярьж байна. Тэгээд хэрвээ ингээд нэг хүнийг дугуйлаад, нэг намыг дугуйлаад ингээд дараа нь саналын дүн гаргахад яаж тооцох юм. Тэр хүмүүсийн тэр нэр дэвшигчийг дугуйлсныг нь яаж тооцох юм. Намыг дугуйлсан нь бол тэр авсан саналаараа гараад ирдэг юм байгаа биз. Тэр 1, 1 хүнийг дугуйлсныг нь яаж. Зөвхөн нам болгоноос нэг хүнийг дугуйлж болох юм уу, эсвэл зөвхөн дэмжиж байгаа намынхаа нэг хүнийг дугуйлах юм уу. Энийг яаж ялгах юм. Ийм 3 асуултад хариулт өгөөч.

Г.Занданишатар: Эхлээд зочид танилцуулчихъя.

Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг, Жамъянхорлоогийн Сүхбаатар нарын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 9 дүгээр ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүндэт эрхэм сурагчид та бүхэндээ сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Сурах чиглэлийг эрхэм болгож, хандах зүгээ өөрөө тогтоож, улам сайн хичээж, ирээдүйдээ гэрэлтэй эрхэм хүмүүс болцгоогоорой гэж хүсэн ерөөе.

Улсын Их Хурал дээр бол асуулт хариултын цаг үргэлжилж байна.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн. Цэндийн Сандаг-Очир гишүүний асуултад хариулна.

Д.Тогтохсүрэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Манай Үндсэн хуулийн өөрчлөлтийг хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүдийн хамгийн их ярьсан асуудал энэ байгаа юм. Жагсаалтаар нэр дэвшигч нарт нийгмийн бүлгийн төлөөллийг их сайн оруулж өгмөөр байна. Ажил мэргэжлээр нь ч, жендерээр нь ч, тэгээд өөр олон төрлөөр нийгмийнх нь байдлаар нь ч гэсэн оруулмаар байна гэдэг санал их байсан учраас ажлын хэсэг ярилцаж байгаад нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ ардчилсан, ёс, шударга, ёсны зарчмыг баримталж, нийгмийн төлөөлөл, оролцоог хангана гэдэг ийм л байдлаар тавьчихаад байгаа юм. Илүү нарийвчлах юмнууд нь бол би Улс төрийн намын хуулиар явах болов уу гэж ингэж бодож байна. Сонгуулийн хуулиар үүнээс илүү нарийвчлах боломж байхгүй байгаад байгаа юм.

Пропорциональ тогтолцоотой улс орнуудад байдаг нэг том зарчим бол их үлдэгдлийн зарчим байгаад байгаа юм. Энэ бол босгоос дээш санал авсан намууд нь суудлаа хуваарилж авдаг, босго хүрч чадаагүй намд өгсөн саналуудыг их үлдэгдлийн зарчмаар үлддэг, тэр үлдэгдлийг санал авсан намууд нь хуваарилж авдаг ийм л зарчим юм байна лээ. Энэ зөвхөн Монголд байдаг юм биш. Дэлхий нийтийн бүх л оронд пропорциональ системтэй бүх л оронд байгаа юм. 2012 онд манайх бас холимог тогтолцоо авахдаа энэ зарчмаар явж байсан юм байна лээ. Тэр үед нь 3 суудал

хуваарилагдаж байсан юм байна лээ. Их үлдэгдлээс.

Саналын хуудас 2 хэсэгтэй байгаа. Нэг хэсэг нь тойрогт нэр дэвшигчдийн зориулсан хэсэг байгаа. Тэр нь нөгөө тойрогт нэр дэвшсэн хүнээс аль нэгийг нь дугуйлна гэсэн үг. 2 дахь нь улс төрийн намд санал өгнө. Улс төрийн намд санал өгнө. Улс төрийн намын нэр дэвшигч нарт санал өгөхгүй. Жагсаалтаар нэр дэвшигчид өгөхгүй. Намд нь санал өгнө. Нямаа Энхболд нарын гишүүдийн өргөн барьсан дээр бол аль нэг хүнд өгнө гэж орж ирсэн юм. Тэрийг нь олон талаас нь харгалзаж үзээд, тэгээд техникийн боломж бол байхгүй байгаа юм. Манай сонгуулийн хорооныхон тооцоо хийж үзсэн байна лээ. Нэг нам 48 хүний нэр дэвшүүлнэ гээд үзэхээр доод тал нь 3 метр, дээд тал нь 6 метр саналын хуудас болох юм байна гээд байгаа юм. 3-6 метр саналын хуудас болох юм. Тийм учраас бол сонгогчид бол энд санал өгөх боломж байхгүй. Санал өгөхөд бол хамгийн гол нь сонгуулийн журам бол сонгогч саналаа өгөх, хамгийн ойлгомжтой, боломжтой тийм хувилбар байх ёстой гэж үзэж байгаа. Тийм учраас намд санал өгнө гэж байгаа юм. Харин нам жагсаалтын 48 хүнээ сурталчлах ёстой гэдэг хэлбэрээр сурталчилгааны хэвлэлийн хуудас, цахимаар, телевизээр сурталчилна гэдэг байдлаар хуульд оруулж өгсөн байж байгаа.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулна.

Ц.Сандаг-Очир: Энэ шигтгэсэн хувилбарын чинь 66.2 дээр тэгээд байна шүү дээ. Тоогий дарга аа. Тэгвэл Энхболд гишүүдийн өргөн барьсан тэр санал чинь тэгэхээр энэ чинь байгаа юм уу, байхгүй хасагдчихаад байгаа юм уу. Нэг нэр дэвшигчид саналаа өгнө гэж байна шүү дээ. Тэрийг хасчихсан юм уу. Хасчихсан гэж ойлголоо. Тэгэхээр та саналын хуудас ерөөсөө намуудын нэр л байх юм уу. Ард иргэд чинь болохоор саналын

хуудсан дээр тухайн нам ямар ямар нэр дэвшигчдийг 48 хүнийг дэвшүүлсэн бэ гэдгийг танилцах боломжоор хангаж өгөөч ээ. Бид нар тэгж байж кабинд орж байж аль нам ямар нэр дэвшигчтэй нь нэр цэвэр хүмүүсийг дэвшүүлж вэ, нэр хүндтэй хүмүүсийг дэвшүүлж вэ. Нөгөө талаар нь нөгөө муу нэртэй, луу данстай хүмүүсээ яаж дэвшүүлж вэ гэдгийг харж байж намын дугуйлах бололцоог хангаарай гэдэг ийм юм яриад байгаа шүү дээ. Тэгэхээр та бүхний оруулж ирж байгаа чинь бол тэр 48 хүний нэрийг жагсаахгүйгээр зүгээр намыг дугуйлах саналын хуудас.../минут дуусав/

Г.Занданишатар: Дуламдоржийн Тогтохсүрэн ажлын хэсгийн дарга хариулна.

Д.Тогтохсүрэн: Тэгэхээр би түрүүн хэлсэн. 1 дүгээрт бол пропорциональ тогтолцоондоо ер нь л үндсэн сонгодог тогтолцоо нь бол намд л санал өгдөг. Яах вэ зарим нэгэн оронд бол хүнд санал өгөх юм бий. Энэ бол улс орны хэмжээнд нэг тойрог болдог ийм зүйл байгаа юм. Энэ нь манайд тохиромжтой юу, үгүй юу гээд олон талаас нь ярьж байгаад ажлын хэсэг энэ хувилбарыг нь авсан юм.

2 дахь нь би түрүүн хэлсэн. Техникийн хувьд санал хураахад бол манайд хүнд санал өгөх хэлбэрээр намын ард байгаа хүнд санал өгөх хэлбэрээр бол боломж алга гэж байгаа юм. Харин бид нар энэ хуулийн төслүүд дээр санал хураахад гарчихсан байгаа. Материал тараах, нам нь материалыг нь тараах, сурталчилгаа хийх ийм 48 хүн байгаа Манай энэ 48 хүн бол нэр цэвэр ийм хүмүүс байгаа. Та бүхэн саналаа өгөөрэй гээд сурталчлах бүх бололцоог нь орж ирж байгаа зарчмын зөрүүтэй саналуудаар хийгээд өгчихсөн байгаа. 3 хэвлэлийн хуудас сурталчилгаа байгаа. Цахимаар сурталчилна гэж байгаа. Телевиз, радиогоор сурталчилна гэж байгаа. Ингээд бүх юмыг нь заагаад.../минут дуусав/

Г.Занданишатар: Төрийн байгуулалтын байнгын хороо, ажлын хэсэг энэ шигтгэсэн хувилбараа тараа. Сандаг-Очир гишүүн ээ, нэгтгэсэн төсөл тараагаад, таны уншаад байгаа хараар бичсэн нь бол Нямаагийн Энхболд нарын гишүүдийн төсөл, цэнхэр өнгөөр нь Цогтгэрэл нарын гишүүдийн төсөл, тэгээд нэгтгэсэн хувилбар л юм байна энэ тараагдсан чинь. Шигтгэсэн хувилбар биш байгаа байхгүй юу. Шигтгэсэн хувилбар тараагдаад тэр дээр нөгөө саяын 66.2-ын хасагдсан хувилбар. Давхиуулаад 2 төслийг нэгтгэж хэлэлцэж байгаа учраас нэгтгээд нийлүүлчихсэн төсөл цэнхэр нь Цогтгэрэл нарын гишүүдийнх, ногоон нь энэ 2 давхцаж байгаа. Энэ дээрээ биччихсэн байгаа. Хамгийн эхнийх нь хуудсан дээр. Ногоон нь давхцаж байгаа гээд. Нэгтгэсэн төсөл гэдгийн доод талыг уншихаарай. Тэгээд зарчмын зөрүүтэй саналын томъёолол дараа нь уншаад явчихаар энэ 2 төсөл чинь нэгтгэгдээд цагаан, ногоон, цэнхэр чинь ингээд жигдрээд нэгдсэн хувилбар эцсийн хэлэлцүүлэгт гарна. Тэгж ойлгохгүй бол бас гишүүдийн толгой эргүүлээд байх шиг байна.

Дашидондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Ингээд Сонгуулийн хуулийг бид нар хэлэлцэж байна. Сонгууль маань өөрөө эрх баригчидтай хариуцлага тооцох ийм арга хэрэгсэл л дээ. Бид нар ард түмний хүссэнээр ард түмний амьдралыг өөд нь татаж чадаагүй бол нөгөө дотоод нам нь Улсын Их Хурал нь хоорондоо хариуцлага тооцож чадахгүй бол тэрийг ард түмэн тооцож өгдөг ийм боломж өгдөг 4 жилд 1 удаа хийдэг ийм сонгууль. Энийгээ бид нар хэл амгүй аятайхан шиг хийгээд ингээд явуулчихмаар байгаа юм. Тэр ард түмний яг хүсээд, хүлээгээд байгаа тэр хүмүүс нь энэ танхим дотор орж ирээд, энэ асуудлыг шийдээд явах ийм боломжийг нь өгөх ёстой. Тэр ард түмний элч гэдэг яг тэр юунд нь заасан. Энэ сонгуулийн хуулийг ярихдаа бид нар

сонгогдох гэж байгаа дарга нарын өмнөөс ярих биш, сонгох, сонгууль өгөх тэр ард түмний өмнөөс л ярьж байх ёстой юм байгаа юм гэж ойлгож байна. Тэгээд бүх хуулийн зүйл заалтыг заагаад, хайрцаглаад ингээд явах нь ямар билээ. Тухайлбал хэд хэдэн зарчмууд байдаг. Ил тод, шударга гээд. Жишээлбэл яг олонхын саналыг авсан байж чадах уу. Тэгж байж нөгөө хүн чинь ард түмний элч болно шүү дээ. Тэгэхгүй бол олны саналыг авсан гээд л тусгачихсан л байна лээ. Нэг.

2-т яг хугацаандаа 4 жил бүрэн эрхээ эдлээд яг 6 сарын 20-доо сонгууль нь явах уу. Нэг жилийн дараа. Энэ зүйлийг надад тодруулж өгөөрэй. Нөгөө талаар бас бид нар социалистууд цугларчихсан юм шиг л юм яриад байх юм. Эр, эм хүйс гээд л. Нөгөөх чинь ялгаж болохгүй шүү дээ. Монгол Улсын Үндсэн хуулиар тэр тийм хүйс, энэ нь ийм хүйсийг ингэж тэгж өгнө гээд. Үгүй, одоо тэгээд бас хоцрогдож. Энэ чинь хүйсээ очоод солиулчихдаг болсон юм биш үү. Манай баахан эмэгтэйчүүд ингээд л баярлаад байдаг. Ардын намын дарга нар чинь бүгд хүйсээ солиулчихаад л ирнэ шүү дээ. Тайланд яваад. Мөнгөтэй, төгрөгтэй болчихсон. Тэгээд тэрийг нь ямар хүйст тооцох юм гэх мэтчилний ийм юмнууд байна. Тэгээд яах вэ? бурхнаас эр, эм хүйсийг заяасан гээд сая Трамп бурхан тийм юм шийдсэн гээд л үг хэлэнгүүт л тэнд чинь бөөн замбараагүй байдал бий болж байна шүү дээ. Өөр ямар ч хүйс бий болчихсон юм. Тэрийг нь сайн мэдэхгүй байна. Тэгээд ийм ийм юмнууд дагалдаад явна. Тэгээд тэр хүйсийн төлөөлөл чинь бид нар байна гээд гадаа жагсаад эхэлбэл яах юм. Бас л хүний эрх шүү дээ. Ийм ийм зүйлүүдийг бодож тооцож ингэж ярих ёстой гэсэн ийм ойлголтууд байна.

Нөгөө талаар бол намууд төлөвшиж чадаагүй байгаа. Хоорондоо энэ намууд ингээд намуудаа наймаалаад эхэлчихжээ. Нөгөө мөнгө төгрөг багатай сонгууль юун бүүр их болчихож

магадгүй байна. Тэгэхээр энэ босгыг бас арай ямар тавиад байна вэ. Энэ талаар яаж анхаарч байна вэ гэсэн ийм асуудал байна. Нөгөө талаар тэр жагсаалтаар орж ирж байгаа хүмүүсийг энэ удаа бол ард түмнээрээ эрэмбэлүүлье. Цогтгэрэл гишүүн бид 2-ын Ардчилсан намаас өргөн барьсан хууль дээр тэгж байгаа шүү дээ. Одоо яриад байгаа нь бол 6 хуудас болох юм байна. 3 тийм метр юм болох юм байна гэсэн юм яриад байх юм. Үгүй ээ, энэ чинь технологийн шийдэл бол амархан шүү дээ. Чадахгүй бол Сонгуулийн ерөнхий хороо бол тэр чаддаг хүмүүст нь өгчих хэрэгтэй. Би зохион байгуулаад өгье. Амархан шүү дээ энэ чинь.

2 дугаарт тэр хар машин, энэ бүх юмнуудыг бол цэгцлэх юм байгаа биз дээ. Баталгаагүй юмаар бол олон удаа сонгууль явуулсан шүү. Тэгэхээр энэ удаа энэ сонгуулийг баталгаатай юмаар явуулах ёстой гэдгийг Сонгуулийн ерөнхий хороо шийдэх ёстой. Нөгөө талаар төрийн албан хаагчид оролцож явуулна. Энийг би зүйтэй гэж бодож байгаа. Төрийн албан хаагчид Сонгуулийн ерөнхий хороо, хэсгийг ахалж ажиллаж байхдаа Сонгуулийн ерөнхий хороо энэ сонгууль дээр ямар нэгэн будилаан гаргавал.../минут дуусав/

Г.Занданшатар: Байнгын хороон дарга Нямаагийн Энхболд гишүүн. Түр байж байгаарай. Зочид танилцуулаадахъя. Улсын Их Хурлын гишүүн Энхтайвангийн Бат-Амгалангийн урилгаар нийслэлийн Баянзүрх дүүргийн 22 дугаар хорооны ахмадуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт ахмадууд та бүхэндээ сайн сайхныг хүсэн ерөөе. Нямаагийн Энхболд дарга асуултад хариулъя.

Н.Энхболд: Ганбат гишүүний асуултуудад хариулъя. Олонхыг төлөөлөх гэдэг үгийг зориуд дурдаад асуулаа. Энэ нөгөө урьд нь бид нарын хуульд хэрэглэж

байсан мажоритар гэдэг үгээ ер нь ийм үгээр яг манайд тохирсон хэрэглэж байгаа аргад нь нийцэх Монгол үг юу байна. Утга элдэв талаас нь харж байгаад хэлний үндэсний зөвлөлийнхөнтэй хүртэл зөвлөж байгаад яг манайд хэрэглэж байгаа тойрог дээрээ хамгийн олон санал авсан хүмүүс сонгогддог энэ аргыг олныг төлөөлөх арга гэж нэрлэе гэж ингэж тогтсон. Үндсэн хуульд ингээд орчихсон. Одоо тэгэхээр хэрэглээнд ороод цаашидаа тогтсон үг хэллэг болно гэж ойлгож байна. Ер нь тойрогт 28-аас доошгүй санал авсан хүн бол сонгогдсонд тооцохгүй. Дор хаяж 28 хувийн санал авч байж сонгогдоно. Хүрэхгүй дахин сонгууль явуулна. Тийм байгаа байх аа Бат-Эрдэнэ ээ. Тэрийг хасчихсан уу. Тэр хасагдсан байна. Хамгийн олныг авсан нь тэгээд л явна. Уг нь босго байх нь зөв байсан юм байгаа юм. Тэгээд одоо хасагдаж байгаа юм байна. Ээлжит бус сонгууль явахгүй байх гэж ойлгож байгаа. Бид нар Үндсэн хуулийн дагаж мөрдөхөд шилжих тухай хуулийнхаа төсөлд ч энэ талаар ойлгогдохоор заалт оруулсан. Тэр хуульд заагдсан зүйлүүд Үндсэн хуулийн нэгэн адил хүчин төгөлдөр хүчинтэй болохоор ээлжит сонгуулийн тухай асуудал яригдахгүй гэж бодож байна. Жендерийн асуудлаар Ганбат гишүүний байр суурийг сонслоо. Тэгээд энэ бас санаа зовохоор асуудал нээрээ сая бас Ганбат гишүүн хүндээ орхичихлоо. Одоо ингээд хуулийн ийм бололцоо гараад ирэхээр хуучин санал худалдаж авдаг байсан бол намуудыг худалдаж авдаг юмнууд эхэлж байна гэж. Түрүүчийн зарим намууд жагсаалтад дээр байгаа намууд бүрэн батлагдсан эсэхийг мэдэхгүй байна. Зарим нам намаа худалдсан, тэгээд худалдаж авсан хүмүүс нь тухайлбал жагсаалтад дээгүүр орох ийм боломжийг бүрдүүлээд эхэллээ гэсэн мэдээллүүд яваад байна. Энэ бол өөрөө байж боломгүй л асуудал байгаа юм. Энийг яаж зохицуулах вэ гэдгийг харин бид нар тэр дараа намуудын тухай хуулиар юм уу, ямар нэгэн байдлаар

зохицуулахгүй бол нөгөө мөнгөнөөс хол байя, нөгөө ил далд нь байсан мөнгөтэй хүмүүс сонгуульд орох бололцоогоо нэмэгдүүлэх ялах бололцоогоо нэмэгдүүлэхийн тулд дээд шүүхийн бүртгэлээр дээгүүр жагссан намуудыг худалдаж авах, санал худалдаж авахаас хамаагүй том худалдаа наймаа явж эхэлж байгаа ийм асуудлууд гараад байна. Энийг бид нар бүгдээрээ тал талаасаа бодож байж яаж зохицуулах вэ гэдгээ намуудын хуулиар байдаг юм уу, ямар нэгэн байдлаар газар авхуулахгүй байх шаардлагатай гэж ингэж харж байгаа.

Бид нарын боловсруулж өргөн барьсан хууль дээр жагсаалтаар хүнээ дэвшүүлж байгаа эсвэл намд нь өгнө эсвэл нам дотроос нэг хүнд өгнө гэсэн ийм санаагаар заалт орсон. Тэгээд энэ хэлэлцүүлгийн явцад явж байгаа техникийн боломж, бусад асуудлуудаас шалтгаалаад намдаа өгөөд явна. Нам нь мөрийн хөтөлбөрөө дэвшүүлнэ, бодлогоо гаргана. Тэр бодлогыг ийм хүмүүс хэрэгжүүлэх юм шүү гэсэн жагсаалтай хамт гаргана. Тэгэхдээ санал хураах хуудас 2 юутай. Тойргоо сонгоход нэг тэмдэглэгээ хийнэ. Намуудыг сонгоход намд нь тэмдэглэгээ өгөөд. Тэгээд хүмүүс харахдаа 1 дүгээрт мэдээж бодлогыг нь ямар бодлого явах гээд байгаа юм, юу хийх гээд байгаа юм гэдгийг нь хараад, тэр бодлогыг хэрэгжүүлэх хүмүүс.../минут дуусав/

Г.Занданшатар: Дуламдоржийн Тогтохсүрэн ажлын хэсгийн дарга хариулна гэж байна.

Д.Тогтохсүрэн: Тэр намуудын наймаалдаг эд нар дээр 2 асуудал байгаа. Сонгуулийн хуулийн 33 дээр бид нар ажлын хэсэг ярилцаж байгаад ийм заалт оруулсан байгаа. Нам эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн дэмжигчдээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглоно гээд. Өөрөөр хэлбэл намууд бол маш их хэмжээний ийм мөнгө

урьдчилж авах ийм юм руу явчих вий гэдэг ийм болгоомжлолын үүднээс оруулсан.

2 дахь нь сая Энхболд гишүүн хэллээ. Улс төрийн намын хуулийг үүний дараа шууд үргэлжлээд орж ирнэ. Энэ дээр их хатуу оруулах ёстой. Хатуу оруулах ёстой. Шаардлагатай гэвэл би бол бас боддог юм. Шаардлагатай гэвэл улс төрийн намыг намын хууль гарсны дараа бүртгэлийг нь дахиж цэгцлэх хэрэгтэй гэж бодож байгаа юм. Бүртгэлийг. Тийм боломж бас бий шүү дээ. Ийм ажлууд хийхгүй нам нэртэй 1 хүний нам ч явж л байгаа шүү дээ. Тийм тийм учраас энийг цэгцэлж авах ёстой гэж бодож байгаа юм.

Г.Занданишатар: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя. 1 минут.

Д.Ганбат: Бас өөр 1 асуудал байна. Тэр төрийн албан хаагчдаар хариуцлага сайн тооцох хэрэгтэй. Сонгуулийн ерөнхий хорооны хууль, заалт харах ёстой байх. Үүнээс гадна бас Монгол улсын Ерөнхийлөгч нар байгаа. Энэ чинь ард түмний эв нэгдлийг илэрхийлнэ гээд ажиллаж байсан. Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч байсан онцгой субъект. Энэ хүмүүс маань аль нэг намыг толгойлоод ч юм уу, дотор нь оролцоод явах нь хэр зохимжтой юм бэ. Бусад улс орнуудад бол тэгээд номоо зараад, ногооны талбай дээр ажиллаад, дурдатгалаа бичээд байж байдаг. Манайд бол арай тэгэхгүй байх шиг байна. Тэгэхээр чинь нөгөө нэг сурталчилгаанд оролцоод л ингээд л явах нь ёс зүйд хэр нийцдэг юм. Яадаг юм. Энийг яаж зохицуулах юм бэ. Энэ чөлөөтэй байх юм уу. Ямар байх юм. Тэр хүмүүс чинь бүх насаараа цалин авч байгаа байх. Андуураагүй бол. Засгийн газрын гишүүд шиг. Тэгээд эв нэгдлийг илэрхийлнэ гээд бүх ард түмнээсээ сонгогдохсон байж байдаг, эргээд бас аль нэг намд нь ороод явахаар чинь бас л.../минут дуусав/

Г.Занданишатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн, ажлын хэсгийн дарга. Нямаагийн Энхболд дарга яаж зохицуулах вэ гэж асуусан.

Н.Энхболд: Би түрүүн Ганбат гишүүний асуултад хариулахдаа нэг зүйл дээр дутуу орхисон байна. Хар машинтай холбоотой асуудал. Ямар ч байсан техник маань программ нь өөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийг явуулж чадах хэмжээнд байна уу, үгүй юу гэдэг талаар л тал дээр Сонгуулийн ерөнхий хорооныхонтой ярьж санал солилцож байгаад, шинэчлэх хөрөнгө мөнгөний асуудлыг ярих ёстой гэдэг дээр нь бид нар санал нэгдсэн. Дэлгэрнарар дарга энийг нь хэлчихнэ биз. Зүгээр энэ даширамд хэлэхэд сүүлийн сонгуулиудаар уг нь намжчихаад байгаа, ойлгоод хүмүүс. Тэгэхдээ ингээд сонгууль болохоор гарч ирээд байх юм. Ерөөсөө хар машин гэдэг юмаар дандаа булхайтай сонгууль явж байсан юм шиг. Санал тоолох машины дүнг сүүлийн 2 сонгуулиар 100 хувь гараар тоолж хянасан. Тийм ээ, зөрсөн асуудал ерөөсөө гараагүй. Тухайн тойрог дээрээ цөөхөн саналаар ялагдчихсан хүмүүс хүртэл хүсэлтээ тавьж байгаад тухайн хэсгийн хороон дээр очоод, машины.../минут дуусав/

Г.Занданишатар: Ер нь Байнгын хороо дээр хэлэлцэгдсэн чиглэлээр хариулах ёстой л доо. Тэгээд Байнгын хороон дээр Бөхчулууны Пүрэвдорж гишүүн энэ асуудлыг хөндөж тэр домино нэтворкс билүү компани бол хар машин луйвартай программ алдаа зөрүүтэй гэдэг асуудлаар шүүхэд хандаад, тэр шүүмжилсэн хүмүүсээс 758 сая доллар нэр төрөө сэргээлгэхээр ялсан гэсэн мэдээллийг Байнгын хороон дээр өгч байсан. Яригдаж байсан. Тэгэхээр тэр программын хангамжаа асуудалгүй гэдгээ шүүхээр тогтоолгосон юм байна тэр компани гэж мэдэгдэж байсан. Тэгээд энийг шинэчлэх шаардлага нь хугацаа нь дууссан учраас энийг Сонгуулийн ерөнхий хороо уг нь

хариулуулах ёстой. Дараа нь жич хариулна биз.

Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Сонгуулийн 2 хуулийг нэгтгээд хэлэлцэж байгаа. Бас яг өргөн барьсан гишүүний хувьд тодорхой энэ хуулиуд дээр нарийн асууж тодруулах зүйл алга. Ерөнхийдөө өмнө нь өргөн барихаас өмнө бас ярилцаж ойлголцсон олон зүйлүүд бас харилцан тусгалцаад явж байгаа гэж бас бодож байгаа. Энэ хэлэлцүүлгийн шатад тэгээд цаашаа явна биз. Харин өргөн барьсан хувилбаруудад байхгүй мөртөө бас нэг зүйл заалт яваад байгаа. Энийг ажлын хэсгийн даргаас бас асуух гэж байна л даа. Ер нь Монгол Улсын Үндсэн хуульд Монголын ард түмэн төрөө байгуулна гэдэг нэг үзэл санаа цаана нь байж байгаа. Үүний цаана яг энэ 2 хууль болоод энэ зүйлүүдээр явахаар намууд төр барих тэр тусмаа намуудад илүү тийм чадавхжуулах чиглэлд маш их олон өөрчлөлтүүд энд хийгдэж байгаа. Үүний цаана тэр Үндсэн хуулийн үзэл санаанаас ингээд харахаар иргэн хүн төрөө барина гэдгийн цаана бие даагч гэдэг утга тэрний цаана бас харагдаад байгаа юм. Тэгэхээр энэ өргөн барьсан 2 хуулийн төсөлд алинд нь ч бие даагчдын тухай ямарваа нэгэн өгүүлбэр ороогүй.

Улс төрийн нам байгуулахад 800 хүний саналаар байгуулагддаггүй бол иргэн хүн бие дааж нэр дэвшихэд бас 800 хүний саналаар гэдэг. Тэгэхээр намуудад тодорхой хэмжээний бодлогоо нэгтгэж, зангидаж явуулах боломж бололцоог хуулиуд дээр оруулж байгаа нь маш зөв зүйтэй. Нөгөө талаасаа тэр иргэн хүний боломж бололцоо тэр сонгогдох эрх чөлөөг нь хангах чиглэлд ер нь цаашид энэ хуулиудад ямарваа нэгэн тийм ажлын хэсэг дээр хэлэлцэж ярилцсан, энэ чиглэлд ямарваа нэгэн бодлогын өөрчлөлт байх тийм шаардлага болоод тийм санал санаачилгууд гарсан уу. Энэ дээр та нэг тайлбар өгөөч.

Ер нь цааш цаашидаа Үндсэн хуульд ч гэсэн Монгол Улсын Ерөнхийлөгчид зөвхөн улс төрийн намаас нэр дэвшинэ. Аль нэг намын харьяалалтай хүн л нэр дэвшинэ. Их Хуралд суудал авсан намын гишүүн хүн нэр дэвшинэ гэдэг үзэл санаа ч гэсэн өөрөө бас бид бүгдийн хувьд цааш цаашидаа эргэж үзэх ёстой. Энэ чинь Монгол Улсын нам бус төрийн тэргүүн. Магадгүй олон мянган иргэний саналаар тэр хүн дэвидэг байж болох. Тэгэхээр үүний цаана Үндсэн хуулийн өөрийнх нь суурь үзэл санаа бас үүний цаана яваад байна гэж бодож байгаа юм. Тэгээд бие даагчтай холбоотой ажлын хэсэг дээр ямарваа нэгэн ярилцсан болоод тийм шаардлага санаачилгууд гарсан уу. Энэ дээр та нэг мэдээлэл өгөөч.

Г.Занданишатар: Дуламдоржийн Тогтохсүрэн ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Энэ хууль бол нэмэлт, өөрчлөлт байгаа. 2 хууль санаачлагч хоёулаа нэмэлт, өөрчлөлтөөр өргөн барьсан. Нэмэлт, өөрчлөлт нь бие даагчдын асуудлаар ямар нэгэн шинээр юм орж ирээгүй. Одоо мөрдөж байгаа Сонгуулийн хуулиараа бие даагчдын асуудал явж байгаа. Яг тэр зохицуулалт хэвээрээ байгаа. 801 хүний нөгөө гарын үсэг, дэмжлэг авч нэр дэвших эрхээ олж авдаг. Энэ систем нь юм нь бол хэвээрээ байгаа. Харин зүгээр тэр саналын хуудас дээр бол нөгөө намаас нэр дэвшигчдийн дараа бичигддэг тэр нь хэвээрээ байгаа. Тийм учраас бол бие даагчтай холбоотой асуудал дээр ажлын хэсэг дээр ч яригдаагүй, одоогийн мөрдөж байгаа сонгуулийнхаа хуулиар зохицуулагдсан харилцаа нь хэвээрээ байгаа.

Г.Занданишатар: Эрхэм гишүүн Чимэдийн Хүрэлбаатар асуулт асууна.

Ч.Хүрэлбаатар: Би 2 л асуулт асуух гэсэн юм аа. Ингээд 2008 оноос

хойш 4 удаа Улсын Их Хуралд нэр дэвшиж, өрсөлдөж байна. Ингэх болгонд л сонгуулийн хууль өөрчлөгддөг. Тэгээд энэ нь ингээд байнга өөрчлөгдөөд байдаг учраас их амаргүй л байдал бий болгодог л доо. Нэр дэвшиж байгаа хүмүүстээ ч тэр, өрсөлдөж байгаа хүмүүстээ ч тэр, тэгээд хамгийн гол нь саналаа өгч байгаа ард иргэдэд аягүй төвөгтэй байдал оруулдаг. Тийм учраас би сонгуулийн хуулийг маш энгийн бөгөөд ойлгомжтой байх ёстой гэж үзэж байгаа юм. Улсын Их Хурал дээр Их Хурлын сонгууль явагдсан энэ хууль бол орон нутгийн сонгуулийг явуулахад бас л яг адилхан хэрэглэгддэг байх ёстой. Тэгэхгүй бол Ерөнхийлөгчийн сонгууль нэг өөр хуулиар, орон нутгийн сонгууль нэг өөр хуулиар, Их Хурлын сонгууль өөр хуулиар. Тэгээд дүрмийн тоглоом тоглоомынх нь дүрэм нь байнга өөрчлөгдөөд байдаг учраас улс төр гэж бараг ний нуугүй хэлэхэд бол ер нь их нерв шаардсан, ихээхэн хэл ам дагуулсан ийм л зүйл болдог. Одоо энд сууж байгаа 76 гишүүн маань бүгдээрээ 1 удаа 1 хүн нь өрсөлдөхөд доор хаяхад 15 хүнтэй өрсөлддөг. Дараа нь өрсөлдөхөд дараа нь энэ хүнтэй өрсөлдөнө гээд дахиад 20 хүн цаана нь сууж байгаа. Ингээд 35 хүнээр балбуулсан улс төрч гэдэг бол эргээд л юу гэдэг юм хамаг нэр хүндээ ч байдаг ч юм уу элдэв бусаар гүтгэлэг доромжлолоор дамжиж явсаар байгаад дараа нь эргээд энэ парламент нь муу нэртэй болдог ийм л тогтолцоо Монголд үйлчлээд, энэ нь эргээд Их Хурлынхаа нэр хүндэд нөлөөлдөг. Гаргаж байгаа хуулийн нэр хүндэд нөлөөлдөг ийм зүйл болчихоод байгаа учраас би сонгуулийнхаа хуулийг Их Хурлын сонгууль явагдсан энэ дүрэм бол орон нутгийн сонгуульд яг адилхан үйлчилдэг байхаар хийж өгөх хэрэгтэй. Дээр нь улс төр рүү орж ирж нэлээд их самардаг, аль нэг олон суудал авсантай нийлж улс төрийг нэлээд тийм будилуулж явдаг бие дааж нэр дэвшдэг хүмүүсд ингээд цэг тавигдах болов уу гэж би горьдож байгаа юм. Тэгэхээр энэ асуудал дээр ямар өөрчлөлтүүд орсон бэ гэж.

Дараагийн асуудал нөгөө ухуулагчийн тухай асуудал байгаа. Томсгосон тойргоор явж байгаа бол ухуулагч хэрэггүй. Нэг намынхныг дотор нь хуваагаад, тэрний ухуулагч, энэний ухуулагч гээд явчихдаг. Тэгээд тэр нь эргээд нам дотроо зөрчилдөөн үүсгэдэг. Жижиг тойргоор явна гэж байгаа бол ухуулагч хэрэгтэй болно. Томсгосон тойргоор явж байгаа тохиолдолд бол ухуулагч хэрэггүй. Тэгэхээр ухуулагч дээр ямар байр суурьтай байгаа вэ. Хэрвээ ухуулагч орж байгаа бол жижиг тойрог руу шилжинэ гэж ойлгож явах уу. Ер нь тэгээд хамгийн их зардал бол ухуулагч дээр явагддаг юм шүү дээ. Тэгээд өөрийг нь дэмжиж байгаа олон хүнээс цөөхөн хэдэн хүнийг ухуулагч гээд авчихдаг. Энэ нь эргээд цаана нь хүндрэлүүд үүсгэдэг. Би таны ухуулагч биш учраас би таны тухай ярьж явахгүй гэдэг ч юм уу. Тийм учраас энэ ухуулагч дээр нэлээн сайн болгоомжтой хандаж явахгүй бол ер нь эргээд дараа их төвөгтэй байдал үүсгэдэг зүйлүүд шүү. 1 удаа сонгуульд орох бол гайгүй. Гэтэл 2 орно, 3 орно, 4 орно. Энэ бүгдийн цаана ингээд л асуудлууд хуримтлагдаад яваад байдгийг би энд онцгой хэлмээр байна. Тэгээд энэ дээр яг байр суурь ямар байгааг асууя.

Г.Занданшатар: Эхлээд зочин танилцъя. Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарын урилгаар “Ханжин Транс” ХХК-ийн ажилтнууд болон Америкийн Монгол судлалын Төвийн Монгол хэлний зуны эрчимжүүлсэн хөтөлбөрийн оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүд, Дамдин Цогтбаатарын нэрийн өмнөөс болон гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе.

Асуултад Дуламдоржийн Тогтохсүрэн ажлын хэсгийн ахлагч, Монгол Ардын намын бүлгийн дарга.

Д.Тогтохсүрэн: Хүрэлбаатар гишүүний нэг дэх асуудал нь бол санал байсан.

2 дахь асуултад хариулъя. 2 хууль санаачлагчид ухуулагчдын тоог оруулж ирсэн хэмжээнд нь байгаа. Нийслэлийн хэмжээнд болон аймгийн төвийн хэмжээнд ухуулагчдын тоо өмнө нь ер нь улсын хэмжээнд 200 сонгогч тутам 1 ухуулагч гэдэг ийм хэлбэрээр явж байгаа. Хууль санаачлагчид энийг ялгаварласан байна лээ. Ялгаварласан байдлаар оруулж ирсэн. Нийслэл болон аймгийн төв дээр 400 сонгогч тутамд 1, сум, багт 200 сонгогч тутамд 1 гэдгээр оруулж ирсэн байна лээ. Энэ хууль санаачлагчийн оруулж ирсэн тоо хэвээрээ явж байгаа. Ер нь бол ухуулагчийн зардал бол тодорхой хэмжээгээр тоо буурч байгаа учраас буурна гэж үзэж байгаа юм.

Ажлын хэсэг дээр ярилцаад зардлыг бууруулах нь зүйтэй гэж үзээд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй гэдэг үг байсан. Ухуулагчийн зардал, 1 ухуулагчид өгөх урамшуулал. Тэрийг ажлын хэсэг дээр ярьж байгаад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас хэтрэхгүй байна гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл 50 хувиар багасгаж өгсөн байгаа.

Сонгуулийн тойрогтой холбоотой асуудал бол энэ сонгуулийн тухай хуулийнхаа 12 дугаар зүйлд заасны дагуу сонгуулийн жилийн 2 сарын 1-ний дотор Улсын Их Хурал тогтоолоор шийдэхээр байгаа. Тийм учраас 1 сарын сүүлээр энэ асуудал жичдээ яригдах байх гэж бодож байна.

Г.Занданишатар: Чимэдийн Хүрэлбаатар гишүүнд тодруулж асууна. 1 минут.

Ч.Хүрэлбаатар: Их Хурлын сонгууль, орон нутгийн сонгуулийн явуулдаг зарчим нь нэг юм уу, өөр юм уу гэж асууж байгаа юм. Яагаад вэ гэхээр

бид нар энийгээ байн байн өөрчлөөд байхаар аягүй төвөгтэй байдалтай ороод байгаа байхгүй юу. Хэрвээ нэгэнт л энэ дээр холимог системээр явж байгаа бол орон нутаг мөн ялгаагүй холимог л байх ёстой. Тэгэхгүй бол юу гэдэг юм нөгөө мажоритарар орон нутагтаа явуулна. Улсын Их Хурал нь холимог байна гээд ингэхээр чинь өөрөө л холион бантан болж хувираад байна л даа. Тийм учраас сонгуулийн тогтолцоо нь өөрөө улс орон даяар нэг л байг. Ер нь нэг тоглоомын дүрмээр явж сурахгүй бол үндсэндээ холион бантан болоод байна шүү дээ. Тэгээд дараа нь олон төрлийн сонгуулийн системээр явсаар байгаад бүгд толгой нь эргэчихсэн. Юу нь хэрэгтэй, юу нь хэрэггүй гээд ялгахаа болиод эхэлчихлээ шүү дээ. Тийм учраас ер нь тоглоомын дүрмүүд ижил байх гэдэг ийм юм. Дараа нь тэр ухуулагч хэрэггүй гэдэг зүйл дээр ярьж байна. Энэ дээрээ бас нэг тодорхой хариулт авъя.

Г.Занданишатар: Нямаагийн Энхболд дарга хариулах уу. Нямаагийн Энхболд дарга хариулна. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга.

Н.Энхболд: Түрүүн би нэг удаа энэ асуултад бас яг хариулсан. Яг одоогийн байдлаар бол орон нутгийн сонгуулиа яаж явуулах вэ гэдэг талаар ямар нэгэн тийм зарчмын байр суурь аль нэг газраас гараагүй байна. Хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын Сонгуулийн хууль ингэж өөрчлөгдөж явах болно. Хэрэв Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орчихвол гэж ярьж явахад бол лав миний явсан газарт дийлэнх олонх нь орон нутгийн сонгуулийг холимог явуулж болохгүй шүү. Түрүүчийн удаа ингэж явуулсан. Энэ нь өөрөө ёстой нөгөө хаалгаар гарсан тооноор орж ирдэг хамгийн сонгодог жишээнүүд энд гарсан шүү гээд тодорхой жишээнүүдтэй ярьж байсан. Тэгэхээр цаашидаа бид нарын үргэлжлүүлээд явах яригдах асуудал гэж хүлээгдэж байгаа гэж ойлгож болно. Ёыр нь нэг жигдлээд авчихвал сонгуулийн хууль.../минут дуусав/

Г.Занданишатар: Нямаагийн Энхболд гишүүн гүйцээж хариулъя.

Н.Энхболд: Ер нь сонгуулийг бол тогтвортой үйлчилдэг байх хэрэгтэй гэсэнтэй бол санал нэг байна аа. Бид нар уг нь бас түүхээрээ үзсэн шүү дээ. Бүх сонгуулиа явуулдаг нэг хуультай болж үзсэн. Болохгүй байна гээд дахиад эргээд задалсан. Яагаад болохгүй байна гэхээр тэр сонгуулийн үр дүнд бий болж байгаа нутгийн өөрөө удирдах байгууллага буюу хурал, Монгол Улсын Их Хурал 2-ын хийдэг ажил, шийддэг асуудлууд хоорондоо бас их өөр өөр юм. Тэгэхээр энд тохирсон хуулиуд байхгүй болохгүй юм байна гээд салгачихсан дахиад. Тэгэхээр энийг Үндсэн хуулийн өөрчлөлт орсонтой холбогдуулан нэг мөсөн нэг талдаа шийдээд, бүр болохгүй бол ёстой тодорхой хугацаанд огт өөрчлөхгүй мөрдөх ёстой гэдэг баталгаа юмнуудыг нь хийж аваад явах нь би зөв болов уу л гэж бодож байгаа.

Г.Занданишатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Ж.Бат-Эрдэнэ: Бид нар сая Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулсан. Хоёронтой ард иргэдтэйгээ уулзаж, орон нутагтайгаа уулзаж, орон нутгийнхантайгаа уулзчихаад ирсэн. Тэндээс тавьж байгаа олон саналуудын нэг нь бол ерөөсөө сонгуулийн хуульд сонгуулийн зардлыг бууруулах асуудал байлаа шүү дээ. Нэг талаасаа.

Нөгөө талаасаа бид нар Үндсэн хууль ярьж байхдаа юу ярьж явсан гэхээр ерөөсөө энэ нийгмийн өнөөдрийн хүртэл 30 жилийн хугацаанд алдсан алдаа оноогоо л алдаагаа засъя л гэсэн шүү дээ. Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулъя гэсэн. Энийг дагаад 2 хууль байгаа гэсэн. Тэрний хамгийн гол хууль нь Сонгуулийн тухай хууль. Мөнгөний хамаарлаас гаръя. Мөнгөтэй, төгрөгтэй, эрх мэдэл бүхий хүмүүс орж байж бусниулдаг, будилуулдаг. Тэгээд энэ саарал байшин дотор чинь нөгөө муухай

76 айхтар хүмүүс гэдэг нэрээ ус автлаа ингээд явж байгаагийн гол уур уурхай чинь ерөөсөө энэ мөнгөтэй холбоотой асуудлуудыг болиулъя гэсэн шүү дээ. Тэгээд орж ирж байгаа хуулийн төслийг харахад үнэхээр сэтгэл гонсгор байна. Ард түмэн дээр очиж ярьж ярьж байсан, үнэхээр амлалт аваад ингээд хүрч байсан. Үнэхээр сайхан өөрчлөлтүүдийг хийнэ гэж ярьж ярьж явчхаад. Тэгээд одоо орж ирж байгаа царай нь ерөөсөө энэ байна шүү дээ. Яах вэ тэр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 хувиар бууруулж байгаа юм байна. Тэгээд самбар хэдэн самбараа яах вэ цөөлж л байгаа юм шиг байна. Үгүй, тэгээд өөр юу гарч ирж байгаа юм бэ энд. Энд ухуулагч нарыг 1 дүгээрт сайн дурын байна гэж байгаа юм. Тэгсэн мөртөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулна гээд явчхаж байгаа юм. 50 хувиар. Тэглээ гээд ер нь бол ухуулагч гэдэг үг чинь бас яг зохистой юм уу, үгүй юм уу. Сурталчлах эд нар гэх тийм юм байх ёстой юм уу. Дээр үеийн агитатаар ухуулдаг, тархи угаагч гэсэн утгаар л энэ чинь л үндсэндээ яваад байна шүү дээ. Үг нь ч зөв ч юм уу, буруу ч юм уу.

2 дугаарт энэ 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага улсын хэмжээнд гээд 100 хүртэл, нийслэл 20 хүртэл гэснийг 500 хүртэл, аймаг, нийслэлд 100 хүртэл гээд 5, 5 үржүүлээд ихэсгээд тавьчихдаг нь ямар учиртай юм. Энэ чинь тодорхой хэмжээний намаас гарч байгаа зардлууд биш юм уу. Зардал нэмэгдэх биш үү.

2 дугаарт бид ер нь задалъя гээд байгаа шүү дээ. Нэг нам дангаараа ноёлдог, дангаараа сонгуульд ялдаг ийм байдлаас гаръя. Олон намын тогтолцоо руу оръё. Нэр дэвшиж орж ирэх бие даагчдыг бас орж ирэх бололцоог нь хангая гээд байгаа. Тэгээд бид нар сонгууль эрхэлсэн байгууллагынхаа хүчин чадлыг нэмэгдүүлээд байдаг. Тэгвэл бие даагч чинь яаж өрсөлдөх юм. Энэ их

зардлаар энэ их олон хүн ажиллуулж байгаа энэ том намтай яаж өрсөлдөх юм. Үгүй, хэдүүлээ юунаас нь айдаг юм бэ энэ чинь жоохон юмнуудыг задлаад задлаад энгийн болгоё л доо энэ чинь. Өөрсдөө ялагдчихна гэдэг юм уу. Эндээс бид нар энэ нам чинь Монгол Ардын нам жишээ нь яг өнөөдөр засаглаж байгаа энэ нөхцөл байдалтай намынхаа эрх ашгийг арагшаа тавья гэж хэдүүлээ ярьсан шүү дээ. Тэгээд улсын эрх ашгаа урд нь тавья, хөгжлөө хурдан тавья гэж ярьсан шүү дээ хэдүүлээ. Тэгээд энэ хуульд чинь жишээ нь сонгууль эрхэлсэн байгууллагынхаа тоог 5 дахин үржүүлээд 100 байсныг 500 болгоод ороод ирдэг нь ямар учиртай юм. Яагаад улам хүчин чадлаа нэмэгдүүлээд байгаа юм. Үгүй, тэгээд дөнгөж хэдхэн хоногийн өмнө орон нутаг дээр очиж ярьсан зүйлийнхээ эсрэг хийх гээд, кнопдох гээд суугаад байна шүү дээ. Жишээ нь мэдэхгүй. Энэ санал асуулгад бол би оролцоогүй байна нээрээ. Өөрчлөх нь зөв. Сонгуулийн тухай хуулийг задлах нь зөв. Гэхдээ энэ дотор чинь мэдэхгүй аятайхан зүйл заалт сэтгэлд таарсан зүйл заалт орж ирсэн харагдахгүй л байгаад байх юм. Энэ 2 асуултыг асуучихъя.

Г.Занданишатар: Дуламдоржийн Тогтохсүрэн дарга асуултад хариулна.

Д.Тогтохсүрэн: Бат-Эрдэнэ гишүүн ээ, энэ сонгуулийн хууль. Сонгуулийн хууль гэдэг бол сонгууль зохион байгуулах журам гэсэн үг. Сонгуулийг ямар хэлбэрээр зохион байгуулах вэ, ямар бүрэлдэхүүн байх вэ, ямар боломж олгох вэ, нам, бие даагч нарт, нэр дэвшигч нарт гээд. Энэ харилцааг л зохицуулж байгаа асуудал. Тэрнээс нийгмийн бүх харилцааг ганцхан сонгуулийн хуулиар зохицуулаад бүх юм өргөс авсан юм шиг сайхан болчихно гэж ойлгож болохгүй ээ. Нам болон сонгууль эрхэлсэн байгууллагын хүмүүсийн тоог нэмэгдүүлсэн. Энэ яагаад нэмэгдүүлсэн юм гэхээр 48 хүнийг нам нь сурталчилна гээд бид нар хуульд оруулчхаж байгаа юм. 48 хүнийг сурталчилна. Хэвлэмэл

материал гаргана, цахим болон телевиз, радиогоор сурталчилна. Тэр ажлыг зөвхөн нам хийнэ гэж байгаа юм. Тийм учраас намын эрхэлсэн сонгуулийн байгууллагын ажилтнуудыг зөвхөн улсын хэмжээнд тоог нь нэмэгдүүлсэн байгаа. Зөвхөн улсын хэмжээнд. Сонгуулийн зардал тодорхой хэмжээгээр буурч байгаа. Бат-Эрдэнэ гишүүн ээ, хэвлэх зардал 2 дахин буурсан байгаа. Нөгөө хэвлэдэг тараадаг материал 2 дахин буурсан байгаа. Ухуулагч нарын тоо 40 орчим хувиар буурч байгаа. 1 ухуулагчид өгдөг урамиууллын хэмжээ 2 дахин буурч байгаа. Самбар нэлээд хөрөнгө зардаг байсан. Самбар байхгүй болж байгаа. Ингээд бид нарын тооцоогоор 42-45 хувиар өмнөх сонгуульд зарцуулж байсан зардал 42-45 хувиар буурах нь гэж ингэж үзэж байгаа юм. Бие даагч бол яг хууль дээр байгаа. Энэ хууль чинь нэмэлт өөрчлөлт байхгүй юу. Сонгуулийн хууль дээр бие даагч байж байгаа. Тэр хуучин явдаг зарчмаараа 801 хүнийхээ дэмжлэгийг аваад л явдгаараа явна. Нэр дэвшээд ингээд явдаг нь бол хэвээрээ байж байгаа.

Г.Занданишатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя. Асуулт, хариултын дараа санал хураалттай. Гишүүд чуулганы танхимд цуглана. Асуулт хариултын цаг үүгээр дуусаж байгаа. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн 1 минут.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг ахалсны хувьд нэг их айхтар хичээл заагаад яах вэ Тоогийн дарга аа. 2 дугаарт түрүүнээс хойш олон гишүүд асуулаа. Яг саяын тоо тоогоор тэдэн хувь тэдэн хувийг ингэж өөрчилнө, ингэж бууруулна гэснийгээ та хариулаагүй байхгүй юу. Одоо хариулж байна.

2 дугаарт яг ямар ямар заалтаар гэдэг юм чинь энэ дотор ерөөсөө харагдахгүй байгаад байгаа байхгүй юу даа. Мэдэхгүй би олж харахгүй байна. Энэ ерөөсөө бүтэн хуудас хуудас юмнууд

л орж ирчхээд байна шүү дээ. Тэрийг тэдийг, тэдийг гээд ганцхан, ганцхан үг үсгээр, нэг тоогоор засчихсан болохоор энэ дотор чинь олж харж үнэхээр чадахгүй байгаад байна. 2 хуудас үргэлжилсэн үргэлжилсэн үгийн юмнууд орчхоод байна шүү дээ. Өөрчлөлтүүд чинь зөвхөн тооны өөрчлөлтүүд орж ирчхээд байна. Түрүүнээс хойш 5, 6 гишүүн асуусан. Энэ асуултад сая л та үнэхээр яг тэдэн хувиар, тэдэн хувиар бууруулна гэдэг юмнууд чинь орж ирж байгаа байхгүй юу даа. Яах вэ хэдэн доошоо бууруулж байгаа юмнууд орж ирж л байгаа юм байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Хариулах уу. Нэг зүйл зарлан мэдээлье.

Эхлээд Зочид танилцуулаадахъя. Улсын Их Хурлын гишүүн Энхтайвангийн Бат-Амгалангийн урилгаар Нийслэлийн Баянзүрх дүүргийн 22 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе.

Улсын хэмжээнд жил бүр зохион байгуулдаг стратеги, команд штабын дадлага, сургуулийн зарлан мэдээллийн дуут дохио өнөөдөр буюу 2023 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 16 цагт орон даяар дуугарна. Зарлан мэдээллийн дохио дуугарах үед Төрийн ордонд үйл ажиллагаа явуулдаг байгууллагын албан хаагчид Сүхбаатарын талбайн зүүн хойд хэсэгт байрлаж, түр цугларах цэгт аюулгүй байдлыг хангаж оролцож, холбогдох байгууллагын мэдээлэл, заавартай танилцана уу.

Нэг.Эхний дохио дуугарахад газар хөдлөлтийн чичирхийлэл мэдрэгдэх үе гэж бодон барилгын даацын хана, бат бөх ширээ доогуур орж, өөрийн аюулгүй байдлыг ханган түр хүлээх.

Хоёр.2 дахь дохио дуугармагц газар хөдлөлтийн чичирхийлэл мэдрэгдэхээ

болих үе гэж бодон баруун гарын дүрэм баримтлан аюулгүйн талбай руу гарна.

Гурав.3 дахь дохио дуугарахад барилга байгууламжаас хүн үлдсэн эсэх талаар мэдэх аюулгүй байдал хариуцсан ажилтан бүртгүүлэх шаардлагатай.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо чинь аюулгүйн дохио дуугарах юм байна. Гишүүд цуглаж байх хооронд нэг зүйл онцольё. 16 цаг болох гээд байна. Асуултад хариулах юм уу. Нямаагийн Энхболд гишүүн 1 минут.

Н.Энхболд: Тэр сая Бат-Эрдэнэ гишүүний асуусан шиг энийг чинь 50 байсныг нь 500 болгоод нэмчихлээ энэ тэр гэсэн асуултууд гарч байна л даа. Тэгэхээр энийг бас нөгөө тойргоос хасагдаж байгаа ухуулагч нарын тоотой харьцуулж үзэх хэрэгтэй юм байгаа юм. Маш олон тойргууд 2 мянга хэд билээ хэсгүүд дээр 2100 орчим хэсгүүд байж байгаа. Тэр дээр дэвшсэн хүмүүст ноогддог ухуулагчдын тоог нь бууруулна. Зардлыг нь бууруулна. Наад саяын хэлэлцсэн тэр 500 боллоо энэ тэр гээд нэмэгдчихсэн гэдэг бол тэр чинь хүн болгоны тоогоор нэмэгдэж байгаа ухуулагч биш шүү дээ. Намын мөрийн хөтөлбөрийг бүхэлд нь тодорхой нутаг дэвсгэрт хариуцаад явах хүмүүсийн л тоо. Тэгэхээр энэ 2-ыг ингээд яг эцсийн дүнгээр нь харьцуулаад үзвэл бас ингээд хэлэлцүүлгийн явцад Сонгуулийн ерөнхий хорооноос санал авч байхад ухуулагчдын тоо бол 40-50 хувь буурах учиртай гэсэн ийм тооцоо гарч байгааг бас танилцуулж байсан. Тэгэхээр нэг газар нэмэгдсэн нь зөвхөн.../минут дуусав/

Г.Занданишатар: Гишүүд олон санал хэллээ. Асуулт асууж, хариулт авч дууслаа. Тэгээд ер нь ажлын хэсэг, Төрийн байгуулалтын байнгын хороо сая Улсын Их Хурлын гишүүдийн хэлсэн санал, асуулттай холбогдуулж хэд хэдэн санааг анхаарах хэрэгтэй байна. Сая ард иргэдээс ч тэр, иргэд олон нийтээс ч гэсэн олон санал, хүсэлтүүд Үндсэн

хуулийн өөрчлөлт батлагдсантай холбогдуулаад ирсэн. Үндсэн хуулийн өөрчлөлт бол төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх, төр ард түмний итгэлцлийг сайжруулах, төр, бизнесийн харилцааны тэнцвэр харилцааг зохистой болгох, эцсийн дүндээ төрийн легитим чанар төрт ёсныхоо багана суурийг батжуулахад чиглэгдсэн. Бас үндэсний аюулгүй байдлыг хангаж, хүний эрхийг дээдлэх зарчимд ч нийцүүлэхийг чармайсан. Гэхдээ энэ бүх Үндсэн хуулийн өөрчлөлт маань эцсийн эцэст Улс төрийн намын тухай хууль, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар бодит ажил хэрэг болно. Цогц өөрчлөлт болж байж амьдралд хэрэгжинэ. Ирэх сонгуулиас эхлээд энэ Үндсэн хуулийн өөрчлөлт маань бодит үр дүнгээ өгч эхлэх ёстой. Мэдээж аливаа шинэчлэлт, өөрчлөлт, боломж, эрсдэл 2-ыг хоёуланг нь дагуулдаг. Сорилт бэрхшээл ч бий болно. Ийм учраас нарийн сайн анхаарч Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшилтэд анхаарах шаардлага, шалгуурыг өндөрсгөх гээд маш олон зүйлийг иргэд хэлж байна.

Тэгээд сая гишүүд бас ярилаа. Нам наймааны хэрэгсэл болж болохгүй. Улс төрийн намууд зарагдаад эхэлчихсэн байна гэсэн асуудлыг манай Дашидондогийн Ганбат гишүүдээс авхуулаад хөндөж ярьж байна. Тэгэхээр англи хэлний *devil is in the details* буюу чөтгөр детальд нуугддаг гэдэг нэг үг байдаг. Энэ бол аливаа ажлын деталиудад хамгийн их эрсдэл нуугддаг гэсэн санаа. Тэгээд энийгээ нөгөө Үндсэн хуулийн өөрчлөлт бол том стратегийн өөрчлөлт, тогтолцооны өөрчлөлт хийж байгаа боловч яг органик процессын хуулиуд дээрээ маш сайн анхаарч шигтгэж байж энэ Үндсэн хуулийн өөрчлөлт маань бодитой хэрэгжинэ. Тэгээд эрсдэл бэрхшээлийг бага байлгахад энийг чиглүүлэхийн тулд Сонгуулийн хуулиа маш сайн анхаарах хэрэгтэй. Ер нь монголчууд бид ер нь аливаа асуудлын жижиг детальд хайнга ханддаг. Том тогтолцооны өөрчлөлтийг

ярьдаг. Тэгээд сүүлдээ хүндээ биш тогтолцоондоо гэж ярьдаг. Тогтолцоо болохгүй болоод ирэхээр хүндээ байна гэдэг. Хуучин хүмүүс гэж яриад байгаа. Түүрүүн ч гэсэн зарим гишүүд муу нэртэй, луу данстай хуучин хүмүүсийг яаж дэвшүүлэхгүй байх вэ гээд ярьж байгаа. Ер нь тэгээд Нилсон Мандела хүртэл шоронд хоригдож байсан. Муу нэртэй, луу данстай л байсан хүн. Тэгээд энэ бүхэн маань эцсийн эцэст Улсын Их Хурлын гишүүдээр сайн шаардлага шалгуурыг өндөрсгөөрэй. Ахмадуудаас ахмад улс төрчдөөс зөвлөгөө ирүүлж Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд иргэдийн ашиг сонирхолд нийцүүлж, нэр дэвшилтэдээ дараах шалгууруудыг хангахыг анхааруулсныг би та бүхэнд бас хэлье. Юуны өмнө бол өмнө нь юу ярьж хийж явсан хүн бэ гэдэг маш чухал аа. Олон улсад ч гэсэн тийм байдаг юм байна. Өөрийгөө удаан хугацаанд шалгуулж шалгарсан, мэдүүлсэн хүн байх ёстой. Ард түмнийхээ дунд амьдарч хийсэн, хэлсэн нь ил байж танигдсан хүн байх ёстой. Хаана ч хэлсэн бай хэлсэн үгийнхээ төлөө хариуцлага хүлээдэг хүн байх ёстойн. Ёс суртахууны өндөр төлөвшилтэй, ямар ч тохиолдолд авлига, албан тушаалын гэмт хэрэггүй хийхгүй хүн байх ёстой. Ард иргэдийнхээ амьдрал нийгмийн байдлыг сайн ойлгож, илүү сайжруулах ёстой гэдгийг ухамсарласан хүн байх ёстой. Дарга болохыг эрмэлзсэн биш ард түмнээ төлөөлж тэмцэгч байхыг хүсэл зорилгоо илэрхийлсэн хүн байх ёстой. Өөрийнхөө хүсэл бодлыг ард түмнийх мэтээр ойлгож яваа хүн төрд ард түмнийг төлөөлөх эрхгүй ээ. Би би гэдэг үзэлтэй хүн бол болохгүй ээ. Бид гэж ярьдаг ард түмнээ төлөөлдөг хүн байх хэрэгтэй. Цогц мэдлэгтэй асуудлыг бүхлээр нь харж шийдэх чадвартай хүн байх ёстой. Иргэдтэйгээ байнга холбоотой байж тэдний юу хүсэж байгааг мэдэрдэг, түүнийгээ төрийн бодлогод тусгуулдаг ийм хүн байх ёстой. Ард түмний төлөөлөгч бол. Ард түмний амьдралыг мэддэг, төрд ажилласан туршилагатай, салбар салбартаа ажиллаж үзсэн хүн байвал зохимжтой.

Ийм учраас иргэд сонгогчдын улс төрийн мэдлэг боловсрол ч гэсэн их чухал. Энэ бүхнийг сайн харгалзан үзэж Улс төрийн сонгуулийн тухай хуульдаа тусгах хэрэгтэй. Энэ шалгуур, шаардлага тотго босгыг өндөрсгөж байж төрийн босго, парламентын босго сайжирч, парламентын нэр хүнд сайжирна. Үүнийгээ л энэ Улс төрийн намын тухай хууль, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульдаа онцгой анхаарч хийгээрэй. Шинэ зууныг 126 гараад бүхнийг сайн болгоно гэдэг энэ зорилгоо бодитой болгохын тулд энэ бүх ажлыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Энэ бүхэн маань дараа нь хэлэлцэх тэр Улс төрийн намын тухай хуультай сашиггүй холбоотой. Эх нь булингартай бол адаг нь булингартай гэдэг. Ерөөсөө нэр дэвшүүлдэг улс төрийн тогтолцооны шинэчлэлийн ардчиллын суурь институц нь бол улс төрийн нам. Улс төрийн намгүй ардчилал гэж дэлхийд байхгүй. Улс төрийн намгүй Үндсэн хуулийн институц гэж байхгүй. Ийм учраас энэ улс төрийн намын шинэчлэл маань дотоод ардчилалтай байх, санхүүжилт нь ил тод байх гээд зарчмуудыг 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тусгасан. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн өөрчлөлт маань Улсын Их Хурлын Сонгуулийн хууль, Улс төрийн намын тухай хуулиар нэгд зохицуулж шинэчлэгдэх ёстой. Одоо намын жагсаалт зарагдаж байна гээд л, нам намууд зарагдаж байна гээд наймааны хэрэгсэл боллоо гэсэн шүүмжлэл явж байна. Энийг л энэ Улс төрийн намын тухай хуулиар бид Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар хааж байгаа гэдгээ яриад, бид зарлан тунхаглаж энийг бодитой хэрэгжүүлэх хэрэгтэй. Тэр мөнгөтэй хүн жагсаалтад ордог гэдэг биш. Ер нь тэр шаардлага шалгууруудыг хангасан, мэдлэг туршлагатай, улс орныхоо төлөө ажиллах чинхүү хүсэл эрмэлзэлтэй. Ингэж байж Үндсэн хуулийн өөрчлөлт маань бодитой, амьдралд хэрэгжиж, төр ард түмний итгэлцэл бэхжиж, парламентад бас төлөвшинө. Энэ л

зарчмуудыг Улсын Их Хурлын сонгууль, Улс төрийн намын тухай хуульд бас суулгахад анхаараарай гэж хэлсэн. Энийг Улсын Их Хурлын олон гишүүд өнөөдөр асуулт, хариулт, санал бодолдоо илэрхийллээ. Энийг бол Улсын Их Хурал ийм зарчим баримталж байгаа гэдгийг бас Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль хэлэлцэж байхдаа бид цохон тэмдэглэж байна.

Ингээд санал хураалтад орох ирц бүрдсэн бол санал хураалтдаа орёе. Ийм учраас санал хураалтууд дээр яг л ийм зарчмаа баримталж, өөрчлөлтүүдийг хийж хэрэгжүүлж, зарчмаа гаргана. Сонгуулийн тухай хуулиа батална.

Санал хураалтын томъёолол тараагдсан уу. Яах вэ энэ бас зарим гишүүд материал энэ тэр тараагдсан уу. Тэр янз бүрийн байх шиг байна. Үндсэндээ Улсын Их Хурлын Тамгын газар бол асар их ачаалалтай өдөржин, шөнөжин сууж Төрийн байгуулалтын байнгын хороо саналын томъёоллыг эцэслэж олон дахин өөрчлөгдөөд 2 том төслийг нэгтгэнэ гэдэг чинь Улс төрийн намын тухай хуулийн, Улсын Их Хурлын сонгуулийн 2 хууль 2 намаас өргөн баригдсан. Үгүй ээ, ажлын хэсгүүдээс өргөн баригдсан. Энийг нийлүүлэн нэгтгэнэ, зөрчил хийдлийг арилгана гээд асар том ажил дээр Тамгын газрын ажилтнууд, Төрийн байгуулалтын байнгын хорооныхон өдөр, шөнөгүй сууж байгаа шүү дээ. Тийм учраас энийг бол бас.

Саналын томъёолол тараагдсан уу. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Тайван амгалан байцгаа. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиа ажил хэрэгчээр хэлэлцэж баталцгаая. Аль аль нь анхаарч. Ингээд Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын

томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 62 санал байгаа.

**Нэг.Төрийн байгуулалтын
байнгын хорооны дэмжсэн санал.**

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хасах:

“1/4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг:

4.3.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 126 гишүүнийг дараах байдлаар сонгоно:

4.3.1.Улсын Их Хурлын 78 гишүүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос олныг төлөөлөх /мажоритар/ аргаар;

Тайлбар: “олныг төлөөлөх /мажоритар/ арга” гэж тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү бөгөөд хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцохыг ойлгоно.

4.3.2.Улсын Их Хурлын 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорционал/ аргаар.”

Тайлбар: “хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорционал/ арга” гэж сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн авсан саналынх нь тоо, хувьд үндэслэн энэ хуульд заасны дагуу суудал хуваарилж, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцохыг ойлгоно.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн, Энхтайвангийн Бат-Амгалан, Баагаагийн Баттөмөр, Наянтайн Ганибал, Тогмидын Доржханд, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Салдангийн Одонтуяа, Бөхчулууны Пүрэвдорж, Даваажанцаны Сарангэрэл, Цэвэгдоржийн Туваан,

Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Баттөмөрийн Энхбаяр цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт явуулъя. Сандагийн Бямбацогт, Жамъянхорлоогийн Сүхбаатар нарын гишүүдээр үг тасаллаа.

Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлнэ.

С.Бямбацогт: Энэ санал хураалт дээр бас санал байгаа юм. Сая Их Хурлын дарга хэллээ. Үнэхээр Их Хурлын гишүүн, төрийн түшээ, ард түмнийг төлөөлөх эрх бүхий хүн ямар байх ёстой вэ ямар шалгуур, шаардлага хангасан байх ёстой вэ гэдэг тал дээр маш тодорхой Их Хурлын дарга үг хэлсэн. Яг л ийм л хүн байх ёстой. Хууль зөрчдөггүй, хулгай хийдэггүй, хийсэн ажилтай, хэлэх үгтэй, өөрийнхөө төлөө бус өрөөл бусдын төлөө ажилладаг, үнэхээр юу гэдэг юм тэ төр, ард түмнийхээ төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэж чадна гэгчихсэн, биеэ засчихсан, гэрээ засчихсан, төрөө засалцах хоёргүй сэтгэлтэй ийм л хүн байх ёстой. Их Хурлын гишүүн гэдэг албан тушаалыг эрх мэдлийг хувийнхаа ашиг сонирхлын төлөө ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх гэж зорилго тавьдаг ингэж орж ирдэг иймэрхүү хүмүүс энд Монгол төрийн босгоор дахиж битгий алхаасай. Ийм хүмүүс алхдаг байсан учраас өнөөдөр Монгол төрийн нэр хүнд унасан. Ингэж орж ирчхээд ингэж ажилладаг учраас Их Хурлын гишүүн болох гэж хүн болгон дурладаг болсон. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт 126 болж байгаа үүний цаад талд бол үндсэндээ бол Их Хурлын гишүүдийн эрх мэдэл бол буурч байгаа, хумигдаж байгаа. Цаашидаа Их Хурлын гишүүн болохыг дурладаг, сонирхдог хүн цөөхөн болно. Үнэхээр төр, ард түмнийхээ төлөө хоёргүй сэтгэл зүтгэж чадна гэсэн ийм хүмүүс л орж ирдэг болно. Энэ ч үүднээсээ 76, 78 гишүүн бол тойргоос ард түмэнд нүүрээ улайлгаад, нүдээ бүлтийлгээд амлалтаа аваад, хийсэн ажлаа тайлагнаад, хийх, хэрэгжүүлэх ажлаа зорилго зорилтоо танилцуулаад мөрийн хөтөлбөр

дэвшүүлээд, дэвшээд сонгогдох байх. Энэ бол хуучин тэгж явдаг байсан. Энүүгээрээ явчихна. Ард түмэн өөрөөр хэлэх юм бол эмхэрч үзэж байгаад л сонгоно. Миний хувьд ч гэсэн бас жагсаалтаар дэвшихгүй. Тойргоосоо нэр дэвшинэ. Ард түмнээрээ дүнгээ тавиулна гэж бодож байгаа. Гэхдээ энэ 48 гишүүн хувь тэнцүүлэх пропорциональ аргаар сонгогдож байгаа. Энийг зүгээр ингээд юу гэдэг юм. Намын жагсаалт дугуйлаад намын жагсаалт нь ард талд нь нэрийг цагаан толгойн дарааллаар гэх юм уу эс үгүй бол юу гэх юм. Намаас Бага хурлаас жагсаасан жагсаалтаар гэх юм уу. Ямархуу байдлаар дэвшүүлэх гээд байгаа юм. Ийм байдлаар юу гэдэг юм карманы хүмүүсийг дэвшүүлдэг хаалгаар биш, тооноор орж ирдэг, мөнгөтэй нь орж ирдэг, дарга нарыг дагаж гүйдэг нь орж ирдэг ийм жагсаалт байх ёсгүй. Тийм болохоор энэ дээр тодорхой хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох энийгээ тодорхой болгож өгье. 48-ыг сонгохдоо тэр гишүүдийнхээ нэрийг дугуйлъя давхар. Жагсаалтад орж болно. Намын жагсаалтад орох дээрээ ард түмнээр нэрээ дугуйлуулаад олон санал авсан хүн нь Их Хурлын гишүүн тэр намын авсан квот дотор багтдаг, цөөн санал авсан хүмүүс нь үлддэг ийм шударга зарчим байх ёстой. Ийм шударга. Тийм болохоор энийг энд томъёолж яагаад оруулж болохгүй байна вэ. Энийг оруулаач. Ийм л баймаар байна. Нэгэнтээ л шударга ёс тогтоох гэж байгаа бол нэгэнтээ асуудлыг хуулиа ард түмнийг төлөөлөх бүрэн эрхээ хангуулах гэж байгаа ийм боломжийг бий болгож өгье. Энийг оруулж өгөөч оруулах ёстой гэсэн ийм саналтай байна.

Г.Занданишатар:

Жамгянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Энэ сонгуулийн хууль бас их тийм сонирхлын зөрчилтэй хууль гэж тооцогддог хууль. Ялангуяа энд сууж байгаа Их Хурлын гишүүд өөрсдийгөө сонгох дүрмээ шийддэг. Бас дээр нь сонгуульд оролцох бусад нам

эвслүүд бусад нэр дэвшихээр горилж байгаа хүмүүсийн асуудлыг хөнддөг эрх ашгийг нь, дээр нь бүр том утгаараа хэлбэл Монгол Улсын нийт иргэдийн эрх ашиг, сонгогчдын эрх ашгийг хөнддөг ийм хууль. Тийм учраас олон янзын үзэл бодол гарна. Намын бүлгийн ашиг сонирхол зарчим гэж байвал байна. Гэхдээ Их Хурлын гишүүний ашиг сонирхол зарчим гэж бас байна. Иргэдийн ашиг сонирхол зарчим гэж байна. Энэ болгон ил тод яригдана. Хуулиар нийгмийн бүлгүүдийн асуудал хөндөгдөж байна. Төлөөллийн асуудлууд хөндөгдөж байна. Тэгэхээр ардчилсан нийгэмд бол сонирхлын зөрчлийг үгүйсгэдэггүй байхгүй юу. Сонирхлын зөрчлийг ил тод байлгаж зохицуулах арга механизм байгаадаа л ардчилал оршин тогтнодог. Ярилцъя, хэлэлцье гэсэн утгатай энэ талбар бол парламент. Парле гэдэг чинь бол ярилцах хэлэлцэх гэсэн Франц үг шүү дээ. Үгийн утга. Тэгэхээр сонгуулийн хууль ярьж байна гэдэг бол засгийн бүх эрх ард түмний мэдэлд байхтай холбоотой асуудлыг ярьж байгаа учраас олон янзын санал гарна. Намын бодлого гэж байна. Гишүүний өөрийнх нь бодол гэж байна. Иргэний байр суурь гэж байна. Энэ талаасаа бид ярилцах байх. Ярилцах ч ёстой юм. Ер нь их олон заалтууд бас байна. Найруулгын талаас анхаараад хуучин бол сонгуулийн хууль дээр чинь бол маш их удаан, нэлээн нухацтай ярьж байсан шүү дээ. Энэ чинь өөрөө олон сонирхол мөргөлдөнө. Тэгэхээр хэн нэгэн хүн тийм архад юм уу, янз бүрийн юм яриад байх шаардлагагүй. Аяндаа л өөрсдөө олонхоороо саналаа өгөөд л явчихна. Тэгээд л тэр нь төрийн бодлого.

Би энд нэг юм хэлэх гэж байгаа юм нь Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль гэж 12 жилийн өмнө гарсан. Энэ хууль дээр Монголын төрийн бодлого гэж гарсан. Үе үеийн Ерөнхий сайд нар Жендерийн үндэсний хорооны дарга болсон. 2021 оны 3 сарын 25-нд 77 дугаар захирамжаар Бодлогын зөвлөлийг байгуулсан юм байна лээ. Энэ зөвлөлд нь Их Хурлын эмэгтэй гишүүд, Ерөнхийлөгч, Засгийн газрын эмэгтэй гишүүд, Их

Хурлын дарга, Ерөнхий сайдын зөвлөхүүд гээд эд нарын хажууд Ерөнхий сайд, Ерөнхийлөгчийн хажууд ажилладаг зөвлөхүүдээс гадна Улсын Их Хуралд суудалтай намуудын төлөөлөл орчихсон ийм байдаг юм байна.

Сая 9 сарын 16-нд өнгөрсөн оны 16-нд зөвлөлийн анхдугаар хуралдааныг Монгол Улсын сайд, Хэрэг эрхлэх газрын дарга Амарбаясгалан тэргүүлэн оролцоод хуралдаанаараа энэ сонгуулийн хууль дахь квотын асуудал, намын тухай хуулийн үзэл баримтлал, дотоод ардчилал, жендерийн асуудал, санхүүжилт гээд энэ болгон дээр дэмжлэг үзүүлэх ийм лобби бүлэг байгуулах талаар энэ хуралдаанд яригдсан юм байна. Ингээд энэ хуралдаанд оролцсон гишүүд дэмжиж байгаад намайг байх нь зүйтэй юм байна. 13 жилийн өмнө энэ асуудал ярьж байсан хүн байна гээд ингээд яах вэ их ажилтай ч гэсэн энэ ажлыг итгээд надад энэ ажлыг итгээд санал болгосон байна. Ингээд манай улс бол жендерийн эрх тэгш байдлын үзүүлэлтээр одоо явж байгаа юмаар дэлхийд бол хойгуур жагсаж байгаа юм байна. 145 орноос 70 дугаарт жендерийн ялгаатай байдлаар, эрх мэдэл үзүүлэлтээрээ 113 дугаарт орж байна. Азидаа бид нар Монгол улс 17,1 хувьтай байгаа нь гэж байна. Азидаа хүртэл бүс нутагтаа бол доогуур орж байна. Тэгэхээр юу хэлэх гэж байгаа юм гэхээр бүлэг байгуулж байгаагаа бол мэдэгдээд эмэгтэй гишүүд орж байна. Зарим эрэгтэй гишүүд орж байгаа. Занданшатар дарга мэдээж сонсох байх. Ийм бүлэг байгуулж байгаа юм байна. Урьд нь бол Мөнхбат гишүүн ахалж байсан юм байна. Тэгээд энийг та бүхэндээ бас мэдэгдье ээ. Тэгээд Сонгуулийн хууль гэдэг бол хэдэн Их Хурлын гишүүд тойрсон, тулга тойрсон асуудал эсвэл 2, 3 намын хувийн асуудал бол биш. Монголын ард түмний ашиг сонирхлыг илэрхийлж байгаа. Тэр дундаа жендерийн асуудал бол ганц эмэгтэйчүүдийн асуудал биш. 10 жилийн дараа бол эрэгтэйчүүдийн асуудал болох

ийм магадлалтай юм байна лээ. Судалгаа тооцоогоор харахаар. Тэгээд Мянганы хөгжлийн зорилго гэдгийг үргэлжлүүлээд Тогтвортой хөгжлийн зорилтыг НҮБ дэвшүүлсэн. Энэ дотор багтаж байгаа ийм асуудал байгаа юм байна лээ шүү гэж хэлээд энд байж байгаа Монгол.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Дэмжсэн, дэмжээгүй үг хэллээ. Одоо санал хураалт явуулна. Санал хураалтаа явуулъя. Санал хураалтыг уншиж танилцуулсан байгаа. Ингээд санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай. Санал хураалт. Энэ чинь Үндсэн хуулийн заалт байна. 81,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт, мөн зүйлийн 16 дахь заалтыг нэгтгэн 1 дүгээр зүйлийн 19 дэх заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2 дугаар зүйлийн 5 дахь заалтыг хасах:

“19/20 дугаар зүйлийн 20.22 дахь хэсэг:

20.22.Гадаад улсад байгаа иргэн гадаадад санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө сонгуульд оролцохоо мэдэгдэж, бүртгүүлнэ.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 81,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ажлын хэсэг Тогтохсүрэн дарга, Төрийн байгуулалтын байнгын хороо тэгээд түрүүний санал хураалт дээр би хэлэх гэж байгаад мартчихаж. Энэ хуулийн дагуу байгуулагдсан тойргоос гэдэг үг чинь засахгүй бол энэ хуулиар тойрог байгуулах юм шиг агуулга байна. Тэгвэл энэ хуульд заасны дагуу гэж найруулахгүй бол энэ хуулиар байгуулагдсан гэгчээр энэ хуулиар байгуулчхаж байгаа юм шиг ойлгогдоод. Найруулгаар дараа нь авахгүй бол энэ хуульд заасны дагуу байгуулагдсан гэж

байгаа юм. Хуульд заасны дагуу байгуулагдсан.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.4.4 дэх заалт, 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.6-7.10 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Ер нь тэгээд манай гишүүд Тогтохсүрэн дарга руугаа их дайрч хэрэггүй шүү. Ажил хийсэн хүн л сайн, муу үг сонсдог юм. Муу нэр, сайн нэр сонсдог юм. Ажил огт хийгээгүй хүн, ажлын хэсэг ахлаагүй хүн бол ямар ч шүүмжлэлд өртөхгүй. Тэгэхээр нэр ус гэдэг чинь ийм л учиртай. 2 төслийг нэгтгэсэн хувилбарыг тараачихсан байгаа.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалтыг хасах:

“7/9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг:

9.3.Гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдөр /цаашид “гадаадад санал авах өдөр” гэх/-ийг сонгуулийн төв байгууллага /цаашид “Сонгуулийн ерөнхий хороо” гэх/-ын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтоох бөгөөд гадаадад санал авах өдөр нь дөрөв хүртэл өдөр байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу 11.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 40 гишүүн дэмжиж 83,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 10, 11 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10/11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг:

11.4.Улсын Их Хурлын гишүүнийг энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар сонгох сонгуульд Монгол Улсын нутаг дэвсгэр сонгуулийн нэг тойрог байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 39 гишүүн дэмжиж, 81,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 12, 13 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12/12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг:

12.2.Энэ хуулийн 4.6-д заасны дагуу ээлжит бус сонгууль явуулах тохиолдолд Улсын Их Хурал ээлжит бус сонгуулийн санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө энэ хуульд нийцүүлэн сонгуулийн тойргийг байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураана. Дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ. Тогмидын Доржханд гишүүн үг хэлнэ.

Т.Доржханд: Би ажлын хэсгийн гишүүн юм аа. Тэгээд энэ дээр зүгээр протоколд л нэг зүйл үлдээх гэсэн юм. Ажлын хэсгийн түвшинд бас Төрийн байгуулалтын байнгын хорооны түвшинд бас ярьсан зүйл юу вэ гэхээр энэ сонгуулийн тойрог буюу гадаадад байдаг Монголчууд өнөөдөр 200 гаруй мянган иргэд байгаа. Тэгээд үүнээс сонгогчдын тоо нь болохлоор доор хаяж 120-оод мянган иргэд байгаа. Өөрөөр хэлэх юм бол доор хаяж сонгуулийн 3 тойрог гарч ирээд байгаа юм. Тэгээд үүнтэй холбоотойгоор Солонгост байдаг Монголчуудад нэг тойрог гаргах, Америк болон Европт байдаг бүсчилсэн байдлаар ингээд тойрог хийдэг олон улсын жишиг байна. Тэгээд үүний дагуу энэ асуудлыг хөндөж тавьсан. Тэгээд энийг энэ сонгуулийн тойрог ярих үед буюу 60-аас доошгүй хоногийн өмнө тойрог ярих үедээ бол хэлэлцээд асуудлаа сөхөж болно гэж ингэж ярьсан байдаг. Тэгээд үүнийг би бас боломжтой юм шүү гэдгийг зориуд мэдэгдээд, энэ протоколд үлдээе гэж ярь ирж байгаа юм. Бас энэ

асуудлыг нь дэмжиж байгаа юм аа. Баярлалаа.

Г.Занданишатар: Санал хураалт явуулъя. Сонгуулийн тойрог бол Монгол Улсын нутаг дэвсгэр гэж байгаа. Сонгуулийн нутаг дэвсгэр бол. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Сонгуулийн тойрог байгуулна гэж ярьж болохгүй. Тэрийг бол консетивенци буюу сонгуулийн тойрог биш. Зүгээр санал авах тойрог бүр тусдаа тийм газар. Санал авах хэсгүүд. 77,1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Сонгуулийн тойрог бол Монгол Улсын нутаг дэвсгэр байршсан.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 19¹ дүгээр зүйлийн 19¹.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“19¹.3.Төв комиссын дарга дотоод ажлын асуудлаар захирамж гаргана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 81,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалтын 19¹ дүгээр зүйлийн гарчгийн “бүрэн эрх,” гэснийг хасаж, 19¹.7 дахь хэсгийн “эрхийг” гэснийг “чиг үүргийг” гэж, 19¹.7.10 дахь заалтын “эрх” гэснийг “чиг үүрэг” гэж, 19¹.7.2 дахь заалтын “сахин биелүүлэх явдлыг хангах” гэснийг “хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 83,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 20.16 дахь хэсгийн “танилцах” гэсний дараа “, ашиглах” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 83,3 хувийн саналаар санал дэмжигдлээ. Одонтуяа дарга

11.Төслийн 1 дүгээр зүйлийн 19 дэх заалт буюу 20 дугаар зүйлийн 20.18 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн

найруулж, төслийн 2 дугаар зүйлийн 6 дахь заалтыг хасах:

“19/20 дугаар зүйлийн 20.21 дэх хэсэг:

20.21.Энэ хуульд заасан журмын дагуу Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигч, төрийн бус байгууллагын төлөөлөл сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаатай танилцаж нягтлах эрхтэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Асуулт хариултын цаг дууссан. Тэгээд найруулга дээр анхаарахгүй бол. 86. протоколд энийгээ тэмдэглэж тодруулж эцсийн найруулга дээр бас янзлах хэрэгтэй байж магадгүй. Яг процесстой нь танилцах гээд байна шүү дээ. Нэрсийн жагсаалттай танилцана гэвэл нэг ондоо хэрэг. Нэрсийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаатай нь танилцаж нягтлах хэрэгтэй гэж байгаа байхгүй юу. 86 Дэлгэрсайхан дарга тодруулчихъя. Чухал асуудал хэлэлцэж байгаа учраас.

Д.Дэлгэрсайхан: УБЕГ-ын дарга Дэлгэрсайхан тодруулга хэлье. Сонгогчдын нэрийн жагсаалт гэдэг бол үндсэндээ иргэний улсын бүртгэлийн сонгуулийн насны иргэдээс, мэдээллээс мэдээллийн нэгдсэн сан үүсгэж энэ сан дээрээ нэлээн хэд хэдэн үйл ажиллагаа хийгддэг юм байгаа юм. Энэ нь үндсэндээ 4-5 процесс байгаа юм. Ерөөсөө улсын бүртгэлийн үндсэн зарчимтай л яг санал нэг явдаг. Өөрөөр хэлбэл аливаа бид нар мэдээллийг эхлээд бүртгэдэг, нягтлан шалгадаг, хадгалдаг, хамгаалдаг, боловсруулдаг, тэгээд тодорхой хэмжээнд танилцуулж түгээж тараадаг. Энэ бүх процессоо л бид нар сонгуулийн нэрийн жагсаалттай холбоотойгоор авч үздэг юм байгаа юм. Тэгэхээр үйлдэх гэдэг бол 1 дүгээрт иргэний улсын бүртгэл дээр байж байгаа сонгуулийн насны иргэдийг тасалж авахыг, 2 дугаарт нөгөө хэсгийн хороонууддаа хуваарилахыг, 3 дугаарт

тодорхой хэмжээний өргөдөл гомдол байдаг юм уу, иргэдээс ирсэн мэдээллийг шалгах зориулалттайгаар түүн дээр шалгалтын ажлууд хийгддэг ийм процессыг бас хэлдэг юм. Дээрээс нь энэ бол сонгуулийн хуваариараа тодорхой хугацаануудтай. 1 дүгээрт 1-3 дугаар сард бид нар эхний хувилбарыг нь хийдэг, дараа нь 4 сарын 1-ээс бид нар цахим хуудсаараа иргэддээ мэдээлдэг. 5 сарын 1-нд бол бид нар 6 байгууллага тодруулбал БХЯ, ЦЕГ, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Дээд шүүх гэдэг юм уу ийм байгууллагуудаас мэдээллийг аваад энэ дээр апдэйт хийгддэг. Дараа нь энийгээ бид нар түгээж тараах ийм олон процесс байдаг юм. Тэгэхээр энэ ажлын хэсэг дээр яригдсан үйлдэх үйл ажиллагаа гэдэг бол саяын бүх процесс бол орж байгаа юм. Эхнээсээ авхуулаад дуусах хүртлээ. Үндсэндээ сонгуулийн жилд бол 1 сарын 10 дээр эхлээд сонгууль дуустал хийгддэг үйл ажиллагаа байж байгаа.

Г.Занданишатар: Түрүүчийн саналыг 38 гишүүн дэмжиж, 11 гишүүн татгалзаж, 77,6 хувийн саналаар дэмжсэн гэдгийг дахин товч хэлье.

Тэгэхдээ Монгол хэл найруулгын хувьд үйлдэл, үйлдэх үйл ажиллагаа гэдэг чинь нэг л язгууртай юмнууд байгаа юм. Тийм нягтлах эрх гэж байхгүй. Энийг холбогдох байгууллагууд хяналт шалгалт үйлдэх үйл ажиллагаа гээд бүр хоёулаа хамт орчхоод байгаа байхгүй юу. Жагсаалт үйлдэх явцтай танилцаж болно. Танилцах эрхтэй, болно гэж. Санал гарсан ажлыг хэсэг. Жагсаалт үйлдэх явцтай танилцана гэвэл илүү найруулга нь ч гэсэн зөв л болж байгаа юм. Үйлдэх үйл ажиллагаа. Санал хураалт явуулъя. Энийгээ найруулгаар гүйцээн боловсруулах чиглэл өгье. Найруулгын засвар хийх гэсэн чиглэл өгчихье. Тэгээд сая саналын хураалтын томъёог хэлэлцсэн. Дараагийнх нь

12.Төслийн 1 дүгээр зүйлийн 20 дахь заалт буюу 23.8 дахь хэсгийн “улсын

бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас” гэснийг “холбогдох байгууллагаас” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 71,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 24 дэх заалт буюу 29 дүгээр зүйлийн 29.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

24/29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэг:

“29.10.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ ардчилсан ёс, шударга ёсны зарчмыг баримталж, нийгмийн бүлгийн төлөөлөл, оролцоог хангана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Үг хэлж байгаа. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн, Чимэдийн Хүрэлбаатар гишүүдээр тасаллаа. Содномын Чинзориг гишүүн. Ингээд 3 гишүүнээр тасаллаа. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн үг хэлнэ.

Д.Өнөрболор: Ажлын хэсгийнхэн маань, Тогтохсүрэн дарга ажлын хэсгийнхэн маань маш ажил хэрэгч нэлээд хичээл, чармайлт гаргаад ажиллаж байгаа гэдгийг бол ойлгож байгаа. Энэ заалт дээр бас би хэт ерөнхий байна гэж бол хэлэх гэсэн юм. Энэ заалтыг ер нь хэрхэн хэрэгжүүлэх юм бэ. Хэрэгжүүлэх арга механизм дагасан зохицуулалт нь дутуу байна гэж ойлгогдоод байна. Өөрөөр хэлэх юм бол ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдлын зарчмыг бол Үндсэн хуулийн яг энэ агуулгаар нь хэлэх гэж байгаа бол энэ сонгуулийн хуулиар бид нар нарийвчлах ёстой. Үүнд бол ёс зүйн асуудал орж байна уу. Зарчим баримтална гэхээр ер нь хэний тогтоосон яг ямар зарчмаар энэ асуудлыг шийдэх гэж байгаа юм бэ. Энэ сонгуулийн хуулийн бас өөрчлөлтөөр ер нь бид Үндсэн хуулийн өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлж чадах эсэх, мөн түүхэн өөрчлөлт гэж бид нарын нэрийдээд байгаа энэ зүйлийг бид нар амилуулж чадах уу эсэх асуудал нь яг л

энэ хуулиар шийдэгдэх ёстой. Хэрэв үгүй бол энэ түүхэнд бид Үндсэн хуулийн хулгайч болж үлдэх ийм аюул бид нарт байгаа. Тийм учраас та бүгд маань хариуцлагатай хандаач гэдэг ийм асуудал байгаа. Үндсэндээ бол манай улсад иргэд төр хоорондын итгэлцэлд маш том ангал үүссэн байна. Энэ итгэл, итгэлцэл байхгүйгээр төлөөллийн ардчиллыг бид нар төсөөлөх боломжгүй ээ. Улс орнууд бол улс төрийн ёс зүйд өнөөдөр яг бодитой анхаараад байгаагийн цаад гол шалтгаан нь бол иргэд олон түмний итгэлийг сэргээх гол арга зам болоод байгаа учраас л энийг маш анхаарах ёстой асуудлын нэг хэсэг болгоод байгаа юм. Тийм учраас нэр дэвшигчийн ёс зүй, намуудын ёс зүй, тэдний удирдлагын ёс зүйн асуудлыг маш тодорхой хариуцлагатайгаар зааж өгөх хэрэгтэй. Хуульчлах ёстой. Жагсаалтаа худалдагддаггүй байх хэрэгтэй. Мөнгөний сонгуулиас татгалздаг байх хэрэгтэй. Улс төрийн намын үнэт зүйл улс орныхоо хөгжлийн төлөөх бодлого дээр бодлогоо дэвшүүлдэг байх ёстой. Энийг хэрэгжүүлж чадах ийм ёс зүйтэй, чадвартай ийм хүмүүсийг л нэр дэвшүүлэх нөхцөлийг хуульчлах нэн шаардлагатай. Яагаад гэхээр зөвхөн Сонгуулийн хууль бол хугацааны хувьд хязгаарлалттай учраас сонгуулийн хуульд бол энийг яг ард түмний хатуу шаардаж байгаа энэ агуулгаар нь энийг бол хуульчилж өгөх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа юм. Тийм учраас энэ заалтыг боловсронгуй болгож гүйцээн боловсруулах чиглэл өгөх саналтай байна дарга аа.

Г.Занданишатар: Чимэдийн Хүрэлбаатар гишүүн үг хэлнэ.

Ч.Хүрэлбаатар: За энэ ингэж байна л даа. Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ ардчилсан, ёс, шударга, ёсны зарчмыг баримталж, нийгмийн бүлгийн төлөөлөл оролцоог хангана гээд. Ардчилсан ёс нэр дэвшүүлэхдээ ардчилсан ёс гэдэг чинь юу гэсэн үг вэ. Өрсөлдөнө л гэж байгаа болов уу гэж бодож байгаа. Нам дотроо

энэ дээр орж ирэхдээ нэр дэвшихдээ бид нар эрх авахдаа өрсөлдөнө гэж ойлголоо шүү дээ. Гэтэл бүх нийгмийн бүлгийн төлөөлөл нь хангагдахгүй болчихвол яах вэ. Яг энэ ардчилсан өрсөлдөөд ороод ирэхэд. Шударга гэхээр яг яана гэж байгаа юм. Шударга ёсыг баримтална гэж. Шударга ёс гэдэг бол би нэр дэвшмээр байна гэхэд өрсөлдөх эрхийг нь хангаж өгнө л гэж ойлгож байгаа юм. Тэгэхээр нэр дэвших эрх авахын тулд бид нар яаж орж ирэх юм. Яг энэ заалт дээр ирэхээр нэлээд тийм сарниад явчих юм уу. Одоо бол ингээд л намын Бага хурал дээрээ ч юм уу яриад л нэр дэвшигчдийг оруулаад ирж байгаа шүү дээ. Тэгэхээр энэний өмнө бас нэлээд тийм нэр дэвшүүлэхтэй холбоотой ажлууд явагдана гэсэн үг үү. Нам эвсэл нэр дэвшүүлэхдээ гэж байна шүү дээ. Нэр дэвшүүлэх явцдаа ардчилсан байна. Шударга ёсыг баримтална гээд. Тэгээд өрсөлдчихөж байгаа юм чинь тэгээд л нэг нь л гарч ирж таарна шүү дээ. Тэгэхээр бүх талын оролцоог хангахгүй болчихвол яах вэ. Тэгэхээр энийг яана, юу гэж ойлгох юм.

Г.Занданишатар: Саналаа хэлсний дараа яг санал гаргасан хүн нь нэг үг хэлээрэй. Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Би энэ заалт дээр бас жаахан бас эргэлзээд л байгаа юм л даа. Манай сонгуулийн тогтолцоо чинь холимог тогтолцоотой болчихлоо. Тэгээд ялангуяа иргэдийн яриад байгаа юм чинь тэр нөгөө намын жагсаалтад ямар хүн орох юм бэ, яаж оруулах юм бэ гэдэг асуудал иргэдийн дунд маш их тийм эргэлзээтэй байгаа асуудал шүү дээ. Ялангуяа намын жагсаалттай холбоотой асуудлуудыг яаж оруулах яаж эрэмбэлж оруулах юм гээд. Тэгэхээр энийг бас жаахан тодорхой болгож болохгүй юм уу. Эсвэл ер нь бол улс төрийн намуудын боловсон хүчний бодлого тодорхой байх, ил тод байх, нээлттэй байх, ер нь тоглоомын дүрэм нь тодорхой байх ёстой гэдгийг л иргэд маш их яриад байгаа юм л даа. Тийм

учраас бол нэр дэвшүүлэхтэй холбоотой асуудлыг яах юм. Гүйцээн боловсруулаад дахиж ярих юм уу. Эсвэл тэр нэр дэвшүүлэхтэй холбоотой бүтэц байх юм уу. Эсвэл нэр дэвшүүлэх журам бас байна. Тэрийг нь Улс төрийн намын тухай хуулиар зохицуулна гэдэг юм уу. Тэгээд ийм асуудлуудыг нэлээн тодорхой болгоод бас оруулчихвал яасан юм бэ гэж. Иргэдтэй уулзаад ярихад бол тэр ялангуяа жагсаалттай холбоотой асуудлыг л пропорциональ тогтолцоо орж ирж байгаатай холбоотойгоор жагсаалтад оруулах тэр хүмүүсийг яаж оруулах юм. Нөгөө итгэл даахгүй гээд байсан ёс зүйн бас алдаа дутагдал гаргаж байсан ийм хүмүүс чинь ороод ирэх юм биш биз дээ. Нөгөө хаалгаар өшиглөөд гаргасан нөхөр чинь тооноор орж ирээд хойморт суучих юм биш биз дээ. Тэгээд иргэдийн дунд бол тийм нэг эргэлзээ тээнэгэлзээ маш их байгаа шүү дээ. Тэгээд Сонгуулийн хууль дээр чинь бол анх гишүүдийн өргөн барьсан хуулиар бол тэр жагсаалт пропорциональ тогтолцоогоор сонгогдох гэж байгаа намын жагсаалтад бичигдсэн хүмүүсийг нэрийн өмнөх дугаарыг нь дугуйлна гээд ингээд хүнд нь санал өгөх болохоор юм шиг байсан. Одоо тэр чинь бол байхгүй болчихлоо. Тэгэхээр нөгөө иргэдийн эргэлзээ, болгоомжлол чинь улам л их нэмэгдчихэж байна гэж би хараад байгаа юм л даа. Тэгээд энд нь нэг хариулт өгсөн, нэлээн тодорхой болгосон заалт, эсвэл тэр нэр дэвшүүлэх бүтэцтэй байна. Нэр дэвшүүлэх тэр журмыг нь бас намын төв байгууллага нь ч юм уу баталсан байна энэ тэр гээд иймэрхүү асуудлыг оруулах юм уу эсвэл тэр Улс төрийн намын тухай хуулиар энэ харилцаагаа тодорхой нарийвчилж зохицуулсан байна гээд ингэж оруулах юм уу. Жаахан тодорхой болгоод гүйцээн боловсруулах нь зүйтэй болов уу гэсэн ийм л бол саналтай бол байна.

Г.Занданишатар: Яг санал гаргасан хүн нь үг хэлж болно. Саналаа тайлбарлаж. Хэн юм бэ. Энхбаяр гишүүн

та хэдэд 2, 2 минут өгье. Тогтохсүрэн дарга.

Д.Тогтохсүрэн: Тэгэхээр ингээ, гишүүд ээ, би энэ дээр 1 дүгээрт даргыг гүйцээн боловсруулах гээд чиглэл өгчхөөрэй гэх гэж байгаа юм. Энийг яах вэ дээ хуульд анх байгаагүй. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Үндсэн хуулийн өөрчлөлт хэлэлцэх үед манай гишүүд ерөөсөө ганцхан энийг ярьчихсан байхгүй юу. Тэгээд бид нар ажлын хэсэг дээр ярьж ярьж байгаад үүнээс өөр томъёолол олж чадахгүй ингээд л тавьсан юм. Их нарийвчлахаар нөгөө улс төрийн намын хуулиар зохицуулах гээд. Ер нь нэр дэвшигчид тавигдах шаардлага, нэр дэвшигчдээ тодруулах тэр процесс бол тэр чигээрээ улс төрийн намын хуулиараа бид нар зохицуулъя гээд байгаа юм. Тэр ил тод нээлттэй байх, сонгон шалгаруулалт энэ тэр бүх ажлыг Улс төрийн намын хуулиар зохицуулъя гэж байгаа.

Тэгэхдээ Сонгуулийн хууль дээр заавал үүний төлөөлөл 1 чухал зүйл байх ёстой гэж үзээд ингээд оруулчихсан. Хэтэрхий ерөнхий байна гээд байна. Гэхдээ хэтэрхий задгай бас байж болохгүй болчихоод байгаа юм. Тийм учраас яах вэ та бүхэн харин саналууд байвал бичиж өгөөрэй. Сая үг хэлсэн Хүрэлбаатар гишүүн, Өнөрболор гишүүн бусад хүмүүс энэ дээр тодорхой санал байвал бичиж өгөөрэй. Би даргаас юу гэж хүсэх гэж байна вэ гэхээр энэ заалт дээр гүйцээн боловсруулах чиглэл авчихъя гэдэг ийм л саналтай байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн 2 минут.

Б.Энхбаяр: Энэ бол ер нь бол хуулиар биш улс төрийн намын дотоодын соёлоор зохицуулагддаг зүйл байхгүй юу. Хэнийгээ нэр дэвшүүлэх, нэр дэвшүүлэхдээ шударга ёс байх уу, ардчилсан ёс байх уу. Ардчилсан ёс байх уу гэдэг чинь тухайн намын төлөөллийн дээд байгууллагын олонхын санал авч

байж л намаасаа нэр дэвших ёстой шүү дээ. Ялагдчихсан цөөнх болчихсон хүнийг нь олон санал авсан хүнээс нь урдуур нь оруулж болохгүй л гэсэн үг байхгүй юу. Ийм зарчмуудаа л биччихье гэж байгаа юм. Тэгээд нам өөрөө шийддэг. Ажлын хэсэг дээр зүгээр ямар санал яригдаж байсан гэхээр нөгөө нэр дэвшүүлэх процесс нь шууд ил тод, нээлттэй явагдана энэ тэр гээд бичигдчихсэн байсан юм. Тэгэхээр тэр намын нэр дэвшүүлэх процесс чинь бол хаалттай явагддаг зүйл байхгүй юу. Яагаад гэхээр тэнд чинь хоорондоо өрсөлддөг, санал хураалтууд явагддаг, сайн муугаа ярилцдаг. Тэр намын дотооддоо тэр нээлттэй ярих бололцоог нь хангах ёстой. Тэрнээс биш ингээд шууд лайвдаад л нэр дэвшүүлэх процесс дээрээ нөгөө нэр дэвшүүлж байгаа хүмүүс бие биеийгээ хэлээд л тэр бүх юм нь ил тод ингээд л байна гэсэн үг бол би байхгүй гэж ойлгож байгаа юм.

2 дугаарт ажлын хэсэг дээр гишүүд яриад байсан. Сая Өнөрболор гишүүн яриад байгаа. Яг томъёолоход хэцүү байгаад байгаа юм. Нам нийгмийн бүлгүүдийн төлөөллийг яг тэгш хангана гэхчээр малчин хэдэн хувь байх юм. Дээд боловсролтой хэдэн хүн байх юм. Сонирхлын бүлгүүд гэвэл тэгвэл шатар тоглодог нь хэд байх юм. Ном уншдаг нь хэдэн хувь байх юм. Энэ чинь бүр утгагүй юм руу орно. Одоо бүр ёстой миний санаачилсан гэрийн тэжээвэр амьтан тэжээдэг нь хэдэн хувь, тэжээдэггүй нь хэдэн хувь гээд ингээд энэ чинь бүр задарч өгнө. Тэгвэл бүр цаашаа нохой тэжээдэг нь хэдэн хувь, муур тэжээдэг нь хэдэн хувь гээд явна шүү дээ. Тийм учраас энэ бол ингэж хууль дээр нарийн тодорхойлогдож болохгүй зүйл байгаа юм байгаа юм. Ер нь байхгүй байхдаа ч гэмгүй. Намын өөрийнх нь дотоодын асуудал байхгүй юу.

Г.Занданишатар: Энийг Улсын Их Хурлын судалгааны хүрээлэнгээс нэр дэвшүүлэхтэй холбоотой судалгаа хийсэн байгаа юм. Тэр дээр бол

ардчилсан аливаа ардчилсан дэг журмын гол цөм нь нэр дэвшигчийг тодруулах явдал байдаг. Улс төрийн намууд тодорхой ялагчийг тодруулах, чадварлаг улс төрчийг дэвшүүлэх, дотоод өрсөлдөөний сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх гэсэн 3 зорилгод хүрэх үр дүнтэй нэр дэвшүүлэх үйл явцыг шаарддаг. Нэр дэвшүүлэх үйл явц нь холбогдох бүх төлөөлөгчдийн ашиг сонирхлыг тэнцвэртэй хангасан байх ёстой. Онолын хувьд төвлөрсөн болон институтчилсэн гэсэн 2 хэлбэр байна. Зарчмын хувьд эрх чөлөөний болон дотоод ардчиллын гэсэн 2 зарчим байна гээд энэ чинь нарийн онолын арга зүйтэй юм байна. Тэгэхээр энэ зарчмуудаа үндэслээд л гүйцээн боловсруулаад, гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Тэгэхгүй бол нийгмийн бүлгийн ашиг сонирхлыг хангана гэдэг чинь заавал малчин оруулна гэсэн үг билүү. Малчдыг төлөөлж дуугардаг, тэрүүгээр дагнан уулзалт хийдэг, малчидтайгаа уулзаад явж байдаг ийм хүн байна гэсэн ийм санаа гэж үздэг хэсэг байна. Ингээд дараагийн асуудал оръё.

14.Төслийн 1 дүгээр зүйлийн 27 дахь заалт буюу 33.1.10 дахь заалтын “дэвшигчийг” гэсний дараа “, 29.7-д заасныг зөрчсөн бол тухайн нэр дэвшигчийг” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.Санал хураалт. 74,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 1 дүгээр зүйлийн 28 дахь заалт буюу 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсгийн “хэмжээнээс” гэснийг “хэмжээний 50 хувиас” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 74,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн 1 дүгээр зүйлийн 29 дэх заалтын 38.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.13.Төрийн аудитын дээд байгууллага нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн энэ хуулийн 38.5-д заасан

мөрийн хөтөлбөр, 38.7-д заасан хандивын тайланд тус бүр нэг дүгнэлт гаргана. Хандивын тайлан нь ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааг, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацааг хамаарна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 76.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 1 дүгээр зүйлийн 31 дэх заалтын 41.16, 41.17 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41.16.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нь тухайн нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааг эрхлэн явуулна.

41.17.Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нэгдсэн хэвлэмэл материал нь гурван хэвлэлийн хуудаснаас хэтрэхгүй байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Содномын Чинзориг, Чимэдийн Хүрэлбаатар, Сандагийн Бямбацогт 3 гишүүнээр тасаллаа. Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Төслийн заалт дээр тодруулах юм байх юм. Нам эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нь тухайн нам эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааг эрхлэн явуулна гэж сонгуулийн сурталчилгааны нэгдсэн хэвлэмэл материал нь 3 хуудас хэтрэхгүй гэж. Тэгээд нам чинь тэгээд намын сонгуулийн эрхэлсэн байгууллага чинь зөвхөн жагсаалтаар нэр дэвшигчийн сурталчилгааг л явуулах юм уу. Нам чинь нөгөө намынхаа сонгуулийн сурталчилгаагаа бас явуулна шүү дээ. Энэ ямар ялгаатай байгаа юм бол 1 дүгээрт.

2 дугаарт тэгээд нам чинь өөрийнхөө намын сонгуулийн сурталчилгааны асуудлыг эрхэлж

явуулна. 2 дугаарт нэр дэвшигчийнхээ асуудлыг ч гэсэн нам чинь бас мэдээлэл гаргадаг, ядаж л намын дарга нь дэмжээрэй гэж үг хэлдэг, зурагт плакат, нөгөө Монгол Ардын нам, Ардчилсан нам гээд л ингээд нэг юм гардаг шүү дээ. Тэгээд энэнтэйгээ зөрчилдөхгүй юу, үгүй юу. Би яг жаахан гайхаад байгаа юм. Үгүй бол ойлголт мэдээлэл буруу байна уу. Энийг тодруулж өгөөч.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар гишүүн.

Ч.Хүрэлбаатар: Яг л түрүүн Чинзориг гишүүний асуусан асуулт л даа. Энэ дээр ингэж ойлгогдож байна шүү дээ. Нам бол зөвхөн жагсаалтаар орж ирсэн хүний сурталчилгааг л эрхлэн явуулна гэж байгаа юм. Тэгэхээр нөгөө очиж тойрог дээрээ шууд ард иргэдээсээ санал авдаг мань мэтийн хүмүүсийг яах юм. Хаячих юм байна шүү дээ. Тэгээд өөрсдөө тэр учраа олж ирэх юм уу. Үгүй яалаа гэж. Гэхдээ ийм байгаа бол энэ хүн намын хийх ажлыг нь бүгдэд нь хамааруулахаар хийхгүй бол маниус чинь тэнд өөрсдийн хүчээрээ явах нь байна шүү дээ. Тэгэхээр чинь хардаа. Нам бол ер нь ингээд томсгосон тойргоор явахад нам хоорондоо гишүүд хоорондоо зөрчилддөг, хоорондоо өрсөлддөг, тэгээд намаа сулруулдаг. Дахиад одоо бүр дээр нь нам энэ дээр сурталчилгаанд орохгүй гэдэг үг ойлгогдож байна шүү энэ дээрээс. Тэгээд хэдэн хүнийг золигт нь гаргаад шидчихдэг. Хоорондоо хэрэлдэнэ үү, зодолдоно уу. Хамаагүй. Тэгээд нам бол зөвхөн өөрийнхөө жагсаалт дээрээ анхаарна гээд. Тэгж болохгүй шүү дээ. Тэгэхээр энэ бол хамтад нь нийлүүлж боловсруулж оруулахгүй бол болохгүй. Ерөнхийдөө ингэж хийчхээд ухуулагч нараа бүгдийг нь аваад хаячих. Тэгж байж энэ сонгууль зөв явуулна шүү. Мөнгөний сонгуулиуд алга болно. Нам хүмүүсээ ялгахгүй. Одоо ингээд бүр 2 гишүүдээ одоогоос нь эхлээд 2 ялгаж эхэлж байна шүү дээ. Энэ хэд нь яах вэ нөгөө очиж нүүр түлж үздэг, гардан тулаанд орж явдаг. Нөгөө хэд нь сайхан

намаас бүгдийнх нь сурталчилгааг нь хийгээд явдаг гээд. Анх орж ирэхдээ л 2 янзаар ороод ирэх юм бол энэ хүмүүс чинь парламент чинь дотроо 2 янзтай л явагдана. Тийм учраас энэ сурталчилгаа хийдэг зүйлүүд нь адилхан л байх ёстой. Тэгэхээр ингэж ялгаварласан байдлаар хандаж болохгүй шүү гэдгийг хэлье ээ.

Г.Занданиатар: Сандагийн Бямбацогт гишүүн. Дараа нь Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн. Санал гаргасан гишүүн саналаа тайлбарлаж үг хэлж болно.

С.Бямбацогт: Би Чинзориг гишүүн, Хүрэлбаатар гишүүн нарын бас хэлж байгаа саналуудтай адилхан саналтай байгаа юм. Нөгөө мордохын хазгай. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Жагсаалтаар сонгогддог болъё, бас улс орны эрх ашиг. Зөвхөн тойрог, жалга дов ярьдаггүй, улс үндэстний эрх ашиг, үндэсний аюулгүй байдал, хөгжлийн бодлого ярьдаг ийм гишүүд хэрэгтэй байна. Ийм гишүүдтэй байхын тулд жагсаалтаар улс орны хэмжээнд сонгогддог ийм хүмүүсийг бий болгоё гэдэг үүднээс жагсаалтыг бас Үндсэн хуульд оруулж нэмэлт, өөрчлөлт хийсэн. 2012 онд холимог тогтолцоогоор сонгууль явуулсан. Жагсаалтад баахан нөхдүүд давхиад орчихсон. Тэгээд хаалгаар хөөгөөд гаргахаар тооноор ороод ирлээ. Тэгээд намын нэрийн дор янз бүрийн хүмүүс ороод ирлээ гэдэг нэлээн олон асуудал болж байсан. Янз бүрийн хүмүүс ч орж ирж байсан. Энэ алдааг давтахгүй гэдэг үүднээс л бид нарын жагсаалтын асуудал ярьж байгаа л даа уг нь. Гэтэл алдаа давтагдах гээд байна л даа. Жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааг намын сонгууль эрхэлсэн байгууллага хариуцна гэж байгаа юм. Ерөөсөө тэгээд жагсаалт гэдэг юм чинь хэн орох юм, яаж орох юм. Түрүүн би бас хэлсэн. Тодорхойгүй. Жагсаалт нь нээлттэй байгаа тэр жагсаалтад орсон хүмүүсийг улс орны хэмжээнд санал авхуулаад авсан хүмүүс нь тэр намын авсан

саналдаа хуваагдаад шударгаар орж ирдэг бол бас зөв. Гэтэл яаж авах нь тодорхой байхгүй байгаад байгаа юм. Гэсэн мөртөө жагсаалтаар орсон нөхдүүд нь үндсэндээ ямар ч зардал гаргахгүй, сонгуулийн сурталчилгааг нам нь хийж өгөөд, нөхдүүд тэгээд л хойморт гэдсээ илээд л хэвтэж байх юм байна л даа. Нөгөө баастай бурхан гэж ярьдаг шүү дээ. Баастай бурхан жинхэнэ ариун цагаан шударга, цэвэрхэн юу гэдэг юм урилга заллагаар орж ирсэн. Бид нар ерөөсөө гуйж байгаад л оруулаа биз дээ. Би мөнгө гаргахгүй. Гуйж байгаад л оруулаа биз дээ. Ийм л хүмүүс л орж ирэх гэж байгаа юм байна л даа. Тэгээд тэр хүмүүс маань хэр зэрэг ард түмнээс сонгогдоогүй. Өөрсдөө сонгуульд хөлсөө урсгаж зүтгэж зүдэрч яваагүй. Ард түмний өмнө очиж нүүрээ улалзуулж, нүдээ бүлтийлгэж зогсоогүй, амлалт аваагүй, үүрэг хүлээгээгүй ийм хүмүүс орж ирчхээд тэгээд гуйлгаж орж ирж зардал гаргахгүй тэгээд нам өмнөөс нь бөхөлзөөд сурталчилгаа нь хийж өгдөг. Ямар хүмүүс энэ жагсаалтаар орох гээд байгаа юм бэ ерөөсөө. Би орохгүй. Би жагсаалтаар орохгүй. Ийм бас юу гэдэг юм. Нөгөө жор мэддэггүй эмчээс зовлон үзсэн чавганц дээр гэж үг байдаг шүү бас. Мэдлэг боловсрол чухал. Мэдлэг боловсролтой адилхан бас хүний бас сэтгэл зүтгэл гэж юм байдаг юм шүү бас. Турилага гэдэг юм байх ёстой шүү бас. Одоо энэ Их Хурлын гишүүд юу гэдэг юм. Бүгдээрээ л 77 булчирхайгаа тоочуулсаар байгаад, дэлгүүлсээр байгаад хамгийн муу муухай хулгайч, хамгийн муу нэртэй болчихсон. Их л цэвэрхэн хүмүүс өндөг шиг өөгүй, арилгасан сонгино шиг цэвэрхэн хүмүүс л намаар зардлаа даалгаад л орж ирэх юм байна л даа. Энийг чинь яах юм бэ. Ард түмнээр л сонгуулмаар байна шүү дээ энийг чинь. Тийм болохоор ийм юмнуудыг бас байлгамааргүй байна. Тодорхой болгомоор байна. Ажлын хэсэгт саналаа хэл дээ. Энэ жагсаалтад ямар хүмүүс, яаж орох гээд байгаа юм. Хаана байж байгаа тэр арилгасан сонгино шиг өндөг

шиг өөгүй ямар хүмүүс байгаа юм. Энийгээ хэлж өгөөч.

Г.Занданишатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Энэ ийм юм байгаа юм. Хүрэлбаатар гишүүн, Бямбацогт гишүүн, Чинзориг гишүүн ээ, нэр дэвшигчдийг сонгуулийг нь яаж зохион байгуулах вэ, яаж сурталчлах вэ гэдэг асуудал одоо мөрдөгдөж байгаа хуулийнхаа 36, 37, 38 дээр бүгд байгаа юм аа. Энэ хуулийн заалтууд 1 дүгээрт хөндөгдөөгүй. Яг л нөгөө нам нэр дэвшигчийнхээ сонгуулийн ажлыг зохион байгуулах бүх ажлыг хийнэ. Энэ заалтыг яагаад оруулах болсон юм гэхээр манай гишүүд ийм юм яриад байгаа байхгүй юу. 1 дүгээрт намын нэрийн ард нуугдчихна гээд байгаа юм. Намын нэрийн ард нөгөө 48 хүнийг нуугдуулахгүйн тулд нөгөө 48 хүний сурталчилгааг олон түмэнд гаргаж өгч манай нам ийм хүн дэвшүүлсэн гэдгээ сурталчлах гэж байгаа учраас энэ 2 заалтыг оруулаад байгаа юм. Энэ 2 заалтыг оруулахдаа хувь хүн ерөөсөө сурталчлахгүй. Хэрэв сурталчил гэвэл 48-уулаа өөрсдийгөө ирээд гүйчих гээд байгаа юм. Тэгүүлэхгүйн тулд нам энэ хүний талаар 3 хэвлэлийн хуудсанд багтаах нэг удаагийн товхимол ч юм уу гаргаж өгөөд, манайх ийм 48-ыг дэвшүүлсэн гэдгээ л олонд мэдээлж байгаа юм. Тэрнээс энэ 48-аа сурталчлаад, бусдыгаа сурталчлахгүй гэдэг ойлголт огт байхгүй. 36, 37 дээрээ бүх юм явдгаараа явж байгаа. Зүгээр яах вэ унишилт нь тэгж жаахан ойлгогдоод байгаа юм байна. Ер нь үүний санаа бол 48 хүний сурталчилгаа нэгээрээ гэж байхгүй. Зөвхөн нам нь хийнэ. Нам хийхдээ сонгогчдод манайх ийм 48-ыг манай намыг сонгох гээд байгаа, манай намыг дугуйлах гээд байгаа гол шалтгаан чинь энэ 48 чинь ийм учиртай юм шүү гэдгээ тайлбарлах гэж энэ заалтыг оруулсан юм. Тэрнээс биш энийг хасчихаар яг нөгөө Бямбацогт гишүүний хэлж байгаа шиг 2012 он шиг нөгөө нэргүй, харанхуй жагсаалт болоод ингэж явчхаад байгаа

юм. Тийм учраас бид нар нөгөө та бүгдийн саналаар сая Үндсэн хуулийн өөрчлөлт гарахад та бүгд ганц юм энийг яриад байгаа юм. Энэ саналаар л энэ 41.16, 17 гэдэг 2 заалт хууль санаачлагч хөндөөд ороод ирчихсэн учраас энэ 2 заалтыг оруулж тэр жагсаалтаар нэр дэвшиж байгаа хүнийг ийм 48 хүн байна шүү гэдгийг олон нийтэд олгох боломжийг л бий болгож байгаа юм. Тэрнээс бусад юмаа хаяна гэдэг ийм ойлголт огт байхгүй байхгүй юу. Үгүй харин дугуйлахгүй. Гэхдээ нөгөө намыг дугуйлахын тулд ийм 48 хүн бид дэвшүүлсэн юм шүү гэж нам 1 удаа хэвлэлийн материал тарааж өг гэдгийг л зөвшөөрч оруулж байгаа заалт байгаа байхгүй юу. Үгүй ээ, намаа дугуйлахын тулд манай нэр дэвшигчид Үндсэн хуулийн өөрчлөлтөөр ийм нэр цэвэр хүмүүс, ийм чадвартай хүмүүс, ийм улс орныг авч явах хүмүүс гэдгээ тайлбарлаж байж намаа дэмжүүлэх гээд байхгүй юу. Асуудлын гол эндээ л байгаа юм.

Г.Занданишатар: Үг дууссан. Санал хураалт. Дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ санал дээр. Санал хураалт явуулна. Гишүүд дутуу орхисон юм байхгүй ээ, энийг унагаачихаар байна шүү дээ Хүрэлбаатар гишүүн ээ, төслөөрөө үлдчих юм байна. Төсөл дээрээ бас яг ийм агуулгатай юм байна. Тэгэхээр энийг гүйцээн боловсруулах чиглэл өгөөд, үгүй ээ, гүйцээн боловсруулах чиглэл өгөхгүй бол энэ байна шүү дээ зарчмын концепцын ялгаа байна шүү дээ. Хүрэлбаатар сайд хэлээд байгаа үнэн. Нэр дэвшигчийг дугуйлах байсан байхгүй юу. Хуучин төсөл чинь. Одоо нэр дэвшигчийг дугуйлахгүй болчихсон, нам дугуйлах болчихоор нэр дэвшигчийн сурталчилгаа гэдэг тусдаа юм явах юм уу, үгүй юм уу. Тэгэхдээ наадах чинь бас агуулгын юм байна. Энийг гүйцээж боловсруулья.

Энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүнд мэндчилгээ дэвшүүлъя. Ганибал

гишүүн ээ. 6 дугаар сарын 7-нд Бямбацогт дарга сууж байгаарай. Таны хажууд тал. 6 дугаар сарын 7-нд Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Баатарын Бадмаанямбуу, Жамбалын Цэнд нарын айлын отгон хүү болон эхээс мэндэлжээ. Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ танд төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Асуулт хариултын цаг дууссан. Тайлбар дүгнэлт хэлэхгүй. Дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ. Томьёоллоо зөв болго гэж байхгүй л дээ .

Төслийн 1 дүгээр зүйлийн 33 дахь заалт буюу 47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32/47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсэг:

47.12.Жагсаалтаар нэр дэвшигчийн цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааг нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага энэ хуульд заасны дагуу бүртгүүлсэн цахим хуудсаар эрхлэн явуулна. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахад энэ хуулийн 50.1-д заасны дагуу тогтоосон зардлын дээд хэмжээний 15 хувиас хэтрэхгүй байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Тэгээд энэ яг фэйсбүүкт бүүст хийж байгаа зардлыг бид нар хянаж чадахгүй байгаа шүү дээ. Үгүй ээ, ер нь яг зарчмын хувьд байна шүү дээ. Зарчмын хувьд нам дугуйлах юм бол намын нэр дэвшигчийн сурталчилгаа гэж байх юм уу, үгүй юм уу гэдэг нэг зарчмын асуудал байгаа. Тэгэхдээ тэрийг бол яг ингээж зохицуулах юм уу, үгүй юм уу гэдэг асуудал байгаа юм. Гүйцээ боловсруулах чиглэл өглөө. Энэ намын сурталчилгаа

дотроо багтаж явж болно. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Намын сурталчилгаа дотроо бүх юмаа оруулаад явж болно шүү дээ.

19.Төслийн 1 дүгээр зүйлийн 34 дэх заалт буюу 48 дугаар зүйлийн 48.1.8-48.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34/48 дугаар зүйлийн 48.1.8 дахь заалт:

48.1.8.тухайн жилийн төсөвт тусгаагүй нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх, амлалт өгөх, зарлах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 76,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Төслийн 1 дүгээр зүйлийн 35 дахь заалт буюу 48 дугаар зүйлийн 48.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34/48 дугаар зүйлийн 48.10 дахь хэсэг:

48.10.Радио, телевиз нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлэхийг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ чинь ингээд нам эвслийн дарга нар ярилцлагад орж болохгүй болчих чинь зөв юм уу. Дүрс гарчихвал яах юм. Хуучин нэг ярьж байсан ярилцлага гарчихвал яах юм.

21.Төслийн 1 дүгээр зүйлийн 37 дахь заалт буюу 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37/53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсэг:

53.4.Энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшигч нь нам, эвслийн сонгуулийн сурталчилгаанд зориулан хандив өгч болох бөгөөд нэг нэр дэвшигчийн өгсөн хандивын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон нэр дэвшигчээс тойрогт зарцуулах зардлын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Төслийн 1 дүгээр зүйлийн 38, 39 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37/59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг:

59.4.Саналын хуудас нь дараах хэсэгтэй байна:

59.4.1.энэ хуулийн 4.3.1-т заасан сонгуулийн тойрогт нэр дэвшигчид өгсөн саналыг тэмдэглэх;

59.4.2.энэ хуулийн 4.3.2-т заасан нам, эвсэлд өгсөн саналыг тэмдэглэх.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 68,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Төслийн 1 дүгээр зүйлийн 41 дэх заалт буюу 63¹ дугаар зүйлийг хасах. санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт уу? Санал хураалт. Энэ урьдчилж санал өгөхийг ингээд хасчихаар болж байгаа юм уу. Ер нь урьдчилан санал өгдөг өвчтэй зовлонтой, гадаад дотоод явдаг тэр юм хаагдахаар хүний санал өгөх эрхэд бас халдаж байгаа асуудал гарч болзошгүй дээ. Зөөврийн санал ч яах вэ тусдаа. Жилийн турш өгнө гэсэн юм байхгүй. 5 хоногийн өмнө гэж ярьж байгаа биз дээ.

24.Төслийн 1 дүгээр зүйлийн 42 дахь заалт буюу 64¹ дүгээр зүйлийн 64¹.1 дэх хэсгийн “Сонгуулийн ерөнхий

хорооноос” гэснийг “энэ хуульд заасны дагуу” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 73,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэр электрон төхөөрөмжгүй байх үеийнх л дээ.

25.Төслийн 1 дүгээр зүйлийн 43 дахь заалт буюу 65 дугаар зүйлийн 65.16, 65.17 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43/65 дугаар зүйлийн 65.16, 65.17 дахь хэсэг:

65.16.Бүртгэлийн хуудас авсан сонгогчийг сонгогчийн нэрийн жагсаалтын нэгдсэн санд бүртгэгдсэн тухай тэмдэглэгээ хийнэ.

65.17.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 65.6-д заасан сонгогчийн гарын хурууны хээгээр сонгогчдын нэрийн жагсаалтын нэгдсэн сантай тулган таниулах ажлыг хариуцна.”

Санал гаргасан ажлын хэсэг. Цэвэгдоржийн Туваан гишүүнээр үг тасаллаа. Цэвэгдоржийн Туваан гишүүн үг хэлнэ.

Ц.Туваан: Энэ дээр протоколд тэмдэглүүлэх нэг зүйл байна. Юу гэхээр энэ 2 заалт дээр аль аль дээр нь сонгогчийн нэрийн жагсаалтын нэгдсэн сан гэсэн үг байгаа. Тэгэхээр нэгдсэн санд бүртгэгдсэн тэмдэглэл хийнэ гэсэн заалт орж байгаа. Энэ юу гэсэн үг вэ гэхээр тухайн хэсгийн хороон дээр санал өгч байгаа сонгогч энэ нэгдсэн сан руу бүртгэгдэнэ гэж ингэж ойлгогдож байгаа. Тэгэхээр энэ хэсгийн хороо болгон дээр улсын хэмжээнд бий болох хэд байдаг юм 2000 гаруй хэсгийн хороо байдаг юм уу, энэ болгон дээр компьютер техник хангамжийн хүчин чадалтай холбоотой асуудал гарч ирэх юм байна лээ. Юу гэхээр нэгдсэн сангийн буюу Монгол Улсын иргэний бүртгэлээс түүж

авсан сонгогчдын нэрсийн жагсаалт гээд энэ жагсаалтыг тухайн хэсгийн хороо болгоныг компьютерт хийж өгөх ийм шаардлага үүсэж байгаа. Улсын Их Хурлаас бол сая Байнгын хороон дээр яригдсан хар машинтай холбоотой, сонгогчийн сонгууль явуулах техник хангамжтай холбоотой 2 том зардал яригдаж байгаа. Энэ хүрээнд компьютерын асуудлыг шийдэх 18 тэрбум төгрөгийн асуудал яригдаж байгаа. Тэгэхээр энэ дотор хэсгийн хороо болгон дээр сонгогчдын нэрсийн жагсаалтыг тэр чигээр нь тэр компьютерт нь суугаад, тэндээс нь авах асуудлыг ярих заалт шүү гэдгийг бас протоколд тэмдэглүүлье. Яагаад вэ гэхээр энэ дээр юу гэдэг юм оффлайн горим дээр гээд нэг хэсгийн хороонд 2 мянган хүний нэр өгчихдөг, нөгөөдөх нь нэгдсэн бүртгэлээс шүүгдэхгүй учраас хажуугийн хэсгийн хороонд давхардаж байгаа эсэх нь бол тухайн үед нягтлан шалгах болон тэмдэглэгээ хийх боломжгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр энийг сайжруулсан ийм заалт орж байгаа шүү гэдгийг бас протоколд тэмдэглүүлье.

Дээрээс нь энэ шугам сүлжээтэй холбоотой өчигдөр Тогтохсүрэн даргын, ажлын хэсгийн даргын өрөөнд бид нар бас ярилцсан. Сонгуулийн ерөнхий хороо, Цахим харилцаа холбооны газартай Улсын бүртгэлийн газартай ярилцсан. Энэ хүрээндээ ирэх 7 хоногийн ажлын хэсгийн хуралдааны өмнө энэ дээр шийдлүүдээ гаргаж ирнэ гэж ингэж тохиролцсон. Тодорхой редакц хийнэ гэж ингэж тохиролцсон байгаа шүү гэдгийг хэлье. Ер нь бол би протоколд оруулж байгаа юм. Тэгээд ер нь бол энэ сонгууль дээр нөгөө царцаа гэж ярьдаг хүмүүсийг л таслан зогсооё. Сонгуулиа шударга болгоё л гэсэн ийм зорилт энэ 2 заалт дотор орж байгаа шүү гэдгийг тэмдэглээд протоколд үлдээе ээ.

Г.Занданшатар: Ингээд онлайн болчихоор, тэгэхээр Тогтохсүрэн дарга аа, түрүүний 63 дугаар санал урьдчилан

өгөх асуудал байна шүү дээ. Энэ санал ингээд хэрэгжчихээр тэр царцаа энэ тэр чинь байхгүй болчихоор урьдчилсан санал өгөхөд ямар нэгэн будилаан 2008 онд хар машингүй байх үед тийм будилаан үүсэж байсан бол одоо электрон төхөөрөмжийн үед онлайнд болчих юм бол энэ ямар ч эрсдэлгүй болно шүү дээ. Олон улсад бол хүнийг сонгох эрх гэж үзээд, Америкт бүүр 30 хувь нь урьдчилж саналаа өгч байсан. Солонгост 5 хоногийн өмнө саналаа өгдөг. Тэгэхээр өвчтэй, зовлонтой янз бүрийн шалтгаанаар хүн урьдчилсан санал өгөх юм хаагдахаар яах вэ сонгох эрхэд халдлаа л гэсэн асуудал сүүлд үүсэхгүй. Энийг Туваан гишүүнтэй адилхан протоколд тэмдэглүүлж байна. Яагаад гэхээр Туваан гишүүний саяын саналаар бол тэр царцаа энэ тэр бүгд хаагдчихаж байгаа байхгүй юу. Энэ чинь онлайн тэмдэглэгээ нэгдсэн санд бүртгэгдсэн сонгогчид чинь хурууны хээгээрээ санал өгөхөөр 2008 оных шиг тийм юм гарахгүй шүү дээ. 2008 онд хурууны хээгээрээ санал өгдөггүй байсан учраас тэр хурууны хээ хувириггүй өөр өөр газар энд тэнд очоод санал өгөөд урьдчилж санал өгсөн хүн дахин санал өгсөн тэр эрсдэл гарахгүй л дээ. Тэгээд энийгээ бол бас сайн харгалзан үзэх л ёстой юм шиг байгаа юм.

Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт. 73,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26. Төслийн 1 дүгээр зүйлийн 44 дэх заалтын 67¹ дугаар зүйлийн 67¹.4, 67¹.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“67¹.4.Энэ зүйлд өөрөөр заагаагүй бол гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажиллагаанд энэ хуулийн 65, 66 дугаар зүйлд заасан журмыг баримтална.”

“67¹.6.Гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн энэ хуулийн 59.4.2-т заасан хэсэгт саналаа өгнө.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэр асуудал үүссэн учраас энэ хар машиныг чинь авч хэрэглэсэн байхгүй юу. Нэг шалтгаан нь. Ингээд саналыг 80,4 хувиар дэмжлээ.

27.Төслийн 1 дүгээр зүйлийн 45 дахь заалт буюу 67 дугаар зүйлийн 67.17 дахь хэсгийн “төв комисст” гэсний дараа “гадаадад санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Төслийн 1 дүгээр зүйлийн 48 дахь заалт буюу 71 дүгээр зүйлийн 71.11 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 82,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Төслийн 1 дүгээр зүйлийн 49 дэх заалт буюу 72¹ дугаар зүйлийн 72¹.4 дэх хэсгийн “дипломат төлөөлөгчийн газарт” гэснийг “салбар комисст” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Төслийн 1 дүгээр зүйлийн 50 дахь заалтын 74.1 дэх хэсэг, 74.1.3, 74.1.4 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 82,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Төслийн 1 дүгээр зүйлийн 51 дэх заалт буюу 74 дүгээр зүйлийн 74.2.2 дахь заалтын “3” гэснийг “4” гэж өөрчилж, төслийн 1 дүгээр зүйлийн 52 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Төслийн 1 дүгээр зүйлийн 53 дахь заалт буюу 74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсгийн 74.3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“74.3.2.Энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвслийн авсан саналын хувь болон нийт нам, эвсэлд өгсөн хүчинтэй саналын хувь хоорондын зөрүүг энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвсэлд тэнцүү хэмжээгээр хуваан нам, эвсэл тус бүрийн авсан саналын хувь дээр нэмж тооцно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Үлдэгдлийг хуваах аргыг дээрээс нь үү, доороос нь уу гэдэг.

33.Төслийн 1 дүгээр зүйлийн 53 дахь заалт буюу 74 дүгээр зүйлийн 74.3.3 дахь заалтын “38-д” гэснийг “48-д” гэж, 74.3.4 дэх заалтын “38-д” гэснийг “48-д” гэж тус тус өөрчилж, төслийн 1 дүгээр зүйлийн 54 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Хуулийг тунхаглалын шинж чанартай биш механизм санкцуудыг нь л сайн ажилга. 71,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34.Төслийн 1 дүгээр зүйлийн 53 дахь заалт буюу 74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 74.3.5 дахь заалт нэмж, 74.3.4 дэх заалтын тайлбарыг хасах.

“74.3.5.энэ хуулийн 74 дүгээр зүйлийн 74.3.4-т заасны дагуу нэг суудалд ногдох саналын хувьд хуваахдаа бутархай нарийвчлалтай гаргаж, эхний ээлжид бүхэл хэсэгт нь тэнцэх суудлыг хуваарилах, хэрэв хуваарилагдаагүй суудал үлдвэл хамгийн их үлдэгдэлтэйгээс нь эхлэн нэг нэгээр суудлыг нам, эвсэлд нэмж хуваарилах зарчмаар бүх суудлыг хуваарилж дуусгана.

35.Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1/4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг:

4.2.Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман

гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ дээр ажлын хэсэг бичээгүй, үргэлжлүүлээд биччихсэн юм байна. 34 дүгээр саналаар тайлбар гэдгийг дараагаар санал хураалт явуулъя. Энийг салгахгүй бол. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. 78,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35.Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1/4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг:

4.2.Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 76,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

37.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 14 дүгээр зүйлийн 14.12 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 82,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

38.Төслийн 2 дугаар зүйлийн 8, 9 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8/30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг:

“30.1.Нам, эвсэл нь 78 хүртэл хүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойрогт, 48 хүртэл хүнийг нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаар тус тус нэр дэвшүүлнэ.” Санал гаргасан ажлын

хэсэг. Санал хураалт. 73,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

39.Төслийн 2 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1 дүгээр зүйлд нэмэх:

“30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг:

30.3.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Дашидондогийн Ганбат, Баттөмөрийн Энхбаяр гишүүн дээр тасаллаа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлнэ ээ.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг Их Хурлаар хэлэлцэж байхад би бас тодорхой санал хэлж байсан юм аа. Энэ тогтолцоо тоотой холбоотой өөрчлөлт орох гэж байна. Үүнтэй холбогдуулаад Улсын Их Хурлын гишүүдийн тоо нэмэгдэж байгаатай холбоотойгоор төсвийн зардал нэмэгдэхгүй байхтай холбоотой асуудал ярьж байсан. Энийг ярьж эцэслэж шийдсэн ийм зүйл байна уу. Улсын Их Хурлын гишүүдийг тэр манай Хэнтий аймгаас сонгогдсон гишүүд бол дундаа 1 ажлын албатай, төсөв зардал орон тоогоо хэмнээд явж байгаа ийм сайн жишиг байгаа шүү дээ. 76 тойрогт бол би байхгүй байх. Энэ их сайн жишиг байгаа юм. Тэгэхээр зэрэг одоо шинэ зохион байгуулалтаар яг ингэж магадгүй бүсээс нь зүүн 3 аймгаас сонгогдсон Их Хурлын гишүүд дундаа нэгдсэн ажлын албатай, байр, өрөө тасалгааны хувьд бол гишүүд 1 өрөөндөө хамт сууж байж болно. Арай томоохон өрөөнд 3, 4-өөр нь суулгаад, бага шиг жижиг өрөөнд бол хоёуланг нь өөд өөдөөс нь харуулаад суулгадаг ийм нэлээн сайн өөрчлөлт оруулах хэрэгтэй гэж. Нөгөө Иүм бол энэ оруулж байгаа заалттай холбоотой энэ их зөв зүйтэй

заалт байна. Улсын Их Хуралд чинь бол ер нь 1990 оноос хойш ингээд Монголд томоохон үйл ажиллагаа явуулж байгаа нүүс компанийн нөхдүүд орж ирээд шивээлээд суучихсан. Тэгээд энэ хүмүүс маань уг нь бизнесийн салбарт ажиллаж байсан хүмүүс энэ мэдлэг чадвар туршлагаа төрийн бодлогод тусах чиглэлээр ажиллах ёстой юм л даа. Тэгэхдээ яах вэ ажиллаж байсан хүмүүсийг би үгүйсгэж байгаа юм биш. Ер нь ихэнх нь бол өөрсдийнхөө бизнесийг хамгаалах өргөжүүлэх чиглэлээр энэ 30 жил ажилласан. Энийг чинь нуух юм байхгүй. Тэгээд муугийн нөлөө олондоо гэж энд орж ирж хөрөнгө санхүү хөөцөлдсөн энэ хүмүүсийн тусгал чинь бол хажууд нь сууж байгаа хүмүүст их айхтар нөлөөлсөн. Ингээд төрд байж байгаад үндэслэлгүйгээр хөрөнгөжих, баяжих, хэрэглээ их том хэрэглээтэй байх ийм зүйл рүү их шилжсэн. Тийм учраас бол энийг нэг их ойлгомжтой болгож, цэгцэлж өгөхгүй бол болохгүй байна гэж. Би энд юм хэлээд байх юм. Булгантуяа а. Үгүй, мөн хэцүү юм аа. Тэгээд л ерөөсөө ингээд л Их Хуралд жишээлэх юм дандаа эмэгтэйчүүд ороод ирэх юм бол бүгдийг нь сайхан болгоно гэсэн. Одоо хаана байна даа нөхдүүд минь. Дандаа шинэ Их Хурлын гишүүд сонгогдох юм хачин юм болно гэсэн бас хаана байна. Олон сонгогдсон хүмүүс их мундаг байгаа гэдэг чинь бас л хэцүү асуудал. Тийм биз дээ. Олон сонгогдсон хүмүүс өөрийнхөө үр хүүхдүүдээс эхлүүлээд шадар шахам улсуудаа бүгдийг нь төрд шивээлүүлээд удам угсаа залгамжлаад суулгачихсан. Тэгээд ийм юмнуудаа нэг цэгцлэх хэрэгтэй. Би бол ерөөсөө энд олон жил сууж ажиллахдаа би нэг л юм хэлж байгаа шүү дээ. Ямарваа нэгэн хэрэг асуудалд орсон хүн байх юм бол энийгээ л бүр тодорхой тэр шалгадаг газраар нь шалгуулаад, баталгаа нотолгоотой тайлбар өгөөд ингээд байж байхгүй бол та нар байж байгаа хүмүүс тийм байгаа биз дээ. Хэн нэгэн цөөхөн хэдэн хүмүүсээс болоод л ингээд л хулгайч, луйварчин болдоггүй, бүтдэггүй ийм нэр цол зүүгээд ингээд

сууж байна гэдэг чинь нүүрээ улалзуулаад, нуруугаа хотолзуулаад сууж байна гэдэг чинь тийм таатай ажил биш шүү дээ. Тэгэхээр энийг нь цэгцлээд бүгдээрээ ямар нэгэн асуудалд орох юм бол нам нь шаарддаг болчихсон. Одоо бид нар яг хажуудаа байж байгаа хүмүүсээ бие биеэ хэлэх хэрэгтэй. Үнэхээр буруу зөрүү томилгоонд оролцчихсон бол тэрийгээ өөрийнхөө эхнэрийг, нөхрийг.../минут дуусав/

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Би 30 дугаар зүйл дээр ярья гэж бодож байгаа юм. Ингээд бас нэг олон ургалч үзэл, олон намын систем гээд ингээд байгаа л даа. Тэгээд нам нам болгон өөр өөр ялгаатай шүү дээ энэ чинь. Дан эмэгтэйчүүдийн нам ч байж болно. Эрэгтэйчүүдийн нам ч байж болно. Тэгээд бас тухайн жагсаалтыг яаж хийх вэ гэдэг чинь намын бодлого байх л даа. Тэгээд энэ юм руу нэг их оролцооморгүй байгаа юм шиг байгаа юм. Намууд үүгээрээ ялгарах ёстой. Нөгөө талаар бол аль нэг хүйс 40-өөс багагүй байна гэдгийг бол би дэмжиж байгаа юм аа. Энэ бол бас дэвшилттэй, олон жил 70-аад жил ингээд социализмд явчихсан улс орнуудад бас зүйтэй ийм зүйл заалт юм шиг байгаа юм. 30-аас доошгүй гээд ингэж байхгүй бол бас нэг хүйс нь хүнд ихээр дарлагдсан ч байдаг юм уу ийм ойлголтууд яваад байдаг. Энийг засаж залруулах хэрэгтэй гэж үзэж байна. Нөгөө талаар бол энэ 30.5-д бол нам эвсэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1, 1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг үндэслэн нэр дэвшүүлж байгаа байхгүй юу. Энэ чинь бол яг ингээд намуудад ингээд тулгаад байгаа. Энэ бол намын дотоод асуудал шүү дээ. Ямар хүмүүсийг дэвшүүлэх вэ, яах вэ гэдэг юмаа нам нь өөрөө мэдээд дан нэг хүйсийнх ч байж болно. Гэхдээ аль болохоор тэгж дэвшүүлэхгүй л дээ мэдээжийн хэрэг. Тэр нам бол тийм юм байхгүй. Тэгэхээр Их Хурлын дарга та бас ингээд чиглэл өгөөд, бас Үндсэн хууль

энэ юманд нийцэж байна уу, үгүй юу гэх мэтчилний. Ингэж тулгаж болж байна уу, үгүй юу гэсэн ийм зүйл заалт байна. Энийг бид нар бас үзэж харж бүх юманд нийцүүлэх ийм шаардлагатай байна.

Үүнээс гадна өөр олон янзын хүйс байна уу, ямар байна. Одоо энэ чинь дэлхий ертөнц өөр болчихоод байна шүү дээ. Бүгдийг л тэр 20 дугаар зуун, 19 дүгээр зууны тэр бурангуй үеэр үзэж болохгүй. Хүмүүс чинь шал өөр юм ярьдаг болчихсон. Өөр бодолтой болчихсон ийм залуучууд, ийм нийгэм, ийм юм байна. Тэгэхээр энийг бид нар харж үзэх ёстой гэж бодож байна.

Нөгөө талаар сая Бат-Эрдэнэ гишүүний хэлээд байгаатай бас санал нэг байгаа юм аа. Бас зовлон жаргал үзчихсэн, тойргоос нэг удаа шүүлтүүрээр гарчихсан ийм хүмүүс тэр нам эвсэлдээ нэр цэвэр нь ингээд ороод явах нь жагсаалт нь зөв байх. Гэхдээ бас нөгөө талаараа олон жилээр сайд хийчихсэн. 5, 6 удаа сонгогдохсон ийм хүмүүсээ бас оруулаад явуулаад байх нь ямар байна. Тийм ээ. Тэр бол намын дотоод асуудал байх. Тэр аль аль талаа бол бодолцож ингэж явах ёстой байх. Тэгээд намын дотоод асуудалд оролцсон ингээд тулгасан ийм юмыг хийж болохгүй ээ. Тухайлбал олон намын системтэй болно гэж байгаа. Олон нам орж ирнэ гэж бид нар үзээд байгаа. Тэгээд тэр орж ирэх намууд нь ийм олон салаавчлах хүн байгаа ч юм уу, үгүй ч юм уу. Тэгээд та нар ингэж салаавчлаагүй байна гээд энэ заалтаараа тэр намыг хасах ийм боломж бүрдчихэж байгаа байхгүй юу. Ийм зүйлийг хуульчилдаггүй л дээ. Тухайн намын бодлого энэ бүх юманд нь нийцүүлээд ингэж орхидог. Тэгэхээр хүний эрхийг олон ургалч үзлийг, олон намын систем энэ бүх юмыг илт зөрччихсөн ийм зүйл заалт бас ингээд дунд нь яваад байна гэсэн ийм бодол байгаа надад. Энэтэй тэгээд хэр нийцэж байгаа юм. Нийцэж барихгүй ажлын хэсгийн хүмүүс байдаг юм бол бас надад хариулна биз. Ийм ийм учраас нийцэхгүй

байна гэж. Би бол бүх юманд бол нийцэхгүй энэ заалт энэ дотор цохиж.../минут дуусав/

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Би 39 дэх санал буюу хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт орж байгаа саналыг дэмжиж үг хэлж байгаа юм. Энэ ямар заалт орох гэж байна вэ гэхээр нам эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглоно гэдэг нэн тодорхой заалт оруулах гэж байгаа юм. Ингэхгүй жишээлбэл сая өнгөрсөн 2020 оны сонгуульд зарим намууд тин пангүй их хэдэн 100 саяар нь горилогчдоос мөнгө авчихсан. Тэгээд нөгөө намын дарга нь мөнгийг нь үрэн таран хийчихсэн. Мөнгийг нь авчхаад нэр дэвшүүлсэнгүй гээд бөөн хүмүүс гомдолтой. Нөгөө Мөнх-Эрдэнэ чинь би хэдийг өгсөн ч гэдэг билээ. Эрдэнэ даргад хэдийг өгсөн гэж яриад л ингээд л байсан шүү дээ. Тэгээд мөнгөө авмаар байна гээд л яваад л. Энэ чинь бүр тийм сонин юм байна лээ. Тэгээд нэгэнт төрийг тунгалаг болгох гэж байгаа юм бол түүнийг нэр дэвшүүлж байгаа намын нэр дэвшилтийг бас тунгалаг болгох ийм шаардлагын үүднээс бол энэ заалт орох нь зөв зүйтэй юм гэж.

Энэ заалттай би протоколд юу хэлэх гэж байна вэ гэхээр сая бид нар сонгуулийн жилийн 3 сарын 1-ээс намууд сонгуулийн хандивын дансаа нээнэ гэдэг заалтыг биччихсэн юм. Тэгэхээр намын хандивын данс бол 3 сарын 1-ээс нээлттэй ингээд ажиллаад явж байна. Тэр заалттай бол энэ харшлахгүй шүү гэдэг зүйлийг би бас протоколд хэлэх гэж байгаа юм. Нөгөө хандивыг хориглож байгаа зүйл бол биш шүү. Хандивыг. Энэ бол яг нэр дэвшүүлэх гэж байгаа тэр горилогч хүмүүсээс мөнгө үйлчилгээ авахыг хориглож байгаа заалт шүү. Тэгэхгүй бол энэ заалтыг бариад нөгөө

улс төрийн намын 3 сарын 1-ээс нээгдсэн хандивын данс ажиллахгүй, энэ хоорондоо зөрчилдөж байна гээд дараа нь бас хууль хэрэглээ дээр өөр өөрөөр тайлбарлаад байх асуудал гарах вий гэж үзэж зориуд бас ажлын хэсгийн гишүүний хувьд протоколд бас ингэж ойлгож энэ заалтыг оруулж байгаа шүү гэдгийг бас протоколд тэмдэглүүлье.

Г.Занданишатар: Тэр чинь тухайн заалт дээрээ л яригдана. Яг холбоотой заалт биш. Санал хураалт явуулъя. Энэ тэгэхдээ тэр агуулгаа тодруулахгүй бол их л найруулгыг нь сонин л бичсэн байна. Гүйцээн боловсруулчихаар тэгээд их чухал заалт дээр гүйцээсэн юм шиг болох гээд. Ажлын хэсэг дээрээ ярь. Санал хураалт. Гишүүд. Нямаагийн Энхболд дарга ажлын хэсэг дээрээ ярья гэж байсан. 65,9, хувийн саналаар санал дэмжигдлээ.

40.Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг:

42.1.Тойрог тус бүрд нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбартай байна. Сум, дүүргийн Засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос батлагдсан журмын дагуу нэгдсэн самбарыг бэлтгэж, байршуулах ажлыг зохион байгуулна. Нэгдсэн самбар дараах шаардлагыг хангасан байна:

42.1.1.энэ хуулийн 60 дугаар зүйлд заасныг үндэслэн зурагт хуудсыг байрлуулах дарааллыг тогтооно.

42.1.2.сонгуулийн сурталчилгааны нэгдсэн самбарыг үнэ төлбөргүй ашиглуулна.

42.1.3.нэгдсэн самбарт байрлуулах нэр дэвшигчийн зурагт хуудас нь нэг хэвлэлийн хуудасны дөрөвний нэг хэмжээтэй байна.

42.1.4.сонгогчийн тоонд үндэслэн суманд хоёр хүртэл, хороонд гурав хүртэл нэгдсэн самбар байрлуулна. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя. 73,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төв аймгаас сонгогдсон Цэвэгдоржийн Туваан гишүүн суудалдаа суугаарай.

41.Төслийн 2 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу 48.9 дэх хэсгийн “орохыг” гэснийг “орох, нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигч хуулах байр ажиллуулахыг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

42.Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“50.2.Сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох аргачлал нь сонгуулийн зардлыг бууруулахад чиглэх бөгөөд сонгуулийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байриил, өрхийн болон сонгогчийн тоо, энэ хуульд заасан бусад шаардлагад үндэслэнэ. Аргачлалыг төрийн аудитын дээд байгууллагын саналаар Сонгуулийн ерөнхий хороо батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. 27 гишүүн дэмжсэн.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогтын урилгаар Ховд аймгийн сумдын болон багуудын Засаг дарга, Тамгын газрын дарга нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд төрийнх нь их ажилд нь өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга Улсын Их Хурлын чуулганы танхимаас сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглоно гэдгийг сануулаадах.

43.Төслийн 2 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу 51 дүгээр зүйлийн 51.3 дахь

хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 68,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

44.Төслийн 2 дугаар зүйлийн 14 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14/65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг:

65.6.Санал авах байранд ажиллаж байгаа итгэмжлэгдсэн ажилтан сонгогчийн гарын хурууны хээг сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбартай тулгаж, энэ хуулийн 66.5-д заасан бэхэн тэмдэглэгээ хийгдсэн эсэхийг нягтлан, зөрчилгүй бол сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Ховдынхон байж байгаарай. 70,7 хувийн саналаар санал дэмжигдсэн учраас Хатанбаатарын Сэлмийн эрч шиг хурц уулстай, харц олзвойн нүдний харц чинь тод нууртай гэж байгаа юм. Үхрийн буурь шиг алга хэр нь ээ, эвийн сэтгэлтэй ард нь сайхан. Ховдчууддаа тэгээд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс багийн дарга нартайгаа дамжуулаад нийт ард түмэнд нь Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт гишүүний чинь нэрийн өмнөөс ингээд та бүхэндээ төрийн анхан шатны ажил үйлсэд нь ард түмэнтэйгээ шууд холбогдож ажилладаг, ард түмнийхээ ажил, амьдралд нь ордог багийн Засаг даргын ажил бол хамгийн чухал ажил. Тэгээд та бүхний ажилд хамгийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. Төр ард түмнээ холбох ажилд нь өндрөөс өндөр амжилт хүсэн ерөөе. Тэгээд маргаашийнхаа семинарт идэвхтэй оролцоорой. Тэгээд багийн дарга нартаа энэ завшааныг ашиглаад өнөөдөр төсвийн төсөл өргөн баригдсан. Та бүхний цалин бараг 40 хувь нэмэгдэж, 1 сая 200 мянган төгрөг болж байгаа. 1,2 сая төгрөг болохоор Улсын Их Хурал дээр гишүүд тойрогтоо ажилласны үр дүнд энэ өөрчлөлт

хийгдэж байгаа шүү. Хамгийн бага цалинтай дор цалинтай байгаа учраас ажлаа сайн хийх хэрэгтэй шүү. Та нар харин. Дандаа гишүүдийнхээ чихнээс хонх уяж байна. Гишүүд ард түмнийг холбож ажиллацгаа. Амжилт хүсье. Одоо явж болно.

45.Төслийн 2 дугаар зүйлийн 15 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“66.2.Сонгогч энэ хуулийн 59.4.2-т заасан хэсэгт нэг нам, эвсэлд саналаа өгнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Бямбацогт дарга сая жаахан дутуу хэлчхэж уучлаарай. Хатанбаатарын сэлмийн эр шиг хурц уулстай, Харц Аюушийн зоригийн илч шиг халуун нартай, Баатар зоригт Олзвойн нүд шиг тод нууртай, Баруун түмний бахархал болсон Ховд нутаг гэдгийг дутуу хэлчихсэн байна. Яах вэ энэ чинь ингээд тэмдэглээд хэлчихье. Энэ хүний шүлгийг бичсэн хүн нь Гайтав гээд чүдэнзний хайрцаг дээр бичсэн юм гэнэ лээ. Ховдын ойгоор. Өвөрхангайн Гайтав.

Баян-Өлгий Аубакир гишүүн алга байна. Би Баян-Өлгийгөөс нэр дэвших гэж байгаа юм гэж ярьж байна лээ.

46.Төслийн 2 дугаар зүйлийн 16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“66.5. Сонгогч саналаа тэмдэглэсэн саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийсний дараа тухайн сонгогч саналаа өгснийг илэрхийлэх бэхэн тэмдэглэгээг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу хийнэ. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

47.Төслийн 3 дугаар зүйлийн “5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “иргэн”

гэсний дараа “гадаад улсад суугаа Монгол Улсын иргэн” гэж,” гэснийг, “20.1 дэх хэсгийн “шийдвэрлэх ажлыг” гэсний дараа “Сонгуулийн ерөнхий хорооны хяналт дор” гэж, “зохион байгуулж,” гэсний дараа “энэ хуульд заасан журмын хүрээнд” гэж, 20.5 дахь хэсгийн “холбогдох мэдээлэлтэй” гэсний дараа “болон байнга оршин суугаа хаягт бүртгэлтэй бусад сонгогчдын мэдээлэлтэй” гэж, 20.13 дахь хэсгийн “цахим хэлбэрээр” гэсний өмнө “санал авах өдрөөс 5 хоногийн өмнө 2 удаа” гэж,” гэснийг, “20.15 дахь хэсгийн “жагсаалтыг” гэсний дараа “хуульд зааснаас бусад тохиолдолд” гэж,” гэснийг, ““жагсаалт дахь” гэсний дараа “энэ хуулийн 20.5 дахь хэсэгт заасан” гэж, “буруу бүртгэгдсэн,” гэсний дараа “байнга оршин суугаа газрын хаягт нь бүртгэлгүй сонгогч нэмэгдсэн зэрэг асуудлаар” гэж,” гэснийг, “, мөн хэсгийн “нэвтрүүлнэ.” гэсний дараа “Сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний хуваарь, цагийг тэнцүү хэмжээнд тогтооно.” гэж,” гэснийг, “67 дугаар зүйлийн 67.14 дэх хэсэгт “67.13” гэсний өмнө “67.1” гэж,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 79,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

48.Төслийн 3 дугаар зүйлийн “харилцах” гэсний өмнө “хороотой” гэж, “46 дугаар зүйлийн” гэсний өмнө “40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “Нэр дэвшигч нь” гэсний өмнө “Сонгуулийн тойрогт” гэж, “54 дүгээр зүйлийн” гэсний өмнө “51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийн “эвсэл болон” гэсний дараа “сонгуулийн тойрогт” гэж, ” гэж, “54 дүгээр зүйлийн 54.2 дахь” гэсний дараа “хэсгийн “эсхүл” гэсний дараа “сонгуулийн тойрогт” гэж,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн карт сугалж болохгүй. Карт сугалбал ёс зүйн зөрчилд тооцохоор ёс зүйн дүрэмд орсон шүү дээ. 76,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

49.Төслийн 3 дугаар зүйлийн “14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “хороо” гэсний дараа” гэснийг “мөн зүйлийн 10.4 дэх хэсгийн “захиргааны байгууллага” гэсний дараа “, сум, дүүрэг” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “болон хэсгийн хороо” гэсний дараа” гэж, “50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсгийн” гэснийг “50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсгийн” гэж, “тойрогт болон жагсаалтаар” гэснийг “тойрогт” гэж, “тоо нь саналаа өгсөн нийт сонгогчийн” гэснийг “тоо нь тухайн хэсгийн хорооны хүлээн авсан саналын хуудасны” гэж, “, нам, эвсэл тэдгээрээс жагсаалтаар нэр дэвшигчийн санал тэмдэглэх хэсэгт нэгээс илүү нам, эвсэл болон жагсаалтаар нэр дэвшигчид нэгээс илүү санал тэмдэглэсэн” гэснийг “, нам, эвслийн санал тэмдэглэх хэсэгт нэгээс илүү нам, эвсэлд санал тэмдэглэсэн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 82,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

50.Төслийн 4 дүгээр зүйлийн “11 дүгээр зүйлийн” гэсний өмнө “10.1.14 дэх заалтын “46, 47, 48.9-д” гэснийг “46, 47 дугаар зүйл, 48.9, 48.10-д” гэж,” гэж, “13 дугаар зүйлийн” гэсний дараа “13.1 дэх хэсгийн “нутаг дэвсгэр, төвийг” гэснийг “нутаг дэвсгэрийг” гэж, мөн зүйлийн” гэж, “21 дүгээр зүйлийн” гэсний өмнө “20.15 дахь хэсгийн “хувилж олируулах,” гэснийг “энэ хуульд зааснаас бусад тохиолдолд хэвлэж” гэж,” гэж, “21.1 дэх хэсгийн” гэсний дараа ““нутаг дэвсгэр, төвийг” гэснийг “нутаг дэвсгэрийг” гэж,” гэж, “39 дүгээр зүйлийн” гэсний өмнө “38 дугаар зүйлийн 38.7, 38.8, 38.12 дахь хэсгийн “26.3.6, 26.4.6” гэснийг “38.13” гэж,” гэж, “46.4 дэх хэсгийн” гэсний өмнө “зүйлийн 46.2 дахь хэсгийн “тогтоосон” гэснийг “баталсан” гэж,” “Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран” гэсний өмнө “журмыг” гэж, “Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн” гэсний өмнө “, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах

журмыг” гэж, “60 дугаар зүйлийн” гэсний өмнө “58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсгийн “26.3.6, 26.4.6, 38.5” гэснийг “38.5, 38.13” гэж,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 82,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

51.Төслийн 4 дүгээр зүйлийн “санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө” гэснийг “цахим хэлбэрээр нэг удаа” гэж, “нам, эвсэл бүртгүүлснээс хойш ажлын 3 хоногт” гэснийг “болон санал авах өдрөөс 3 хоногийн өмнө тус тус цахим хэлбэрээр” гэж, “32.11 дэх хэсгийн “тав” гэснийг “долоо”” гэснийг “32.11 дэх хэсгийн “хүлээн авснаас хойш тав” гэснийг “хүлээн авах хугацаа дууссанаас хойш долоо”” гэж, “хугацаа” гэснийг “хуваарь, цагийг” гэж, “тэдгээрээс тойрогт болон жагсаалтаар нэр дэвшигч, бие даан” гэснийг “тэдгээрээс тойрогт нэр дэвшигч, бие даан” гэж тус тус өөрчлөх.санал гаргасан. Ажлын хэсэг санал хураалт 76,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгээд 52, 53 2-ыг гүйцээн боловсруулах чиглэл өгье. Ер нь боловсруулалт дээр байна шүү дээ. Цэг, таслал өөрчлөгдөхөд л хуулийн үг, үзэл санаа өөрчлөгдөж байдаг шүү дээ. Тэгээд цэг, таслал юунууд дээр их анхаарахгүй бол бас яг найруулгын хувьд ч гэсэн агуулгын хувьд ч гэсэн тийм байгаад байна лээ. 52, 53-ыг гүйцээн боловсруулах чиглэл өгье.

Ер нь хууль зүйн техникийнх нь хувьд Байнгын хороо шахуу байсан байх. Тэгэхдээ сайн хараарай.

54.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 28 гишүүн дэмжиж, 71,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал уу. Өнөөдөр Аубакир, Буланы Бейсен, Хавдисламын Баделхан 3 гишүүн нь хаачсан байна. Сонгуулийн хууль дээр цөөнх бол заавал байх ёстой юм байгаа. Үгийг нь уг нь сонсьё гэж бодсон. Тэмдэглүүлж хэллээ шүү.

Найруулгын санал:

55.Төслийн 1 дүгээр зүйлийн 43 дахь заалт буюу 67¹ дугаар зүйлийн дугаарыг 66¹ болгож, 3 дугаар зүйлийн “10.4 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “, улсын хил хамгаалах байгууллага, батлан хамгаалах байгууллага, архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж,” гэснийг “10.4 дэх хэсгийн “дээд байгууллага” гэсний дараа “, батлан хамгаалах болон архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын хил хамгаалах” гэж,” гэж, “дагалдах хэрэглэл” гэснийг “дагалдах хэрэгсэл,” гэж, 5 дугаар зүйлийн “, 20.6.8” гэснийг “, 20.6.7, 20.6.8” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн “холбоотой өөрчлөлтийн” гэсний дараа “талаар” гэж, 7 дугаар зүйлийн “48 дугаар зүйлийн” гэсний өмнө “29 дүгээр зүйлийн 29.7, 29.8 дахь хэсгийн дугаарыг “29.8, 29.9” гэж,” гэж, мөн зүйлийн “48 дугаар зүйлийн” гэсний өмнө “30 дугаар зүйлийн 30.3, 30.4 дэх хэсгийн дугаарыг “30.4, 30.5” гэж,” гэж нэмж, 7 дугаар зүйлийн “12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийн дугаарыг 12.4 гэж” гэснийг, “71 дүгээр зүйлийн “71.11, 71.12, 71.13, 71.14, 71.15, 71.16, 71.17, 71.18” дахь хэсгийн дугаарыг ““71.12, 71.13, 71.14, 71.15, 71.16, 71.17, 71.18, 71.19” гэж,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулна. Өвөрхайнгай аймгаас сонгогдсон Содномын Чинзориг гишүүн суудалдаа сууя. Санал хураалт явуулах гэж байна. Тусгай хяналтын дэд хорооны дарга Сүхбаатарын Батболд орж ирлээ. Санал хураалт явуулъя. Санал хураалт. 80 гишүүн дэмжиж, саяын найруулгын санал дэмжигдлээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй саналаар санал хураалт явуулна.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогтын урилгаар Ховд аймгийн сумдын болон багуудын Засаг дарга, Тамгын газрын дарга нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Тэгээд амлалчихсан юм хэлэхээс. Тэгээд эрхэм хүндэт төрийн анхан шатын нэгжийн дарга баруун түмний бахархал болсон Ховд аймгийн анхан шатын нэгж баг, сумын Засаг дарга та бүхэндээ Хатанбаатарын сэлмийн ирц шиг хурц уулстай, Харц Аюушийн зоригийн илч шиг халуун нартай, Баатар зоригт Олзвойн нүдний харц шиг тод нууртай, Баруун түмний бахархал болсон Ховд нутгийн та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс үхрийн бөөр шиг алаг хэр нь ээ, эвийн сэтгэлтэй ард түмэн та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн өмнөөс баярын мэндчилгээ өргөн дэвшүүлье ээ. Сайн сайхныг хүсэн ерөөе. Олон жилийн өмнө л Бямбацогт гишүүнээс сонсож байсан юм. Зарим нь алдаатай хэлсэн бол уучлаарай. Уржнангийн цаад жил Ховд явахдаа л. Үхрийн бөөр шиг алаг хэр нь ихрийн сэтгэлтэй ард нь сайхан. П

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 4 дүгээр зүйлийн “30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн” гэсний дараах ““20-оос” гэснийг “30-аас” гэж” гэснийг ““20-оос” гэснийг “40-өөс” гэж” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Амгалангийн Адьяасүрэн, Тогмидын Доржханд, Салдангийн Одонтуяа, Мөнхөөгийн Оюунчимэг, Даваажанцаны Сарангэрэл, Жамъянхорлоогийн Сүхбаатар. Үг хэлэх Жамъянхорлоогийн Сүхбаатар, Даваажанцаны Сарангэрэл, Салдангийн Одонтуяа гишүүдээр тасаллаа.

Хүрэлбаатарын Булгантуяа гишүүнээр тасаллаа.

Та бүхэн маань сонгуулийн хуулийг хэлэлцэх их ачаалал, стресстэй байгаа болохоор шүлэг уншиж өгч сэрээж албан бус байдлаар хөгжсөөж байгаа шүү. Түүнээс маргааш төсвийн тодотгол хэлэлцэнэ. Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн, лобби бүлгийн дарга.

Ж.Сүхбаатар: Яагаад 40 хувь гээд байгаа юм бэ гэхээр түрүүчийн бол хэлснийг бол нөгөө цухас дурдсан. Яагаад гэвэл Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 2011 онд батлагдсан 40/60 гэдэг харьцаа явсан. Дараа нь 2015 онд НҮБ тогтвортой хөгжлийн төлөө зорилгыг гаргасан. Манайх 2016 онд нэгдэж орсон. 193 улс байгаа байх. НҮБ-ын тийм ээ. Тэгэхээр энэ бол юу гэхээр жендерийн асуудал бол эмэгтэйчүүдийн ганцхан асуудал биш. Ер нь жендерийн эрх тэгш байдлын асуудал бол эрхийн асуудал гэхээсээ гадна тогтвортой хөгжлийг хурдасгагч ийм хүчин зүйл байгаа юм гэдэг энэ агуулга байгаа юм аа. Би тэгэхдээ энд нэг юм хэлье. Манай гишүүд ингээд нийт нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна гэхээр нөгөө хэрвээ 40 хувийг дэмжихгүй, 30 хувь байна гэхээр эмэгтэйчүүд бодит байдал дээр 30 хувь хүрэхгүй болчихоод байгаа юм. Жишээлбэл жагсаалтын хойд талын хэсэг дээр баахан эмэгтэй хүн бичигдээд ингээд явчих юм бол одоогийнхоо байдлаас сайжирсан биш болчих гээд байгаа юм. Хэрвээ энэ 40 хувь нь дэмжигдэхгүй гэхэд сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн ядаж 30-аас доошгүй хувь нь гэж байж бодитой сонсогдохгүй байхгүй юу. Тэр нэгийг харьцах 1 гээд нэрийн жагсаалт дээр хадгалаад, тэгээд тойрогт нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь, эсвэл 40-өөс доошгүй гэж нийт нэр дэвшигчдийн байж байж нөгөө тэр 30 хувийн чанар чинь бол ерөнхийдөө бодит үр дүнгээ өгөх гээд байгаа ийм л юм байгаа юм. Тэгээд энэ болгоныг зүгээр яах вэ бодож болгоогоод бүр болохгүй

40-өөс доошгүй болгохын чинь эсрэг хэрвээ өглөө гэвэл тэр цаад талд нь бол Занданшатар дарга аа, тэр тойрогт нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь гэж байж ялгахгүй бол бид нар нийт нэр дэвшигчдийн 30-аас доошгүйг чинь харахад их зүгээр нэр дэвшүүлэхдээ харж байгаа юм шиг боловч цаад чанар нь бол жагсаалтдаа бас ингээд чанартай байж чадах уу гэдэг асуудал бас гарна шүү. Хойшоо бичигдээд ингээд явж байгаа нийт дүнгээрээ ч гэдэг юм уу. Яах вэ манай олон хүмүүс олон талаас нь яриад байгаа юм. Би зүгээр энийг нь бол бас уламжилж байгаа. Мэдээж олон хүний олон санаа бодол байгаа. Бусад гишүүдийг жишээлбэл Тогтохсүрэн даргыг ганцхан онцлоод шүүмжлээд байж болохгүй л дээ энэ чинь. Бүлгийн дарга байр сууриа илэрхийлээд бас бодлого ярьж байгаа байх. Гэхдээ нийгмийн нэг том төлөөлөл болсон хэсэг нь бол эмэгтэйчүүдийн хэсэг бол байна. Гэхдээ жендерийн асуудал бол ганцхан эмэгтэйчүүдийн асуудал биш. Тоглоом биш. 10 жилийн дараа бол эрэгтэйчүүд энэ асуудалтай тулгарна. Ер нь бол тулгарах ийм боломжтой байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр зүгээр 40-өөс гэхээр Тогтохсүрэн дарга аа, нийт нэр дэвшигчийн 40 хувь гээд явчихаар биш 30 хувь гээд явчихаар тэгээд тэр чинь нөгөө бас яг чанарын талаасаа бол шаардлага хангахгүй болчихоод байна гэдэг юм яриад байгаа юм. Тэгэхээр сонгуулийн тойрогт нийт нэр дэвшигчдийнх нь ядаж 40 хувь дэмжигдэхгүй байлаа гэхэд 30-аас доошгүй нь гэж жишээлбэл тодотгоод өгвөл бас 1-ийг харьцах 1-тэйгээ уялдуулаад цуг ингээд явчих юм бол чанарын талаасаа бол болох гээд байгаа байхгүй юу. Уг нь бол. Үгүй ээ, харин тэр чинь нийт нэр дэвшигчдийн гэж байгаад байгаа юм. Тэгэхээр энэ чинь тойрогт гэж бас тодотгохгүй бол тойрог жагсаалт 2 чинь өөрөө жагсаалтыг бол 1-ийг харьцах 1 гэгчихсэн байгаа. Тэгээд тойрогт нь гээд явчих юм бол манай зарим хүмүүс яах вэ энэ чинь бас ард нь олон мэргэжлийн хүмүүс явж байна. Гаднын ОУБ-ынхан харж байна. Хүний

эрхийн чиглэлийн хүмүүс хараад байгаа байхгүй юу. Тэгээд яах вэ, энэ дээр аль болохоор муйхарлаж тал талаасаа зүтгэх биш, явал эмэгтэйчүүдийн жендерийн гэж ярья даа тийм ээ, энэ асуудал чанарын талаасаа дээшлэх үү гэдгийг л бодож хармаар байгаа юм. Тэгэхгүй ингээд нэг тоо барьчхаад ингээд суугаад баймааргүй л байгаа юм л даа. Тэгээд бүр ингээд болохгүй бол энийгээ гүйцээн боловсруулмаар байгаа байхгүй юу. Ингээд унагачихгүй ингээд, унагачихаар чинь бас ингээд асуудал үүсээд байгаа байхгүй юу. Манай зарим гишүүд бол унах ёстой л гээд ингээд яриад байдаг. Тэгэхээр энэ асуудал дээр гол аргумент нь дэмжигдээгүй санал гэдэг бол бас аргумент бас байгаа юм. Тэгээд энэ дээр манай ажлын хэсгүүд уг нь тал талаас нь харах ёстой. Энэ дээр мэдээж олон янзын олон санаа бодол байгааг ойлгож байна шүү дээ. Гэхдээ аргументуудаа л бодмоор байгаа юм.

Г.Занданшатар: Дэмжсэн 3, дэмжээгүй 3 л гишүүн үг хэлнэ. Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Тэгэхээр бас ажлын хэсэг дээр, Байнгын хороо дээр бас эмэгтэйчүүд квотын асуудлыг бол энэ удаа бас овоо дэмжсэнд бол бас баярлаж байгаа. 1/1 бол дэмжигдсэн байгаа. Тэгэхээр одоо бол энэ асуудлыг л яг 20 байсныг 40 болгох гэдгийг бид нар ярьж байгаад шийдчихмээр байна. Яагаад гэхлээр зүгээр хөгжлийн чиг хандлагаа л бид нар сайн тодорхойлох ёстой юм. Олон улсын байгууллага бид нар 2030 онд 50/50 гэж Тогтвортой хөгжлийн зорилтод заачихсан. Тэгээд л манай дарга нар чинь гадаадад очоод л нэг баахан туршлага судлах гээд л явдаг даа. Очоод л улс орноо яаж хөгжүүлэх вэ гэхээр Үгүй ээ, танайх чинь төлөөллийн ардчилал алдагдсан байна аа. Эмэгтэйчүүдийн 51 хувь чинь байхад яагаад эмэгтэйчүүд чинь улс төрд ийм цөөхөн байдаг юм бэ. Шийдвэр гаргах түвшинд яагаад дандаа эрэгтэй дарга нар байдаг юм бэ л гэсэн хариулт өгдөг

шүү дээ. Энэ авлига чинь хэтэрхий их цэцэглэгчхсэн байна. Хулгай чинь хэтэрхий их нүүрлэгчхсэн байна гээд хариу өгч байгаа шүү дээ. Тэгэхээр энэ бүхнийг чинь янзалья, засъя, улс орноо хөгжүүлъя гэсэн үүднээс л бид нар төлөөллийн ардчиллыг хангая гээд байгаа. Одоо зүгээр та нар сая би дүүргээр яваад үзлээ. 1990-ээд оны “Эзэнгүй айл” гээд л кинон дээр гардаг шиг нэг тийм бүрзгэр амьдрал болсон байна шүү дээ. Хамаг залуучууд нь гадагшаа гараад явчихсан. Эмч нар нь бүгд яваад өгчихлөө. Сувилагч нар яваад өгчихлөө. Энэ чинь том айлаар яривал эзэнгүй айл болох гээд байна. Тэгэхээр дэлхийн улс орнууд чинь хөгжлөө хүний хөгжлөөр хэмждэг болчихоод байна шүү дээ. Тэр их олон баялаг гэхээсээ илүү, уул уурхай гэхээс илүү иргэд нь эрүүл байна уу, иргэд нь боловсролтой байна уу, өрсөлдөх чадвартай байна уу, төлөөллийн ардчилал нийгмийн бүлгүүд нь парламентад хэр үгээ хэлж чадаж байна, шийдвэр гаргаж байна гэдэг дээр л асуудал ярьж байна шүү дээ. Өнөөдөр эмэгтэй гишүүд ороод Төсвийн байнгын хороон дээр төсөв дээр кноп дарах ямар ч боломжгүй байна шүү дээ цөөнх. Тэгээд нөгөө хөтөлбөр Монгол зөв хүн, Монгол хүнээ хөгжүүлэх энэ бүх юм чинь явагдахгүй байгаа шүү дээ. Тийм учраас 40 хувь эмэгтэйчүүд баахан дарга нар орж ирэх гээд байгаа юм шиг битгий бод оо. Энэ чинь аав ээж, арга билгийн ухаанаар Монголчууд хөгжөөд ирсэн. Энэ айл чинь нэг ээжгүй айл шиг ерөөсөө төсөв мөнгөө буруу зардаг ийм л замбараагүй болчихоод хөгжихгүй байна шүү. Модон жорлонгоосоо салж чадахгүй л байгаа шүү дээ. Тийм учраас би бол гишүүд ээ, энэ дээр сайн бодоод 40 хувь гэдгийг дэмжээч л гэж уриалмаар байна. 40 хувь дотор чинь олон эмч нар орж ирнэ. Сувилагч, багш нар үгүй ээ, зөндөө л малчин эмэгтэй, өрх толгойлсон гээд бид нар хүмүүс оруулж болно шүү дээ. Нийгмийн төлөөлөл өнөөдөр орох боломж хангагдаж байна. Тийм учраас би энэ асуудлыг дэмжиж өгөөч л гэж хүсэж байгаа. Ер нь Үндсэн хуулийн

нэмэлт, өөрчлөлтийн холимог системийг эхнээс нь аваад л бид нар сайн, муугаа хэлүүлээд л явсны гол үр дүн чинь л энэ төлөөллийн ардчиллаа л хангах байсан юм шүү дээ. Тийм учраас гишүүдийг энэ дээр бас саналаа сайн дэмжиж өгөөч л гэж хүсэх гээд байгаа юм.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Ирэх 7 хоногт Монгол Улсад НҮБ-ын 8 дугаар ЕНБД байсан Бан Ги Мун гуай ирэх гэж байна. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсад “Транс Алтай” Тогтвортой хөгжлийн зорилгын нэлээн томоохон хурал болох гэж байгаа. Энэ бол Тогтвортой хөгжлийн 5 дугаар зорилго буюу жендерийн эрх тэгш байдлын тухай хурлыг Монголд хийгээд, Монгол Улс бид нар бас үүгээрээ нэлээн манлайлж байгаа гэдгээ ялангуяа бүс нутагтаа олон улсад бид нар бас харуулах гэж бас зорьж байгаа. Энэ нь ч бас ялангуяа 3,4 сая хүн амтай Монгол Улсад эмэгтэйчүүдийн маань хөдөлмөр эрхлэлтийн түвшин сүүлийн 10 гаруй жилд 10 гаруй хувиар буурчихлаа. Эмэгтэйчүүд маань ажилгүйдэл, ядууралд хамгийн их өртөж байна. Хүчирхийлэл ч гэсэн хамгийн их өртөж байгаа ийм нийгэм бид нар бас болчихоод байгаа юм. Тэгээд энэ хэдхэн хүмүүсийн сонгох, сонгогдох асуудал угаасаа биш. Энэ бол эмэгтэйчүүд нийгэмд эрх тэгш хөдөлмөрлөх, хөгжих, бусдадаа үнэлүүлэх ийм боломж бололцооны тухай л уг нь асуудлыг яриад байгаа юм. Тэгээд ингээд ярихаар хэдхэн эмэгтэйчүүдийн амбицийн асуудал гэж бас битгий хараач ээ. Өнөөдөр магадгүй Улсын Их Хуралд сууж байгаа эмэгтэйчүүд хэрвээ сонгуулийн гээд ярих юм бол өнөөдрийн квот нэмэгдэхгүй байсан ч нэр дэвших эрхийг хамгийн түрүүнд эдлэх байх. Магадгүй энэ бол дараа дараагийн эмэгтэйчүүд орж ирж, өнөөдөр шийдвэр гаргаад, манай эмч нарын төлөөлөл, багш нарын төлөөлөл гээд эмэгтэйчүүдийн төлөөлөл өнөөдөр Улсын Их Хуралд орж ирж ажиллах үүд

хаалгыг л нээх гээд байгаа юм аа. Магадгүй өнөөдөр хүүхдэд ээлгүй нийгэм бий болчихлоо гэж бид нар бүгдээрээ өнөөдөр үүнд санаа зовоод байгаа бол өнөөдөр эмэгтэйчүүдийн төлөөлөл энд харин илүү байх ёстой юм биш үү. Бид нар нийгмийн олон бодлогууд алдагдсан гэж хэрвээ ярьж байгаа бол энэ чиглэлээр ярьдаг, энэ чиглэлээр санаа зовж байгаа ажилдаг хүмүүс ихэнх нь үнэнийг хэлэхэд эмэгтэйчүүд байдаг. Эд нарын төлөөлөл байх ёстой юм биш үү л гэж л яриад байгаа юм. Тэгээд бид нар нөгөө НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд амласан амлалтдаа хүрэхийн тулд л өнөөдөр бас 40 хувь гэж яриад байгаа юм. Энэ хүрээнд бид нар ч бас л их л зээл, тусламж авсан даа. Тэгээд л бүгдийг нь тийм, тийм гээд аваад хэрэгжүүлчхээд яг хуульдаа тусгах болохоороо бас ингээд хойшоо суугаад байх нь зохистой юм уу. Тэгээд энэ юуг манай Төрийн байгуулалтын байнгын хороо дээр бас гишүүд ийм санал гаргаад Ж.Сүхбаатар гишүүн бас ийм саналыг гаргаад уг нь бас нэлээн гайгүй дэмжигдээд явж байсан юм байна лээ. Тэгээд үүнийг бас манай Улсын Их Хурлын гишүүд та бүхэн маань энийг бас зөв зүйтэй харж дэмжиж өгөөч гэж хүсэж байна.

Г.Занданшатар: Даваажанцаны Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Жендерийн тэгш байдлын асуудал нь ганцхан эмэгтэйчүүдийн биш ер нь нийт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн амьдрал бүх салбарт тэгш байдлыг хангах тухай асуудал юм байгаа юм. Тэгээд өнөөдөр бид тэгш эрх, хүний эрх, шударга ёс, төлөөллийн ардчилал гээд ингээд ярьж байна. Тэгээд бид нар Улсын Их Хуралд байгаа эмэгтэйчүүдийнхээ хувийг аваад үзэхээр зэрэг 17 хувьтай л байгаа юм. Тэгээд өнөөдөр саяын миний ярьсан эрхүүдийг ярьж байж ер нь улс төрд тухайлбал Улсын Их Хуралд нэр дэвшихэд 30 хувь нь эмэгтэй хүн байхад хангалттай, бусад дал нь бол

эрэгтэйчүүд байна гээд яриад сууж байна гэдэг бол өнөөдөр бас арай л өрөөсгөл зүйл л дээ. Тэгээд та бүхэндээ хэлэхэд би саяын эмэгтэй гишүүдийнхээ хэлснийг давтан хэлэхэд энд сууж байгаа 13 эмэгтэй өөрсдийнхөө төлөө ерөөсөө яриагүй. Ирээдүйн охид, эмэгтэйчүүд таны охин тийм ээ, таны ач, зээ охины ирээдүйн төлөө ярьж байгаа юм шүү дээ. Өнөөдөр Монгол Улсын айл өрх аж ахуйн нэгжсийн ахуй амьдрал бүх ачааллыг эмэгтэйчүүд нуруундаа үүрээд, биеэ засчихлаа. Төрөө засах үйлсэд эмэгтэйчүүд оролцъё гэхэд эрэгтэйчүүд нь үгүй гэж хэлээд байж байж болохгүй байхгүй юу. Энийг л би та бүхнийг онцгойлон анхаарч, эмэгтэйчүүддээ боломж олго. Боломж олгосон улс орон хөгжиж байгаа ийм туршилагууд байна. Хүйсийн тэгш байдал гэдэг бол ерөөсөө эмэгтэй хүний тухай асуудал биш. Бүх салбарт улс орон тогтвортой тэнцвэртэй хөгжих тухай ийм асуудал юм байгаа юм. Дэлхийн чиг хандлага өөрөө ингээд явчихлаа. Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн нэг эд эс нь. Бид нар бүх зүйл дээр дэлхийгээс жишиг авч байгаа. Тэгвэл жишиг авах энэ зүйл чинь улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо буюу бүх салбарт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдлыг хангах тухай асуудал юм байгаа юм. Тэгш байдал гэдэг бол 70/30 биш. Тэгш байдал гэдэг бол 50/50. Өнөөдөр 50 хувийн тухай ярихгүй байна шүү дээ. 50 хувийн тухай огт ярихгүй байна. Сая жагсаалтыг 1, 1 гэгчихлээцэ. Эмэгтэйчүүд тойрогт 30 хувь гэгчихлээ хангалттай гэж та бүхэн маань хэлээд байна. Тийм биш шүү дээ. Жагсаалтыг бид нар тооцоолоод үзэхэд 10 эмэгтэйн л асуудал байгаа юм. Тэгэхээр энэ жагсаалтын хувь, тойргийн хувь бол тусдаа байх шаардлагатай. Тэгж байж бид нар олон улсын жишигийн дагуу улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоогоо нэмэгдүүлэх ийм бололцоотой юм байгаа юм.

Өнөөдөр ер нь манай Монголын эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд үгүй гэж

хэлэх ямар ч үндэслэл байхгүй шүү дээ. Өрх гэрт эмэгтэй хүнгүй бол энэ айлын амьдрал явах уу. Эхнэр нөхөр байж байж алтан мөнгөн багана нь тэнцвэртэй байж байж айл өрх аж амьдрал нь тэгш, аз жаргалтай сайхан байдаг. Улс орны хувьд ч ялгаа байхгүй. Тийм учраас өнөөдөр жендерийн асуудал дээр бас дэмжиж байгаа хүмүүс байна. Би Улсын Их Хурлын даргадаа Занданишатар дарга, манай Сүхбаатар сайд, манай Доржханд гишүүн гээд бас олон эрэгтэйчүүд Цогтбаатар гишүүн маань байна. Эмэгтэйчүүдийн тэгш байдлыг дэмждэг, ойлгодог ийм дэвшилтэт бас гишүүд маань байна. Нэрийг нь хэлээд яах вэ. Жендерийн тухай ярихаар зэрэг маш эвгүй тайлбар хэлж байгаа эрэгтэй гишүүд ч байна. Сонгууль дөхөж байгаа учраас би улс төрчдийнхөө нэр хүндийг эмэгтэйчүүдийн дунд унагаад яах вэ гэж бодоод энэ удаа тэвчиж байна. Маш эвгүй зүйл хэлж эмэгтэйчүүдээ үгүйсгэж байгаа тийм эрэгтэй улс төрчид, Улсын Их Хурлын гишүүн байна. Тэгээд эрх биш алдаагаа засах байлгүй дээ. Тэгээд засаад саяын ярьж байгаа бидний зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжиж алдаагаа засна гэдэгт итгэлтэй байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Санал хураалт явуулна. Гишүүд ч анхаараарай. Сая бас манай эмэгтэй гишүүд үг хэллээ. Нэг зарлал байна. 6 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд Улсын Их Хурлын Тамгын газар, Стэнфордын Их сургууль, Бан Ги Мун сан хамтран БНСУ-ын Еваийн их сургуульд бид хамтраад “Алтайг дамнасан тогтвортой байдлын яриа хэлэлцээ” гэдэг олон улсын хурал чуулган зохион байгуулж байгаа. Үүний нэг том сэдэв нь бол жендерийн эрх тэгш байдлын талаар, улс төрийн эрх тэгш байдлын талаар ийм том чуулган болж дэлхийн Стэнфордын их сургуулийн зэрэг нэртэй эрдэмтдийн талаар илтгэл тавьж хэлэлцүүлнэ. Манай гишүүдийг идэвхтэй оролцохыг хүсье.

Ер нь тэгэхдээ жендерийн эрх тэгш байдал гэж бол эрэгтэй эмэгтэй хүн аль ч хүйс ялгалгүй улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцохыг хэлж байгаа. Эдийн засаг, нийгэм, соёлын, хөгжлийн үр шимээс тэгш хүртэх, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендерээр ялгаварлан гадуурхалтаас ангид байх асуудлыг л жендерийн эрх тэгш байдал гэдэг ээ. Жендерийн хэвшмэл үзэл гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд бол эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт хандлагыг хэлнэ ээ. Ийм учраас манай улс төрчид бол нийгэмдээ энэ өөрчлөлтийг хавсаргахын тулд Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийсэн. Үндсэн хуулийн өөрчлөлтийг сурталчлаад яриад явахдаа бол бид нийгмийн бүлэг жендерийг тэгш байдлыг хангах талаар хангалттай ярьсан учраас хүлээсэн үүрэг коммитментдоо бас үнэнч байж, ер нь бас энэ өөрчлөлтийг бодитой хэрэгжүүлэхийг зүгээр нэг яриа хэлэлцээний түвшинд биш, бодит үйлдлээрээ харуулах ийм шаардлагатай гэж үзэж байгаа юм. Ингээд санал хураалт явуулна. Санал хураалт явуулъя. Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй. Тийм учраас гишүүдийн гаргасан санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн “32.12 дахь хэсгийн “22” гэснийг “18” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа. Санал хураалт. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Энэ санал дээр Байнгын хорооны саналыг дэмжиж саналаа өгсөн. Харамсалтай нь унасан байна. Эсрэг гарсан байна. жендерийн асуудал дээр тэгэхээр хүчингүй болгож өгнө үү.

Г.Занданишатар: Өмнөх санал хураалтыг хүчингүй болгох горимын

санал гаргалаа тийм үү. Дараагийн 2 дахь Одонтуяа гишүүний санал. 22 гэснийг 18 болгож өөрчлөх гэж гэснийг хасах гэж байгаа юм. 32.12 чинь Цагаанхүүгийн Идэрбат гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 22 гэдэг чинь 18 болохоор юу билээ эхийг нь аваад ир дээ. 18 чинь нас. Идэрбат гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Санал хураалт дахиж явуулна. Гишүүд ээ, нэгэнт болсон үйл явдал гэж хууль зүйн шинжлэх ухааны нэр томъёо. Нэгэнт сан хураагдсан санал ингээд дараагийн санал хураалтаа анхаармаар байх юм. Дараагийн саналууд чинь унаад байна. Санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулъя.

2.Одонтуяа гишүүний гаргасан санал. 22 гэснийг 18 болгох. 3 дахиа хэлж байна. Саяын санал хураалт явчихсан. 64,3 хувийн саналаар санал дэмжигдсэн.

3.Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг:

“60.1.Саналын хуудаст нам, эвслийн нэрийг Улсын Их Хурлын өмнөх сонгуульд авсан суудал, саналын тооны ихээс бага руу жагсааж, дарааллын дагуу бичнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд. Санал хураалт. Тогмидын Доржханд гишүүн үг хэлнэ.

Т.Доржханд: Энэ саналын талаар би бас нэг тайлбар хэлье ээ. Түрүүн бас Их Хурлын дарга хэлсэн. Яагаад вэ гэхээр Үндсэн хуулийн өөрчлөлтийг амилуулах уу, үгүй юу гэж. Амилуулъя гэх юм бол бид нар жагсаалтыг зарж болохгүй. 2 дугаарт жагсаалтаас гадна зарагдаад байгаа зүйл бол Ганбат гишүүн ч бас хэлж байна. Улс төрийн намыг зараад байна шүү дээ. Улс төрийн дээд шүүхэд хамгийн түрүүнд бүртгэгдсэн тэр

бүртгэлийн дарааллыг чинь зараад байна гэдэг мэдээлэл яваад байна. Ийм болохоор энийг бид нар зогсоох ёстой юм. Зогсоохын тулд шударга олон улсад байдаг систем нь юу вэ гэхээр авсан саналынх нь өмнөх сонгуулийн үр дүн дээр үндэслээд эрэмбэлдэг байя гээд. Тухайлбал Оросын Холбооны Улс байгаа юм. Сонгуулийнхаа өмнө шоддог, тэгээд дарааллаа тогтоодог. Гэтэл энэ чинь ардчилсан улс гэхээсээ илүү авторитар дэглэмтэй улс хүртэл ингэж явуулж байна шүү дээ. Тэгээд ийм болохлоор бид нар Үндсэн хуулийнхаа өөрчлөлтийг амилуулах, парламентын ардчиллыг бэхжүүлэх, ардчилсан сонгуулиа зөв, шударга явуулах энэ ажлын хүрээнд бол энэ Их Хурлын үүрэг бол худалдан авалтуудыг зогсоох хэрэгтэй. Сонгуульд ордоггүй, тэгсэн мөртөө намын үйл ажиллагаа явуулдаггүй, тэгсэн мөртөө сонгууль болохоор л тэр эрэмбээрээ бүртгэгдсэн дарааллаа ингээд мөнгөжүүлээд явдаг ийм байдлыг бид нар зогсоох ёстой юм. Ийм болохлоор та бүгдийг энийгээ дэмжиж өгөөч гэж хүсэж байгаа. Өөрөөр хэлэх юм бол дэмжээгүй саналыг дэмжихгүй байж өгөөч гээд.

2 дугаарт би бас түрүүн үг авъя гээд үг авч чадаагүй юм. Юу вэ гэхээр Үндсэн хуулийн өөрчлөлтийн амин сүнс нь юу вэ гэхээр нийгмийн төлөөллүүдийг оруулж ирэх юм. Үүнд бол эмэгтэйчүүдийн төлөөллийг оруулж ирэх нь зүйтэй юм гэдэг энд байгаа Их Хурлын гишүүд бүгдээрээ ярьж явсан шүү. ХҮН нам бол 50/50 гэдэг бодлогыг бол зарлаад явж байгаа. Тийм болохоор 40 хувь гэдэг бол хамгийн доод талын хязгаар шүү. Ийм болохоор энэ жендерийн асуудлаар энд байгаа эрэгтэйчүүд нь манлайлаад энэ шийдвэрийнхээ ард гараарай гэж хүсэж байгаа. Ийм болохоор эдгээр заалтууд маань Үндсэн хуулийн өөрчлөлтийг амилуулах, биежүүлэх бодитой заалтууд болохоор энийгээ та бүгд маань бас өөрсдийн нам биш, өөрийнхөө эрх ашиг биш, улс орны эрх ашиг гэсэн үндэслэлээр хараад шийдвэрээ

гаргаж өгөөч гэж хүсээж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданишатар: Гишүүд үг хэллээ. Одоо санал хураалт явуулна. Улс төрийн намын тухай хуулиар зохицуулах асуудал. Сонгуулийн хуулиар энийг зохицуулж болохгүй л дээ. Тийм учраас Улс төрийн намын тухай хууль дээр Доржханд гишүүний саналуудыг хэлэлцүүлээд, тэнд бас ер нь 2 сонгуульд билүү, 1 сонгуульд санал аваагүй нам, суудал аваагүй нам энэ тэрийн бүртгэлийн асуудал хөндөгдөж байгаа байх. Нам наймааны хэрэгсэл болж болохгүй гэж би эхэнд нь хэлсэн. Эх нь булингартай бол адаг нь булингартай.

Хэрвээ ардчиллын эх булаг болсон олон нийтийн эвлэлдэн нэгдэх эрх чөлөө дээр үндэслэгдсэн улс төрийн намын ардчилсан ёс дотоод ардчиллын зарчим нэгдэж байгуулагдахгүй нэг хэсэг бүлгийн нам болоод зарагддаг ийм арилжааны хэрэгсэл болох юм улс төр булингартана. Эх нь булингартай бол адаг нь булингартай. Ардчилал булингартай болно. Тийм учраас энийг бол Улс төрийн намын тухай хуулиараа энэ зарагддаг, арилжигддаг, гишүүдийн нам биш нэг хэсэг бүлгийн нам болдог. Тийм ч учраас 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд нам дотоод ардчилалтай байх, ардчилсан ёс, зарчимд нийцүүлэн дотоод зохион байгуулалт нь ардчилсан ёс журмаар нийцтэй байх энэ зарчмыг гаргасан. Гишүүд олон түмний нам байх ёстой байхгүй юу. Тийм учраас тэр Улс төрийн намын тухай хуулиар энийгээ зохицуулах ёстой байх гэдгийг тэмдэглэн хэлээд санал хураалт явуулъя. Байнгын хорооны саналаар санал хураалт. Байнгын хорооны саналыг 70 хувийн саналаар дэмжлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсгийн “хяналтын дэд хорооны” гэсний дараа “; Сонгогчдын нэрийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны” гэж нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 87,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 82,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Төслийг хууль санаачлагчид нь буцаах санал дэмжигдсэн тул “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлагдсанд тооцлоо. Тогтоолыг батлагдсанд тооцлоо.

Цогтгэрэл, Ганбат нарын өргөн мэдүүлсэн хуулийн төсөл.

Дараагийнх нь “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын

тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн байна.

1.Төслийн 1 дэх заалтын чиглэлээр гэсний дараа сонгуулийн автоматжуулсан системийн тухай гэж нэмж мөн заалтын 12 дугаар сарын 31-ний гэснийг 10 дугаар сарын 1-ний гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 37 гишүүн дэмжиж, 92,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна. Дуусаагүй байгаа шүү.

Дараагийн асуудал байна шүү. гишүүд суудалдаа сууна шүү. Намайг эмээ хүртэл загнасан та нарыг ер нь яагаад толгой руу нь цохихгүй байна гээд хүртэл загнаад байна лээ шүү. Хурал хаяад байгаа хүмүүсийг.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

18.16 цаг.

Дараагийн асуудалд орно. Ингээд сунгаад хуралдчих уу. Маргааш төсөв хэлэлцэнэ. Ажлын ачаалал их байгаа учраас дараа нь 2 асуудал байна. Сунгаад хуралдах уу. Олонхын саналаар сунгаж хуралдъя гэдгийг шийдэх үү. Олонх нь дэмжсэн тул сунгаж хуралдахаар шийдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 5 дугаар 12 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 4 дүгээр сарын 27, 28, 5 дугаар сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан үнэлгээний хорооны хараат бус гишүүдийг аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас томилох нь хэр оновчтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас зарим асуудлыг гүйцээн боловсруулах

чиглэл өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг томъёоллоор санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар явуулах үед нэр бүхий Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан санал болон анхны хэлэлцүүлгийн саналын томъёололд хөндөгдөөгүй зарим асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас ирүүлсэн саналуудыг нэгтгэн ажлын хэсэг хэлэлцэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан Байнгын хороогоор хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах үед хөндөгдөөгүй саналаар санал хураалгах шаардлагагүй гэж үзсэн болно оо.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга

Зоригтбаатарын Энхболд, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Цэдэнбалын Батзул.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Баттөмөрийн Энхбаяр гишүүнээр тасаллаа. Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууна аа.

Б.Энхбаяр: 1 асуулт байна аа. Би эхний хэлэлцүүлэг дээр бас нөгөө шууд гэрээ байгуулах дээр нөхцөл нь яаж эцсийн хэлэлцүүлэг дээр Байнгын хороо ярьж шийдсэн бэ. Энэ дээр нөгөө шууд гэрээ байгуулах үндэслэлүүдээ яаж заасан бэ гэсэн ийм асуулт байна. Ингээд болчихсон уу.

Г.Занданишатар: Хэн хариулах вэ. Байнгын хороо хэлэлцэхгүй юм уу. 80. Батзул хариулъя. Уг нь байнгын хороо хариулах ёстой байж.

Ц.Батзул: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Батзул. Төрийн худалдаа үйлчилгээний газар. Гэрээ хуулийн төслийн 35 дугаар зүйлд гэрээ шууд байгуулах нөхцөлүүдийг тодорхой заасан байгаа. Үүнд бол анхны хэлэлцүүлэг дээр гишүүдээс санал гаргаад шүүх шинжилгээний байгууллагын нарийн мэргэжлийн шинжилгээнд шаардлагатай урвалж бодис нийлүүлэх боломжтой этгээдийн тоо хязгаарлагдмал бол гэрээ шууд байгуулах нөхцөлд хамаарна гээд шинэ заалт нэмэгдсэн байгаа. Үлдсэн 2 нөхцөл нь бол урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээг яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар гэрээ шууд байгуулж болно. Мөн онц байдал, гамшиг ослын онцгой нөхцөл байдалд гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэж болно гээд хуулийн 35 дугаар зүйлд бол заасан байгаа.

Г.Занданишатар: 80. Гүйцээгээд хариул даа. 80. Шууд гэрээ байгуулах.

Ц.Батзул: Хуулийн төслийн 35 дугаар зүйлд бол гэрээ шууд байгуулах аргыг 3 нөхцөлд хэрэглэхээр заасан байгаа. Эхнийх нь бол захиалагчаас урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол,

2 нь болохоор онц байдал, гамшиг ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон шалтгаанаар энэ хуульд заасан бусад тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй,

3 дахь нь болохоор шүүх шинжилгээний байгууллагын нарийн мэргэжлийн шинжилгээ нь шаардлагатай урвалж бодис нийлүүлэх боломжтой этгээдийн тоо хязгаарлагдмал бол гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэж болно гээд.

Г.Занданшатар: Энэ чинь 16 зүйлд 35 дээр чинь гэрээ шууд байгуулах арга гэж байгаа шүү дээ. Чи 37 гээд гуравхан гээд хэлчих юм. 35 дугаар зүйл дээр чинь 16 зүйл байна шүү дээ. Нөхцөл нь үү. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна. Баттөмөрийн Энхбаяр гишүүн тодруулж асууна.

Б.Энхбаяр: 35.1.1-д сая уншсан дээр тайлбар оруулж байгаа юм байна. Тайлбарын эцсийн хэлэлцүүлэг дээр ийм үг оруулж байгаа юм байна л даа. Төсвийн жил дуусаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болох нөхцөл байдал үүсэх юм бол шууд гэрээ байгуулах юм байна тээ. Тэгэхээр төсвийн жил дуустал санхүүжилтийн эх үүсвэргүй болох нөхцөл байдал гэдэг нь цаг хугацааны юм яриад байна уу. Одоо жишээлбэл төсвийн жил дуусах гэхэд чинь 12 сар дөхөж байгааг хэлээд байна уу. Жилийн

дундуур байж болох юм уу. Жишээлбэл барилгын сезоны үеийг ярих юм бол хаврыг хэлээд байна уу. Энэ яг тийм сар байна уу. Энийг чинь нөгөө хугацаа байхгүй болохоор тэгээд л өөрөөр тайлбарлаад л хэрэгжилт дээр бол нөгөө асуудал үүснэ шүү дээ. Захиалагчаас хамаарах шалтгаанаар худалдан авах ажиллагаа удааширсан бол. Энэ бас нэг тийм баримжаатай хугацаа бол байхгүй байна. Энийг ер.../минут дуусав/

Г.Занданшатар: Батзул хариулах уу. 80.

Ц.Батзул: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Тайлбар дээр ийм нөхцөлөөр гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх юм бол хууль зөрчсөнд тооцогдоно гэдэг тайлбарыг нэмэлтээр оруулсан юм. Тэгэхээс биш өвөл боллоо. Төсвийн жил дууслаа гээд гэрээ шууд байгуулах богино хугацаатай гээд шууд гэрээ байгуулах юм бол хууль зөрчсөнд тооцно гэдэг нэмэлт тайлбарыг оруулж өгсөн юм. Тэгэхгүй бол нөгөө юу гэдэг юм төсөв дуусах гэж байна. Өвөл болох гэж байна. Зун болж байна гэдэг үндэслэлээр гэрээ шууд байгуулаад байж болохгүй гэдгийг нь тайлбартайгаар оруулж өгсөн юм.

Г.Занданшатар: Хуучин төслийн заалт нь төсвийн жил дуусах нөхцөл байдал хамаарахгүй гэж байгааг төсвийн жил дуусаж, санхүүжилтийн эх үүсвэргүй болох гэж тодруулах чинь нөхцөл байдлыг дээрдүүлээгүй, дордуулж байна л даа. Тэгэхээр төсвийн жил дуусах нөхцөл нь хамаарахаар юм шиг болоод санхүүжилтийн эх үүсвэргүй байдал болох нөхцөл хамаарахгүй.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай ер нь тендер зарлана, тендер шалгаруулна гэдэг бол уг нь бол олон улсын сонгодог

ойлголтоороо үнэ, чанар 2-ын тухай л ярьж байгаа боловч Төрийн болон орон нутгийн өмчөөр гээд яриад эхлэхлээрээ зэрэг ажлын байрны тухай энэ асуудал ярьж байгаа шүү. Хамгийн чанартай, хамгийн сайн боломжийн үнэ өгнө гэх юм бол хэдэн олигарх монопол компаниудад юм өгнө л гэсэн санаа. Шинэ, хөл дээрээ босох гэж байгаа компаниудыг дэмжих, тухайн орон нутагт хамгийн гол нь ажлын байр бий болгох гэсэн утга санаа энд хамгийн гол байдаг. Миний хэлэх гээд байгаа санаа асуух. Яагаад гэвэл Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт эд нар гэж явсаар байгаад би бас зарим сүүлийн хурлуудад анхаарлаа тавьж чадсангүй. Миний асуух зүйл гэвэл тендер шалгаруулах, биелүүлэх тэр орон нутагт ажиллаж байгаа хүч, ажиллах хүч, орон нутаг тэр МСҮТ-ийн төгсөгчдийг ажлаар хангасан энэ шалгаруулалт, энэ үзүүлэлт яг тендерийн тэр процесстoo хэр туссан бэ. Би яах вэ санал яг тухайн үедээ гаргаж байгаа юм. Шалгаруулахад 16.1.8, 16.3 дахь зүйл заалтыг мөрдөж байгаа. Энэ дээр бол санхүүгийн чадавхыг шаардлагад ямар шаардлагууд байна вэ гэдгээ л үзэж байгаа явдал. Тэр дотор тухайн орон нутгийн мэргэжил сургалтын үйлдвэрлэлүүдийг төрийн мөнгөөр төгсгөж байгаа шүү дээ. Төгсөгчдийг ажилд авсан уу, үгүй юү гэдэг энэ шалгаруулалт орж байгаа юу. Тендер шалгаруулалтын зохион байгуулалтад 10 дугаар зүйлд өөрчлөн найруулгаар орж болохоор тийм санал би хэлж байсан. Энэ орсон уу гэсэн энэ санааг эцсийн найруулгын үед бас тодруулж асууя.

Г.Занданишатар: 80. Цэдэнбалын Батзул. Худалдан авах ажиллагааны газрын дарга.

Ц.Батзул: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийн 8 дугаар зүйл дээр дотоодын үйлдвэрлэлийг дэмжих болон давуу эрхийг тооцох гээд, энэ дээр ажлын хэсгийн гишүүн Батжаргал гишүүнээс санал гаргаад тухайн орон нутагт үйл

ажиллагаа аж ахуйн нэгж эрхэлж байх юм бол нэмэлтээр давуу эрх тооцдог. Ингэснээрээ бусад газраас ирж оролцож байгаа компаниудаас нэмэлт 5 хувийн давуу эрхтэй байхаар тооцож байгаа. Мөн ажиллах хүчнийх нь харьяаллаар нь бас давуу эрх тооцдог энэ зохицуулалтыг энэ хуулийн 8 дугаар зүйл дээр нь тусгайлан зааж өгсөн байгаа юм. Одоо ч гэсэн энэ зохицуулалт маань хэрэгжиж явдаг. Үүн дээрээ нэмээд шинээр заалт орж байгаа нь тухайн орон нутагт сүүлийн 2 жил ажлын байраар хангаж, үйл ажиллагаа тасралтгүй явуулсан бол нэмэлтээр 5 хувийн давуу эрх олгодог байхаар заасан байгаа.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Идэрбат гишүүн асуулт асуух уу. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Худалдан авалтын тухай хууль бас тодорхой зүйлүүд нэлээн шинэчлэгдээд цаг хугацааны хувьд тэр, ялангуяа манай эрүүл мэндийн салбар дээр байгаа зүйлийг бас эмийн худалдан авалт гээд олон зүйлүүд дээр бас эерэг өөрчлөлтүүд гарч байгаа. Миний хувьд бол бас энэ хуулийг хэлэлцэж эхэлсэн цагаас нь хойш үндсэндээ 2 үндсэн асуудлыг л яриад байгаа юм. Орон нутагт байгаа залуучуудыг ажлын байраар хангах нөхцөл бололцоо юунаас болоод хаагдаад байдаг вэ гэхээр зөвхөн аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж орно гэсэн энэ зүйл заалтаар хаагдаад байдаг. Сургуулийн сандал, ширээ хийхэд тусгай зөвшөөрлийн хэрэггүй байдаг. Мод тариад, түүний гадуур хашаа барихад тусгай зөвшөөрлийн хэрэггүй. Тэгээд энэ зохицуулалтыг ер нь яаж хийж байгаа вэ. Хийсэн бэ. Би бол энийг бас үндсэндээ 3 дахиа ч та бүхнээс асууж байна.

2-т. Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд ялангуяа боловсролын салбарын төсвийн байгууллагуудын худалдан авалт тэр дундаа хүнсний ногоо энэ бүх зүйлүүдийг худалдан авах

бололцоог тендерийн хуулиар бас нээгээд өгөөч ээ. Орон нутагт ажиллаж байгаа тэр сургууль, цэцэрлэг, эмнэлгийн эрхлэгч нар хүнсний зүйл худалдаж авна гэдэг маш хүнд юм руу ороод байдаг аа. Та бүхэн надад хариулахдаа бол Боловсролын ерөнхий газар бас журам боловсруулж байгаа гэсэн. Тэгэхээр ер нь бол амьдрал дээр хуулиас давсан журам гэж байхгүй учраас энэ хууль дээр энэ худалдан авалтын асуудлуудыг уг нь Үжсоохон хөнгөвчлөөд жосоохон нээгээд өгчих юм бол өнөөдрийн хүүхдийн хоол, үдийн цайны мөнгө хүрэхгүй байгаа, дотуур байрны хүүхдийн мөнгө хүрэхгүй байгаа, цэцэрлэгийн хүүхэд 2475 төгрөгөөр бүтэн өдрийн хоолыг зохицуулах гээд байгаа энэ зохицуулалтууд чинь бас нэлээн хялбаршаад уг нь явах юм байгаа юм л даа. Тэгэхээр энэ 2 үндсэн зүйл дээр ямар өөрчлөлт оруулав. Аж ахуйн нэгж, хуулийн этгээд гэсэн үгийн өмнө иргэн гээд л нэмчихвэл уг нь болох гээд байгаа юм л даа. Тэгээд тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр хийлгэх үү, иргэнээр хийлгэх үү гэдгээ тухайн сумын удирдлагууд өөрсдөө шийдээд явчихвал. Би жишээ яриад байгаа шүү дээ. Хэнтий аймгийн Батицрээт сумын Алтанхуяг гэдэг хүн би сургуулийн ширээ сандлыг хийчихмээр байна. Гэтэл заавал тусгай зөвшөөрөлтэй компани, амьдрал дээр яадаг вэ гэхээр тусгай зөвшөөрөлтэй компани нь аж ахуйн нэгжүүд нь гадаадаас худалдаж авч ирээд, оруулаад байдаг. Тэр нь чанарын хувьд бас өөрсдийн хийснээс нь шал өөр болоод байдаг. Тэгэхээр ийм зүйлүүдийг нээгээд өгчихвөл орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлууд үр дүнтэй болно гэдэг л ийм л санаа та бүхэнд хэлсэн. Тэгээд энэ сургууль, цэцэрлэгийн худалдан авалт дээр ямар хөнгөлөлтүүд байгаа юм. Өөрчлөлтүүд орсон юм. Орон нутагт байгаа залуучуудыг ажлын байрыг хангах тал дээр ямар өөрчлөлтүүдийг та бүхэнд тусгав гэсэн үндсэн ийм 2 асуултыг асууя.

Г.Занданшатар: Цэдэнбалын Батзул Худалдан авах ажиллагааны газрын дарга. 80.

Ц.Батзул: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийн 4.1.2 дээр иргэн тендерт оролцохоор бас боломжийг нь нээж өгсөн. Тусгайлан оруулсан байгаа. Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг нь давуу эрх тооцдог зохицуулалт бол 8 дугаар зүйл дээр байгаа. Нөгөө талдаа дотоодод үйлдвэрлэж байгаа бараа Засгийн газраас баталж байгаа жагсаалтад багтсан байвал шууд импортын бараатай өрсөлдөхгүй байхаар хуулийн төсөлд бас тодорхой заасан байгаа. Нөгөө талдаа хүнсний үдийн цай, ногооны талаар бид нар бол бас арга хэмжээ авч явж байгаа. Тэгээд манай газар дээр цахим дэлгүүрийг ажиллуулж байгаа. Төрийн хэмнэлтийн хуульд заасны дагуу. Мөн энэ хуульд заасны дагуу. Тэгээд бол Боловсролын ерөнхий газар болон Боловсролын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтраад орон нутагт байгаа аж ахуйн нэгж, хувиараа эрхлэх аж ахуй, мөн иргэдийг хоршоо хэлбэрээр нь бүртгээд мах, сүү, хүнсний ногоо, бас бусад хүнсний бүтээгдэхүүнийг хоршоолол хэлбэрээр нийлүүлэх боломжийг нь бол оруулж байгаа. Тэгээд цахим дэлгүүрт одоо бол цэвэр хүнсний шим хоршоо орчихсон. Сургууль цэцэрлэгүүдэд арилгасан ногоо, хэрчсэн ногоо мөн хэрчсэн мах нийлүүлж байгаа. Нөгөө талдаа тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал болохоор Зөвшөөрлийн тухай хууль болон бусад хуулиар зохицуулагдаж байгаа. Хэрвээ тэр ажлыг нь тусгай зөвшөөрөл шаардахгүй байх юм бол захиалагч сонголттойгоор шалгуураа тавих боломжийг нь бол хуулийн төслийн 16 дугаар зүйл дээр нь бол тодорхой заачихсан. Хэрвээ захиалагч тусгай зөвшөөрөл шаардлагагүй гэж үзэх юм оролцогчдоос тусгай зөвшөөрөл

шаардахгүй байх эрх нь бол хуулиар нээлттэй болж байгаа.

Г.Занданишатар: Цагаанхүү Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: Та бүхний тайлбараас үдийн хоолны хөтөлбөр энэ төсвөөс гарч байгаа хөрөнгө орон нутагт ингээд худалдан авах бололцоог цахим дэлгүүрээр үүсгэж байгаа гэж ингэж хэлж байна. Тэгэхээр яг орон нутгийн аж ахуйн нэгжүүд цахим дэлгүүрт бүртгүүлэх процесс яг яаж явах юм бэ. Цахим дэлгүүртэй холбоотой асуудлууд дэвшил боловч нөгөө талдаа Монголдоо үйлдвэрлэж чадахгүй гаднаас худалдаж авч байгаа юмны нэрийн тоо нь маш цөөхөн байна гэсэн ийм шүүмжлэлүүд бас яваад байгаа шүү дээ. Тэгэхээр ер нь бол цахим дэлгүүрийг яг орон нутгийн аж ахуйн нэгжүүдтэй холбох ийм зүйл бас яг яаж хийгдэх гээд байгаа юм бэ. Наадах чинь жоохон амьдралаас тасарсан юм болчих вий дээ гэсэн нэг ийм болгоомжлол байна. Харин тэр орон нутгийн залуучуудыг ажлын байраар хангах тал дээр бол би ойлголоо.

Харин та бүхэн Худалдан авах газар, Сангийн яамныхан маань шууд худалдан авалтын тоог бас тодорхой хэмжээнд жоохон босгыг нь нэмээд өгөх тал дээр санаачилгатай бас ажиллаад өгөөрэй л гэж би та бүхнээс эцэст нь хүсье ээ. Баярлалаа.

Г.Занданишатар: Батзул. Өмнөх хэлэлцүүлэг дээр л эхний хэлэлцүүлэг явуулахад л тэр юутай холбоотой асуудлыг Идэрбат гишүүн асууж байсан шүү дээ.

Ц.Батзул: Хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаараа бид нар одоогийн төлөвлөгөөгөөр бол Боловсролын ерөнхий газартай ярьж байгаад, аймаг болгонд кластер хэлбэрээр ийм ерөнхий гэрээ байгуулаад, тэгээд тухайн аймагт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын

болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад үдийн цай болон хоол хүнсний материалыг нь нийлүүлэх гэрээг нь байгуулаад явах боломжтой. Идэрбат гишүүний хэлснээр энэ хуулийг дагаад ерөнхий гэрээ буюу цахим дэлгүүрийн нөгөө зохицуулах журам нь дахиад шинэчлэгдэн батлагдах юм. Тэр үедээ таны хэлсэн санааг хэлээд анхаарч үзээд, орон нутгийн байгууллагууд оролцоход нь бас хялбар байх талаас нь журамлана гэдгээ бол хэлье ээ.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалт явуулна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 3 санал байгаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооны гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байгаа.

1.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.1.2.хүн амын эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах бол,” Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт. Чинзориг гишүүн энийг дэмжиж үг хэлэх юм уу, дэмжихгүй үг хэлэх юм уу. Хууль тогтоох ажил бас их хянуур нухацтай хандана шүү бас энэ чинь. Дэмжиж хэлэх юм бол хэрэггүй. Санал хураалт. 57,9 хувийн саналаар

санал дэмжигдлээ. Чинзориг сайд ажлын хэсэг найруулга дээрээ анхаараарай.

Хүн амын эрүүл мэндийг хамгаалдаггүй эм, эмнэлгийн хэрэгсэл гэж ер нь юу байдаг юм уу. Тийм учраас найруулгад нь хангахгүй бол хүүхэд нохойн доог болох вий.

2.Төслийн 36 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 36.4 дэх хэсэг нэмэх:

“36.4.Энэ хуулийн 36.1.2-т заасны дагуу худалдан авах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.” Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт. 57,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Үгүй, хүн амын эрүүл мэндийг хамгаалах гэдэг чинь ингээд нэг тусдаа салбар. Эм, эмнэлгийн хэрэгсэл чинь тэгээд үгүй үгүй, олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл гээд л байхад болоо юм биш үү. Заавал хүн амын эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой олон улсын чанар шаардлага хангадаг био бэлдмэл гэж байгаа юм. Тэгээд 57,9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсгийн “, хөндлөнгийн” гэснийг хасаж, мөн зүйлийн 50.5, 50.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, үүнтэй уялдуулан 50.7, 50.8 дахь хэсгийг хасах:

“50.5.Үнэлгээний хорооны хараат бус гишүүнээр иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас томилсон иргэн, Засгийн даргын Тамгын газрын ажилтныг сонгоно. Засаг даргын Тамгын газрын ажилтныг сонгон.

50.6.Үнэлгээний хороонд тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн хүнийг томилон ажиллуулж болно.” Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт. Тэгэхдээ хэл эцсийн хэлэлцүүлгийг сонгоно. Хэн сонгох юм яагаад хөндлөнгийн байж болдоггүй юм бэ. Дараа нь асуудалтай л юмнууд байна даа. Тэгээд 61,5 хувийн саналаар санал дэмжигдчихлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

18.41 цаг.

Дараагийн асуудалд орно. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ ээ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. Индэрт урьж байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга Эрхэм гишүүд ээ,

Иргэний нисэхийн салбарт хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэн агаарын тээврийн цар хүрээ өдрөөс өдөрт өргөжиж байгаатай холбогдуулан иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, нисэхийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны чиг үүргээс тусгаарлах, салбарын хөгжлийг дэмжих, үр ашигтай, өрсөлдөх чадвартай иргэний нисэхийг өргөжүүлэхэд чиглэсэн оновчтой, үр

дүнтэй эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор 1999 онд баталж 2001, 2003, 2008, 2011, 2015, 2017 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан Иргэний нисэхийн тухай хуулийг шинэчлэн сайжруулах зайлиггүй шаардлага үүсээд байна.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг нийтлэг үндэслэл иргэний нисэхийн талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, иргэний нисэхийн зохицуулалт, агаарын хөлөг түүнд хамаарах үйл ажиллагаа, агаарын навигацийн үйлчилгээ, Аэродром, нисэх буудал, нисэхийн аюулгүйн хамгаалалт, иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах зэрэг 10 бүлэг 51 зүйлтэй байхаар боловсруулсан.

Мөн олон улсын иргэний нисэхийн байгууллагаас Иргэний нисэхийн тухай хууль шинээр болон шинэчилж боловсруулж байгаа улс, гишүүн улс орнуудын иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх үүднээс зөвлөмж болгон гаргасан агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах загвар хууль, Иргэний нисэхийн аюулгүй байдлын загвар хуулиудыг мөрдлөг болгон боловсруулсан болно.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах шинэ зохицуулалтуудыг тусгасан.

Үүнд, Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага түүний бүрэн эрхийг олон улсын эрх зүйн зохицуулалтын практик туршилагад тулгуурлан эрхийг төвлөрүүлж, үүргийг хавтгайруулсан тогтолцоог өөрчлөх зорилгоор шийдвэр гаргах эрх бүхий субъект болох даргын эрх, үүргийг тодотгож хариуцлагыг тусгаж өгсөн.

Иргэний нисэхийн мэргэжлийн хяналт зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй агентлагийн бүтэц үйл

ажиллагаанаас олон улсын жишигт нийцүүлэн эдийн засгийн зохицуулалт аж ахуйн үйл ажиллагааг салгаж эдийн засгийн зохицуулалтыг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн яаманд, бизнесийн үйл ажиллагааг компанийн хэлбэрт шилжүүлэх, Иргэний нисэхийн ерөнхий газрын статусыг тохируулсан агентлаг байхаар тус тус тусгасан.

Иргэний нисэхийн үйл ажиллагааг нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зохицуулах, үр ашигтай, өрсөлдөх чадвартай агаарын тээврийг хөгжүүлэх, зорчигч иргэдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн эдийн засгийн зохицуулалтыг шинээр тусгасан.

Одоогийн хуульд зөвхөн тээвэрлэгчийн эзэмшилд байгаа агаарын хөлгийг зохицуулж байсан бол шинэчилсэн төсөлд өмчийн олон хэлбэрийн агаарын хөлгийн үйл ажиллагааг зохицуулахаар шинэчилсэн. Өмчийн олон хэлбэрт ашиглалтын төрөл бүрийн нөхцөлд нисэх буудлуудын зохицуулалт, нислэгийн аюулгүй байдал, хөдөлгөөний нэгдмэл байдлыг хангасан үйлчилгээний үйл ажиллагаа төрийн зохицуулалтыг шинээр тусгаж өгсөн. Агаарын навигацийн үйлчилгээ гэсэн тодорхойлолтыг өргөжүүлж Монгол Улсын агаарын зөв агаарын навигацийн үйлчилгээг Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн төрийн өмчит хуулийн этгээд Монгол Улсын нэрийн өмнөөс үзүүлнэ гэж тусгасан.

Шинжлэн шалгах судалгаа, дүгнэлт хийх эрх бүхий байгууллагын статусыг олон улсын иргэний нисэхийн байгууллагад санал болгосон агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах загвар хуульд нийцүүлэн боловсрууллаа.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар дараах ач холбогдолтой. Үүнд, Олон улсын эрх хэмжээнд нийцүүлэн Монгол Улсын иргэний нисэхийн эрх зүйн орчин бүрдэнэ.

Нислэгийн аюулгүй байдал сайжирна. Засгийн газрын тохируулагч агентлагийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын болон иргэний нисэхийн салбарын эдийн засгийн зохицуулалтын чиг үүрэг тодорхой болно.

Шинжлэн шалгах ажиллагааны бие даасан, хараат бус байдал хангагдсанаар осол гарах нөхцөлийг бууруулна. Нислэгийн үйл ажиллагаа түүнд дэмжлэг үзүүлэх агаарын навигац, аэродром, аюулгүй хамгаалалтын үйлчилгээний чиг үүрэг тус тус тодорхой болж, улс орны эдийн засгийн өсөлтийг дэмжсэн дэмжлэг болохуйц харилцан уялдаатай өргөжин хөгжих тогтолцоо бүрдэж хөрөнгө оруулалт үр дүнтэй байх нөхцөлүүд бүрдэнэ ээ.

Иргэний нисэхийн салбарт хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж, хөрөнгө оруулалтыг татах, зах зээлийн шударга өрсөлдөөнийг бий болгох эдийн засгийн үр ашигтай зохицуулалтууд бий болно.

Агаарын тээврийн тогтвортой байдлыг хангаж өрсөлдөөнийг дэмжих замаар нийтэд хүртээмжтэй, хямд үнэтэй, хүртээмжтэй нислэгийн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдэнэ.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон бусад хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгнө үү. Та бүхэнд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Бямбацогт сайдад баярлалаа. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Т.Доржханд: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Иргэний

нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 6-ны өдөр хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах үүргийг хэрэгжүүлэх, нисэхийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, Иргэний нисэхийн салбарын хөгжлийг төрөөс дэмжих, орон нутгийн алслагдсан бүс нутагт нийгмийн зайлиггүй шаардлагатай үйлчилгээг бодлогоор дэмжих, Агаарын тээврийг өргөжүүлэн тогтворжуулахад чиглэсэн оновчтой, үр дүнтэй, эдийн засгийн зохицуулалтыг бий болгох, Агаарын навигацийн хураамжийн тодорхой хувиар нисэхийн аюулгүй байдлын хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэх, иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын санхүүжилтийн зарчмыг тодорхой тусгах, Иргэний нисэхийн хяналт зохицуулалтын болон үйлчилгээний чиг үүргийг тусгаарлах, агаарын навигацийн, аэродромын болон аюулгүй хамгаалалтын үйлчилгээг бие даасан аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлэх, шинэчлэн шалгах ажиллагаа гүйцэтгэгч байгууллагыг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас хараат бус байх зэрэг асуудлыг олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан иргэний нисэхийн загвар хууль, стандарт шаардлага болон зөвлөмжид нийцүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байна. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ нар Иргэний нисэхийн аюулгүй

байдал, эдийн засгийн үр ашгийг сайжруулах болон нийгмийн хариуцлагын хүрээнд ард иргэдэд чиглэсэн ямар зохицуулалтуудыг тусгасан, навигаци, нисэх буудлын иргэний нисэхийн хяналт болон аюулгүй хамгаалалтын үйлчилгээг бие даасан аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлэх талаар судалгаа, тооцоо хийсэн эсэх, энэ талаарх олон улсын жишигийн талаар, хуулийн төслийг олон улсын конвенц, дүрэмд нийцүүлсэн эсэх, иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын санхүүжилтийн талаар асуулт асууж, Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг, Н.Ганибал, Ж.Бат-Эрдэнэ нар агаарын тээврийг либералчлах, дотоодын нислэгийн үнийг бууруулж, өрсөлдөөнийг бий болгох, нислэгийн аюулгүй байдлыг сайжруулах зэрэг саналыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы эцсийн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Иргэний нисэхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн ишлэжүүлэхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Доржханд гишүүнд баярлалаа. Чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Доржийн Эрдэнэбат, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Чимэддоржийн Мөнхтуяа, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга Сүхээгийн Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга Пүрэвжавын Ганболд, Иргэний нисэхийн Үндэсний төвийн дарга Нямсамбуугийн Батсайхан, Иргэний нисэхийн Үндэсний төвийн Захиргаа хүний нөөцийн газрын менежер Зинамидын Туяа нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Баттөмөрийн Энхбаяр, Ганбаатар гишүүнээр тасаллаа. Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуултаа асууя.

Б.Энхбаяр: Надад 3 асуулт байна. Хууль санаачлагчаас. 1 дүгээрт Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар 6 дугаар зүйлийн 1-д Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна гэж заасан байдаг. Яах вэ энд бол агаар ороогүй юм байна лээ. Тэгээд Үндсэн хууль батлагдсаны дараа Агаарын тухай бие даасан хууль гаргаад, энэ хуульд өөрчлөлт ороогүй явж байгаа. Агаарыг бол одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Агаарын хуулиар бол агаарын орон зай өөрөө ямар өмч вэ гэдэг асуудал байгаа юм. Нийтийн өмч публич өмч байгаа. Тэр ч утгаараа Монгол Улс агаарын орон зайгаа ашиглуулсныхаа төлөө буюу эндээс хураамж гэх үү, төлбөр гэдэг юм уу авч, энэ нь эргээд орлого болдог ийм зохицуулалт

үйлчилдэг. Тэгэхээр Монгол Улс агаарын орон зайгаа ашиглуулсны төлөө нэг жилд ямар хэмжээний орлого олдог юм бэ дунджаар. Ковидын хязгаарлалттай үед бол багассан байх. Тэгэхээр энийг нэг багцаалж хэлэх бололцоотой байна уу. Хэдэн төгрөгийн орлого олдог вэ. Энэ орлого улсын төсөвт хэд нь ороод, Улсын Их Хурал түүнийг захиран зарцуулах шийдвэрийг нь гаргадаг, Иргэний нисэхийн ерөнхий газар өөрөө хэдийг нь зарцуулдаг юм бэ. Энэ хуулийн төсөл дээр өмнөх хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиас энэ орлогын хуваарилалтыг яаж хийхээр оруулж ирсэн бэ гэсэн эхний асуулт байгаа юм.

2 дахь асуулт нь болохоор хуулийн төслийн 21.2-т багийн гишүүн нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй үйлдэл гаргасан, гаргахыг завдсан зорчигчийг аюулгүй болгох арга хэмжээ авна гэж байгаа юм. Энэ ер нь ямархуу, олон улсдаа яаж зохицуулагддаг юм. Манай хуульд энийг юу гэж ойлгох вэ. Аюулгүй болгоно гэдэг нь хүлж, баглахыг хэлэх үү бүр буудаад алчихыг хэлэх үү тэр хүнийг. Террорист этгээдийг бол тэр онгоцон дотор чинь нөгөө 9 сарын 11-ээс хойш бол буутай этгээд яваад байгаа шүү дээ. Нууц буутай этгээд. Манай энэ төсөлд заасан аюулгүй болгох гэдэг нь юу гэж ойлгох гэж байгаа вэ гэсэн ийм 2 дахь асуулт байгаа юм.

3 дахь асуулт нь төслийн 23.3-д агаарын хөлгийг албадан саатуулахад зэвсэг хэрэглэхийг хориглоно гэж. Өөрөөр хэлбэл Монгол Улсын агаарын орон зайд хууль бусаар зөвшөөрөлгүй нэвтэрсэн энэ агаарын хөлгийг албадаад буу буу гэж навигациар хэлээд байх юм байна гэж ойлголоо. Би эхний 2 зүйлээр нь. Албадаж бол зэвсэг хэрэглэхгүй юм байна. Пуужин харвахгүй гэсэн үг үү. Устгахгүй гэсэн үг мөн биз дээ. Би буруу ойлгоод байна. Нөгөө нэг хууль зүйн хэллэгээрээ. Энэ нь бусад улсад ямар байдаг юм бол. Бусад улсууд чинь бүр сөнөөгч онгоц нисгээд л, буу барь гээд л буухгүй бол хүч хэрэглэнэ

шүү гээд л. Би нөгөө мэдэхгүй юм л даа. Киноноос л тийм юм хардаг юм шүү дээ. Тэгэхээр манайх яадаг юм бол. Энэ 23.3 гэдэг нь зэвсэг хэрэглэхгүй гэдэг нь манайх яах ч үгүй гэж ойлгож болох уу гэсэн л ийм танин мэдэхүйн чанартай 3 асуулт байна.

Л.Мөнхбаатар: Энхбаяр гишүүний асуултад хэн хариулах уу. Эхний асуултад нь Бямбацогт сайд хариулъя. Дараа нь ажлын хэсэг нэмж хариулъя.

С.Бямбацогт: Иргэний нисэхийн тухай хууль 1999 онд анх батлагдсан. Үүнээс хойш үндсэндээ 20 хэдэн жил, 25 жил энд шинэчилсэн найруулга хийгдэхгүй явж байгаад одоо орж байгаа. 1999 онд батлагдахаас өмнө бол та бас урьд нь сонсож байсан байх. Монгол Улсын агаарын орон зайг 100 жилээр ч билүү гаднын хүмүүст худалдчихсан, барьсан гээд. Тийм асуудал үүсэж байсан. Үүнтэй холбоотойгоор үндсэндээ агаар гэдэг юм чинь бас төрийн өмч юм байна. Төрд байх ёстой юм байна гэдэг асуудал хөндөгдөөд, үүнтэй холбоотой бас энэ харилцааг зохицуулах гэж л тухайн үед бас баталж байсан болов уу гэж боддог юм. Энэ цагаас эхлээд Навигацийн орлого гээд Монгол Улсын газар нутаг дээгүүр, агаарын орон зай дээгүүр нисэж байгаа гаднын онгоцнуудаас төлбөр авдаг болсон. Навигацийн орлого өнгөрөлтийн орлого гэж. Энэ орлого бол ер нь бол сүүлийн 20-иод жил байнга өсөн нэмэгдэж ирсэн. Эд үедээ гэх юм бол 2019, 2020 оны үед 400 тэрбум хүртэл нэмэгдэж байсан. Жилдээ 400 тэрбум. Цаашидаа ч уг нь бол нэмэгдэх бололцоотой байгаа. Үүнээс 200 орчим тэрбум төгрөгийг нь улсын төсөвт төвлөрүүлдэг. Үлдсэн хөрөнгийг бас иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх, нислэгийн аюулгүй байдлыг хангах, мөн бас навигацийнхаа тоног төхөөрөмж, бусад бололцоо, боломжийг нэмэгдүүлэх, боловсон хүчнээ бэлдэх, агаарын нислэгийн аюулгүй байдал, нислэгийн холбоотой үйлчилгээг найдвартай

үйлчлүүлэх энэ зорилгоор зарцуулдаг. Иргэний нисэхийн газар үйл ажиллагаа явуулдаг. Иргэний нисэхийн ерөнхий газрын дэргэд бас Иргэний нисэхийн үндэсний төв гээд 2 мянга гаруй хүмүүстэй байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Мөн бас орон нутгийн нисэх буудлууд үйл ажиллагаа явуулж байгаа энэ бүх зүйлд зарцуулдаг юм. Эндээс гол орлого бол үндсэндээ навигацийн орлого. Бусад чиглэлдээ бид нар харьцангуй орлого, буулт, хөөрөлтийн болон зорчигчийн үйлчилгээний орлого, нисэх буудлын үйлчилгээний орлого гээд орлогууд байгаа. Энэ орлогууд нь бол зардлаа санхүүжүүлж чаддаггүй. Гол нь навигацийн орлогоороо бид нар зардлаа санхүүжүүлж, манай иргэний нисэхийн байгууллага үйл ажиллагаа явуулдаг.

Энэ орлого бол сүүлийн Орос, Украин дайнтай холбоотойгоор буурсан. 400 хүрч байсан тэрбум төгрөгийн орлого үндсэндээ 100 хүрэхгүй болж буурч байгаа. Манайхан бас нарийн тоонуудыг хэлээд өгчхөөрэй. Яагаад вэ гэхээр үндсэндээ Орос, Украин дайнтай холбоотойгоор Монгол улс дээгүүр нисээд ямар Оросын хил дээгүүр агаарын орон зай дээгүүр нисэхгүй, хоригт орчихсон учраас нисэхгүй учраас Монгол дээгүүр нисэхээ больсон. Үүнийг бас манай иргэд буруу ойлгодог юм байна лээ. Монголын дээгүүр онгоц нисэхээ больчихжээ. Монгол Улсын Засгийн газрын ч юм уу, төрийн үйл ажиллагаатай холбоотой гэж боддог. Үгүй. Энэ бол Орос, Украины дайнаас болж Монгол Улсын агаарын орон зай дээгүүр нисэх нислэгийн тоо бол эрс буурсан. Үүнтэй холбоотойгоор бас Иргэний нисэхийн байгууллагын үйл ажиллагаа бас доголдож байгаа. Зардлаа санхүүжүүлж чадахаа больж байна. Улсын төсөвт оруулах төвлөрүүлэх хөрөнгөө төлөвлөсөн хэмжээгээр оруулж чадахгүй байгаа. Иймэрхүү нөхцөл байдалтай. Гэхдээ сүүлийн үед бага зэрэг навигацийн орлого нэмэгдэх ийм хандлагатай байгаа гэдгийг

танд бас хэлье ээ. Тэгээд бусад асуултуудад манай мэргэжлийн хүмүүс нь хариулчих уу. Эрдэнэбат. 85 дугаар микрофон.

Л.Мөнхбаатар: 85 дугаар микрофон өгье. Ажлын хэсгийн. Эрдэнэбат дарга хариулъя. Нэр, албан тушаалаа хэлээд гишүүний асуултад хариулаарай.

Д.Эрдэнэбат: Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Эрдэнэбат. Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Монгол Улс дээгүүр өнгөрч байгаа өнгөрөлтийн нислэгийн тоо бол 2022 онтой харьцуулахад бол 34 хувиар буурсан. Эхний 5 сарын байдлаар бол 13,100 нислэг өнгөрсөн байгаа. Энэ нь ОХУ, Украины асуудлаас болоод барууны буюу ОХУ-тай найрсаг бус орнууд тухайн улсын агаарын зайгаар өнгөрөхийг хориг тавьсан. Эргүүлээд ОХУ маань бас найрсаг бус улсуудаа өөрийнхөө нутаг дэвсгэр дээгүүр өнгөрөхийг хориг тавьсан. Үндсэндээ ОХУ-ын Транс Сибирийн замаар бол Зүүн өмнөд Ази, Азийн орнуудыг Европ, Хойд Америктай холбодог ийм үндсэн агаарын зай хамгийн дөт зай өнгөрдөг. Тэгэхээр энэ асуудлаас болоод нислэгийн хэмжээ маань өнгөрөлтийн нислэг маань 34 хувиар буурсан байгаа.

Энэ хуулийн 21.2 дээр багийн гишүүн нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй үед арга хэмжээ авна гэдэг маань хэрвээ тухайн нислэгт эйр маршал буюу тусгай зориулалтын хамгаалалтын ажилтан явж байвал энэ хүн хариу арга хэмжээ авна. Бусад тохиолдолд бол зорчигч нараас тусалцаа авч хүлж, баглах, аюулгүй болгох ийм арга хэмжээ авах заалттай байгаа. Энэ нь өнөө өглөө батлагдсан конвенц дээр бас заагдсан байгаа.

Дараагийн асуулт энэ 23.2 болон 3 дээр Монгол Улсын агаарын зайн аюулгүй байдлыг зөрчсөн агаарын хөлгийг бол

иргэний нисэхийн байгууллагаас бол зөрчлөө зогсоох албадан буухыг бол шаардлага тавьдаг. Хэрвээ энэ шаардлагыг биелүүлэхгүй Монгол Улсын аюулгүй байдалд ноцтой аюул занал учруулсан гэж үзвэл агаарын зайг нислэгт ашиглах тухай хуулийн дагуу агаарын довтолгооноос хамгаалах цэргийн байгууллага өөрөө шийдвэрээ гаргаж цаашдын арга хэмжээг авна. Мөн олон улсын иргэний нисэхийн байгууллагын конвенцоор бол тухайн улс өөрийнхөө агаарын зайд онцгой бүрэн эрхийг эдэлдэг байгаа.

Л.Мөнхбаатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн тодруулж асууя.

Б.Энхбаяр: Тэгвэл Монгол улсын хилийг хууль бусаар нэвтэрсэн агаарын хөлөгт бол хүч хэрэглэх асуудлыг бол зэвсэгт хүчин өөрөө мэдэх юм байна. Энэ хууль дээр зэвсэг хэрэглэхийг хориглоно гэхчээр чинь нөгөө зэвсэгт хүчин чинь зэвсгээ хэрэглэж чадахгүй болчих юм биш үү. Эсвэл энэ нь зөвхөн иргэний нисэхийн байгууллагад хамаатай заалт байна уу. Иргэний нисэхийн байгууллагад зэвсэг хэрэглэхийг хориглоно гэж унших юм уу. Энэ чинь хууль болчихоор дараа нь бас өөр өөрөөр ойлгоод явчих вий. Энийг нэг бас дахиад тодруулаад асуугаадахъя.

Л.Мөнхбаатар: 85 дугаар микрофон өгье. Ажлын хэсгийн. Эрдэнэбат зөвлөх хариулах юм байна.

Д.Эрдэнэбат: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Энэ 23.3 буюу агаарын хөлгийг албадан саатуулахад зэвсэг хэрэглэхийг хориглоно гэдэг заалт маань газар дээр буусан агаарын хөлөгт хамаарч байгаа. Энэ дээр бол иргэний нисэхийн салбарын байгууллагуудын зүгээс болон бусад байгууллагуудын зүгээс бол зэвсэг хэрэг хэрэглэхийг хориглож байгаа. Хэрвээ тусгай ажиллагааны үеэр арга хэмжээ авагдах бол энэ бас тухайн нөгөө хүчний байгууллагынхаа хуулиар зохицуулагдаад явна.

Л.Мөнхбаатар: Ганбаатар гишүүн асуултаа асууна. Ганбаатар гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа цуглаарай. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууя.

С.Ганбаатар: Энэ их өвөрмөц хууль юм. Иргэний нисэхийн тухай хууль. Тэгээд яах вэ, сонгогчид маань сонгохдоо хууль болгоныг А, Б-гүй уншаад л бөөс хуурсыг нь түүгээрээ бидний өмнөөс санаагаа чилээж ороорой л гэсэн учраас баахан уншлаа. Тэгээд их өвөрмөц нөгөө газар тэнгэрээ өөр л байдаг байх. Тодруулж асуух 2 зүйл байна.

1 дүгээрт 10 дугаар зүйл. Тэгэхээр энэ дээр төрийн захиргааны байгууллагын дарга, түүний бүрэн эрх гээд орчихсон байна. Тэгэхээр даргын эрх үүргийг төрийн захиргааны байгууллагуудынхаа хуульд ороогүй юм байна л даа. Энд ингээд явж байна. Хуудас 6 дээр байгаа юм байна. Тэгэхээр 10.2-т дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гээд нэлээн нарийвчлаад заачихсан байна. 11.1-д дарга иргэний нисэхийн аюулгүй байдал болон аюулгүй ажиллагааны үзлэг шалгалт хийх эрхээ иргэний нисэхийн хяналтын байцаагч болон иргэний нисэхийн мэргэжсэн ажилтанд гэрээгээр бүхэлд нь эсхүл хэсэгчлэн шилжүүлж болно. Дараа нь 11.2-т дарга эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гээд. Эрх шилжүүлэх, гүйцэтгүүлэх журмыг Монгол Улсын тодорхой Засгийн газрын гишүүн батална гээд ингээд биччихсэн. Тэгээд энэ эрхээ шилжүүлчхээд тэгээд дараа нь хариуцлагаас мултрахгүй гэдгийг л би тайлбар авах гээд байгаа юм. Эмч хүн бол хагалгаанд ороод, өмнөөсөө хүн тэрийг хагалчхаарай, хагалгаанд ороорой, эмчлээрэй гэж хэлчхээд тэр хүн чинь янз бүрийн юм болчихвол би хариуцна л гэсэн үг болж байна шүү дээ. Тэгэхлээр энэ дээр хэтэрхий мэргэжлийн учраас би тодруулж асууж байна.

2 дугаарт навигаци их том орлого л доо. Улс орнууд ч их ач холбогдол өгдөг навигацийн орлогод энэ төсвийн орлого биш. Үе үеийн Засгийн гауар энийг бас төсөвтөө авах гээд, төсвийнхөө цоорхойг нөхөх гээд оролддог нь үнэн. Энэ бол аюулгүй байдлыг л баталгаажуулах л тухай олон улсын бас хүлээсэн үүрэг байдаг. Энэ хууль дээр би юм олж харсангүй. Тэгэхээр миний асуух гээд байгаа юм гэвэл навигацийн тэр аюулгүй байдлыг баталгаажуулж байгаа нэг хэлбэр нь нисэхийн боловсон хүчнийг дэлхийн стандартад бэлдэнэ гэсэн нэг үүрэг хариуцлага байдаг болов уу. Тэгээд манай ингээд нисэхийн боловсон хүчнийг бэлдэнэ гэдэг чинь тэгээд дарга нарын арын хаалганы авлигын нэг хэлбэр болоод явчихсан. Энийг харин ёстой холбогдох хүмүүс нь сүүлийн үед бас сайн гаргаж ирж тавьж байгаа. Энийг харин даргын энэ зүйл заалт, эрхээ хэтрүүлсэн юмнууд дотор юу ч байхгүй байна. Ер нь навигацийн орлого 300-аад тэрбум төгрөг, одоо бол 100 тэрбум төгрөг гэж байгаа. Энэ их мөнгө шүү дээ. Энэ мөнгөний хяналт. Бидний мэдэж байгаагаар нисэхийн боловсон хүчнийг бэлдэхдээ дандаа улс төрчдийн шахаа, найраа, тал тохой татах ийм ажиллагаа 20, 30 жил үргэлжилсэн. Урьд нь ч сонсож байсан. Энийг тасалсан зүйл энэ хуульд байх уу.

3-д нь их сонирхолтой юм гэвэл 12.3-д заасан байх юм. Дүрмээр хориглоогүй бөгөөд гээд ингээд явчихсан байгаа юм. 12.3-т. Хуулиар хориглоогүй бол гээд дүрэм журамдаа заадаг санагдаад байх юм. Энэ эсрэгээр нь ингээд явчихсан байх юм. Ингээд энэ 3 асуултад би хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Ганбаатар гишүүний асуултад Бямбацогт сайд хариулъя. Гишүүд танхимдаа орж ирээрэй.

С.Бямбацогт: Ганбаатар гишүүн маш зөв харсан байна. Яах аргагүй л бас

хуулийн бөөс түүгээд харж байна. Энэ хуулийн бас нэг онцлог. 1 дүгээрт энэ хуулийг баталсан шалтгаан бол олон улсын иргэний нисэхийн байгууллага Икиагийн дүрэм гэж байдаг. Загвар, жишиг хууль гэж байдаг. Үүнд нийцүүлбэ гэдэг нэг зорилготой.

2 дугаарт нь энэ хуулийг шинэчилж найруулж байгаа 1 зорилго дарга эрхтэй, дарга үүрэггүй байсан. Үндсэндээ 1999 онд энэ хуулийг баталчихаад яагаад өдий болтол 20 хэдэн жил энэ хуулийг Их Хуралд оруулж ирэхгүй байсан бэ гэхээр үе үеийн иргэний нисэхийн байгууллагын удирдлагууд эрхээ эдэлдэг, үүргээ биелүүлдэггүй, хуулийг шинэчлэн найруулаад баталчих юм бол үүрэгтэй болчих гээд хариуцлага хүлээдэг болчих гээд байсан. Ийм учраас ерөөсөө л тэгээд л үе үедээ лоббидоод л хуулийг ерөөсөө оруулдаггүй. Тэгээд л ингээд явчихсан. Үүний цаад талд нь юу нуугддаг байсан бэ гэхээр таны ярьж байгаа тэр навигацийн орлого. Улсын төсөв чинь орж байгаа орлого болгон хуулиар ордог. Зарцуулах зардлын зүйл заалт болгон тодорхой зүйлээр хуулиар гардаг, зарцуулагддаг байсан. Тэгвэл навигацийн орлогыг дураараа нэмж орлого олж болдог, буцаагаад дураараа гарынхаа салаагаар урсгаад, үзэмжээрээ зарцуулж болдог ийм л эрхтэй байсан учраас үе үеийн Иргэний нисэхийн байгууллагын удирдлагууд энэ хуулийг оруулж ирдэггүй байсан юм байна лээ. Үүнийг өөрчлөх гэж энэ хуулийг оруулж ирж байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт нь дарга эрхтэй. Хууль орчих юм бол дарга үүрэгтэй болчих гээд байгаа юм. Иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, агаарын тээврийн үйл ажиллагаа чинь онцгой үйл ажиллагаа. Аюулгүй ажиллагаа 1 дүгээрт тавигдах ёстой. Маш онцгой анхаарал, өндөр сонор сэрэмж, хариуцлага шаарддаг. Гэтэл үүргээ бусдад тараагаад шилжүүлчихсэн. Өөрөө үүрэггүй зөвхөн л эрхээ эдэлдэг. Тийм учраас энэ хуулиар дарга эрхээ эдэлж байгаа бол үүргээ

биелүүл, хариуцлагаа хүлээх ёстой шүү. Онцгой тохиолдолд эрхээ шилжүүлж болно. Эрхээ шилжүүлсэн тохиолдолд харин хариуцлагаас мултрах үндэслэл болохгүй шүү гэдэг заалтыг энд тодотгоод тусгаж өгч байгаа юм. Яагаад гэвэл урьд нь бол бүх эрхээ тараагаад байрлуулчихсан. Үүргээ. Эрхээ л эдэлдэг байсан. Тэгвэл энэ хууль дээр бол үндсэндээ бол дарга хийх гэж байгаа үүрэгтэй байна. Эрхээ эдлэх гэж байгаа бол үүргээ биелүүл. Ямбыг нь эдэлдэг ялыг нь үүрдэггүй байж таарахгүй. Ял, ямба аль аль нь адилхан эдэл, үүргээ хүлээ гэдэг агуулгаар орж ирж байгаа.

Сургалтын тэтгэлэгтэй холбоотой асуудал бас л үүнтэй холбоотой. Нөгөө навигацыйн орлогоос яах аргагүй Иргэний нисэхийн байгууллага бол онцлогтой. Онгоцны нисгэгч бэлдэх хэрэгтэй байна бидэнд. Онгоцны инженерээр бэлдэх хэрэгтэй байна. Нислэгийн удирдагч нар бэлдэх хэрэгтэй байна. Онцгой мэргэжлийн хүмүүсийг зайлигүй төр бодлогоор бэлдэж байж, энэ навигацыйн орлогоо олно. Дээрээс нь Монгол Улсын агаарын тээврийн үйл ажиллагаа аюулгүй найдвартай явах ёстой. Үүний далбаа доор юу гэдэг юм, ах дүү, хамаатан садан, авгай хүүхдээ сургадаг. Үзэмжээрээ тэр навигацыйн орлогыг сургалтын тэтгэлэгт зарцуулдаг ийм зүйлүүд байсан. Гэхдээ харьцангуй цэцэрээд, жигдрээд 360 гаруй хүнээс чинь үндсэндээ 11 хүн нь гэрээний үүргээ биелүүлээгүй байна. Цаашилаад бас 60 орчим хүн ажиллахгүй байгаа. Энэ дотор бас юу гэдэг юм, хамаатан садан, авгай хүүхдээ сургасан, барьсан асуудал дээр хариуцлагын асуудал бид нар ярьж байгаа. Бусад асуултад нэмээд хэн хариулах вэ. 3 дугаар асуултад хариулчих. 85.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье.

Д.Эрдэнэбат: Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Эрдэнэбат. Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Навигацыйн орлогын хувьд бол яг олон улсын жишигээр бол навигацыйн үйл ажиллагаа болон нисэхийн аюулгүй ажиллагааг хангахад бол зарцуулах зориулалттай байдаг. Хуулийн 28.1 дүгээр зүйл дээр бол Ареа навигацыйн үйл ажиллагааг агаарын навигацыйн үйлчилгээний хураамжийн орлогоор санхүүжүүлнэ гэж хууль дээр тодорхой заасан байгаа. Улсын төсөвт төвлөрүүлэх асуудлын тухайд бол жил болгон улсын төсвийн тухай хуулиар бол бас Иргэний нисэхийн ерөнхий газар тодорхой үүрэг хүлээлгэж ирсэн. Тэрийг бол биелүүлж байгаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна. Санал хураалт явуулна. Гишүүд танхимдаа орж ирье. Ирцээ бүрдүүлье. Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Оюунчимэг дарга, Ардчилсан намын бүлгийн дарга, түүний орлогч Туваан гишүүн ирцээ бүрдүүлээрэй.

Тогтохсүрэн даргын өрөөнд байгаа гишүүд орж ирж саналаа өгье.

Ардчилсан намын бүлгийн гишүүдийн ирцийг Туваан гишүүн бүрдүүлье. Гишүүд танхимдаа ороорой. Санал хураалт явуулах бэлтгэлийг хангая. Гишүүд байж байгаад суудлаа эзэлчих. Томьёолол уншичихъя.

Байнгын хорооны саналаар Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Иргэний нисэхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, мөн Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн

төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 51,4 хувиар дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ. Гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

19.14 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ